



Legum servi esse debemus, ut Liberi esse possimus

ХУУЛЬ ЗҮЙН ЭРТӨМ ШИНЖИЛГЭЭ, СУДСАГАА, ОНОЛ, ПРАКТИКИЙН СЭТГҮҮЛ

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

ЭНЭ ДУГААРТ:

- Монгол Улс дахь хууль тогтоох ажиллагаа ба хууль тогтоомжийн шинэтгэл
- Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа ба хүний эрх
- Монгол Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаа
- Гадаадын зарим орны шүүхийн шинжилгээний байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагаа
- Нотариатын үүсэл хөгжил, тогтолцоо
- Герман улсын Захиргааны шүүхийн хөгжлийн тухай тойм
- БНСУ-ын Үндэсний Их Хурлын хууль тогтоох ажиллагаа
- Гадаадын иргэдийн ангилал, тэдгээрийн эрх зүйн байдлыг тодорхойлсон нэр томъёоны тухайд

ЭНЭ ДУГААРТ:

Төрийн байгуулалтын хууль тогтоомж

МОНГОЛ УЛС ДАХЬ ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ШИНЭТГЭЛ ХЗҮТ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, профессор, Ардын багш, гавьяат хуульч **Б.ЧИМИД**4-8

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГАА БА ХҮНИЙ ЭРХ

Цагдаагийн Академийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор **С.ЖАНЦАН**9-15

ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ АГЕНТЛАГ БОЛОН ТАМГЫН ГАЗРЫН ХЭЛТСИЙН ДҮРМИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

МУИС-Хууль зүйн сургуулийн Төр, захиргааны эрх зүйн тэнхимийн багш, докторант **Д.БАТБОЛД**16-27

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

УИХ-ын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга **Ц.ШАРАВДОРЖ**28-32



Криминологи

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХЗҮТ-ийн Криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан, Хууль зүйн магистр **Г.ОЮУНБОЛД**33-39

ОЛОН УЛСЫН ЭРҮҮГИЙН ШҮҮХИЙН ДҮРМИЙГ МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬТАЙ ХАРЬЦУУЛАХАД

ХЗҮТ-ийн Криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний дэд ажилтан, Хууль зүйн магистр **Б.ОДОНГЭРЭЛ**40-42



Иргэний хууль тогтоомж

Нотариатын түүхэн хөгжлийн харьцуулсан судалгаа

НОТАРИАТЫН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ, ТОГТОЛЦОО

Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш **Х.ЦОГЗОЛМАА**43-48

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХУУЛЬ ДАХЬ ЭЗЭМШЛИЙН ТАЛААРХИ ЗОХИЦУУЛАЛТ, ЗӨРЧИЛДӨӨНТ БАЙДАЛ

Хууль зүйн магистр **А.ДЭЛГЭРМАА**49-54

ШҮҮХИЙН ЖУРМААР ГЭРЛЭЛТ ЦУЦЛАХ НЬ ГЭРЛЭЛТ ДУУСГАВАР БОЛОХ НӨХЦӨЛ МӨН ХЗҮТ-ийн Иргэний хууль тогтоомжийн секторын эрдэм шинжилгээний ажилтан, Хууль зүйн магистр **О.ОТГОНТУЯА**55-57



Олон улсын эрх зүй, харьцуулсан эрх зүй

ГЕРМАН УЛСЫН ЗАХИРГААНЫ ШҮҮХИЙН ХӨГЖЛИЙН ТУХАЙ ТОЙМ

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Төр, захиргааны эрх зүйн тэнхимийн багш, (Ph.D) **Г.БАНЗРАГЧ**58-65

БНСУ-ЫН ҮНДЭСНИЙ ИХ ХУРЛЫН ХУУЛЬ ТОГТООХ АЖИЛЛАГАА

БНСУ-ын Үндэсний Их Хурлын Хууль зүйн албаны хуульч **СУН СУ МИ**66-75

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ, ТҮҮНИЙ УДИРДЛАГА

БНСУ-ын Хууль тогтоомжийн хүрээлэнгийн Хууль зүйн солилцоо, хамтын ажиллагааг дэмжих төвийн захирал **СОН ХИ ДУ**76-79

БНСУ-ЫН ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГАА БА ХҮНИЙ ЭРХ

Сөүлийн Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн доктор **ЛИ ХЮ ВОН**80-91

ГАДААДЫН ИРГЭДИЙН АНГИЛАЛ, ТЭДГЭЭРИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛСОН НЭР ТОМЬЕОНЫ ТУХАЙД

ХЗҮТ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрдэм шинжилгээний дэд ажилтан **Н.МӨНХТУЯА**92-96

CONTENTS:



State organization legislation

THE LEGISLATION PROCEDURE AND LEGAL REFORM IN MONGOLIA

B.CHIMID, Scientific secretary of NLC, Ph.D, Prof, People's teacher, Merited lawyer.....4-8

THE CRIMINAL PROCEDURE AND HUMAN RIGHT

S.JANTSAN, Head of Criminal law Department, Sc.D, Police Academy.....9-15

COMPARATIVE STUDY ON SELF-GOVERNING AGENCY AND CHARTER DEPARTMENT OF GOVERNOR OFFICE

D.BATBOLD, Lecturer of State and administrative law department, School of Law, National University of Mongolia, Ph.D candidate.....16-27

LAW MAKING PROCEDURE OF THE STATE GREAT KHURAL OF MONGOLIA

TS.SHARAVDORJ, General secretary of State Great Khural office.....28-32



Criminology

SYSTEM AND PROCESS OF FORENSIC INQUIRY OF FOREIGN COUNTRIES

/G.OYUNBOLD, Researcher of Criminology Research sector of the NLC, Master of law/.....33-39

THE COMPARATIVE STUDY ON THE ROME RULE OF THE ICC AND CRIMINAL PROCEDURE CODE OF MONGOLIA

/B.ODONGEREL, Research-fellow of Criminology Research sector, NLC, Master of law/.....40-42



Civil legislation

Comparative study on Notary's history

THE NOTARY'S DEVELOPMENT AND ITS SYSTEM

KH.TSOGZOLMAA, Lecturer of Otgontenger University, School of law.....43-48

THE LEGAL REGULATION ON "OWNERSHIP" CIVIL CODE OF MONGOLIA AND ITS MATTERS IN CONTROVERSIAL

A.DELGERMAA, Master of law.....49-54

DIVERGE UNDER JUDGEMENT IS A ONE TYPE OF MARRIAGE TERMINATION BASIS

O.OTGONTUYA, Researcher of Civil legislation sector of the NLC, Master of law.....55-57



International law, comparative law

A BRIEF REVIEW ABOUT ADMINISTRATIVE COURT'S DEVELOPMENT IN GERMANY

G.BANZRAGCH, Lecturer of State and administrative law department, School of Law, National University of Mongolia, Ph.D.....58-65

LAW MAKING PROCEDURE THE ASSEMBLY OF THE REPUBLIC OF KOREA

SON SU ME, Legal official of Law Department, National Assembly of the Republic of Korea.....66-75

THE LEGAL INFORMATION AND MANAGEMENT OF THE REPUBLIC OF KOREA

SOHN HEE DO, Director of legal exchange and cooperation, Korean Legislative Research Institute.....76-79

CRIMINAL PROCEDURES AND HUMAN RIGHT OF THE REPUBLIC OF KOREA

LEE HYU WON, Professor of Seoul University.....80-91

CLASSIFICATION OF EXPATRIATS AND SOME ISSUES ON TERMS DEFINING THEIR LEGAL STATUS

N.MUNKHTUYA, Research-fellow of International law sector, NLC.....92-96

Сэтгүүлийн зөвлөлийн гишүүд:

Ц.БАТ-ОРШИН

Сэтгүүлийн зөвлөлийн ерөнхий эрхлэгч

ГИШҮҮД:

Л.Бямбаа	- Улсын дээд шүүхийн шүүгч, доктор
Д.Даваа-Очир	- Хууль зүйн доктор, хурандаа
Н.Дагва	- Нийслэлийн шүүхийн Тамгын хэлтсийн дарга
А.Доржготов	- Улсын дээд шүүхийн шүүгч
Д.Наранчимэг	- Отгонтэнгэр Их сургуулийн захирал
А.Оюунчимэг	- Монголын нотариатчдын танхимын ерөнхийлөгч
Б.Пүрэвням	- Үндсэн хуулийн цэцийн гишүүн
Т.Уранцэцэг	- Сонгино хайрхан дүүргийн шүүхийн шүүгч
Ш.Үнэнтөгс	- ХЗДХЯ-ны мэргэжилтэн
Б.Цэрэнбалтав	- Улсын ерөнхий прокурорын орлогч
Б.Чимид	- ХЗҮТ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, гавьяат хуульч, доктор, профессор
Н.Чинбат	- Оюуны өмчийн газрын дарга

Дугаарыг эрхэлсэн:

Р.Болормаа

- Сэтгүүлийн хариуцлагатай
нарийн бичгийн дарга

Эрхлэн гаргагч:

Хууль зүйн үндэсний төв

Редакцын хаяг:

Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг, Сүхбаатарын талбай-7

Утас:

315736 Факс: 315736

Вэб сайт:

www.legalcenter.mn

И-мэйл:

magazine_info@legalcenter.mn

Улсын бүртгэлийн дугаар: 279



**ХЗҮТ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
доктор, профессор, гавьяат хуульч Б.ЧИМИД**

МОНГОЛ УЛС ДАХЬ ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ШИНЭТГЭЛ

Үргэлжлэл /Түрүүч нь 2008, №2 /21/-т/

Гэтэл «хэт хуульчилж» заншлыг эвдэж, ингэснээрээ хуулийн зохиомол хийдэл үүсгэх болов. Үүнд хүмүүсийн хувийн «амбиц» гэх өвчин ч хүчтэй нөлөөлж буй. Жишээлэхэд, орчин үеийн ёс зүйн хэм хэмжээгээр зохицуулдаг төрийн янз бүрийн албан хаагчдын ёс зүйн асуудлыг дүрэмдэх, заншилаар тохируулдаг үндэсний спорт, тэр дундаа эрхийн уламжлалт эрийн гурван наадмыг хуульжуулснаас юу харагдана вэ?

Үндэсний бөхийн начингаас дархан аварга хүртэлх Бөхийн холбоо, наадмын комиссоос эртнээс тогтсон болзлоор нь олгодог бүх цолыг (яг л Улсын гавьяат, баатар зэрэг төрийн дээд цолын адил) Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар хүртээдэг хуультай болжээ. Уяачдын цолыг ч адил. Үүнийг дагалдаад аймаг, сумын Засаг дарга бөх, морины цолыг олгодог «төрийн албатай» болж, заншлыг захирамжаар солив. Хэрэв «зарлигтай маргавал» Үндсэн хуулийн цэцэд мэдүүлэхэд болохгүй гэх газаргүй биз. Түүнээс гадна спортын бусад төрөл зүйлээр тоглогч, тамирчин өөрөө болзол хангаж авдаг элдэв зэрэг цолыг мөн л Ерөнхийлөгчөөс шагнадаг хууль гаргахыг шаардахыг хэн байг гэх вэ? Зохиомол «хийдэл» гэдэг энэ. «Сумо бөх» Монголд хөгжөөд ирвэл тэдэнд

«хүмүүсүби», «сэкиваки», «озаки», «якузуно» цолыг бас л зарлигдах уу? Японд эзэн хааны зарлиг буюу Ерөнхий сайдын захирамж гардаг уу?, тийм бол «бусад орны жишиг» гэж булзаж болох. Уул овоо тахиу хууль; ууц тавьж таллах журам, бэр буулгах, бэргэнтэх дүрэм гаргах уу? Төр ёсоо мэддэг төр байхаас гадна түүний дээр өөрийн удирдлага, ёс заншилтай ард түмэн, үндэстэн угсаатан байх л болно. Тэд аж амьдралаа ёс заншлаараа зохицуулж таараа. Харин засаг төр дэвшилт заншлыг дэмжих үүргээ хуульчилж болохгүй гэх газаргүй. Үндэсний спортоо үл тоомсорлосондоо ийнхүү өгүүлсэнгүй. Харин түүний зуу зуун жилийн угшлаас нь салгаж, ард олны цэнгэлийн биш, төрийн хэрэг болгож «цэвдэгшүүлснийг» нь бодогдуулах, хууль юуг, заншил, ёс зүйн хэм хэмжээ юуг зохицуулд-гийн ялгааг эрх биш дурсах гэсэндээ тэр. Хууль нь ард түмний уламжлалт ёс заншлыг «булаах» биш, харин түүнд хэдий чинээ найдаж түшиглэнэ төдий чинээ тус дэмжлэгтэй байдгийг нэмж дурдалтай.

6. Хууль тогтоомжийн шинэтгэлийг гагцхүү сонирхогч байгууллага, албан тушаалтны хүсэлд үндэслэн «хувьсгалч» энерцид дулдуйдан хийх осолтой. Харин улс орныхоо сонгон авсан хөгжлийн эрхэм зорилго, чиг баримжаа, түүний төрж гарсан эдийн засаг, нийгэмшил, соёл ахуйн уугуул нөхцөл буюу бидний ярьдгаар хөгжлийн зүй тогтол, улс үндэснийхээ өвөрмөц нөхцөлийг

харгалзаж, нийгмийн эрэлт хэрэгцээнд тохируулан тогтоох нь зайлшгүй чухал юм. Үүнд бас эрх зүйн түүхэн уламжлалыг ямагт харгалзвал зохино. Эрх зүйн соёлын өмнөх бүх өв уламжлалыг бүгдийг үгүйсгэн, угаас аль ч нийгмийн харилцаанд адилсах хууль зүйн хэм хэмжээ, практик байдгийг «социалист үзэл суртлаас нь» ангижруулан залгамжлан хэрэглэж болох төдийгүй нэн чухал юм! Жишээлбэл, Эрүүгийн хуульд байдаг гэмт зэргийн ойлголт, бүрэлдэхүүн, үе шат, ялыг хөнгөрүүлэн болон хүндрүүлэн үзэх нөхцөл байдал, төрийн ба хүний амь насны эсрэг, хулгай, дээрэм, хээл хахууль зэрэг нэлээд гэмт хэргийн тухай ягуур үндэслэл болсон заалтыг засан сайжруулж, уламжлан авахыг үгүйсгэвээс томоохон алдаанд орох магадлал бий. Жижиг хулгай, булаалт зэрэг ялимгүй хэрэг үйлдсэн эмэгтэйчүүд, хүүхдэд 8-10 жил хорих ял ногдуулахад хүрдэг. «Шүд зуусан» мэт ял хэрэглэж байгаа нь хөнгөн ял шийтгэх шүүгчийн эрхийг «хасах», хэлбэрийн төдий зарим үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй байж болох тухайн уламжлалт заалтыг дутуу бодсон, хохирлоо төлсөн хүнийг хорих ялыг хугацаанаас өмнө уучлахыг хориглосон зэрэг нь чухам үүний нотолгоо бөгөөд хүмүүнлэг бусад хүргэж байгааг нуугаад яах вэ? Үүнчлэн иргэний хууль тогтоомжоос «нийгмийн

өмч, социалист аж ахуйн тогтолцоог" дангаар бэхжүүлэн хамгаалах агуулгатай үзэл сурталжсан заалтуудыг хасаж өмчлөх эрхийн агуулга (эзэмших, ашиглах, захиран зарцуулах гэх мэт) гэрээ хэлцэл, гэм хор, өв залгамжлалын гэх зэрэг түгээмэл ойлголт, зарчмыг сайжруулан уламжлахыг үгүйсгэж болохгүй. Гэтэл бүхэлд нь үгүйсгэж, бусдыг учир утгагүй хуулбарлан, Монголын нөхцөлд тохирох, тохирохгүй хууль, заалт гаргах нь хуулийг хямралд хүргэж болзошгүй. «Хууль тогтоомжийн алив шинэтгэл нь... үндэснийхээ эрх зүйн түүх, соёл, үзэл санааны болон бусад онцлогийн тухайн мэдлэгт суурилсан байх хэрэгтэй»¹² гэсэн эрдэмтний үгийг хүлээн зөвшөөрөхөд буруудахгүй. Энэ нь шинэтгэлд түүхэн үүднээс хэтийн төлөвийг олж харах, өөрийн болон гаднын туршлагыг зохистой харгалзахын нэгэн үндэс юм.

7. Гаднын "туршлага", жишгийн тухайд гэвэл дэлхийн буюу хүн төрөлхтний эрх зүйн соёлтой хөл нийлүүлэх нь зүйн хэрэг. Гэхдээ түүнд хатуу хязгаар бий. Ямар ч нөхцөлд эх орныхоо "есөн зүйлийн" хэрэгцээ, уугуул орчинд нийцэхүйц **эрх зүйн бүлийг**¹³ баримжаалж, зөвхөн тэр хүрээнд харшлагааргүй бусад бүлийн жишгийг авах, гээхийн үүднээс харгалзан үзэх нь тогтолцоот, тогтвортой хандлагын нэг шаардлага мөн. Түүнээс биш нэг бүлийг баримжаалаад бусад "үүдээ барьчихаж" болохгүй нь ойлгомжтой. Түүнчлэн бусад бүлээс «өөрийн бүлд» огт нийцэхгүй элдэв бүлийн хууль, журмыг хуулбарлан хэрэглэх нь үндэснийхээ эрх зүйн тогтолцоог ээдрүүлэхэд хүргэх нь бас магад. Барууны орнуудаас төвлөрөл сааруулахыг, далайн орнуудаас төвлөрүүлэхийг авсан нь өнөөдөр гал ус мэт харшилдаж байгааг хууль зүйн шинжлэх ухааныхан хэлж зүрхлэхгүй загас мэт, улс

төрчдийн зарим нь ойлговч ус балгасан мэт байна. Гадны "зөвлөх"-үүдийн хатгаасаар Газрын хэвлийн эрдэнэ баялгаа үнэгүй, эсвэл эрс хямдруулан өмчлүүлж, төрийн **онцгой өмчийн эрхийг** алдаад эцэст эргүүлж гуйланчладаг хууль гаргачихаад түүнийгээ хосгүй "сайн бэлсөн", "дэлхий шагшиж байна" гэж ярих нь дэндүү харамсалтай. Үнэгүй буюу хямдхан "их олз хайрласан хуулиас" хялбархан олз хайсан хүн яахин татгалзах билээ. Магтаалын учир энд, олзонд байгаагаас биш, хуулийн сайнд биш гэдгийг бид тодоос тод ойлгож байна. Энэ мэтийг "завсраас нь ашиг хүртэгсэд" эс хайхран эрх зүйн элдэв бүлийн, эвдэх тэндэх орны, эзэвээр хураавар хууль, журмыг үгчлэн хуулбарлан зүтгүүлж, «гадаадын мэргэжилтэн»-ээр түрээ барьж хөөсрөн бөхөлзөх нь дэнгийн эрвээхэй шиг дэндүү гэнэн, үлэмжхэн хор уршигтай үзэл дадал мөн. Америкийн хуулиудыг авчраад орчуулаад мөрдчихье гэдэг улс төрчид бий болж. Сайн хууль бол санааг нь "агшааж, сунгаж" авч болно. Гэхдээ Дорнын заншлын эрх зүйн түүхэн уламжлалтай, эх газрын бүлээр цөөнгүй жил дагнасан Монгол оронд 700 жилийн давтамжит Англо-Саксоны жишгийг нэлэнхүйд нь хэрэглэнэ гэдэг санаанд багтамгүй хандлага. Үүнийгээ "даяарчлал" гэж дөвийлгөнө. Зүйрлэн хэлбэл Монгол нь даяаршлаа гээд далайн орон болж, дандаа загасаар хооллохгүй. Холбоот буюу хаант улс болох төрийн төрөл арилжихгүй л болов уу. Хээр талдаа хэдэн малаа өсгөж, байгалийн баялгаа өөрсдөө хэмэнэ ашиглаж, үр шимийг нь хүртсээр байх болно. Тэгээд тэжээлийн ургамал тариад жилд 10-аад удаа "тайран авч" тэжээн ганц үүнэнээс 30-40 литр сүү авах нь юу л бол, зөгнөлт туужид байдаг шиг

Монгол халуун бүсийн орон болбол магадгүй л юм. Алтаар сансрын хөлөг авч саран дээр станц байгуулж энэ зуундаа хараахан амжихгүй л болов уу. Харин уламжлалт аж ахуйн тогтолцоогоо хадгалж, түүндээ суурилсан орчин цагийн аж үйлдвэржилт, шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлж, урлан бүтээцгээж аж амьдралаа дээшлүүлэхийн чухал нь мэдээж. Энэ бүхэн эцэстээ Монголчууд биднээс Монгол төрийн холч бодлого, **хуулийн тууштай үзэл баримтлахыг** нэхэн шаардаж байна.

8. Шинэ тутам хуулиуд олон зүйлийн бичил шалтгаанаас үүдээд хоорондоо зөрчилдөх, давхардах нь цөөнгүй болсноос гадна хийдэл (цоорхой) гэх нэрээр хууль биелүүлэхээс хүлжих болов. Улс төр, эдийн засгийн болон ухамсарын шалтгайг хямралт байдлаас шалтгаалан хуулийн биелэлтийг "холгож", нэр хүндийг унагасан **эрх зүйн үгүйсгэл** (нигилизм) ихээхэн газар авлаа. Энэ байдлыг нотлох гэж нэг их тоо баримт цуглуулах шаардлага байхгүй мэт. Ямар ч хуулийг мэргэжлийн үүднээс биш хар ухаан, хувийн сонирхлоор мушгин тайлбарлах нь дэндлээ.

Авлига, албан хариуцлагагүйдэл, ашиглан шамшигдуулал, албан тушаалтны ёс зүйгүй авир, эрх мэдлээ урвуулах, хэтрүүлэн ашиглахаас авахуулан хүн амын зарим хэсгийн доторх танхайрал, дээрэм, хулгай, хүчин төдийгүй хүний амь эрэлгээр хөнөөсөн аюулыг гэмт хэрэг төрөл, хэлбэрийн хувьд өсөж сэтгэл түгшүүлсээр байна. Дуулиант хэргүүдийг мөрдөн шалгах, таслан шийдвэрлэх асуудалд хүлээгдэл, чирэгдэл, гайхшрал төрүүлсэн чимээгүйдэл байн байн гарч шүүх эрх мэдлийн байгууллага хүчгүйдэн үнэлэмж нь буурч ард олны итгэл алдаж

¹² Н.И. Матузов, А.В. Малько. Теория государства и права. Юристы. М., 1997. С.169

¹³ Энэ тухай Б.Чимид "Үндсэн хуулийн үзэл баримтлал" 16оть. УБ., 2005 он.

ирсэн зэрэг нь хууль хэрхэн үйлчилж байгаагийн баримт болох биз. Тэгэхээр "шинэтгэлээ дууссан" гэж үзээд зогсоочих уу! Ажиллалт судалгаанаас ямар санал, зөвлөмж дэвшүүлэх хэрэгцээ, шаардлага байна?

3. Шинэтгэлийн хоёрдугаар шат, түүний гол агуулга

Юутай ч бүх хуучин хуулиа бүгдийг өөрчилж, шинийг нэмж 2007 оны 11 дүгээр сарын 28-ны байдлаар 377 хуультай болсноор¹⁴ барахгүй, энэ завсар зарим хуульд бараг жилд 1-2 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж амжжээ. Энэ бол засаг төр маань үлэмжхэн ажил амжуулсан гэсэн үг. Сайн ч, саар ч эдгээр олон хуулиар Монголын нийгмийн харилцаа «амьсгалж», шинэчлэгдэн «ажиллаж» байгаа нь маргаангүй. Гэвч үүнд сэтгэл ханах яагаа ч үгүйг дээр дурдсан байдал эрх биш цухалзуулсан болов уу. Иймд нэгийг бодож урагш ахиж цаг болж. Энд би мөрөөдөл ч гэх үү, шинжлэх ухааны төсөөлөл ч гэх үү, цөөн санаа илэрхийлэх гэсэн билээ. Бид хууль тогтоомжийн **хоёрдахь шатны шинэтгэлийн тухай** санаагаа хоёр гурван жилийн өмнөөс сонин хэвлэлээр илэрхийлсэн. Бүүр 4 жилийн өмнө Улаанбаатарт болсон олон улсын онол-практикийн бага хурал дээр ч ийм санаа илэрч байв. Тэнд Ц.Мөнх-Оргил илтгэлдээ: «Эцэст нь нийгэмд шинээр бүрэлдэн бий болж буй харилцааг олон улсын хандлагад нийцүүлэн зохицуулахаас гадна **эрх зүйн шинэтгэлийн эхэн үед ач холбогдлоо өгсөн хэдий ч нийгмийн хөгжлийн явцад хуучирсан хуулиудыг эргэн харж, шинэчлэх илүү нарийвчилсан зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна**»¹⁵ гэжээ. Эрх зүйн шинэтгэлийн 1998 онд батлагдсан хөтөлбөр, түүний дагуу гаргасан «төлөвлөгөө»-нүүдийн биелэлтэд (хэрэгжилт гэх) ХЗДХЯ, ХЗУТ-өөс 2007 оны турш хийсэн хяналт

шинжилгээ ("мониторинг" гэх)-ний үр дүнг саяхан (2007 оны 9 дүгээр сард) хэлэлцсэн онол, практикийн бага хурлын дүнгээс энэ санал үндэслэлтэй нь харагдав. Өөрөөр хэлбэл, хөтөлбөрийн зорилт "үндсэндээ хэрэгжиж", түүнийг гүнзгийрүүлэх чанарын шатанд дэвшин орох илүү шинэ хэрэгцээ, зорилт тулгарсныг харуулав.

Хууль тогтоомжийн шинэтгэлийн 1990 оноос эхэлсэн анхдугаар шатны их ажил үндсэндээ шувтарсныг бид дээр дурдсан гурван зурвас үеэр ангилж нотолсон. Хуучин дэглэмийн хуулиудтай зууралдах цаг хэдийн өнгөрсний сацуу шинэ цагийн хууль тогтоомжийн анхны тогтолцоо бүрдэв. Шинэ хуулиудад урсгал засвар хийх төдийхнээр цаг их нөгцөөх нь нийгэмд үр нөлөө муутай болов. Иймийн учир улсынхаа бүх хуулийг бүхэлд нь шинжлэх ухааны тогтолцооны нь түвшинд хянан үзэж чанарын өөрчлөлт хийх буюу **боловсронгуй болгох зорилго** тавьж ажиллахыг засаг төрд бид санал болгож байна. Үүнийгээ шинэтгэлийн шинэ 2 дахь шат гэж нэрлэж байгаа ч угтаа "боловсронгуй болгох" гэдэг¹⁶ нь илүү оновчтой болов уу. Үүний тул их зүйл хийх ёстойгоос энд арга зүйн чанартай хэдхэн санал хэлэхийг хүснэ. Үүнд:

1. Хууль тогтоомжид тогтолцооны үүднээс хандаж шинжилгээ хийх. Хууль санаачлагчид, гүйцэтгэгчид, хэрэглэгч байгууллагууд юуны өмнө УИХ-ын байнгын хороод, Засгийн газар, УДШ, ҮХЦ өөрийн хэрэглэдэг болон тус тусын хүрээний нийтээр дагаж мөрдөж буй бусад хуульд эрх зүйн болон холбогдох бусад мэргэжлийн үүднээс чанарын шинжилгээ хийхгээ! Түүний мөрөөр цаашид авах цогц бөгөөд **"зохицтой"** арга

хэмжээг Засгийн газрын түвшинд хугацаа, эзэнтэйгээр нэгтгэн төлөвлөж санхүүжүүлэн хэрэгжүүлмээр болжээ. Энэ шатны эхний үед хуулиудыг харьцуулан судалж оносон, алдсаныг цэгтнэн, ололтоо бататган, алдаж эндсэнээ арилгах **«их цэвэрлэгээ»** хийвэл зохино. Хуулийн «цэвэрлэгээ» гэж юуны өмнө алдаа, зөрчил, давхардал, бүрхэгдэл, хийдлийг илрүүлж арилгаж бүхэлд нь уялдуулахыг хэлнэ. Уул ажил өөрийн гэсэн үзэл баримтлалтай, мэргэжлийн ажил билээ. Энэ явцад тулгамдсан асуудлаар шинэ хууль гаргах нь мэдээж. Гэхдээ байгууллага бүхэн, албан тушаалтан бүр "өөрийгөө хамгаалах" хууль боловсруулж батлуулан «өөрийн хуультай» болж бусад хууль руу «нулимлах» хандлага газар авсныг давтаж болохгүй.

2. Цэвэрлээд үлдээснийг нь яах вэ? гэдэг асуулт гарна. Юуны өмнө хууль, заалтуудыг нэгтгэх, төрөлжүүлэн хуульчлах нь нэн чухал. **Хууль «цэвэрлэх», «төрөлжүүлэн хуульчлах»** (кодексчлох) хоёрын хооронд ямар холбоо байна вэ? Хуулиас давхардсан, зөрчилдсөн, бас "илүүц" (лоозон шийр хэрэгцээгүй), найруулгын алдаатай зүйл, заалтыг ялгаж хасахаар цаана нь утга бүрхэг, авцалдаа муутай, хэсэг бусаг заалт үлдэнэ. Тэдгээрийг оргүй хасаад хаячихаж бас болохгүй. Яагаад гэвэл сул орон зай буюу шинэ хийдэл нэмэгдэнэ. Иймд шинэчлэн найруулж таарна. Ийнхүү хуульд угаас байсан хийдлийг цэвэрлэгээгээр бий болсон хийдэлтэй нь нөхөж, учир шалтгааны уялдаатай, цогц шинжийг бүрдүүлэх зайлшгүй хэрэгцээ гарна. Энэ мэт шалтгаанаар тэр хуулийг дахин иж бүрэн боловсруулахад ч хүрэх магадлал бий. Нэг хуульд орсон шинэлэг заалтууд нь бусад

¹⁴ www.legalinfo.mn (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд авсан мэдээлэл. ХЗҮТ)

¹⁵ Монголын эрх зүйн шинэтгэл-8 жилд. (Илтгэл болон зөвлөмжүүдийн эмгэлтэй). УБ, 2003 он. 91 дэх тал

¹⁶ "Шинэтгэх" нь хуучныг халах, "сайжруулах" нь зарим засвар (тоон) өөрчлөлтийг хийх; боловсронгуй болгох гэж бүхэлд нь шинжж зарчмын (чанар)-ын өөрчлөлт хийх гэсэн ялгаатай гэдэг тул ийм томъёо хэрэглэв.

хуультай холбогдон нөлөөлж, түүнийг өөрчлөхөд хүргэж бас болзошгүй. Иймд шууд холбоотой бөгөөд нэг төрлийн харилцааг зохицуулдаг хэд хэдэн хуулийг нэгтгэж нэг төрөлжсөн хууль (кодекс) гаргавал тэдгээр хуулийг цөөтгөж боловсронгуй болгохын дээд түвшин, чанарын шинэтгэл болмой. Цөөтгөх нь сайжруулах (тоон) өөрчлөлт, боловсронгуй болгох нь чанарын өөрчлөлт гэх ялгаа бий. Ер нь төрөлжүүлсэн (кодексчилсон) хэдхэн чамбай хуультай, тэр нь газар сайгүй тогтвортой мөрдөгдөн, мадаггүй биелдэг байхад л хуулийн гол бодлого чиглүүштэй. УИХ энд чангахан хандваас зохилтой.

3. Дэд актыг цэгцэлж ном журамд нь оруулах. Хуулийн үндсэн дээр засаг захиргааны дээд төв, орон нутгийн байгууллагаас гаргадаг тогтоол, захирамж, дүрэм, заавар зэрэг "хэм хэмжээний" актыг хуульд нийцэж буй эсэхийг болон бүрдэл чанарыг шинжин үзэж цэгцлэх цаг болсон байна. ХЗҮТ дээр Дэлхийн банкны "Шүүх, эрх зүйн шинэтгэл" төслийн шугамаар хийж буй төслийн судалгаанаас үзэхэд хуулийг янз бүрээр "бажуулсан" шинэ "хэм хэмжээ" тогтоож замруулдаг олон арван тушаал, заавар гарч байна.

Энэ бол хуулийг заавраар орлуулдаг өмнөх үеийн буруу зуршлын үргэлжлэл байна гэсэн үг. Уг гажуудал нь төрийн албаны ерөнхий соёлын түвшин, уламжлалтай, удирдлагын хоцорсон дадалтай холбоотойн дээр хууль тогтоогч маань алив нэгэн хууль гаргахдаа ямар нэг асуудлаар "журам тогтоох" заавар, дүрэм гаргахыг Засгийн газарт даалгадаас их шалтгаалдаг бололтой. Хууль "том асуудлыг хамарсан ерөнхий заалттай байх, тэдгээр заалтыг заавраар тодруулах ёстой" юм шиг ойлгож баримтлах, "заавар шиг хууль байж болохгүй" гэж үзэх, ингэснээрээ агуулгын (материаллаг) хуулийг үйл явцын (процессын) хуулиар хангаж хэрэглэх тэр маш чухал соёлыг үгүйсгэх

хоцрогдол бараг л хэвээр байна. Процессын журамгүй хууль бол хоосон тунхаг лоозон болж хоцроод тэр зайг нь тогтоол, заавраар орлуулан нөхөж, хуулиа завхруулдаг нь социализмын үеийн хуулийн сул тал гэдгийг барууныхан хэдий нь тэмдэглэж ирсэн буй.

Монгол Улсын Үндсэн хуульд "...хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү УИХ-д хадгалах" гэсэн нь хууль "төлөөлөн гаргах"-ыг Монголд хориглосон гэсэн үг. Гэтэл УИХ энэ эрхээ бусдад шилжүүлэхээ больж хуулиа "заавар шиг" нарийн боловсруулж гаргах, Засгийн газар, олон яам, агентлаг, Засаг дарга нарын норматив тогтоол, захирамж, тушаал, заавар нь түүнийг "хэрэглэх арга" техникийг тодорхойлохоос илүү гажуу юм нэмж захиргаадгагийг зогсооход өгүүлэн буй ажил чиглэвэл зохино. Заавраас хуульд шилжих нь эрх зүйт ёсонд шилжих нэг гол арга зам мөн гэдэг.

4. Лавлагаа мэдээллийн сан хөмрөг бүрдүүлж хэрэглэх хэзээ ч гүйцэд хийж амжаагүй ажил ундарна. Энэ бол төр улсад нэн хэрэгтэй ажил¹⁷. Хууль тогтоомжийг цаг тухайд нь нийтлэх, гүйцэтгэгчдэд нь хүргэх, бүртгэл лавламжийн цахим хийгээд энгийн сан хөмрөг бүрдүүлж хэрэглэх, үүний тул засаг төрийн төв, орон нутгийн байгууллагуудыг "Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоол"-оор хангаж, тус тусын хэрэглээний сан бүрдүүлэх нь төрт ёс, эрх зүйн соёл, хууль дээдлэл зарчимд бүрэн нийцнэ.

Сүүлийн үед парламент баталсан хуулиа ч цаг тухайд нь нийтлэхгүй, засаг төрийн байгууллагуудад биетээр буюу түүнчлэн нутгийн захиргаад албан ёсны эхээр нь илгээхгүй, хэзээ хойно хэдэн 7 хоног, сарын дараа хэвлэх болсон¹⁸ зэрэг нь яавч эрүүл биш үзэгдэл мөн.

5. Хууль бол тэр чигээрээ төр улсын түүхийн

их толь бичиг, ард түмний өв залгамжилсан хөрөнгө мөн гэхэд хэтрэхгүй. Австрийн хуульч эрдэмтэн агсан Ханс Кельзений хэлсэнчлэн төрийг дуран авайгаар хараад ч олж харахгүй, зөвхөн хууль тогтоомжийн хэм хэмжээнээс л танин мэдэж болно. Улсын дэглэм, засаг төрийн мөн чанар, шинж байдал, гүйцэтгэж ирсэн үүргийг гэхчлэн ерөөс төр улсын өнгөрснийг голчлон хуулиас нь олж мэдэж, сэргээн харж болно. Үүнээс үүдэн улсын хуулиа он дараалан эмхлэн цэгцэлж, бадгалж хамгаалан, залгамжлан баяжуулж байдаг нь төрийн чухал соёл мөн. Монгол Улс 1926 оноос 1990 он хүртэл хуулиудыг «Засгийн газрын албаны сэтгүүл», «Улсын Их, Бага Хурал, Засгийн газрын эмхтгэн хавсруулсан сэтгүүл», «БНМАУ-ын хууль, дүрэм, тогтоолын эмхтгэл», «БНМАУ-ын хууль, зарлиг, тогтоолын эмхтгэл»-д, 1990 оноос «Төрийн мэдээлэл» гэх албан сэтгүүлд он, сар, өдөр дараалан хэвлүүлж, хэрэглэж ирсэн түүх бий. Харин манай шинжлэх ухааны байгууллагынхан түүнийг бараг хэрэгсэхгүй, намын удирдамж, шийдвэрийг л төр улсын түүхийн эх сурвалж болгон баримтдаг гэж зуршилтай. Энэ нь он дараалан эмхтгэлийг улсын сан хөмрөг болгон нэгэн газар эрхлэн дансалж хамгаалж ирээгүйгээс цаг цагийн хямралд өртөн эзэнгүйдэж, үрэгдэж бараг дууссантай холбоотой байж мэдэх юм. Бид 1979 оноос хойш ХЗДХЯ-д цуглуулж эхэлсний (одоо бас л үрэгдсэн бололтой) дээр 1980-аад оноос "БНМАУ-ын хүчин төгөлдөр хууль тогтоомжийн системчилсэн бүрэн эмхтгэл"-ийн 7 том ботийг хэвлүүлэхээр төлөвлөн төрийн дээд байгууллагын шийдвэр гаргуулж нэлээд ахицтай эхэлсэн. Уг ажил ардчилсан хувьсгалын эхээр арга буюу шалтгаанаар тасалдан зогсов.

¹⁷ Энэ талаар хийж буй шинэлэг ажлыг мэдээллийн хэсэгт өгүүлсэн болно.

¹⁸ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 3, 6 дугаар тогтоолд үзнэ үү.

Гол шалтгаан нь уг эмхтгэл «хүчин төгөлдөр хууль тогтоомжийн» байсан бөгөөд Монгол Улс ардчилсан дэглэмд шилжиж эхэлснээр тэдгээр "хуучин" хууль мөн чанарын хувьд халагдаж, хүчин төгөлдөр байдлаа алдсанд оршино. Гэлээ ч түүхэн баримтын хувьд бүр мөсөн устгасан хэрэг огт биш. Улс маань **өнгөрсөн, одоо, ирээдүй** гурван цагийн хэлхээнд оршихын учир түүнийг дагуулан хууль тогтоомжийн сан хөмрөгөө цэгцлэн өвлөж, баяжуулан уламжилж байх учиртай.

Энэ ёс төрийг бодолцон Монголын Тулгар төр тогтносон 1206 оноос 2006 он хүртэлх Монгол Улсын хуулиудыг он дараалан олж судлан шинжлэх ухааны зохих аргачлалын дагуу эмхтгэн хэвлүүлэх ажлыг ХЗҮГ-ийн санаачилгаар эхэлсэн болно. Хөрөнгө мөнгөний гачаал ихтэй учир Засгийн газраас гаргах хөрөнгөөр эхлээд хүчин төгөлдөр хуулиудыг эмхтгэн 4 ботиор хэвлэн борлуулж, "орлогоор" нь өнө эртнээс өдгөө хүртэлх он дараалсан түүхэн эмхтгэлүүдийг боловсруулж гаргахаар бодолцсон аж. Энэ бол Үндсэнийхээ хууль тогтоомжийг төр, эрх зүйн түүхэн эх сурвалж болгон судлах, суралцах, хууль боловсруулах ажилд уламжлал болгон хэрэглэх нөхцөл бүрдэж Монгол Улсын хууль тогтоомжийн бүрэн

сан хөмрөг болж түүхэнд орох, шинэтгэлийн үеийн сод бүтээл болно гэж найдна.

Хууль тогтоомжийг ийнхүү цэвэрлэн, иж бүрэн шинэтгэхийн сацуу түүний түүхэн эх сурвалжуудыг цэгцлэн тайлж нийтээр нь сэргээн нийтэлж, улсын бүрэн гүйцэд сан хөмрөг болгож хойч үедээ өвлүүлэхэд үлэмжхэн хүч, хөрөнгө, ухаалаг шургуу хөдөлмөр шаардагдана. Түүнд гар татвал "охор ухааны охь" олон үеийн "хохь" болох тул төрийн мэргэн шийд, эрдэмтдийн нөр хичээнгүй зүтгэл хэрэгтэй байна. Ажил хийвэл дуустал, давс хийвэл уустал!

Энэ бол зүгээр нэг архивын баримт олоод эмхтгэх ажил мэт үзэж, сонирхогчдын санаачилга төдийгээр гүйцэтгэх хөнгөн хялбар ажил биш билээ. Шинжлэх ухааны мэдлэг мэргэжил шаардсан эрдэмтэн судлаачдын хүч шавхсан «хар ажил» байж таарна.

Дээр өгүүлснээс үзвэл **эрх зүй, хууль тогтоомжийн шинэтгэлийг бид аливаа хуучныг хөсөр хаяж бүхнийг шинээр боловсруулах, бусдыг хуулбарлах гэдэг өрөөсгөл, туйлширсан хандлагаар бус Монголын онцлогийг тусган ширээсэн уламжлалаа сэргээн залгамжлах үйлс** бас мөн хэмээн үзэж болно.

б . Е р ө н х и й г э э с

тодорхойд. Хууль тогтоомжийн шинэтгэл "өөрийнх нь зорилт" биш. Хэрэв зөв хандваас нийгмийн бүх харилцааны хөгжлийн хурдасгуур, хамгаалагч бөгөөд бусад хүрээний шинэтгэлийг тээж дамжуулах сүлжээ мөн. Энэ утгаар шинэтгэх, түүний үр дүнг боловсронгуй болгох бүхий л ажлыг улс төрийн амьдрал, эдийн засаг, нийгмийн харилцааны хөгжлийн жам ёс, нийгмийн сэтгэл зүй, ухамсрын хүчин зүйл, байгалийн хувьсал хийгээд гадаад орчны хөгжлийн хандлагыг сайтар харгалзан төлөвлөж, хэрэгжүүлбэл илүү үр дүнд хүрнэ. Энд ерөнхийгээс тодорхойд, түүнээс нарийвчлалд шилжихийн гайхамшиг орших учиртай. Эцсийн дүндээ хуулийг сайжруулах, боловсронгуй болгохын философи нь хүний эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрч, бататган тэдний харилцан ажиллагаанд сайн сайхныг сахин хамгаалахад оршино. Ардчилсан нийгмийн туйлын хүслэн нь эрх чөлөө, тэгш байдал, шударга ёс бөгөөд хүн ба хуулийн шүтэлцээ үүнд оршдог билээ. Үүнийг би засаг төр «Хуулийг доодсыг энэрэн хамгаалах, дээдсийг эрхэмлэн хязгаарлахын тулд гаргадаг» хэмээн тайлбарладаг юм. Буруу бол өршөөн хэлтрүүлэх буй заа!

Цагдаагийн академийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн
эрхлэгч, Хууль зүйн шинжлэх ухааны доктор,
профессор С.Жанцан

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГАА БА ХҮНИЙ ЭРХ

Монгол Улсын Ардчилсан Үндсэн хуулийн оршил хэсэгт: Монголын ард түмэн бид: "...хүний, эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлээ эрхэмлэн дээдэлж, ...эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно" гэж тунхаглан зарласан билээ. Хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэмд хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдсан байх учиртай.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 3 дугаар зүйлд "хүн бүр...эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй ...хэнд ч эрүү шүүлт тулгах буюу хэрцгий, хүний ёсноос гадуур эсхүл нэр төрийг нь гутаан харьцах, шийтгэхийг хориглоно" Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пактын 9 болон 17 дугаар зүйлд Хүний халдашгүй дархан байх эрхийг дэлгэрэнгүйгээр тогтоосон байдаг. Тухайлбал, хүний халдашгүй чөлөөтэй байх эрх "улс оронд онцгой байдал тулгарч, улс үндэстэн оршин тогтоход аюул учирсан үед ч зөрчигдэх ёсгүй"² гэж онцлон заасан нь чухал ач холбогдолтой юм.

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1975 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 3452 дугаар тогтоолоор "Бүх этгээдийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс

хамгаалах тухай" тунхаглал гаргасан ба энэ тунхаглалын зорилгыг бодитой хангахын тулд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр "Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийг албан ёсоор батлан гаргасан. Манай улс 2000 онд энэ конвенцид нэгдэн орсоноор эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд мөрдөх болсон юм. Нэрд гарсан соён гэгээрүүлэгчид, сэтгэгчид, гүн ухаантнууд хүн, түүний эрхийн асуудалд онцгой анхаарч байсан. Тухайлбал, Германы гүн ухаантан И.Кант "...иргэний нийгэм нь угтаа агуу их эрх чөлөө юм. Эрх чөлөөний эрх зүйн үндэс нь хүний эрх, эрх чөлөө юм. Энэ эрх, эрх чөлөө халдашгүй ариун байх ёстой"³ гэж сургасан.

Профессор Г.Совд "хүн бүр халдашгүй чөлөөтэй байх нь хүний угаас заяасан хувийн эрх...энэ эрх бол хүн бүрд Үндсэн хуулиар баталгаажуулсан хөндлөнгийн хэн боловч дур мэдэн халдаж болохгүй туйлын эрх..."⁴ гэж түүний эрх зүйн агуулгыг оновчтой тодорхойлжээ. Аливаа ардчилсан төр иргэдийнхээ өмнө тэдгээрийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахын тулд гэмт хэрэгтэй



гэмцэх, нийгмийн дэг журмыг сахиулах, иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох үүргийг хуулиар хүлээсэн байдаг. Монгол Улсын Үндсэн хуульд хүний эрхийг тунхаглаад зогсохгүй мөн хуулийн 19 дүгээр зүйлд "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцана"⁵ гэж төрийн чиг үүргийг тодорхойлов.

Үндсэн хуульдаа хүний эрхийг баталгаатай хангах, халдашгүй эрхийг сэргээхийг төрийн чиг үүрэг болгон анх удаа ингэж хуульчилсан нь Монголын захиран тушаах дэглэм бүхий /тоталитар/ төрийн үйл ажиллагаанд хүний эрхийг бүдүүлгээр зөрчин, хуулийн хүрээнд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаагаар өөрөөр хэлбэл шүүхийн оролцоогүй олон иргэдийг хэлмэгдүүлсэн хар түүхийг давтахаас урьдчилан сэргийлэх зорилготой гэж үзэж байна.

Хэлмэгдүүлэлттэй холбоотой түүхэн баримтыг иш үндэс болгоход 1930-аад оны сүүл 1940 оны эхэн үед манайд өрнөсөн их хэлмэгдүүлэлтийн үр дүнд гэм буруугүй нийт 31

¹ "Монгол Улсын Үндсэн хууль" УБ, 2005 он, 1 дэх тал

² Хүний эрх: Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл. УБ, 1990 он, НҮБ. 3 дахь тал

³ Д.Лүндээжанцан, Н.Жалбажав Эрх зүйн философи, УБ, 1998 он, 137-142 дахь тал

⁴ Г.Совд Монгол Улсын Үндсэн хууль. Хүний эрх, 1999 он, 50-51 дэх тал

⁵ Монгол Улсын Үндсэн хууль, УБ, 2005 он, 10 дахь тал

мянга 742 хүн хэлмэгдсэн бөгөөд тэдгээрийн 20262 хүн буудан алах, 11446 хүн хорих болон нутаг зааж суулгах/цөлөх/ ялаар шийтгэгдсэн байдаг⁶.

1937 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн УБХ-ын тэргүүлэгчид, АСНЗ, Ерөнхий сайд, мөн ерөнхий сайдын 1 дүгээр орлогч сайд нарын хавсран хуралдсан хурлаас "...эх орноосоо урвах болон онц аюултай зарим гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн хэргийг таслах онцгой бүрэн эрхтэй комисс байгуулж, даргаар нь Х.Чойбалсан, гишүүнээр Лувсаншарав, Цэрэндорж нарыг томилж, улмаар шүүхээс өөр байгууллага шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх онцгой эрхийг эдлэх болсон нь дээд зэргийн завхрал, хүний эрхийн зөрчлийн бүдүүлэг эхлэл тавигдсан юм. Мөрдөн байцаах, шүүн таслах эрх бүхий онцгой бүрэн эрхт комисс 1937 оны 10 дугаар сараас 1939 оны 4 дүгээр сарын 4-22-нд татан буугдаж хүртлээ 51 удаа хуралдаж 27785 улс төрийн хэрэгтний хэргийг авч хэлэлцэж 20099 хүнийг буудан алах, 5739 хүнийг хорих ялаар шийтгэжээ. Зөвхөн нэг удаагийн хурлаар 1278 хүнийг бөөнөөр нь /нэрсийн жагсаалтаар/ хэлэлцэн бараг бүгдэд нь буудан хороох ял ногдуулсан байдаг⁷.

1942 оны 2 дугаар сарын 24-нд МАХН-ын төв хорооны тэргүүлэгчдийн онц хурлаас гаргасан тогтоолд "... дайсан этгээд нарыг эрхтэнд нь гэмтэлгүйгээр зодох ба занчиж болох эрх зөвшөөрлийг ДЯЯ-ны сайд нөхөр Шагдаржавын өөрийн хариуцлагад хатуу даалган өгсүгэй гээд энэхүү аргыг ...зөвхөн төвд хэрэглэхийг зөвшөөрсүгэй" гэж заасныг хэрэгжүүлэн хүмүүсийг зодох, занчих өөрөөр хэлбэл эрүүдэн шүүлт тулгах аргаар хэргийг өөрөөр нь хүлээлгэж байсан нь Зөвлөлтийн эрдэмтэн Вышинскийн "хэргээ хүлээж мэдүүлэх нь хамгийн дээд зэргийн нотолгоо

/нотолгооны хаан/ мөн гэсэн бүдүүлэг онол манайд биеллээ олж байсны бодит илрэл юм.

Гэмт хэрэг үйлдэх, гэм буруутай эсэхийг нотлох зорилгоор Үндсэн хууль, ЭБШ хуулийг удирдлага болгон төр, түүнийг төлөөлсөн байгууллага эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах үед зайлшгүй хүний халдашгүй болон бусад эрх хөндөгдөх, хязгаарлагдах эрх зүйн үндэслэл бий болдог. Академич Ж.Амарсанаа "Хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад гол зүйл бол хязгаарлалтыг хортойгоор ашиглах явдлыг гаргуулахгүй байх асуудал чухал юм"⁸ Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь аливаа гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлж, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох, гэмт хэрэг үйлдсэн этгээд нэг бүрт зохих ялыг шударгаар ногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцогүй байх явдлыг хангах зорилтыг хэрэгжүүлж буй байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгч субъект болох хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хуульд нийцсэн үйл ажиллагаа юм. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хүний эрх зайлшгүй хөндөгдөх болдог.

Эрх зүйн онолын үүднээс хүний эрх нь ямар ч тохиолдолд хэмжээ хязгааргүй дүр зориг биш юм. Монгол Улсын олон улсын гэрээ, конвенци болон үндэсний эрх зүйн хэм хэмжээнд аливаа хүний эрх, эрх чөлөө бусдын эдлэх эрхээр хязгаарлагдах нийтлэг жишиг шаардагддаг жамтай. Тухайлбал, Хүний эрхийн түүгэмэл тунхаглалын 29 дүгээр зүйлийн 2-т "хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхэд бусдын эрх, эрх чөлөөг эрх зүйн дагуу зөвшөөрөн, ёс суртахууны

шударга шаардлагыг биелүүлэх ардчилсан нийгэмд байдаг хэв журам, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосон зохих хязгаарлалтанд захирагдана"⁹ Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй"¹⁰ гэж заасан. Гэмт хэрэг үйлдэх замаар бусад хүний эрх, эрх чөлөөнд халдаж хохирол учруулж байгаа нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм буруутай эсэхийг шалгах ажиллагааны үед эрхийг хөндөх хангалттай үндэслэл болох ёстой.

Хүний халдашгүй эрхийн хязгаарлалт нь Үндсэн хуулийн түвшинд, хязгаарлалтын хязгаарлалт нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хүрээнд тус тус тодорхойлогдоно¹¹. Иймд хүний халдашгүй эрхийг хамгийн товчоор хүний хүсэл зоригийн хуульчлагдсан илэрхийлэл болохын хувьд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хүрээнд онцгойлон авч үзэх шаардлагатай.

МУ-ын Үндсэн хууль болон холбогдох бусад хуулийн заалтын агуулгаас үзвэл, хүний халдашгүй эрх гэж өөрийнх нь төрөлх, жам ёсны хэрэгцээнээс үүдэлтэй мөн чанарын хувьд төрөөс тогтоосон болон зөвшөөрсөн бөгөөд эрх зүйн хэм хэмжээгээр баталгаажин хамгаалагдсан ямар ч тохиолдолд хөндлөнгийн хэн боловч хөндөж, хязгаарлаж хэрхэвч болохгүй хэд хэдэн туйлын эрхийн цогц ойлголт юм. Хүний халдашгүй эрх цогц ойлголтыг:

а/ чөлөөтэй байх эрх;

б/ бие эрхтний халдашгүй

эрх;

⁶ ТЭГ-ын тусгай архив Ф-МБ, ХН-ОБЭК N16. 220 дахь тал

⁷ М.Бадагч. Нүгэл хийх амархан, буян үйлдэх хэцүү "Тусгаар тогтнол" сонин, 1990 он, №100

⁸ Ж.Амарсанаа. Хүний эрх: олон улсын ба үндэсний эрх зүйн асуудал УБ. 2000 он. 127 дахь тал

⁹ Хүний эрх: Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл. НҮБ. УБ, 1992 он, 8 дахь тал

¹⁰ Үндсэн хууль УБ, 1992 он, 8 дахь

¹¹ Х.Эрдэнэбат Хүний халдашгүй эрх УБ. 2002 он. 38 дахь тал

в/орон байрны халдашгүй эрх;

г/хувийн нууцын халдашгүй эрх;

д/ нэр, төр, алдар хүндийн халдашгүй эрх;

е/өмчийн халдашгүй эрх гэсэн эрхийн төрөл бүрдүүлдэг. Халдашгүй эрх нь хүний эрхийн гол зангилаа асуудал болохын хамт хувийн эрхийн цөм юм.

А/Чөлөөтэй байх халдашгүй эрх ба Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа
Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 3 дугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай ОУ-ын пактын 9 дүгээр зүйлийн 19 дэх хэсэг, МУ-ын Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт харьцангуй бие даасан байдал тусгагджээ. Хүн чөлөөтэй байх гэсэн оюунлаг амьтан болохынхоо хувьд бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхол болон ардчилсан нийгэмд байдаг дэг журмыг зөрчихгүй, ямар ч дарамт, шахалт, хязгаарлалтгүйгээр өөрийнхөөрөө эрхээ эдэлж оршихыг хэлнэ. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хуульд заасан үндэслэлээр чөлөөтэй байх эрх хязгаарлагдана. Тухайлбал, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58 дугаар зүйлд зааснаар сэжигтэн оргон зугтахыг завдсан, эсхүл хүнд, онц хүнд гэмт хэрэгт сэрдэгдэх хангалттай баримт байгаа бол баривчилж болно. Мөн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлж болох бусад эрүүгийн хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулж болох үндэслэлтэй бол

а/ оршин суугаа газраасаа гадагш явж болохгүй тухай баталгаа авах,

б/ цагдан хорих зэрэг эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 64, 68 дугаар зүйлд заасан таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэж, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 129 дүгээр зүйлд заасан үндэс-

лэлээр хүний биед үзлэг, 135 дугаар зүйлд зааснаар нэгжлэг хийж байгаа нь хүний чөлөөтэй байх эрхийг шууд хөндөхөд хүргэдэг. Хуульд заасан үндэслэл журмаас гадуур хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг хязгаарлах, эх орноос нь хөөн гаргахыг хориглоно. Баривчлах нь чөлөөтэй халдашгүй байх эрхийг хамгийн ноцтой хязгааралдаг. Баривчлах гэдэг нь хүнийг зохих дэглэм бүхий байранд, хуульд заасан хугацаа, үндэслэл журмын дагуу албадан байлгах/хорих/ гэсэн утгатай үйл ажиллагаа юм. Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үүднээс баривчлах нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад гэмт хэрэг үйлдсэн байж болох сэжигтэй этгээдийн чөлөөтэй байх халдашгүй эрх хязгаарлагдаж цагдаагийн ажилтан, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн хяналтад орсон үеэс эхлэн эрүүгийн хэрэг үүсгэж хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч болон прокурор, шүүгчээс тодорхой шийдвэр гаргах хүртэл түр хугацаагаар түүнийг эрх мэдэлгүй болгож байгаа төрийн албадагын арга хэмжээ юм. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, прокурорын байгууллагын үйл ажиллагаанд хүний халдашгүй чөлөөтэй байх эрх ноцтой зөрчигдөх явдал арилахгүй байна. ХЭҮК-оос нийслэлийн хэмжээнд 2001 он, 2002 оны эхний улиралд хэрэгсэхгүй болгосон хэрэг хийсэн судалгааг дүгнэж үзэхэд "нийт 1873 хэргийг хэрэгсэхгүй болгосон бөгөөд үүнд 2403 хүнийг холбогдуулан шалгасан байна. Тэдгээрийн 571 хүнийг 5-487 хоног цагдан хорьсон байна". Ганц худаг, бусад таймагт ХҮЭК-оос хийсэн судалгаагаар тэнд хоригдож байсан 1338 хүний 17,1 хувь нь 6 сараас 1 жилийн хугацаагаар 10,9 нь бусад 8,1 хувь нь 1-2 жилийн хугацаагаар 17 хүн буюу 1,2 хувь нь 2 жилээс дээш хугацаагаар хоригдсон байна"¹²

¹² Монгол Улс дахь хүний эрх, эр чөлөөний тухай илтгэл, 2002 он, 2006 он, 24 дэх тал

Б/Бие эрхтний халдашгүй эрх ба эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа – Бие махбодь, эрхтний халдашгүй эрх нь ОУ-ын болон үндэсний хууль тогтоомжоор хамгаалагдсан байдаг. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 5 дугаар зүйлд "хэнд ч эрүү шүүлт тулгах буюу хэрцгий ...харьцах шийтгэхийг хориглоно". МУ-ын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хүн бүр "амьд явах эрхтэй..." мөн зүйлийн 13 дахь хэсэгт "...хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус хэрцгий хандаж болохгүй..." гэж заасан. Энэ эрхийн агуулга нь:

а/ хүн бие махбодийн хувьд бусад этгээдийн хүчирхийлэл, зовиур, шаналгаа, дарамтаас ангид байх;

б/ хүний бие махбодь нь анатомийн бүтцээрээ бүрэн бүтэн байх;

в/ хүний бие эрхтнээс түүний зөвшөөрөлгүй дээж авахгүй, туршилт хийхгүй, мөн бие дээр нь элдэв зураг, шивээс тэмдэг тавихгүй байх;

г/ эд эрхтэн нь хэвийн ажиллагаатай байх зэргээр илэрнэ.

Бие эрхтний халдашгүй эрхийг хамгийн ноцтойгоор хөнддөг нэлээд түгээмэл байдаг хууль бус үйлдэл бол эрүүдэн шүүлт юм.

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр "Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хүнлэг бусаар хэрцгий нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийг батлан гаргасан ба манай улс 2000 оны 11 дүгээр сарын 2-нд энэ конвенцид нэгдэн орсноор үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил хэрэгжих болсон. Энэ конвенцийн заалт ёсоор төрийн албан тушаалтан буюу албан үүргээ гүйцэтгэж байгаа этгээд, түүний хатгалгаар бусад илэр, далдуур зөвшөөрснөөр аливаа нэг хүнийг түүнээс бусад гуравдагч этгээдээс үйлдсэн

буюу үйлдсэн гэж сэжиглэгдэж байгаа хүний талаар мэдээлэл авах, хэрэг хүлээлгэх, шийтгэхийн тулд түүнчлэн түүнийг бусад гуравдагч этгээдийг аливаа үндэслэлээр ялгаварлан гадуурхах шалтгаанаар айлгах, албадах, санаатайгаар хүчтэйгээр өвтгөх, бие махбодыг сэтгэл санааны хувьд тарчлаан зовоох аливаа үйлдлийг ойлгох бөгөөд хуулийн цээрлэл, тохиолдлоор үүсэн өвдөлт, шаналгаа, хамаарахгүй¹³

Эрүүдэн шүүлт нь зөвхөн бие махбодийг өвтгөхөөр хязгаарлагдахгүй бөгөөд өвтгөх, шаналгах нь олон удаа давтагдсан, тарчлаах шинжтэй байдаг. Эрүүдэн шүүхийн хэрцгий хандах гэдэгт:

- а/ хилсээр хэрэг хүлээлгэх;
- б/ албадан мэдүүлэг авах;
- в/ эрүүдэн шүүхээр заналхийлэх;
- г/ тохуурхан даажигнах;
- д/ доромжлох;
- е/ зодох бие махбодид нь ямар нэгэн төрлийн гэмтэл санаатай учруулах;
- ё/ тарчлаан зовоох зэрэг үйлдэл хамаарна.

Хүнлэг бус эрүү шүүлт нь:

- а/ догшин хэрцгий харьцах;
- б/ төрөл садан ойр Dotны хүмүүсээс эргэлт, уулзалт авах эрхийг хязгаарлах, хасах;
- в/ зохистой хоол ундаар хангагдах эрхийг хязгаарлах;
- г/ хоригдосдын салхилах эрхийг хаах;

д/ хүнлэг бус нөхцөлд хорьж цагдах хэлбэрээр хэрэгжинэ. ХЭҮК "Эрүүдэн шүүхийг хориглох нь" сэдэвт нээлттэй хяналт, шалгалт, судалгаа явуулсан. Энэ судалгаанд хамрагдсан сэжигтэн, яллагдагч 1338 хүний 39,9 хувь нь дарамталж, айлган сүрдүүлж хэрэг хүлээлгэдэг, 32,0 хувь нь зодож, хүч хэрэглэж хэрэг хүлээлгэдэг гэж хариулсан нь тохиолдлын зүйл биш юм.

1999 оны 1 дүгээр сард Баянзүрх дүүргийн хүнсний захын манаачийг алж, алт, мөнгөн эдлэл дээрэмдсэн хэрэгт хилсээр холбогдон мөрдөгдөж

байхдаа эрүү шүүлтэд өртсөн "О" 1115 хоног, "О" 315 хоног, "Х" 201 хоног, "Б" 1252 хоног тус тус цагдан хоригдсон. Тэд ХЭҮК-т гаргасан өгөгдөлдөө "Биднийг хилс хэрэгт холбогдуулан баривчилж, ганц худгийн подвалын 7-9 камер дамжуулан хорьж, шинэ камер болгонд ороход тэнд хоригдож байсан хүмүүс "алуурчид хийсэн хэргээ хүлээ, нуусан алт, мөнгөө гаргаж өг" гэж шаардаж, бакал гутал болон наарны 5 см-ын банзаар биеийн бүхий л газраар цохиж, зодуулаад хөдөлж чадахгүй болоход шалан дээр ус асгаж байгаад нүцгэлж, нүцгэн биеэр хэвтүүлж асгасан усандаа тог хүргэж тоогоор цохиулж, гялгар уут болон сойзны иш түлж хайлуулан биеэн дээр нь дусаах, наах, нойр хоолгүй хонуулах, зэрэг аймшигт тамлалыг биеэрээ амсаж эцэст нь сүрьеэ өвчин тусч хохирсон гэж бичсэн байна. Энэ хэрэгт холбогдон мөрдөгдөж байхдаа "Д" нас барсан¹⁴

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нарын эрх зөрчигдөх цаашилбал эрүүдэн шүүгдэх нь хавтгайрсан учир ХЭҮК-ийн илтгэлийг УИХ тусгайлан хэлэлцсэн билээ.

В/ Орон байрны халдашгүй дархан эрх ба эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа- Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 12 дугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 17 дугаар зүйл, Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт орон байрны халдашгүй эрхийг заасан. Иргэдийн орон байрны халдашгүй байдлыг зөрчих нь Эрүүгийн хуулийн 137 дугаар зүйлд заасан гэмт хэрэг юм. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 11 дүгээр зүйлд "иргэний орон байр нь халдашгүй байна. Энэ хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэн ч иргэний орон байранд оршин суугчийн зөвшөөрөлгүй нэвтрэн орох

эрхгүй. Орон байранд хийх нэгжлэгийг прокурорын зөвшөөрлөөр, энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу гүйцэтгэнэ" гэж заасан. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 132 дугаар зүйлд заасан

а/ хэрэг шийдвэрлэх ач холбогдолтой зүйл, баримт бичиг байна гэх хангалттай үндэслэл байвал түүнийг эзэмшигчээс хураан авах;

б/ эрэн сурвалжиж буй этгээд нуугдаж байгаа бусад гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, хэрэгсэл, гэмт хэрэг үйлдэх замаар олж авсан эд зүйл, түүнчлэн хэрэг шийдвэрлэхэд ач холбогдолтой бусад зүйл байна гэх хангалттай үндэслэл байвал тэдгээрийг олж илрүүлэх гэсэн хоёр зорилгоор л прокурорын зөвшөөрлөөр иргэдийн орон байранд нэвтрэн орох эрхтэй.

Г/ Хувь хүний нууцын халдашгүй эрх ба эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа Хувь хүний нууцын тухай хуулийн 2 дугаар зүйлд "Хувь хүний нууц гэж Монгол Улсын болон гадаадын иргэн харьяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн нууцалсан бөгөөд задруулбал тухайн хүнийг хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлсийг хэлнэ" гэж тодорхойлсон. Хувь хүний нууц нь:

а/ захидал харилцааны нууц;

б/ эрүүл мэндийн нууц;

в/ эд хөрөнгийн нууц;

г/ гэр бүлийн нууц;

д/ хуулиар тогтоосон бусад нууц гэсэн төрөлтэй байна. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 12 дугаар зүйлд "Иргэний хувийн болон гэр бүл, захидал харилцааны нууцын хуулиар хамгаалах ба энэхүү эрхийг зөвхөн прокурорын зөвшөөрлөөр хуульд заасан

¹³ Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх. Эмхтгэл. УБ. 1996 он. 60 дахь тал

¹⁴ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл. УБ. 2006 он. 13-15 дахь тал

үндэслэл, журмын дагуу хязгаарлаж болно” гэж заасан.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 136 дугаар зүйлд “Шуудан цахилгаанаар явуулсан зүйлийг шуудан цахилгаан харилцааны байгууллагад байх үед нь битүүмжлэх, хураан авах, түүнд үзлэг хийхийг прокурорын зөвшөөрлөөр хөндлөнгийн гэрч байлцуулан явуулна” гэж заасан.

Эрүүгийн хуулийн 135 дугаар зүйлд “Иргэний захидал харилцааны нууцын халдашгүй байдлыг зөрчсөн бол 136 дугаар зүйлд хуулиар хамгаалагдсан хувь хүний нууцыг мэдсэн этгээд задруулсан бол тус тус гэмт хэрэг болж эрүүгийн хариуцлага хүлээнэ.

Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үүднээс хүний нууцтай байх эрх нь эрүүгийн хэрэгт ач холбогдолгүй бол ямар ч тохиолдолд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдоос бусдад задруулж болохгүй туйлын эрх юм.

Д/ Нэр төрийн халдашгүй эрх ба эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа Энэхүү эрх нь олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нэгэнт тусгагдан хэрэгжиж ирсэн. Тухайлбал, “Хүүхдийн эрхийн тухай” конвенцийн 16 дугаар зүйлд “хэн ч хүүхдийн... нэр төр, алдар хүндэд хууль бусаар халдаж болохгүй” гэж заажээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт “хэнд боловч... хүнлэг бус хэрцгий хандаж нэр төрийг гутаан доромжилж болохгүй”, Эрүүгийн хуулийн 7 дугаар зүйлд “гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ногдуулах ял, Эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төр, алдар хүндийг гутаах зорилго, хэлбэр агуулж болохгүй” Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй” гэсэн хэд

хэдэн эрхийн хамгаалалт тогтоожээ.

Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үүднээс хүний нэр төрийн халдашгүй эрх гэдэг нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, иргэний хариуцагч, нэхэмжлэгч, хохирогч зэрэг эрх ашиг нь хөндөгдөж буй оролцогчид түүнчлэн төрийн нэрийн өмнөөс эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгч субьектууд болох хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч, нарын нэр төр, алдар хүндэд халдашгүй байх ёстой. Ялангуяа гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай болох нь шүүхээр тогтоогдоогүй байхад яллагдагч, шүүгдэгчийг гэм буруутай мэт үзэх зэргээр нэр төр, алдар хүндэд халдаж болохгүй.

Эрүүгийн хуулийн 259 дүгээр зүйлд зааснаар хэргийг хянан хэлэлцэх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагаатай холбогдуулан шүүгч, иргэдийн төлөөлөгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, өмгөөлөгч, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийг гүтгэсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Е/ Өмчийн халдашгүй эрх ба эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа Энэ эрх нь олон улсын эрх зүйн хэм хэмжээ болон үндэсний хууль тогтоомжид бүрэн тусгагдсан. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө” гэж өмчийн халдашгүй эрхийг зөвшөөрсөн. Өмчийн халдашгүй эрх гэдэг нь аливаа хүний шударгаар өмчилж байгаа эд хөрөнгөд хэн ч дураар халдаж өмчлөлөөс нь эд

хөрөнгийг хууль бусаар салгаж болохгүй туйлын эрх юм. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад зөвхөн иргэний нэхэмжлэлийг хангах, гэмт хэрэг үйлдэж олсон орлого, эд хөрөнгө, мөн түүнчлэн эрүүгийн хэрэгт нотлох баримтын ач холбогдолтой зүйлсийг эрх бүхий этгээд хуульд заасан үндэслэл, журмын дагуу эзэмшигч, өмчлөгчөөс гаргуулан авахаас /хураан авах/ бусад тохиолдолд өмчлөх эрх халдашгүй юм. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 188 дугаар зүйлийн 1-2-т зааснаар баривчлагдсан, цагдан хоригдсон этгээдийн эзэнгүй үлдсэн эд хөрөнгө, орон сууцыг хамгаалуулах арга хэмжээ авах үүрэгтэй байгаа нь өмчлөх эрхийн чухал баталгаа юм.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 388 дугаар зүйлд зааснаар “Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харъяалалгүй хүн нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохиролоо нөхөн төлүүлэх сэтгэл санааны үр дагавараа арилгуулах болон тэтгэвэр, тэтгэмж авах, орон сууц эзэмших хийгээд бусад эрхээ сэргээлгэх эрхтэй” Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 389 дугаар зүйлд “Иргэнийг хууль бусаар ял шийтгэн баривчилсан, цагдан хорьсон, албан үүргээ бие-лүүлэхийг түр түтгэлзүүлсэн, эмнэлэгийн байгууллагад байлган, албадан эмчлүүлэх арга хэмжээ хэрэглэсний улмаас учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн гэм бурууг үл харгалзан төр хариуцан арилгана” гэж заагаад нөхөн төлөх үйл ажиллагааны үндэслэл, эд хөрөнгийн хохирлын төрөл сэтгэл санааны хохирлын үр дагаварыг арилгах тухай Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 390-393 дугаар зүйлд хуульчилсан байдаг.

Е/ Өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрх ба эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа- Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт "...өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, өмгөөлүүлэх, эрхээр хангагдах" эрхтэй.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 35, 36 дугаар зүйлд сэжигтэн, яллагдагч нь өөрийгөө өмгөөлөх, энэ хуулийн 39 дүгээр зүйлд зааснаар өмгөөлөгчөө өөрөө сонгон авах, өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах эрх эдэлнэ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 172 дугаар зүйлийн 172.3-т заасан хойшлуулашгүй ажиллагаа явуулаагүй бол гэмт хэрэгт сэжигтнээр тооцсон үеэс эхлэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох эрхтэй. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 40 дүгээр зүйлд заасан хүмүүсийн хэрэг дээр өмгөөлөгч заавал оролцоно. Өмгөөлөгчөө сонгон аваагүй бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх уг хэрэгт өмгөөлөгч оролцуулах явдлыг хангах үүрэгтэй.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хүний халдашгүй эрхийг хангахад ач холбогдол бүхий эрх зүйн баталгаануудыг Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуульд суулгаж өгсөн байдаг. Тухайлбал:

а/ хуулиар тогтоосон үндэслэл журмаас гадуур сэжигтнээр тооцож, яллагдагчаар татаж, ял шийтгэхгүй байх;

б/ эрүүгийн байцаан шийтгэх хуульд нийцсэн байх;

в/ шүүх эрх мэдлийг зөвхөн шүүх хэрэгжүүлэх;

г/ хүний халдашгүй байх эрхийг хангах;

д/ иргэний орон байр, захидал харилцаа халдашгүй байх, иргэний хувийн болон гэр бүлийн нууцыг хамгаалах;

е/ сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч хохирогчийн өмгөөлүүлэх эрхээр хангах нь эрүүгийн

байцаан шийтгэх ажиллагааны зарчим болон хуульчлагдсан. Онцолбол хүний халдашгүй байх эрхийг хангах нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны тулгуур зарчим бөгөөд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 10 дугаар зүйлд:

1/ хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч гэмт хэрэгт сэрдэн баривчлах;

2/ прокурор, шүүгчийн зөвшөөрөлгүйгээр хэнийг ч шинжилгээ хийлгэхээр эмнэлгийн байгууллагад байлгах;

3/ шүүгчийн зөвшөөрөлгүйгээр хэнийг ч хорих;

4/ хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус хэрцгий хандаж нэр төрийг гутаан доромжлох зэрэг хууль бус үйл ажиллагааг шууд хориглосон байдаг. Тухайлбал, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 20 дугаар зүйлд зааснаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн үйл ажиллагаа, шийдвэрт энэ хуульд заасан журмын дагуу гомдол гаргах нийтлэг эрхийн хүрээнд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 35, 36 дугаар зүйлд заасан мэдүүлэг өгөхөөс татгалзах, өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгчөө өөрөө сонгон авах, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын үйл ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөх, гэмт хэрэгт холбогдолгүйгээ нотлох үүрэг хүлээхгүй байх зэрэг сэжигтэн яллагдагчийн эрхийг эдлүүлэх нь халдашгүй эрхийн чухал баталгаа юм.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн халдашгүй байлыг алдагдуулдаг зарим хууль бус ажиллагаа явуулахыг хуулиар шууд хориглосон байдаг.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 92 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Нотлох баримт цуглуулахдаа иргэний амь нас, эрүүл

мэндэд аюултай, эсхүл тэдний нэр төрийг гутаан доромжлох, хүнлэг бус хэрцгий харьцах, айлган сүрдүүлэх, мэдүүлэг тайлбар, дүгнэлт гаргуулахаар тулган шаардах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэхийг хориглоно", мөн хуулийн 186 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахдаа хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх болон бусад хууль бус арга хэрэгсэл хэрэглэх, түүнчлэн оролцогчийн амь насанд аюултай байдал бий болгохыг хориглоно"¹⁵ гэж тус тус хуульчилсан. Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулж "илт гэм буруугүй хүнийг сэжигтнээр тооцсон, яллагдагчаар татсан, ял шийтгэсэн/Эрүүгийн хуулийн 248 дугаар зүйл/", "Хүнийг хууль бусаар баривчилсан"/Эрүүгийн хуулийн 249 дүгээр зүйл/, "Шүүхээс хууль бус шийдвэр гаргасан"/Эрүүгийн хуулийн 250 дугаар зүйл/, "мэдүүлэг өгөхийг албдсан"/Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйл/, "нотлох баримт хуурамчаар бүрдүүлсэн"/Эрүүгийн хуулийн 253 дугаар зүйл/, "гэрч хохирогчоор худал мэдүүлэг өгүүлсэн, шинжээчээр худал дүгнэлт гаргуулсан, орчуулагчаар худал орчуулуулсан, худал хэлмэрчлүүлсэн"/Эрүүгийн хуулийн 256 дугаар зүйл/ бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч холбогдох бусад хүнд эрүүгийн хариуцлага хүлээхгээр байгаа нь хүний халдашгүй эрхийн чухал баталгаа юм. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эрхийг хангах үйл ажиллагааны зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход шаардлагатай зарим санал дэвшүүлж байна. Үүнд:

1. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хүний эрх хэрхэн хөндөгдөж байгаад ХЗҮК, УЕПГ, хүний эрхийн төрийн бус

¹⁵ Эрлийн хууль, Эрлийн байцаан шийтгэх хууль, УБ, 2007 он. 103, 127 дахь тал

байгууллагуудын хамтарсан шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээг тогтмолжуулах;

2. Нэгдэн орсон "Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийг хориглох тухай конвенцийн заалтуудад үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх;

3. Эрүү шүүлтийг арилгах түүнтэй тэмцэх ажлын арга барил эзэмшүүлэх зорилгоор Их дээд сургуулийн сургалтын төлөв-лөгөөнд тусгагдсан "Хүний эрх-2 хичээлийн бие даасан" сэдэв болгон зааж сурталчлах;

4. Тагнуулын Ерөнхий газар, АТГ-ын ажилтнуудаас харъяал-лын гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах зорилгоор явуулж буй гүйцэтгэх

ажилд хөндлөнгийн хяналтын тогтолцоо бүрдүүлэх;

5. Цагдан хорих, баривчлах байруудын хорих өрөөнүүдийн нөхцөлийг бүх талаар сайжруулж, ердийн амьдралын нөхцөлд ойртуулах, энэ ажилд дорвитой хөрөнгө оруулалт хийх;

6. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, гүйцэтгэх ажил эрхлэх, хорих ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналт болон дотоод хяналтыг төгөлдөржүүлэх, гэм буруутай албан тушаалтнуудад хуулийн хариуц-лага хүлээлгэж ил тод мэдээлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх;

7. Эрүүдэн шүүгдсэний улмаас эрүүл мэнд, эд хөрөнгө, сэтгэл санаагаар хохирсон хүний хохирлыг барагдуулах, нөхөн олговор олгох ажиллагааны эрх

зүйн зохицуулалтыг боловс-ронгуй болгох;

8. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 251 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн субъектийг зөвхөн хэрэг бүртгэгч, мөрдөн бай-цаагчаар хязгаарлахгүйгээр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа болон ял эдлүүлэх явцад хүний эрхийг хөндөх боломжтой шүүгч, прокурор, ШШГБ-ын ажилтан, хойшлуулш-гүй ажиллагааг гардан явуулдаг эрүүгийн төлөөлөгч нарыг хам-руулан өргөтгөх;

9. Эрүүдэн шүүх зөвшөөрөл олгосон, хатгасан, хамтран оролцсон, хамжсан зэрэг үйлдлийг эрүүдэн шүүх ажиллагаанд хамтран оролцсон гэж хуульд тусгах замаар эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмыг хэрэгжүүлэх. ■



МУИС-Хууль зүйн сургуулийн Төр, захиргааны эрх зүйн
тэнхимийн багш, докторант Д.Батболд

ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ АГЕНТЛАГУУД БОЛОН ТАМГЫН ГАЗРЫН ХЭЛТСИЙН ДҮРМИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Үргэлжлэл, Түрүүч нь 2008, №2 /21/

хэлтэс, алба, ажилтан, сумдын ЗД, ААН-ын удирдлагад үүрэг даалгавар өгөх, үйл ажиллагаанд нь төрийн хууль тогтоомжийн дагуу хяналт шалгалт хийх; 4. Хууль ёс дэг журам, сэхилгэ, хариуцлага, өнц төрөнгийн ажиллалт, хөдөлмөр, амил үйлчилгээ, технологийн холбогдолтой асуудлыг хууль хяналтын болон мэргэжлийн байгууллагад чиглэл өгч шалгуулах, шаардлагатай гэж үзвэл холбогдох байгууллагад шилжүүлэх арга хэмжээ авахуулах санал тавих; 5. Иргэдийн СӨГ, ЗДДЗ – ийн хурлаар хэлэлцэх асуудлын талаар холбогдох байгууллагын ажилтнуудаас судалгаа тооцоо, дүгнэлт, тодорхойлолт гаргуулан авах; 6. Монгол Улсын хууль, ЗГ, ЗГХЭГ-аас гаргасан шийдвэр, үйл ажиллагааны талаар болон аймгийн ЗД-ын захирамж ЗДДЗ-ийн хуралдаанаар шийдсэн асуудал, хийсэн шалгалтын талаар аймгийн хэвлэл, мэдээлэл, радио телевизэд материал бэлтгэн өгөх, иргэд, хөдөлмөрчдийн дунд сурталчилгаа хийх ажлыг зохион байгуулах; 7. Төрийн дээд шагналаар тус аймгийн иргэд, ажиллагсдыг шагнуулахаар албан тодорхойлолт гарган, ЗД-ын зөвшөөрлөөр АИТХТ-д уламжлах.	шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавих, шалган дүгнэж холбогдох арга хэмжээг төлөвлөх; 6. Аймгийн ажилтны гаргасан тэргүүний ажилтнуудыг гадаад, дотоодын сургалтанд хамруулах шагнах, шагналд тодорхойлох; 7. Мэргэжлийн анхан шатны байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудыг шинээр байгуулах эрх олгуулах, үйл ажиллагааг зогсоох татан буулгах асуудлыг боловсруулж шийдвэрлүүлнэ; 8. Мэргэжлийн байгууллагуудын үлгэрчилсэн дүрмийг баталж мөрдүүлэх; 9. Сумдын ЗДТГ-тай зөвшилцөж мэргэжилтэй боловсон хүчнийг шилжүүлэх талаар санал гаргах, захиалгат хуваарь хийх.	дүгнэлт гаргах; 9. ХЗДХС-ын эрхлэх асуудлын хүрээний ОН дахь нэгжүүдийн удирдах ажилтнуудын сонголт мэдээллийг хэлтсийн зөвлөгөөнөөр хэлэлцэж үйл ажиллагаанд нь үнэлэлт дүгнэлт өгөх; 10. ЗХУХША явуулах.
--	--	---

Хэлтсийн дүрмээр нэгдүгээрт, хэлтсийн чиг үүргийг тодорхойлсон, хоёрдугаарт, үүргийг, гуравдугаарт эрхийг нь тодорхойлжээ.

Хөвсгөл аймгийн ТГ-ын хэлтсүүдийн дүрмээр ТЗУХ-ийн чиг үүргийг "тамгын газрын тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэнэ", НБЗХ-ийн чиг үүргийг "бодлого, хөтөлбөр, төсөл боловсруулах, зөвлөгөө дэмжлэгээр хангах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, хяналт шинжилгээ, үнэлгээг хийх", ҮДББОБЗХ-ийн чиг үүргийг "хяналт тавих, иргэдэд үйлчилэх, ЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх", ХЗХ-ийн чиг үүргийг "албадын үйл ажиллагааг мэргэшил, арга зүйн удирдлагаар хангаж, уялдуулан зохицуулах, зөвлөх", СЭЗБЗХ-ийн чиг үүргийг "төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, зарлага санхүүжилтийг гүйцэтгэх" гэх мэтээр хэлтсийн хариуцах ажлын үндсэн алгаанаас хамаарч харилцан адилгүй тогтоосон байна. Гэхдээ нэгэн ТГ-ын хэлтсүүд атал үндсэн чиг үүргийн хувьд ижил бүс байгааг анзаарууштай.

Арханай аймгийн ХЗХ-ийн дүрэм нь Хөвсгөлийнхөөс нилээд хэдэн зүйлээр олон чиг үүрэгтэй байлаа. Тухайлбал, Хууль зүйн хэлтэс нь ТГ болон холбогдох бусад газруудынхаа жишээлбэл, Цагдаагийн хэлтсийн хөдөл-

мөрийн сахилгыг бэхжүүлэх, ажлын хариуцлагыг дээшлүүлэх асуудлыг эрх зүйн арга хэрэг-лүүрээр ханган, үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангана¹. ХЗХ цагдаагийн байгууллагын мэргэжлийн удирдлагаар хангана гэвэл гэмт хэрэг мөрдөх ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангахад хүрэх гээд байна. Гэтэл тэр нь ЭБШХ-ийн дагуу явагддаг захиргааны ямар ч оролцоогүй ажиллагаа байдаг.

Хэлтсийн дүрэмд агентлагийн үйл ажиллагаатай давхардсан зүйл байна. Жишээлбэл "хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, шалган дүгнэх" гэсэн Хөвсгөл аймгийн ҮДББОБЗХ-ийн эрх, БОА-ны эдлэх эрхтэй яг давхацсан².

Хэлтсийн дүрэмд хэлтэс хариуцан гүйцэтгэх шаардлагагүй үйл ажиллагаа нилээн байна. Жишээлбэл, Хөвсгөл аймгийн ҮДББОБЗХ-ийн дүрэмд "салбарын байгууллагуудад мэргэжлийн онцлогийг харгалзан боловсруулсан стандарт, нормативуудыг мөрдүүлэн ажиллуулах", гэж заасан нь Стандарчилал тохирлын үнэлгээний тухай хуулиар байгууллагын эрх чөлөө болгон тогтоосон зүйлд халдсан шинжтэй болсон. Мөн "мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааны түвшин, ажиллагсдын мэдлэг чадварыг шалгах, үнэлж дүгнэх, зөвлөн туслах гэж

заасан" мэргэжлийн асуудалд захиргааны зүгээс үндэсгүй оролцох нөхцөлийг бүрдүүлсэн гэж үзэхээр болжээ.

Дүрэмд зааснаар бараг бүх хэлтэс сургалт зохион байгуулахаар заасан нь багшийн үүрэгтэй тун адил. Мөн ААН-д арга зүйн зөвлөгөө өгч бодлогын удирдамжаар хангана гэсэн байна. Нэг аймаг дунджаар 100 ААН-тэй гэвэл тэр бүгдэд арга зүйн зөвлөгөө өгч ажиллах уу? Архангай аймгийн ХЗХ-ийн дүрэмд ХЗХ нь ТГ-ын зэрэгцээ ХЗЯ-д давхар харьяалагдахаар заасан нь байж боломгүй жигтэй зүйл юм. ТГ-ын хэлтэс хаа холын яаманд яагаад харьяалагдах болов оо.

Ер нь хэлтэс, агентлагийн дүрэмд байгаа нийтлэг алдаа бол ӨУБ-д дүрмийн төсөл оруулж батлуулж эргээд түүнийгээ хэрэгжүүлэх асуудлыг огт тодорхойлоогүй байгаа явдал нь НӨУЕ-ны хэрэгжилтэнд үлэмж саад болсон шинжтэй болжээ. Зөвхөн өөрийнхөө явцуу чиг үүргийн хүрээнд эрх хэмжээгээ тодорхойлсон, яам агентлаг гэж дээд шатныхаа байгууллагын шийдвэрийг биелүүлэх тухай заасан нь үнэхээр залруулуштай. Аймгийн хэлтэс, агентлагийн нэгэн үндсэн чиг үүрэг бол НӨУБ-даа гүйцэтгэх байгууллагын үүднээс үйлчлэх явдал билээ.

¹ Архангай аймгийн ХЗХ-ийн дүрмийн 2-ын а. Архангай аймгийн баримт мэдээлэл. Удирдлагын академи, УБ., 2006, 26 дахь тал.

² Хэлтэс, агентлагийн дүрмийн агуулгыг зэрэгцүүлсэн өгүүллийн холбогдох хэсгээс үзнэ үү.

Гурав. Агентлагийн дүрмийн агуулга

Хөвсгөл аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагийн дүрмийн агуулгыг зэрэгцүүлсэн нь

Акты нэр	д/д	Байгаль орчны албаны дүрэм		Газрын албаны дүрэм	Боловсрол, соёлын газрын дүрэм	Нийслэл, аймгийн ЗД-ын дэргэдэх статистикийн газар, хэлтэс (НАЗДДСГХ)-ийн нийтлэг дүрэм*	Стандарчилал, хэмжил зүйн төвийн дүрэм
		Баталсан субъект	Аймгийн Засаг дарга	Аймгийн Засаг дарга	Аймгийн Засаг дарга	ҮСГ-ын дарга	(Тодорхойгүй, дүрэм дээр дарсан тамга нь харагдахгүй)
1.		Нэг. Нийтлэг үндэслэл Хоёр. Албаны удирдлага, бүтэц Гурав. Албаны хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл. Дөрөв. Албаны санхүүжилт, өмч хөрөнгө	Нэг. Нийтлэг үндэслэл Хоёр. Албаны үүрэг Гурав. Албаны эрх	Нэг. Нийтлэг үндэслэл Хоёр. Үндсэн үйл ажиллагаа Гурав. Зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны хүрээ Дөрөв. Эрх, үүрэг Тав. Төсөв, санхүүгийн талаар Зургаа. Ахлах тайлагнах	НАСГХ-ийн эрхэм зорилго. Нэг. Нийтлэг зүйл Хоёр. Хэлтсийн үүрэг. Гурав. Хэлтсийн эрх. Дөрөв. Хэлтсийн даргын бүрэн эрх	ҮСГ-ын дарга	Стандарчилал, хэмжил зүйн төвийн дүрэм
2.		Бүтэц					Нэг. Нийтлэг үндэслэл Хоёр. Стандартчилал, хэмжил зүйн төвийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц Гурав. Стандартчилал, хэмжил зүйн төвийн ажиллагаа Дөрөв. ...

* НАСГХ-ийн эрхэм зорилго. Статистикийн үйл ажиллагааг хараат бус, бие даасан зарчмын дагуу нутаг дэвсгэрийн хэмжээнд төвлөрүүлэн эрхэлж үнэн бодит, чанартай мэдээлэл, тооллого, судалгаагаар хэрэглэгчдийг хангаж, статистикийн талаар хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах нь ОН-ийн статистикийн албадын эрхэм зорилго мөн.

[illegible]

хэмжээний хэмжээнд зохион байгуулах; 2. АЗД-тай БОСайдын байгуулсан бүрдүгдүүн нийлүүлэх гэрээнд тусгагдан тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг харилцан зохион байгуулах; 3. БО-ыг хамгаалах тухай хуулийн 12.9-хэсгийг жишиг болгон ашиглан БО-ны төлөв байдлын жил бүрийн тайланг гарган ЗДТГ-ын ХХААБО сард уламжлан гаргаа оны 1-р сард багтаан АИТХ-аар хэлэлцүүлэн БОЯ-д хүргүүлж байх; 4. Ой, ус, ургамал, амьтан зэрэг байгалийн баялгийг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэрэгжилтийг даалгаварт оруулж хэрэгжилтг орон нутагт зохион байгуулах; 5. Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг хангах зорилгоор ноогдон орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх. Энэ ажилд байгууллага иргэдийн хувь орлоцоо хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах; 6. БО-ыг холбогдолтой асуудлаар холбогдох мэрэгжлийн болон ЗШБайгууллагайг гэрээ байгуулж гүйцэтгүүлэх үр дүнг хүлээн авах; 7. БО-ыг доройтсоо хамгаалах нөхөн сэргээх үүний дотор ойжуулах, ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх, хоргүй, хангалтгүй технологи хэрэгжүүлэх арга хэмжээ зохион байгуулах, тухайн амьтат энэ чиглэлд үйл ажиллагааг өвүүлж буй иргэд болон ой, ус, ургамал, ангийн мэрэгжлийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах; 8. Байгалийн нөөц ашигласны төлбөрийг орлогоос БОХАамаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах	тогтоомжийн дагуу ногдуулах, хураах; 10. Газрыг хамгаалах, нөхөн сэргээх асуудалд хяналт тавих; 11. Газрын биржин үйл ажиллагааг зохион байгуулах; 12. МУ-ын хэмжээнд өмчлөгдсөн газар болон үнэлгээ өгсөн хөрөнгийн үнэлгээ тогтоож бүртгэн уялсан бүртгэлийн гэрчилгээ олгох; 13. Газрын дарга болон аймгийн ЗД-ыг газрын болон үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн талаарх мэдээлэлээр хангах; 14. Иргэд, хуулийн этгээдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх.	Гурав. Албаны эрх. 1. Албаны ажилтнуудын амжилсан жил албан тушаалын ангилал зэргийг харгалзан сүлжээний дагуу цалин олгуулах; 2. Ажлын хариуцлага алдсан албаны ажилтнуудад Хөдөлмөрийн хуульд нийцүүлэн хариуцлага хүлээлэх; 3. Тэр албан үйл ажиллагайд шааргдах төсөв, хөрөнгийг жил улирлаар төлөвлөж батлуулах, батлагдсан төсвийг захиран зарцуулах; 4. Албаны ажилтнуудын ажлыг дүнжэ шангал олгуулах; 5. Газрын харилцаа болон үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн талаар гарсан маргаантай асуудлыг шийдвэрлэхэд дүгнэлт гаргах; 6. Газрыг эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр зөвшөөрөлгүйгээр дур мэдэн ашигласан газрын төлөв байдлыг алдагдуулсан бол газрыг чөлөөлүүлэх зэрэг холбогдох арга хэмжээг авах.	тогтоолгоог батлах, хяналт тавих 6. Нутаг дэвсгэрийн боловсрол, соёлын байгууллагын оюутныг бугца, байршил бий болгох тэднийг захирагч бий болгох мэргэжил арга зүйн удирдлагаар хангах ажиллах 7. Аймгийн Бүх шатны сургууль, цэцэрлэг, суурь урлагийн мэргэжилтэй байгууллагаар хэрэгжүүлэх боловсон хүчээр хангах бодлого ажиллах 8. Бүх шатны сургууль, цэцэрлэгийн багш, арга зүйн менежер, захирлуудын соёл урлагийн байгууллагын шаналаар шагнуулах асуудлаар санал хувируулах аймгийн засаг даргаар дамжуулан шийдвэрлүүлэх 9. Бүх шатны сургууль, цэцэрлэг, суурь урлагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, аттестат хийх; Сургалтын байгууллага байгуулах, тэдгэрийн үйл ажиллагааг зоогдох талаар санал, дүгнэлт гаргах 10. Сургууль завсардалтыг бууруулах, зогсоох, иргэдэд албан бус албан бус арга замаар боловсрол, мэргэжил олгох, соёл урлагийн хүртээмжтэй, чанартай үр ашгитай үйлчилгээ үзүүлэх 11. ЕБС-ийн төгсөлт болон мэргэжлийн сургуулийн элсэлтийн шалгалтыг хангах Байгууллагайг хамтран дүрэм, журмын дагуу зохион байгуулах, зохих түвшний боловсрол зэмшисэн иргэдэд олгох боловсролын гэрчилгээ, үнэмлэх захиалах, нагж байгууллагад хүргэх, тайлан мэдээ гаргах	үндсэн үзүүлэлтүүдийн өөрчлөлт, өсөлт статистикийн тоон материалд тулгуурлан тооцооны богино хугацааны прогноз болговруулах. 6. АН-ын 33, байгаль нийгмийн стандартын бүртгэл хөтөлөх болон салбарын мэдээлэл, тавигч лавлгааны төвийн салбарыг орон нутагтаа зохион байгуулах. 7. Газар, хэлтэс нь албан ТБЗ-ын хөтөлгөө хэрэг албан хөтөлгөөний архивын бүрдүүлэлтийн үндсэн заавар албан хэрэг хөтөлж журмыг удирдлага болон мөрдөнө 8. СДБ-ын статистик хариуцсан ажилтнуудыг мэргэжлийн удирдлагаар хангах тэдний мэргэжил мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд туслахаа үзүүлж зохих сургалт зохион хийх; Нутаг дэвсгэртээ ААНБ-н хамжил зүйн ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах, мэдээлэл арга зүйн туслахаа үзүүлэх. Дөрөв. ... 1. Уг дүрмийг СХУ Төвтэй зөвшилцсний
--	--	---	--	--

хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх, уламзар баталгаатай эх үүсвэрийг бий болгож, тэдгээр хөрөнгөөр аймаг, сум, ОН-т хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулж хэрэгжилт зохион байгуулах, 9.Ой, ус, ургамал, ан зэрэг байгалийн нөөц байгалийн талаархи мэдээллийн сангийн үйл ажиллагаа эргэлдэж холбогдох байгууллага иргэдэд БО-ны мэдээллээр үйлчлэх;	7. Сумдын газрын даамлыг СДЗ-тай зөвшилцөн томилох. 8. Сумын 3Д-ын газар эзэмшүүлэх, ашиглуулахтай холбогдсон буруу шийдвэрийг хүчингүй болгуулах санхүүг хуулийн дагуу дээд шатны 3Д-д тавьж ариулуулах. 9. Дэнс бүртгэл хөтөлбөр, кадастрын зураглал хийх, холбогдох бичиг баримтыг бүрдүүлэхэд хууль тогтоомж, заавар, журмыг зөрчсөн албан тушаалтанд, эрүүгийн хариуцлага хүлээлгэхэргүй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу захиргааны хариуцлага хүлээлгэнэ.	12. ЕЕБ, цэцэрлэг, дотуур, баяр, соёлын байгууллагын барилгыг засварлах, өргөтгөх, шинээр барих зэрэг хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах. 13. Боловсрол, соёлын байгууллагыг ном, сурах бичиг, хөгжмийн зэмсэг, тоног төхөөрөмж, тавагтай, компьютер, кабинет лабораториор хангах ажлыг төлөвлөх, ашиглалт, байгуулах, хамгаалалтыг сайжруулахад хяналт тавих 14. Түүх, соёлын дурсгалт зүйл, урлаг, соёлын өвийг хадгалах, хамгаалах, сурталчилах үндэсний болон орон нутгийн өвөрмөц дэвшилтэд зан ашлыг өвлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, бүрдэл, мэдээллийн сан бүрдүүлэх Гурав. Зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны хүрээ 1. Боловсрол, соёлын газар нь төрийн захиргааны болон мэргэжил арга зүйн нэгжтэй байх бөгөөд төрийн захиргааны албанд дарга, орлогч бөгөөд санхүү аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн, мэргэжил арга зүйн албад арга зүйчид хамаарагдана. Газарт үйлчилгээний амжилчид ажиллана. 2. Газрын даргыг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр амгийн Засаг дарга томилж, чөлөөлнө. 3. Газрын мэргэжилтэн, арга зүйчдийг ажлын тавигдсан тодорхойлолтод дагуу сонгон шалгаруулж аймгийн Засаг дарга, хариуцсан хэлтсийн даргад танилцуулж зөвшөөрсний дагуу газрын дарга томилж чөлөөлнө	бүтэц, байдлыг шалгаж ашиглалтыг байдалд хяналт тавьж ажиллана бүтээгдэхүүн гэрээг нийлүүлэх үйл ажиллагааны гэрээг УЦ-ын даргатай, элхотийн мэргэжилтнүүд нь бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнийн гэрээг хэлтсийн даргатай хилийн хугацаатай байгуулан ТАХ-ын үйл ажиллагааг мэргэжлийн түвшинг үнэлэх журмын дагуу уялрал тугам үнэлж дүнүүлнэ. 11. Статистикийн мэдээлэгч болон хэрэглэгчид статистик мэдээлэл, судалгаа, арга-чиглэл зэрэг асуудлаар сургалт сурталчилгаа, зөвлөгөөн зохион байгуулж явуулна. 12. Мэдээлэл судалгааны дүнг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд сурталчилна. 13. АН-ийн удирдлагын ажиллагаанд албан ёсны мэдээллийн гаргалт үнэм зөв байхад хяналт тавьж шаардлагатай үзүүлэлтээр
хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх, уламзар баталгаатай эх үүсвэрийг бий болгож, тэдгээр хөрөнгөөр аймаг, сум, ОН-т хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулж хэрэгжилт зохион байгуулах, 9.Ой, ус, ургамал, ан зэрэг байгалийн нөөц байгалийн талаархи мэдээллийн сангийн үйл ажиллагаа эргэлдэж холбогдох байгууллага иргэдэд БО-ны мэдээллээр үйлчлэх;	7. Сумдын газрын даамлыг СДЗ-тай зөвшилцөн томилох. 8. Сумын 3Д-ын газар эзэмшүүлэх, ашиглуулахтай холбогдсон буруу шийдвэрийг хүчингүй болгуулах санхүүг хуулийн дагуу дээд шатны 3Д-д тавьж ариулуулах. 9. Дэнс бүртгэл хөтөлбөр, кадастрын зураглал хийх, холбогдох бичиг баримтыг бүрдүүлэхэд хууль тогтоомж, заавар, журмыг зөрчсөн албан тушаалтанд, эрүүгийн хариуцлага хүлээлгэхэргүй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу захиргааны хариуцлага хүлээлгэнэ.	12. ЕЕБ, цэцэрлэг, дотуур, баяр, соёлын байгууллагын барилгыг засварлах, өргөтгөх, шинээр барих зэрэг хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах. 13. Боловсрол, соёлын байгууллагыг ном, сурах бичиг, хөгжмийн зэмсэг, тоног төхөөрөмж, тавагтай, компьютер, кабинет лабораториор хангах ажлыг төлөвлөх, ашиглалт, байгуулах, хамгаалалтыг сайжруулахад хяналт тавих 14. Түүх, соёлын дурсгалт зүйл, урлаг, соёлын өвийг хадгалах, хамгаалах, сурталчилах үндэсний болон орон нутгийн өвөрмөц дэвшилтэд зан ашлыг өвлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, бүрдэл, мэдээллийн сан бүрдүүлэх Гурав. Зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны хүрээ 1. Боловсрол, соёлын газар нь төрийн захиргааны болон мэргэжил арга зүйн нэгжтэй байх бөгөөд төрийн захиргааны албанд дарга, орлогч бөгөөд санхүү аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн, мэргэжил арга зүйн албад арга зүйчид хамаарагдана. Газарт үйлчилгээний амжилчид ажиллана. 2. Газрын даргыг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр амгийн Засаг дарга томилж, чөлөөлнө. 3. Газрын мэргэжилтэн, арга зүйчдийг ажлын тавигдсан тодорхойлолтод дагуу сонгон шалгаруулж аймгийн Засаг дарга, хариуцсан хэлтсийн даргад танилцуулж зөвшөөрсний дагуу газрын дарга томилж чөлөөлнө	бүтэц, байдлыг шалгаж ашиглалтыг байдалд хяналт тавьж ажиллана бүтээгдэхүүн гэрээг нийлүүлэх үйл ажиллагааны гэрээг УЦ-ын даргатай, элхотийн мэргэжилтнүүд нь бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнийн гэрээг хэлтсийн даргатай хилийн хугацаатай байгуулан ТАХ-ын үйл ажиллагааг мэргэжлийн түвшинг үнэлэх журмын дагуу уялрал тугам үнэлж дүнүүлнэ. 11. Статистикийн мэдээлэгч болон хэрэглэгчид статистик мэдээлэл, судалгаа, арга-чиглэл зэрэг асуудлаар сургалт сурталчилгаа, зөвлөгөөн зохион байгуулж явуулна. 12. Мэдээлэл судалгааны дүнг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд сурталчилна. 13. АН-ийн удирдлагын ажиллагаанд албан ёсны мэдээллийн гаргалт үнэм зөв байхад хяналт тавьж шаардлагатай үзүүлэлтээр
хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх, уламзар баталгаатай эх үүсвэрийг бий болгож, тэдгээр хөрөнгөөр аймаг, сум, ОН-т хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулж хэрэгжилт зохион байгуулах, 9.Ой, ус, ургамал, ан зэрэг байгалийн нөөц байгалийн талаархи мэдээллийн сангийн үйл ажиллагаа эргэлдэж холбогдох байгууллага иргэдэд БО-ны мэдээллээр үйлчлэх;	7. Сумдын газрын даамлыг СДЗ-тай зөвшилцөн томилох. 8. Сумын 3Д-ын газар эзэмшүүлэх, ашиглуулахтай холбогдсон буруу шийдвэрийг хүчингүй болгуулах санхүүг хуулийн дагуу дээд шатны 3Д-д тавьж ариулуулах. 9. Дэнс бүртгэл хөтөлбөр, кадастрын зураглал хийх, холбогдох бичиг баримтыг бүрдүүлэхэд хууль тогтоомж, заавар, журмыг зөрчсөн албан тушаалтанд, эрүүгийн хариуцлага хүлээлгэхэргүй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу захиргааны хариуцлага хүлээлгэнэ.	12. ЕЕБ, цэцэрлэг, дотуур, баяр, соёлын байгууллагын барилгыг засварлах, өргөтгөх, шинээр барих зэрэг хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах. 13. Боловсрол, соёлын байгууллагыг ном, сурах бичиг, хөгжмийн зэмсэг, тоног төхөөрөмж, тавагтай, компьютер, кабинет лабораториор хангах ажлыг төлөвлөх, ашиглалт, байгуулах, хамгаалалтыг сайжруулахад хяналт тавих 14. Түүх, соёлын дурсгалт зүйл, урлаг, соёлын өвийг хадгалах, хамгаалах, сурталчилах үндэсний болон орон нутгийн өвөрмөц дэвшилтэд зан ашлыг өвлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, бүрдэл, мэдээллийн сан бүрдүүлэх Гурав. Зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны хүрээ 1. Боловсрол, соёлын газар нь төрийн захиргааны болон мэргэжил арга зүйн нэгжтэй байх бөгөөд төрийн захиргааны албанд дарга, орлогч бөгөөд санхүү аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн, мэргэжил арга зүйн албад арга зүйчид хамаарагдана. Газарт үйлчилгээний амжилчид ажиллана. 2. Газрын даргыг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр амгийн Засаг дарга томилж, чөлөөлнө. 3. Газрын мэргэжилтэн, арга зүйчдийг ажлын тавигдсан тодорхойлолтод дагуу сонгон шалгаруулж аймгийн Засаг дарга, хариуцсан хэлтсийн даргад танилцуулж зөвшөөрсний дагуу газрын дарга томилж чөлөөлнө	бүтэц, байдлыг шалгаж ашиглалтыг байдалд хяналт тавьж ажиллана бүтээгдэхүүн гэрээг нийлүүлэх үйл ажиллагааны гэрээг УЦ-ын даргатай, элхотийн мэргэжилтнүүд нь бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнийн гэрээг хэлтсийн даргатай хилийн хугацаатай байгуулан ТАХ-ын үйл ажиллагааг мэргэжлийн түвшинг үнэлэх журмын дагуу уялрал тугам үнэлж дүнүүлнэ. 11. Статистикийн мэдээлэгч болон хэрэглэгчид статистик мэдээлэл, судалгаа, арга-чиглэл зэрэг асуудлаар сургалт сурталчилгаа, зөвлөгөөн зохион байгуулж явуулна. 12. Мэдээлэл судалгааны дүнг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд сурталчилна. 13. АН-ийн удирдлагын ажиллагаанд албан ёсны мэдээллийн гаргалт үнэм зөв байхад хяналт тавьж шаардлагатай үзүүлэлтээр

	ханах ажлыг зохион байгуулах; 14. Аймгийн нутаг дэвсгэрт байгаа он, ус ургамал, амьтан ан зэрэг байгалийн нөөц баялаг үүнээс ашиглах болох тоо, хэмжээг нэрийнчлэн тогтоолох тэдгээрийг мөрдүүлж ажиллах; 15. ААН-ы, иргэдэд ойн санг эзэмшүүлэх, ашигуулах талаар баримт, материал бүрдүүлэх гэрээ байгуулах, батламжлуулахад мэргэжлийн туслалцаа үзүүлэх; 16. Аймгийн ойн сангийн тооллого явуулах, өөрчлөлтийг тооцон мэдээлэх ойн ашиглалт, хамгаалалтын бүс, хот суурин газрын ногоон бүсийг тогтооход санал өгөх мэргэжлийн туслалцаа үзүүлэх; 17. Ой хамгаалалт, ашиглалт нөхөн сэргээх арга хэмжээний хэрэгжилтэнд технологийн хяналт тавьж зөрчлийг ариулуулах. 18. Аймаг бүс нутгийн БО-д зохицсон зохих материаллаг бааз бүхий мод ургамлын үржүүлгийн газар байгуулж, тарьц суулгац уруулах, мод сөөгийг үрийн нөөцийн сан бүрдүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах замаар сайн чанарын үр, тарьц суулгац бэлтгэн ОН-ын хэрэгцээг хангах. 19. Аймгийн мод бэлтгэх талбайг тусгаарлах, мод бэлтгэлийн амжилд технологийн хяналт тавьж талбайг хүлээн авч дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулах. 20. Аймгийн усны нөөц, түүний зохистой ашиглалт хэрэгцээний байдлыг тогтмол үнэлж, усны мэдээллийн сангийн сүлжээг байгуулах. 21. Гадаргууны усны тооллого хийж ширгэж хатсан гол горхи рашаан, булаг шандын тоон мэдээллийг гаргаж холбогдох дээд байгууллагын мэдээллээр хангах. 4. Боловсролын болон соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн нь тухайн салбарын төрийн болон орон нутгийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавьж, үр дүнд үнэлгээ өгөх, орон нутгийн байгууллагуудыг мэргэжлийн боловсон хүчээр хангах, сургууль, цэцэрлэг, соёлыг үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үнэлдгээ өгөх, аттестатчилах ажлыг зохион байгуулах 5. Газрын санхүү аж ахуйн асуудал хариуцсан орлогч нь боловсрол соёлын байгууллагын админ засаг санхүүгийн удирдлага болон стратегий төлөвлөлт тухайн жилийн түсвийг төлөвлөх, тэсвийн гүйцэтгэл, нягтлан болон бүртгэлийн хэрэгжилтийг зохицуулах, хяналт шинжилгээ хийх, тайлан балансыг хянан нэгтгэж зохих хууль тогтоомжийн дагуу тайлагнана 6. Мэргэшлийн хичээлийн арга зүйчид нь багш, соёл урлагийг ажилчдыг арга зүйн удирдлагаар хангаж зөвлөн туслах, тэдний мэргэжлийг дээшлүүлэх, боловсрол соёлын байгууллагын статистикийн мэдээ тайлан гаргаж холбогдох байгууллагад хүргүүлнэ Дөрөв. Эрх, үүрэг 1. Газар нь доор дурьдсан эрхтэй. 1.1. Боловсрол хөгжлийн асуудлаар холбогдох байгууллага хүмүүст санал тавьж шийдвэрлүүлэх 1.2. Багалдсан төсөвт баглааж бүтэц орон тоогоо багтаах 2. Газар нь дараах үүрэгтэй 2.1. Нутаг дэвсгэрийнхээ боловсрол, соёлын үйл ажиллагааг захиргаа болон мэргэжлийн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт үйл ажиллагаанд нь хяналт мэдээллийн баяжуулна. 14. Төсвийн анхан мөрдөгдөх шатны болон бодох зөвөөр дагуу хөтлүүлнэ. Гурв. Хэлтсийн эрх. 1. АН-ийн НД-т байгаа ...¹⁰ харагдаагүй хэсэгт –ээс графикт хугацаанд нь мэдээ тайлан тоолого судалгааны материалыг гаргуулан авна. 2. Статистикийн мэдээлэгчдээс гаргасан албан ёсны статистикийн мэдээллийн үнэн зөв байдал болон статистикийн талаар гаргасан хуульд... тогтмол хяналт шалгалт заавар зөвлөмж өгнө. 3. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар холбогдох хүмүүст хуульд тавьж хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлэх буюу энэ талаар асуудал боловсруулж зохих
--	---

	модон материал нийлүүлэх явдлыг дэмжих хууль бус мод бэлтгэхийг хязгаарлах ажлыг ОН-т модны хэрэгцээг хангахтай уялдуулан зохион байгуулах. 31/ Аймаг сумын хэмжээнд БО-ыг хамгаалах асуудлаар зөвлөгөөн, сургалт семинар сурталчилгаа зохион байгуулж иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ авч байх. Дөрөв. Албаны санхүүжилт, өмч хөрөнгө. 1. Албаны санхүүжилт дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд: 1/ БОХТХ-ийн 33.1-д заасны дагуу БОХ түүний баялгийг нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулан ОН-ын төсвөөс олгосон хөрөнгө 2/ БОСамд АЗД-ын хооронд байгуулсан гэрээний дагуу тухайн жилд албанаас нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээнд зориулан улсын төвлөрсөн төсвөөс олгосон хөрөнгө. 3/ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос БО-ыг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээний тухай МУ-ын хуулиар зохицуулагдсан тодорхой хэсэг 4/ ОН-т байгалийн баялгийг нөхөн сэргээх, хамгаалах талаар иргэн, ААНБ-аас гаргасан хандив тусламж болон бусад хөрөнгө. 5/ Албаны өөрийн хөрөнгө, хууль тогтоомжийн хүрээнд явуулсан үйл ажиллагааны орлого 2. Алба нь өөрийн өмч хөрөнгөтэй байж холбогдох хууль тогтоомжийн дагуу зарцуулна.	холбогдох бүрдүүлэх материалуудыг Тав. Төсөв санхүүгийн талаар 1. Газар нь үндсэн ба эргэлтийн хөрөнгөтэй байх ба түүнийг зохих хууль журмын дагуу зарцуулж ашиглана. 2. Газар нь төсөвтэй байх ба дотоод, гадаадын байгууллага иргэдийн тусламж, хандив гэрээт ажил болон бусад эх үүсвэртэй байна. 3. Газрын төсвийг захиран зарцуулахдаа 1 дүгээр гарын үсгийг Газрын дарга, 2 дугаар гарын үсгийг ня-бо зурна. Зургаа. Ажлаа тайлагнах 1. Боловсрол, соёлын газар нь жилд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймгийн ЗДТГ-аар ажлаа дүгнүүлнэ.	заавар, зөвлөмж, чиглэл улирдаж, өгөх. Тэдэнтэй шууд харьцаж өөрийн суурийг илэрхийлж, тавьж шаардлага хамтран ажиллана.
--	--	---	--

Агентлагийн дүрмээр нийтлэг байдлаар

- тухайн агентлагийн эрх зүйн байдал

- агентлагийн хийж гүйцэтгэх ажил буюу чиг үүрэг

- эрх, үүрэг гэсэн 3 зүйлийг тогтоохыг оролдсон нь тодорхой харагдаж байна.

Дүрмүүдээр агентлагийн эрх зүйн байдлыг янз бүрээр тогтоожээ. Жишээлбэл, Хөвсгөл аймгийн Байгаль орчны алба (БОА)-ны дүрмийн 1 дүгээр зүйлд зааснаар тус алба нь **"төрийн захиргааны нутгийн удирдлагын бие даасан байгууллага"**¹¹ юм. Нэгэнт бие даасан байгууллага болгохыг эрхэмлэсэн тул дүрэмд албаны санхүүжилт, өмч хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг бусад агентлагаас хавьгүй их байхаар тогтоожээ¹². Гэтэл Засаг даргын дэргэдэх агентлаг гэдэг бол бие даасан шинжгүй хараат бус байгууллага билээ. Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага бол Засгийн газраас багийн Засаг дарга хүртлээ шатлан захирах ёсонд үндэслэсэн дээд байгууллага нь доод байгууллагаа захирсан, шууд хараат байгууллагууд байдаг. Энэ бол зарчмын алдаанд тооцогдох зүйл.

Гэтэл Архангай аймаг БОА-ныхаа статусыг дээрхээс огт өөрөөр "Засаг даргын дэргэдэх агентлаг"¹³ гэж үндэстэй тодорхойлжээ.

Дүрмүүдээр орон нутгийн агентлагуудын статуст "төрийн удирдлагын нутгийн захиргааны байгууллага", "төрийн захиргааны байгууллага", "байгууллага", огт тодорхойлолгүй орхих зэрэг янз янзаар хандсан байна. Гэтэл угтаа нэг л байгууллага байдаг. Тэгэхлээр дүрмээр дур зоргоор статус тогтоож байгааг зогсоох нь чухал.

Агентлагуудын чиг үүргийг мөн харилцан адилгүй тогтоосон байна. Хөвсгөл аймгийн БОА нь **өөрийн хийх ажлыг 31 зүйлээр тодорхойлсон**. Тэгвэл Архангай аймгийн дүрмээр БОА "доорхи

үүргийг гүйцэтгэнэ" хэмээн **10 зүйлээр** чиг үүргээ тогтоожээ. Энэ 10 зүйлийн ихэнх нь өөр бусад агентлагийн хийх ажилтай давхацсан байна. Жишээлбэл, Архангай аймгийн БОА-ны дүрэм нь мэргэжлийн хяналтын албаны хийж гүйцэтгэдэг хяналт шалгалт хийх, захиргааны хариуцлага хүлээлгэх зэргийн ажилтай (хууль, дүрмийн заалттай) давхардсан байна. Мөн тус аймгийн байгаль орчны алба газар зохион байгуулалтын үйл ажиллагааг эрхлэх чиг үүрэгтэй байгаа нь газрын албаны дүрэмтэйгээ мөн л ижилсжээ¹⁴.

Энэ нь дүрмүүдийг **мэргэжлийн өндөр түвшинд боловсруулж нэг байдлаар нэг субьектээс батлах шаардлагатайг харуулж байна. Энд орон нутгаа төв засгийн түвшинд удирдаж буй ЗГХЭГ-ын мэргэжил, арга зүйн зөвлөмж, туслалцаа байх нь зүйн хэрэг бизээ.**

Сайхь акт нь нутгийн захиргааны дүрэм учраас бүх аймагт нэг янзаар тохирон үйлчилнэ гэдэг нь эргэлзээтэй юм. Жишээлбэл, Хөвсгөл аймгийн БОА-ны хариуцсан ажилд ойн баялагтай холбогдсон зүйлс их байхад Өмнөговь, Дундговь аймгийн дүрэмд цөлжилт, элсний нүүдлийн асуудал голлох нь бодит үндэстэй. Хангай нутгийн асуудал говийнхонд төдийлөн хамааралгүй байх нь зүйн хэрэг бөгөөд энэ НӨУЕ-ны хэрэгцээ, ач холбогдлыг нэгэн зэрэг харуулах буй заа.

Дөрөв. Харьцуулан үзэхэд юу ажиглагдав?

Хөвсгөл аймгийн УДББӨБЗХ-ийн тэргүүн үүрэг бол **"харьяа салбар нэгж байгууллагын мэдээ, мэдээллийг хүлээн авч хариу өгөх,**

шийдвэрлүүлэхээр эрх бүхий этгээдэд шилжүүлэх"¹⁵ явдал юм. Энэ нь юуны өмнө хэлтэс, агентлаг өөрөө шийдвэр гаргахгүй, эрх бүхий этгээдэд дамжуулдаг, явцуу эрх мэдлийнхээ хүрээнд ажилладаг төрийн албаны нэгэн ёс журмыг харуулж байгаа заалт юм.

Эндээс нэгдүгээрт, агентлаг нь хэлтэст асуудлаа оруулдаг, хоёрдугаарт, хэлтэс нь түүнийг нь хүлээн авч хариу өгдөг, эсвэл шийдвэр гаргах эрх бүхий этгээдэд шилжүүлдэг зэргийн агентлаг, хэлтсийн зүй зохиистой эрх зүйн харилцааг харж болно.

Энэ нь миний үзэж байгаагаар хэлтэс агентлагийн харилцааны зөв загвар нь юм. Учир нь агентлагууд нутаг дэвсгэрийн эрх хэмжээтэй бөгөөд төрийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ Засаг даргын удирдлага дор байдаг.

Зарим дүрмийн хүрээнд дээрх харилцаа эсрэгээрээ тогтоогджээ. Мөн түүнчлэн Газрын тухай хуулийн 23.2.6-д зааснаар аймгийн газрын албаны даргыг ГХГЗЗГ-ын дарга томилдог тул удирдлагын хувьд аймагтаа биш төв засгийн байгууллагад харьяаладаг болсон нь гажуудал мөн.

Төрийн удирдлага нь хуулийн дагуу хэрэгждэг зарчимтай. Засаг дарга хуулинд тодорхойлсон чиг үүрэг буюу удирдан чиглүүлэх үйл ажиллагааг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх ёстой. Жишээлбэл, Авто замын хуулиар Засаг дарга орон нутгийн чанартай авто замыг хамгаалах арчилах, холбогдох маргаан шийдэх чиг үүрэгтэй. Гэтэл Хөвсгөл аймгийн УДББӨБЗХ дүрэмд энэ талаар холбогдох ажил алба огт тодорхойлогүй байна. Эндээс зарим тохиолдолд хууль дүрэм

¹¹ Хөвсгөл аймгийн баримт мэдээлэл. Удирдлагын академи. УБ., 2006

¹² Агентлагийн дүрмийн агуулсан зэрэгцүүлсэн өгүүллийн холбогдох хэсгээс үзнэ үү.

¹³ Архангай аймгийн БОА-ны дүрэм. 1-ийн нэг. Архангай аймгийн баримт мэдээлэл. Удирдлагын академи. УБ., 2006.

¹⁴ Архангай аймгийн Газрын албаны дүрмийн 2. Архангай аймгийн баримт мэдээлэл. Удирдлагын академи. УБ., 2006.

¹⁵ Эл өгүүллийн холбогдох хэсгээс үзнэ үү.

хоёр амьд холбоогүй болохыг харж болно. Үндсэн хууль, бусад хууль, тамгын газрын хэлтсийн дүрэм, агентлагийн дүрэм гэдэг цогц хэм хэмжээний цомирлогоор төрийн удирдлага, түүнийг хэрэгжүүлэх захиргааны газрын үйл ажиллагаа тодорхойлогдоно. Тиймээс энэ 4 баримт бичиг өөр хоорондоо нягт холбогдсон, нэг санаа илэрхийлсэн, эрх хэмжээг тодорхой гаргаж ирсэн байх ёстой. Иймд хууль, дүрмийг уялдаа холбоог хангах хэрэгцээтэй.

Орон нутгийн агентлагийн

үйл ажиллагааны талаар холбогдох хуулиудад ямар хэм жэмжээ байхгүй байгаа заруулмаар. Ядаж чиг үүрэг, эрх хэмжээ, эрх зүйн байдлыг нь хуулиар тогтоох нь чухал. Агентлагууд нийтийн захиргааны байгууллага тул үйл ажиллагаа нь хуулиар тодорхойлогдож байж гэмээн хууль дээдлэх зарчимд бүрнээ нийцнэ.

Агентлаг, хэлтсийн дүрмийг аймаг бүр эрс өөр өөр тогтоосон замбараагүй байдалтай байгааг цэгцлүүштэй. Батлах субъектын хувьд тухайн байгууллагын дарга, аймгийн Засаг дарга эсвэл

тов байгууллагын дарга гэсэн янз бүрийн этгээдүүд дүрмийг баталдаг нь энэхүү гажуудлын гол үндэс болж буй. **Агентлагууд нь нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж, Хурлын өмнө хариуцлага хүлээдэг Засаг даргын алба тул түүний дүрмийг аймгийн ИТХ нь батлах нь зөв мэт санагдана.**

Цаашид хэлтсүүдийн 5 дүрмийн оронд тамгын газрын нэгэн дүрэмтэй болоод түүндээ хэлтсүүдийнхээ үйл ажиллагаатай холбоотой харилцааг тодорхойлож байх нь зүйтэй болов уу.

"МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ" нь шүүхийн шийдвэрийг нийтийн хүртээл болгох замаар шүүхийн ил тод, нээлттэй байдал болон эрх зүйн онол, шүүхийн практик /шийдвэр/ судлалыг хослуулан хөгжүүлэх явдлыг дэмжихэд оршино.

Шүүхийн шийдвэр олон нийтэд ил тод болсноор орчин үеийн төр эрх зүйн хөгжлийн нийтлэг зүй тогтолд нийцүүлэн шүүхийг шинэчлэн хөгжүүлэхэд чухал алхам болно.

Шүүхийн шийдвэр өөрөө онол, практик судлалын эргэлтэд орж, шүүгч, хуульч, судлаач, эрдэмтэд, багш оюутны гарын аалага, шүүхийн практик танин мэдэх судлах сурах бичиг болно.


Энэ цуврал 7 эмхтгэлийн I ботид банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо болон иргэд, хуулийн этгээд хоорондын зээл, мөнгөн хадгаламж, банкны баталгаа, үнэт цаас, хуулийн этгээдийг татан буулгах болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, арбитрын шийдвэртэй холбоотой шийдвэрүүд;

II ботид хэлцэл, бусдын газар нутаг дээр барилга, байгууламж барих эрх, хөршийн эрх, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгчийн эрхийг хязгаарлах эрх, бусдын эд хөрөнгийг хязгаартайгаар эзэмших, ашиглах эрх, барьцаа, хөдөлмөрлөх, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах, хамтран ажиллах гэрээ, тээвэрлэлт, даалгавар, зуучлал, илгээмж, шагнал олгохоор нийтэд амлах, уралдаант шалгаруулалт, хадгалалт, даатгал болон бусад шийдвэр;

III ботид оюуны өмч, түрээс, эд хөрөнгө хөлсөлх, санхүүгийн түрээс, франчайз, эд хөрөнгө үнэ төлбөргүй ашиглах, бусдын нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, хувийн нууц, гэм хор учруулснаас үүсэх үүрэг, шүүх, прокурор, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон бусад аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаанд гаргасан гомдол болон гэр бүл, эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоолгох, иргэний эрх зүйн чадамжийг хязгаарлах, иргэнийг сураггүй алга болсонд тооцох, нас барсан гэж зарлах, өв залгамжлал, бэлэглэл болон бусад шийдвэр орсон.

Бусад ботид ямар харилцааг зохицуулсан болохыг та энэ ботиудыг худалдан авч мэдэх боломжтой.

Утас: 319144





УИХ-ын Тамгын газрын ерөнхий
нарийн бичгийн дарга Ц.ШАРВДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол Улс эрх зүйт төртэй ардчилсан нийгмийг хөгжлийнхөө замнал болгон Үндсэн хуульдаа тодорхойлсноос хойш 16 дахь жилтэйгээ золгоод байна.

Монгол Улсын Үндсэн хуульд Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулан асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд байхаар хуульчилж өгсөн байдаг билээ.

Өнөөдөр манай Улсын Их Хурал хууль тогтоох үйл ажиллагаандаа Үндсэн хууль, Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг удирдлага болгон ажиллаж байна.

Улсын Их Хурал нь Үндсэн хуульд заасан хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлж, үүний дотор Монгол Улсад эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр Улсын Их Хурал нэлээдгүй ажлыг хийж гүйцэтгэж, тодорхой үр дүнд хүрч байна гэж үзэж байна.

Зарим тоон үзүүлэлтээр эдгээр ажлыг авч үзвэл, 1990 оноос өмнө нийгмийн харилцааг 50-иад хуулиар зохицуулж байсан бол өнөөдөр эрх зүйн шинэтгэлийг үе шаттайгаар хэрэгжүүлж байгаагийн үр дүнд нийгмийн олон талт харилцааг манай улсад нийт 380 гаруй бие даасан хууль, 1400 гаруй тогтоолыг Улсын Их Хурлаас

хэлэлцэн баталсан байна.

Монгол Улс 14 олон улсын байгууллагын гишүүн бөгөөд бүс нутгийн түвшинд 2 олон улсын байгууллагын үйл ажиллагаанд ажиглагч орноор оролцож байна. Манай улсын хувьд өнөөдөр хоёр талт 1044 олон улсын гэрээ, олон талт 208 олон улсын гэрээ хүчин төгөлдөр үйлчилж байна.

Төрийн эрх мэдлийн хуваарилалт нь хууль дээдлэх, хүний эрх эрх чөлөөний баталгааг хангах эрх зүй, бүтэц зохион байгуулалтын илэрхийлэл болж төрийн засаглалын байгууллагуудыг харилцан тэнцвэртэй орших, бие биеийн хэрэгт үл оролцох, харилцан бие биеэ хянах бүтэц, зохион байгуулалтад оруулж, Үндсэн хуулиар хамгаална гэсэн үг билээ. Ингэснээр төрийн засаглалын аль нэг өндөрлөгийн хүсэл зориг дангаар ноёрхох бололцоог хааж, хуулийг зөвхөн ард түмний төлөөлөгчдийн байгууллага Улсын Их Хурал тогтоохоор зааж өгсөн билээ.

Гэхдээ өнөөдрийн Бага Хурлын зорилго чиглэлтэй уялдуулан Монгол Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаа ямар байгаад гол анхаарлаа хандуулж ярилцах шаардлагатай байна.

Хууль тогтоох үйл ажиллагаанд судалгааны зөв арга, бүтээлч хандлага шийдвэрлэх үүрэгтэй. Өнөөдөр хууль тогтоох үйл ажиллагааны үе шатанд судалгааны аргыг буруу хэрэглэснээс гадаад бусад орны хууль тогтоомжийг харьцуулан

дүгнэж алдаа гаргах магадлал их байна. Тийм учраас ялангуяа ерөнхий танин мэдэхүйн үүднээс дүгнэлт хийхэд алдаа гардаг хэдэн тохиолдлыг манай хууль, эрх зүйн мэргэжлийн эрдэмтэдийн нэгтгэн томьёолсноор "... объектыг буруу сонгон авах, улс орныхоо бодит нөхцөл байдлыг зөв харгалзан үзэлгүй хуулбарлах, эрх зүйн шинжлэх ухааны тодорхой үзэл баримтлалыг өөрийн орны нөхцөл байдалд тохирох эсэхийг үл харгалзах, эрх зүйн бүл, салбар, төрөл хэсэг гэх зэрэг ойлголт, өөрөөр хэлбэл эрх зүйн тогтолцооны өөр өөр бүтцийг харгалзахгүй, өөрийн болгох, хууль эрх зүйн шинжлэх ухааны хэвшсэн нийтлэг ойлголт, зарчим, нэр томьёо загварыг буруу хэрэглэж эрх зүйн тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүд, түүний дотор хууль тогтоомжийн болон хууль зүйн бусад арга хэрэглүүрийн хоорондын уялдаа, тэнцлийг үл харгалзах, гэсэн асуудлуудад юун түрүүнд хууль тогтоогчдын анхаарвал зохих асуудлууд юм.

Түүнчлэн Парламентаас батлан гарсан хуулийн чанар, үр нөлөөг авч үзэхдээ түүний хэм хэмжээ, зүйл заалт нь тогтвортой, түгээмэл, хэрэглэгддэг, суурь шинжтэй байх, салаа утгагүй, нэг мөр тодорхой ойлгогддог, өөр хоорондоо зөрчилгүй, тэдгээр нь юуны урьд иргэний эрхийг хэрхэн дээдэлснээр тайлбарлагддаг байх шаардлагад хэрхэн нийцэж байгааг юуны урьд анхаарах хэрэгтэй юм.

Улсын Их Хурал бүтцийн хувьд Аюулгүй байдал гадаад бодлогын, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны, Төрийн байгуулалтын, Төсвийн, Хууль зүйн, Эдийн засгийн гэсэн Байнгын 7 хороо, тэдгээрт харьяалагддаг 6 дэд хороотой юм.

Байнгын хороо нь салбар тус бүрээр хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх, эрхлэх асуудлын хүрээнд төрийн бодлого, Улсын Их Хурлын үйл ажиллагааг боловсронгуй болгох санал боловсруулах, Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэйгээр ажилладаг.

Дэд хороод нь харьяалах Байнгын хорооны эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцаж бодлогын баримт бичиг, асуудал боловсруулах буюу санал, дүгнэлт гаргаж, түүнийгээ харьяалах Байнгын хороонд, шаардлагатай бол Байнгын хороогоор уламжлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, түүнчлэн хариуцсан асуудлын хүрээнд хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх эрхтэйгээр ажиллаж байна.

Ажил хэрэгт тустай энэ шаардлагын үүднээс Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагааны чанар, үр нөлөө өнөөдөр ямар байна гэдгийг авч үзье.

Улсын Их Хурал хууль тогтоогчийн хувьд үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш түүхийн харьцангуй бага хугацааны практик дадлагатай боловч өөрт тавих шаардлага, хяналтаа ямагт өндөр байлгаж, хариуцлагаа дээшлүүлж байх ёстой.

Хууль тогтоох үйл ажиллагааны чанар, үр нөлөө гэдэг бол аливаа хууль нь эрх зүйт төрийн нөхцөлд нийгмийн бүхий л харилцааг ухаалаг

байдлаар нарийвчлан зохицуулж чадсан маш нарийн үйл ажиллагааны үр дүнгээр тодорхойлогдох учиртай. Энэ талаас нь авч үзвэл Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаанд нэлээдгүй алдаа, дутагдал оршиж байна.

Хууль тогтоох үйл ажиллагаа нь хуруу гарын үзүүрээр, зав чөлөөндөө яаран сандран, бас тодорхой захиалгаар юм уу, нэг болон хэсэг бүлгийн ашиг сонирхолд нийцүүлэн хийгддэг ажил биш. Харамсалтай нь Улсын Их Хурлаас батлан гаргаж буй хуулиуд нь зарим тохиолдолд нийгмийн харилцааг нарийвчлан зохицуулах ерөнхий шаардлагад нийцэхгүй, ерөнхий, тунхаг шинжтэй байна. Хуулийн төслийн хэлэлцүүлэг богино хугацаанд явагдаж, хуулийг хурдавчлан хэлэлцэж батлах гэж оролдох явдал ч байна. Нийгмийн харилцааг зохицуулах гол гол хуулийн төслийн нээлттэй хэлэлцүүлгийг тодорхой хугацаанд шахалгүйгээр, нийгмийн санаа бодол, эрдэм шинжилгээний байгууллагын мэргэшсэн судлаачид, шинжээчид, мэргэжлийн байгууллагын саналыг сонсох, мэдээлэл авч хэлэлцэх журмаар явуулах зайлшгүй шаардлагатай байна. Нэгэн удаагийн шийдлээр төгс төгөлдөр хууль гаргах боломжгүй ч, сайн хууль гаргах бүхий л боломж бололцоог бүрэн дүүрэн ашиглаж ажиллах ёстой. Үүний зэрэгцээ нийгмийн хэрэгцээ шаардлагын дагуу нэмэлт, өөрчлөлтүүд орж, түүний чанар улам сайжирч байх учиртай. Тийм учраас хуулийн хэлэлцүүлгийн нээлттэй байдал бодит үндэслэл, гарцаагүй байдлын шаардлагыг хангах нь түүний чанарт шууд нөлөөлнө.

Иргэд, байгууллагаас хуулийн талаар гарч буй аливаа санал бүрт дүн шинжилгээ хийж, эдгээр санал мэдээлэл нь бодлого, хуулийн зохицуулалтаас, эсхүл хуулийн хэрэгжилтээс хамаарч буйг

задлан шинжилж, судалгаа, тооцоо, дүн шинжилгээнд үндэслэн хуулийн төсөл санаачлах, боловсруулах, батлан гаргах үйл ажиллагаа явагдаж байх ёстой. Сүүлийн үед хуулийн төсөл боловсруулах ажил чанаргүй хийгдэж байна. Ийм ч учраас хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдэд хэлэлцүүлгийн шатанд ихээхэн хүндрэлүүд үүсч байна. Жишээ нь, Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурал хэлэлцэхээр шийдвэрлэсэн боловч уг төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэх шатанд зарчмын зөрүүтэй 95 санал гарч, уг төслийг боловсруулалтын шаардлага хангаагүй гэж үзэн хууль санаачлагчид нь буцаажээ. Хуулийн төсөл боловсруулах ажлыг хууль санаачлагчид энэ байдлаар ор нэр төдий зүйл болгож, энэ алдаагаа хуулийн хэлэлцүүлгийн шатанд засах гэж оролдсон "хэвийн бус" техник ажиллагаатай холбоотой. Энэ бол хууль тогтоох үйл ажиллагааны чанарт сөргөөр нөлөөлж байгаа нэг хүчин зүйл юм.

Хууль тогтоох үйл ажиллагаанд олон нийтийн оролцоо дутмаг, судалгаа шинжилгээний байгууллагуудын санал, дүгнэлт бага, мэргэжлийн бус хүмүүс бусад хуулийн хэв загварыг "дуурайлан" боловсруулдаг ажлын арга барил амь бөхтэй оршиж байна. Санаачлан боловсруулсан хуулийн төслийг хууль бүтэх ёс, техникийн талаас нь мэргэшсэн хэсгийнхээ зөвлөж хэлсэн үгийг төдийлөн анхаардаггүй хандлага бий болсноос хууль хүчингүй болгох, удаа дараа нэмэлт, өөрчлөлт орж нэр хүнд нь буурч байна.

Хуулийн улс төрийн бодлогын алдаа гажуудлаас хамгаалах, улс төрчдийн эрх ашиг, үзэл бодлын хэрэгсэл болгохгүй байх, хууль зүйн болон бусад арга, хэрэгслийг шинжлэх

ухааны үүднээс судалж боловсруулах шаардлага улам хурцаар тавигдаж байна. Хууль тогтоох бодлогод улс төр, эдийн засгийн бүлэглэлүүд нөлөөлж ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх орон зай бий болгохыг оролдож буйг шударгаар хэлэх ёстой. Үүнд холбогдох жишээ баримтыг манай хууль тогтоомжуудаас олоход тийм хэцүү биш болсон нь мэргэжлийн хуульчид төдийгүй жирийн иргэн, хэвлэл мэдээллийнхэн олж хараад бичиж, шүүмжилж байгаагаас тодорхой билээ.

Хууль тогтоох үйл ажиллагааны эцсийн үр дүн болсон хууль нь иргэний эрх, эрх чөлөөг баталгаажуулж, хамгаалснаар, хүний эрх, эрх чөлөөг эрх зүйн оргил хэм хэмжээ хэмээн үзэж, түүнд бусад бүхий л хэм хэмжээнүүдийг захируулснаар түүний агуулга тодорхойлогдоно.

Өнөөдөр хууль ард түмнээр хүлээн зөвшөөрөгдсөн байх зарчмыг хэрэгжүүлэхэд Улсын Их Хурал дутуу анхаарч ирлээ. Улсын Их Хурлаас баталсан, нэмэлт, өөрчлөлт оруулсан хуулиуд бүгд хүлээн зөвшөөрөгдөж байгаа юу гэж асууж, нягтлан судалбал сонин дүр төрх гарч мэднэ. Үүнийг судалж зохих дүгнэлт хийх хэрэгтэй байна.

Ард түмэн амьдралаас хэт хөндий, хатуу, өөрсдийн эрх ашгийг хамгаалаагүй, бодит зүй тогтолд тулгуурлаагүй хуулийг хэзээ ч жинхэнэ ёсоор дээдэлж, хүндэтгэж, хэрэгжүүлэхгүй. Харин үүний оронд айл эмээх, аргалах, биелүүлсэн дүрийг л үзүүлэх, үл тоох хандлага нийгэмд тогтвол үүнээс илүү аюул гэж үгүй. Хууль дээдлэгдэх үндэс нь хууль өөрөө хүлээн зөвшөөрөгдөхүйц байх явдал мөн. Хууль хүлээн зөвшөөрөгдөхүйц байхын гол шалгуур нь хүний жам ёсны бөгөөд бусад эрхийг хамгаалсан, байгаль, нийгмийн хөгжлийн бодит зүй тогтлыг зөв тусгасан, зохицуулалтын гол арга, механизм нь

тодорхой хүнлэг энэрэнгүй, шударга ёсыг агуулсан байх учиртай. Ийм л хуулийг ард түмэн аяндаа дээдэлнэ, хүлээн зөвшөөрнө. Ийм хууль цаасан дээр үлддэггүй, амьдралд үйлчилдэг. Гэтэл өнөөдөр Улсын Их Хурлаас батлан гарсан зарим хууль түүнийг хэвлэхэд орсон цаасны үнэ цэнэгүй болсон байдалд бид анхаарах хэрэгтэй байна. Өнөөдөр хэн ч мэддэггүй, хэнд ч хэрэглэх шаардлага тулгардаггүй, хэн ч биелүүлдэггүй цөөнгүй хууль байгаа нь бас үнэн юм.

Хууль тогтоох үйл ажиллагааны чанар бол хууль нь хэрхэн батлагдан гарснаас үл хамааран хууль биелүүлэгч, хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн байдлаар шууд ба шууд бус байдлаар илэрч байна.

"Хүнийг хамгаалсан хууль гармагц хүмүүс хуулийг хамгаалах сонирхолтой болдог" гэдэг үг бий. Хууль нь хүнээ хамгаалахгүй бол хүмүүс хуулийг хамгаалахгүй. Хууль үйлчлэхгүй байна гэдэг нь иргэдийн хувьд өмч хөрөнгө, амьнас, эрх чөлөө нь хамгаалалтгүй болсон гэсэн үг. Нөгөө талаас, төр засаг ажиллах дүрэмгүй, дүр зоргын байдалд орно гэсэн үг. Тиймээс бид хэн нэгэн эрх мэдэлтэн, ямар нэгэн төрийн байгууллага гэхээсээ хууль ёсонд дээд хүчин чадал олгож сурах хэрэгтэй байна. Үүнд, Улсын Их Хурлын үүрэг асар өндөр билээ.

Гадаад улс орнуудын хууль тогтоомжийг үлгэр загвар болгох, зарим үед зээлдэн хэрэглэх явдал олон улсын практикт байдаг ч өөрийн орны онцлогийг сайтар харгалзаж хийлгүй, агуулга, зориулалт, зохицуулалт нь эрс ондоо зүйлүүдийг механикаар нийлүүлэн хуулан хэрэглэх явдал байна. Улс орныхоо үндэсний аюулгүй байдал, түүхэн уламжлал, хүн амын байршил, суурьшил, үндэсний бүрэлдэхүүн, нутаг дэвсгэрийн хэмжээ, байгаль эдийн засгийн

нөхцөл, дэд бүтэц зэрэг гол шалгуурыг харгалзаж үзэхгүй байгаагаас болж парламентаас баталсан зарим хууль Монголын амьдралд тэр бүр оновчтой үйлчлэхгүй байна.

Хууль тогтвортой үйлчлэх нь хууль тогтоох үйл ажиллагааны чанарыг харуулсан гол үзүүлэлт мөн. Улсын Их Хурлаас хийж буй хуулийн өөрчлөлтийн хурдыг хууль биелүүлэгчид, хэрэглэгчид үнэндээ гүйцэхгүйд хүрч байгаад шүүмжлэлтэй хандах ёстой юм. Тухайлбал, Засгийн газрын тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль батлагдсанаас хойш нийт 32 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан нь дунджаар жилд 2-3 удаа өөрчлөлт оруулсан гэсэн үг юм. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нийт 26 удаа нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд үүнээс 2002 онд 8, 2003 онд 4, 2005 онд 5, 2006 онд 4, 2007 онд 2 удаа нэмэлт, өөрчлөлт оржээ. Улсын Их Хурлаас 2004-2008 оны 2 дугаар сарын 7-ны байдлаар нийт 77 хууль баталж, 285 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Энэ их өөрчлөлтийн үр дагавар эцсийн эцэст хууль хэрэглэгчдэд тусна. Ялангуяа иргэний эрх зүйн салбар дахь хууль тогтоомжуудыг тогтвортой байлгах асуудал манай улсаас бусад улс оронд эрх зүйн соёлыг нь харуулдаг шалгуур бололтой. Гэтэл ийм хүний толгойд тогтохын аргагүй хувирамтгай, өөрөөр хэлбэл бараг байнга өөрчлөлт орж байдаг хуультай улсад ажиллаж амьдардаг манай бизнес эрхлэгчдэд хэн итгэж хөрөнгө оруулалт хийж, хамтран ажиллах вэ, яаж үйл ажиллагаа нь тогтворжиж хөгжих вэ?

Батлан гаргасан хууль тогтоомжийн тоо нь Улсын Их Хурлыг багагүй ажилласныг харуулж байна. Гэвч хууль тогтоох үйл ажиллагааны чанарыг батлагдсан хуулийн тоогоор бус зохицуулах чадвартай хуулийн тоон үзүүлэлтээр дүгнэвэл хангалттай гэсэн

үнэлгээ, дүгнэлтийг тэр бүр өгөхгүй байна. Үүний нэг ирэл бол Улсын Их Хурлаас баталсан хуулиуд Үндсэн хууль зөрчсөн гэх Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтүүдээр тодорхой харагдана. Энэ бол Улсын Их Хурлын үйл ажиллагаатай холбогдож яригдах ноцтой алдаа дутагдал мөн. Энэ нь Улсын Их Хурлын хариуцлагын тогтолцоог өөрчлөх хангалттай шалтгаан юм. Одоогийн Улсын Их Хурлын маань дүр төрх үйл ажиллагаа ийм байна. Парламентын хариуцлага ийм байгаагаас ихээхэн цаг хүч гаргаж, арай ядан батлагдсан хууль хэрэгжихгүй байна, хангалтгүй хэрэгжиж байна. Парламент нэгэнт баталсан л бол тэр нь хууль. Хууль нь биелж байвал хууль тогтоох чиг үүрэг хэрэгжиж, Улсын Их Хурал байгаагийн хэрэг бүтэж байна гэсэн үг.

Улсын Их Хурал нь Улс, ард түмнийхээ язгуур эрх ашигт нийцсэн хуулийн бодлого тодорхойлж, баталсан хуулийнхаа хэрэгжилтийг хэр биелүүлж байгаад Засгийн газраа хянах ажлыг байнга эрхлэх ёстой.

Улсын Их Хурал олон хууль баталж байгаа боловч хуулийнхаа биелэлтэд тэр бүр үр дүнтэй хяналт тавьж ажиллаж чадахгүй байна. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулж ямар үр дүнд хүрсэн талаар Засгийн газраас хааяахан асуулга асуухаас цааш хэтрэхгүй байна. Улсын Их Хурал хууль батлахын зэрэгцээ, тэдгээрийн хэрэгжилтэд нь дээд зэргийн, үр дүнтэй хяналт тавихад онцгой анхаарч байх ёстой. Улсын Их Хурлын хяналт хүч султай, эргэж хариуцлага тооцох, хяналтын үр дүнтэй хэлбэрүүдийг сонгон хэрэглэж чадахгүй байна.

Улсын Их Хурал баталсан хуулиа яаж хэрэгжүүлэх, биелэлтэд нь хэрхэн хяналт тавьж ажиллах вэ гэдэгт

анхаарал хандуулж чадахгүй байгаагаас өөрийгөө зүгээр нэг хууль гаргадаг газар болгочихоод байна.

Үүний нөгөө талд, хууль, эрх зүйг үгүйсгэх, хууль зүйн онол, шинжлэх ухааныг үл тоомсорлох, хуульчийн үүрэг, ролийг улс төрд зүй ёсоор үнэлэхгүй байх хандлага бий болж байна. Энэ бол Монголын нийгэмд сүүлийн жилүүдэд буй болсон нэг сөрөг үзэгдэл. Хуулийг биелүүлэх, хэрэгжүүлэхийн төлөө ажил хийгээгүй байж шүүмжилдэг эрүүл биш үзэгдэл ч нийгэмд газар авч байна. Улсын Их Хурал хууль батлаад гаргахад салбар хариуцсан сайд нь "манай яамны бодлого өөр байсан" гэх, яамны ажилтан болохоор "хуулийн цоорхой" гэхчилэн шалтаг зааж ил далд эсэргүүцнэ. Хуулийн хэрэгжилтэд чөдөр тушаа болж байгаа иймэрхүү хандлага байсаар байна. Ийм ёс уул нь хаа ч байдаггүй. Эрх зүйт төрд, хууль дээдлэх зарчмыг дээдэлсэн нийгэмд бид ажиллаж амьдарч байгаа бол хуулийг биелүүлдэггүй, хуульд хайхрамжгүй хандаг байдлыг устгаж, хууль гарсан л бол түүнийг үг дүүгэй биелүүлдэг сахилга хариуцлагыг бий болгох ёстой.

Улсын Их Хурал батлан гаргасан хуулийнхаа биелэлтэд хяналт тавих ажиллагаанд хараат бус шинжээчдийг татан оролцуулах тогтолцоог бүрдүүлэх цаг нь болсон байна. Засгийн газрын гаргасан мэдээлэл, тайлангийн хүрээнд Улсын Их Хурал ажиллаж болохгүй. Улсын Их Хурал өөрсдийн шинжээчтэй байх, мэдээлэлтэй байх, мэдээллийн эх сурвалж дээрээ үндэслэн хяналтаа тавьж чаддаг байх явдал нь парламентын хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд чухал зүйл гэж үзэж байна.

Түүнчлэн Улсын Их Хурал бичиг ч нөхцөлд Үндсэн хууль ямар бусад хуулийг чанд баримталдаг байх, Улсын Их

Хурлын гишүүд үйл хэргээрээ хуулийг сахин биелүүлэх, сахилга, хариуцлагатай байхын жинхэнэ үлгэр дууриал болж чаддаг байх нь эрх зүйт төрийн ёсыг үлс орондоо бэхжүүлэхэд ихээхэн чухал ач холбогдолтой байх болно.

Хуулийг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах, зөрчил, давхардал, хийдэл, хэлбэрдлийг арилгах талаар Улсын Их Хурлын үүргийг дээшлүүлж, хяналтыг сайжруулах, Засгийн газар, түүний харьяа байгууллага, яам, агентлаг, төрийн бусад байгууллага хууль биелүүлэх хариуцлагаа сайжруулах асуудал дээр анхаарлаа хандуулах цаг нэгэнт бий болсон байна.

Хууль тогтоох эрх мэдэл гэж зөвхөн хууль батлан гаргах үйл ажиллагааг хэлэхгүй нь тодорхой байна. Хууль батлан гаргасны дараа хянаж дүгнээд, биелэлтийг нь хангуулах өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа эрчимтэй явагдах ёстой. Гэтэл бид үнэндээ энэ ажлынхаа хагасыг хийдэг буюу хуулиа гаргаад орхичихдог, төрийн түшээд нь хэт үлстөржиж, цагийн ихэнхийг барж байгаа парламенттай болчих гээд байгаа үнэн байдлыг хүлээх ёстой. Дэлхийн аль ч улс орны парламентын хийдэг ажлыг Улсын Их Хурал тэр жишгээр нь хийж, хууль тогтоох үйл ажиллагааны чанар, үр нөлөөг дээшлүүлж, хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг шинэ түвшинд гаргахыг цаг үе, эх орон, ард түмний нийтлэг эрх ашиг шаардаж байна.

Цаашид Улсын Их Хурал хууль тогтоох үйл ажиллагаандаа, хуулийн төсөл боловсруулахдаа тухайн хуулийн хэрэгцээ шаардлага, нийгмийн харилцаанд үзүүлэх эерэг, сөрөг үр нөлөө, үр дагаварыг урьдчилан судалдаг мэргэжлийн судалгаа шинжилгээний бүтцийг бий болгож, хуулиудын хоорондын уялдаа холбоог нарийвчлан үзэж, зөрчил

хүртэлх бүх шатанд хууль санаачлагч, хэрэгжүүлэгч, сонирхогч байгууллага, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг, мэтгэлцээн, мэргэжлийн зөвлөлдөх уулзалт, нээлттэй хэлэлцүүлгийг байнга зохион байгуулж, тэдний саналыг судлан үзэж хувийн

Түүнчлэн хуулийн төслийг УИХ-аар хэлэлцэн батлах үед ажлын хэсгээс гадна эрдэмтэн, мэргэжилтнүүдийн багийг зөвлөх эрхтэйгээр ажиллуулж, тэдний санал зөвлөгөө, мэргэжлийн дүгнэлтийг анхаарч үздэг байх нь чухал асуудал юм.

“Хууль дээдлэх ёс”, 2008 он, №3



ХЗҮТ-ийн Криминологийн судалгааны секторын
эрдэм шинжилгээний ажилтан,
хууль зүйн магистр Г.Оюунболд

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Эрүүгийн байцаан шийтгэх тодорхой ажиллагааны нэг болох шинжилгээ хийлгэх нь ЭБША-нд оролцогчдын эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн хэргийн бодит үнэнийг тогтооход ихээхэн ач холбогдолтой төдийгүй, энэхүү үйл ажиллагааг шинэ түвшинд гаргах, олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлж судлан дүгнэх шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа бөгөөд энэхүү шаардлага нь судалгаа хийх үндэслэл болсон юм. Гадаадын орнуудын шүүхийн шинжилгээний байгууллагын хууль тогтоомж, бүтэц зохион байгуулалтыг судлах нь судалгааны ажлын зорилго байлаа.

Шүүх шинжилгээний зарим салбарууд, тухайлбал: Шүүх эмнэлэг, Криминалистикийн шинжилгээ нь хууль зүйн практик шаардлагаар үүсч бие даасан салбар шинжлэх ухаан боллоо хөгжсөн. Ингээд гадаадын зарим улсын шүүхийн шинжилгээний байгууллагын зохион байгуулалт, тогтолцоог авч үзье.

ХБНГУ:

ХБНГУ-ын хууль, хуулийн байгууллагын тогтолцоог манайд авч хэрэглэхэд нэлээд төвөгтэй асуудал гардаг. Энэ нь дараах шалтгаантай:

1. Холбооны улсын системтэй. Тиймээс холбооны улсын хэмжээнд нэг „дэввэр байгууллага“ байх, 16 муж улс тус бүр тус тусын асуудлыг хариуцсан муж улсын дээд, дунд, доод шатны гэх мэт

байгууллагатай, эрхлэх асуудлынх нь хүрээ нь ямар хуульд яаж зааснаасаа шалтгаалаад янз бүр байдаг. Манайд бол аль нэг мужаас нь жишээ авахад тохиромжтой.

2. Манай улсад хэрэглэгддэггүй энэ төрлийн салбарын мэргэжлийн үг хэллэг их байдаг.¹

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны чиглэлээр эмнэлгийн болон эмнэлгийн бус шүүхийн /forensic/ шинжилгээ явуулдаг. Эрүүгийн болон криминалистикийн чиглэлээр „эмнэлгийн бус шүүхийн шинжилгээ“-г Холбооны улсын Дотоод хэргийн яамны харъяанд байх Холбооны Эрүүгийн Цагдаагийн ерөнхий газар (ВКА буюу Bundeskriminalamt) болох муж улсуудын Эрүүгийн цагдаагийн газрууд (LKA буюу Landes Kriminal Amt) өөрсдөө шүүхийн шинжилгээ хийдэг².

ВКА буюу Холбооны эрүүгийн цагдаагийн газар нь 9 хэлтэстэйн нэг нь криминалистикийн техникийн институт (Das Kriminaltechnische Institut гэж байдаг. Энэ институтэд Chemiker /химич/, Physiker /физикч/, Biologen /биологич/, Ingenieure /инженер/, Phonetiker /утасны мэргэжилтэн/, Psychologen /физиологич/, Linguistik /хэл

судлаач/, Pharmakologie /эм зүйч/, Phonetik Kriminalbeamte, Mineralogen, IT-Spezialisten /IT чиглэлийн мэргэжилтэн/, Elektroniker /электроникч/, Techniker, technische Assistenten ба Laboranten гэх мэт 60 гаруй мэргэжлийн 300-аад хүн ажилладаг. Эдгээр ажилтан нь дотоод, гадаадад болон муж, дүүргийн эрүүгийн цагдаа нарт сургалт явуулдаг шүүхийн /forensic/ шинжилгээнийхээ чиглэл тус бүрээр хийдэг.

ВКА буюу Холбооны эрүүгийн цагдаагийн газрын хуульд ВКА-ийн бүтцийн талаар тусгагдаагүй. Энэ байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагааны чиглэл, хамрах хүрээ, мужийн Эрүүгийн цагдаагийн газартай, Олон улсын адил төстэй байгууллагуудтай хэрхэн хамтран ажиллах, хувь хүнтэй холбоотой мэдээллийн нууц, сан гэх мэтийг зохицуулсан байна. ХБНГУ-д байгууллагын бүтэц зохион байгуулалтыг хуулиар биш журмаар зохицуулдаг. Эрүүгийн цагдаагийн газрын /ВКА/-ийн хариуцсан асуудалд жишээ нь олон улсын зохион байгуулалттай гэмт хэрэг, галт зэвсэг наймаалах тэсэрч дэлбэрэх бодис, мансууруулах бодис хил давуулан борлуулах, хуурамч мөнгөн дэвсгэрт үйлдэх, төрийн зүтгэлтний амь нас эрүүл мэндэд улс төрийн сэдэлтээр халдсан

¹ <http://en.wikipedia.org/wiki/Forensics> энэ сайтаас ерөнхий мэдээллийг авч болох ба маш олон чиглэлээр forensic examination буюу манайхээр шүүхийн шинжилгээ явуулдаг юм байна.

² www.bka.de

гэмт хэргүүдэд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, шүүхэд шинжээч, мэргэжилтнээ явуулах гэх мэт ордог.

Үүнээс гадна дотоод хэргийн сайдын хүсэлт, даалгавраар, аль нэг мужийн дээд байгууллагын хүсэлтээр эсвэл улсын ерөнхий прокурорын хүсэлт болон даалгавраар хуульд заасан бусад гэмт хэрэг гарсан үед мэргэжилтнээ илгээх, оролцох, ихэнхдээ шинжээчээр ажиллах, дүгнэлт гаргаж өгөх эрхтэй байдаг³.

Нийт 20 шинжилгээний чиглэл бүхий салбартай⁴ (физикийн лабораторитай, бичиг баримтын үнэн зөвийг шалгах, аюулгүйн техник, дуу авиа таних, бичгийн хэлбэр хэвийн шинжилгээ гэх мэт), жил бүр 14000 гаруй шинжилгээний тайлан, шинжээчийн дүгнэлтийг шүүхэд гаргадаг, ялангуяа дэлхийн бусад орны эрүүгийн цагдаагийн газартай /энэ нь иргэний цагдаа байж болох/ шинжээчээр ажиллаж, шинжээчийн дүгнэлт гаргаж өгдөг.⁵

ВКА нь эмнэлгийн бус шүүхийн шинжилгээний чиглэлээр (forensic science гэдэг утгаараа) ХБНГУ-даа ганц төв нь төдийгүй, хамгийн том судалгаа, шинжилгээний байгууллага юм б. Тиймээс ч бусад бүх мужийнхаа орон нутгийн цаг-даагийн газрын шинжээчидтэй хамтарч ажилладаг. Мьонштэр хотод байдаг Германы Цагдаагийн дээд сургуультай нягт хамтын ажиллагаатай. ВКА нь Судалгаа шинжилгээний үр дүн, шүүхээр шийдэгдсэн тодорхой эрүүгийн хэргүүдтэй холбоотой шинжилгээний үр дүн зэргийн зарим хэсгээс олон нийтийн хэвлэл, мэргэжлийн ном, гарын авлага зэрэгт нийтлүүлдэг.⁶

Ялангуяа эдгээр байгууллагатай улсаа төлөөлж харцдаг. Жишээ нь Baden-Württemberg хотын Эрүүгийн цагдаагийн газрын 6 дугаар хэлтсийн үйл ажиллагааг авч үзье

"Хууль дээдлэх ёс", 2008 он, №3

1. Чанарын менежмент;
2. Криминалистик техникийн институт болон төв албаны мэргэжлийн Coordination.

Доорх нарийн мэргэжлийн салбар хэсэгт шинжээчид нь хуваагддаг.

1. Нэгдүгээр хэсэг
- Материалын шинжилгээ буюу сонгодог Криминалистикийн техник (krim.technik.);
- Физик, ерөнхий хими;
- Биологи, textil, ул мөр судлал;
- Бичгийн хэв, бичиг баримт;
- Буу, галт зэвсэг, баллистик шинжилгээ, хэв хэлбэр авах (Form).

2. Химийн болон техникийн шинжилгээний хэсэг

- Гал түймрийн шалтгаан;
- Тэсэрч дэлбэрэх бодис;
- Хор, хортой зүйлс.

3. Гуравдугаар хэсэг.

Молекул генетикийн шинжилгээ
- ДНК-цусны;
- ДНК-нууц (ялгадас)-ын ул мөр;

- DANN-data-base /өргдлийн сан/.

4. Дөрөвдүгээр хэсэг
- Танин олуулах шинжилгээ

/identification/d
- Дактилоскоп /Daktylo-skopie/.

- Хэргийн газрын мэргэжлийн групп /fototechnik/ манайхаар бол жижүүрийн бүрэлдэхүүн гэсэн бүтэцтэй. Бусад муж ч гэсэн энэ мужтай адилхан зохицуулалттай.

Эдгээр үйл ажиллагааг тухайн муж улсын хуулиудаар зохицуулсан байдаг ба хуульдаа товч тодорхой эрх зүйн үндсийг

тусгаж түүнийгээ тушаал журам хэлбэрээр дэлгэрүүлэн хэрэгжүүлдэг.

Сэтгэц гэм судлалын чиглэлээр муж бүр „эмнэлэг-шорон“-той. Ийм байгууллагад эмч, сэтгэл зүйч, хуульч гэх мэт шаардлагатай мэргэжилтнүүд ажилладаг. Эрүүгийн хэргийн журмаар эрх зүйн бүрэн, бүрэн бус чадамжтай этгээд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт шүүхийн явцад болон шүүхийн дараагийн шатанд ч хүргэгдэн ирж эмчлүүлдэг. Сэтгэц судлалын шинжилгээ энэ байгууллагад хийгддэг, шинжээчийг нь мөн энэ байгууллагаас томилдог.

Ерөнхийдөө аль ч мэргэжлээр шинжээч болоход ХБНГУ-д нэг хууль үйлчилдэг. Төрийн байгууллагад ажилладаг нарийн мэргэжлийн албан хаагч нар эрх үүргийнхээ дагуу эсвэл тодорхой мэргэжлийн хүн уг хуульд заасны дагуу төрөөс томилогдсон буюу эрх авсан, тангараг өргөсөн шинжээч гэж 2 янз байдаг. Тэдгээр нь ихэнхдээ салбарынхаа хамгийн дээд мэргэжлийн нийгэмлэгт шалгалт өгч тангараг өргөн сертификат авдаг. Сертификат өгсөн байгууллагаас мөн эрхийг нь хасах, түдгэлдзүүлэх эрхтэй байна. Эдийн засаг банк санхүү, нягтлан бодох бүртгэл үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, хөдөө аж ахуйн үнэлгээ, гэх мэтчилэн маш олон чиглэлээр шалгалт аван эрхийг нь олгож, нутаг дэвсгэрийн хязгаарлалт, томилгоо хийдэг гэнэ. Дээр дурдсан бүх асуудал салбар тус тусынхаа

³ http://www.bka.de/profil/bka_organigramm.pdf

⁴ 20 Untersuchungsbereichen B. Physikalisches und Chemisches Zentrallabor, Ballistik, DNA-Analytik, Urkundenprüfung, Sicherungstechnik, Sprechererkennung, Handschriften-Untersuchung

⁵ BKA ist "ENFSI-Member", d. h. Mitglied des

⁶ "ist zentraler Ansprechpartner für nationale und internationale Organisationen in Fragen der Kriminaltechnik, darunter

IKPO-Interpol (Internationale Kriminalpolizeiliche Organisation - Interpol), EU-Kommission,

IAFS (International Association of Forensic Sciences),

GTFCh (Gesellschaft für Toxikologie und forensische Chemie),

DGRM (Deutsche Gesellschaft für Rechtsmedizin).

<http://dict.leo.org/>

http://www.lka-bw.de/download/Organigramm_LKA.pdf

хуулиар зохицуулагдсан байдаг. Тухайлбал Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Төрөөс эрх олгосон шинжээчийн тухай хууль /энэ нь бүх төрлийн шинжээчийн, Шүүхийн тухай хууль, Насанд хүрээгүй хүмүүсийн шүүхийн тухай хууль, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх хууль гээд л тус бүрдээ шинжээчийн үйл ажиллагааг зохицуулсан байдаг.

ЯПОН УЛС:

Шүүхийн шинжилгээний үндэсний судалгааны хүрээлэн Японы Үндэсний цагдаагийн газар нь улс төр болон төвийн гүйцэтгэх засаглалын хяналтаас хараат бус, бие даасан байгууллага юм. Иргэний хяналтыг Ерөнхий сайдын албанд харъяалагдах Олон нийтийн аюулгүй байдлыг хангах Үндэсний Комисс (*National Public Safety Commission*)—оор дамжуулан хэрэгжүүлдэг. Шүүхийн шинжилгээний үндэсний судалгааны хүрээлэн нь Үндэсний цагдаагийн газрын дэргэдэх байгууллага юм.⁷ (*National Research Institute of Police Science - An attached National Police Agency in Japan.*)

Зохион байгуулалт:

• Ерөнхийлөгч (Мэргэжлийн хүн) - *President (technical officer)*

• Дэд ерөнхийлөгч (Цагдаагийн ажилтан) - *Vice President (Police Officer)*

• Ерөнхийлөн захирах газар: Ерөнхийлөн захирах хэсэг, Нягтлан бодох хэсэг - *Department of General Affairs: General Affairs Section and Accounting Section*

• Шүүхийн шинжилгээний нэгдүгээр газар: Биологийн нэгээс тавдугаар хэсэг - *First Department of Forensic Science: First Biology Section, Second Biology Section, Third Biology Section, Fourth Biology Section, Fifth Biology Section*

• Шүүхийн шинжилгээний

хоёрдугаар газар: физикийн хэсэг, гал түймрийн шинжилгээний хэсэг, дэлбэрэлтийг шинжлэх хэсэг, механикийн шинжилгээний хэсэг - *Second Department of Forensic Science: Physics Section, Fire Investigation Section, Explosion Investigation Section, Mechanical Investigation Section*

• Шүүхийн шинжилгээний гуравдугаар газар: Химийн нэгдүгээр хэсгээс Химийн дөрөвдүгээр хэсэг - *Third Department of Forensic Science: First Chemistry Section, Second Chemistry Section, Third chemistry Section, Fourth chemistry Section*

• Шүүхийн шинжилгээний дөрөвдүгээр газар: Мэдээллийн шинжлэх ухааны нэгдүгээр хэсэг, Мэдээллийн шинжлэх ухааны хоёрдугаар хэсэг, Мэдээллийн шинжлэх ухааны гуравдугаар хэсэг - *Fourth Department of Forensic Science: First Information Science Section, Second Information Section, Third Information Section*

• Криминологи, хүний гэмт зан, үйл судлалын газар: Өсвөр насныхны гэмт хэргийг хариуцсан хэсэг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэсэг, Мөрдөн байцаалтын хэсэг - *Department of Criminology and Behavioral Science: Juvenile Section, Crime prevention Section, Investigation Support Section*

• Замын хөдөлгөөн судлалын газар: Замын хөдөлгөөн судлалын нэгдүгээр хэсэг, Замын хөдөлгөөн судлалын хоёрдугаар, Замын хөдөлгөөн судлалын гуравдугаар хэсэг - *Department of Traffic Science: First Traffic Science Section, Second Traffic Science Section, Third Traffic*

Science Section

• Судалгаа шинжилгээний зохицуулагч - *Research Coordinator*

• Таних, (нэр хаяг) тогтоох төв - *Identification Center*

• Шүүх шинжилгээний сургалтын төв - *Training Center of Forensic Science*

Шүүхийн шинжилгээний үндэсний судалгааны хүрээлэнгийн хариуцсан ажил - *Activities of National Research Institute of Police Science*

Япон дахь шүүх шинжилгээ хариуцсан гол байгууллагын хувьд, тус хүрээлэнд шүүх шинжилгээнд мэргэшсэн зуу гаруй судлаачид ажилладаг. Тэд биологи, анагаах ухаан, шинжлэх ухаан, хими, эм судлал, физик, газар тариалан, инженер, нийгэм судлал, боловсрол, сэтгэл судлал гэх мэт олон салбарын нарийн мэдлэг ур чадвар шаардсан судалгаа, задлан шинжилгээ, танин тогтоох ажил хариуцан хийдэг. Тус хүрээлэн нь шүүх шинжилгээний салбарт дотооддоо болон олон улсын түвшинд нэр хүндтэй газар мөн.⁸

Судалгаа шинжилгээ, боловсруулан бүтээх ажил

Нийгэм эдийн засгийн олон төрлийн нөхцөл байдлаас үүдэлтэй гэмт хэрэг, осол ихэсч байгаатай холбогдуулан жил бүр олон шинэ судалгааны төсөл хэрэгжүүлдэг. Эдгээр төслийн дагуу гэмт хэргийг илрүүлэх аргачлал техникийг сайжруулах, гэмт хэрэг болон өсвөр насныхны гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой олон төрлийн судалгаа хийгдэж байна. Зам тээврийн осол, бөглөрөл, бохирдолын эсрэг арга хэмжээ авахад мөн эдгээр нь

⁷ <http://www.nrips.go.jp/en/index.html>

⁸ As the central organization of police science in Japan, this institute is staffed with approximately 100 qualified researchers who are knowledgeable in police science. They are engaged in a broad range of analysis, identification, and research work that requires specialized knowledge and skills in biology, medicine, science, chemistry, pharmacy, physics, agriculture, engineering, sociology, education, psychology, and other disciplines. The institute has now established both a domestic and an international reputation in the field of police science.

чиглэгдэж байна. Иймээс хүрээлэнгийн үйл ажиллагааны цар хүрээ байнга өргөжсөөр байна.⁹

Задлан шинжлэх, танин тогтоох ажил

Гэмт хэргийг шинжлэх ухааны арга хэрэглэн мөрдөхөд дэмжин тусалдаг тус хүрээлэн нь байгуулагдсан цагаасаа гэмт хэргийн ул мөр, нотолгоог шинжлэн, танин явдлыг үндсэн үүргээ болгон ажиллаж ирсэн билээ. Эдгээр ажлыг бид цагдаагийн газраас, мөн шүүх прокурорын газраас хүрээлэн авдаг. Хуурамчаар үйлдсэн бүх мөнгөн дэвсгэрт, гэмт хэрэгтэй холбоотой галт зэвсэг, сум зэргийг зөвхөн манай хүрээлэнд нарийвчлан шинжилдэг. Гэмт хэрэгтнүүдийг шүүхээр тогтоох ажилд ийнхүү чухал хувь нэмэр оруулж байна.¹⁰

Сургалт

Шинжлэх ухаан технологийн салбарт гарч буй хурдацтай хөгжлөөс үүдэн, шинжлэх ухааны аргаар гэмт хэрэг мөрдөх ажиллагааг шинэчлэн сайжруулж стандартчилах шаардлага тулгараад байна. Иймээс орон даяарх мужийн цагдаагийн газрын лабораторид ажилладаг шинжээчдийг Шүүхийн шинжилгээний сургалтын төвд урьж, шүүх шинжилгээний гол салбаруудыг хамарсан цуврал сургалтын курс зохион байгуулдаг. Сургалтын төв нь хөгжиж буй орны шинжээчдэд зориулан танин тогтоох арга техникийг сайжруулах хэд хэдэн олон улсын семинар зохион байгуулдаг. Тус төвийн шинжээчид орон нутгийн цагдаа нарт зориулж семинар зохиодгоос гадна хавтаст хэргүүдтэй нь холбоотой асуудлаар зөвлөгөө өгч, аргачлалаа сайжруулахад нь дэмжин ажилладаг.¹¹

Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс:

Шүүхийн шинжилгээний тухай хууль ИБУИНВУ-ын Гэмт хэргийн /Шүүхийн шинжилгээний

/хууль нь 2001 оны 1 дүгээр сарын 1-нд батлагдан гарсан. Энэхүү хууль нь сэжигтэнд шүүхийн шинжилгээг хийх журмыг хуульчлан тогтоож өгсөн ба ноцтой хэмжээнд авч хэлэлцэгдэх гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээдэд шүүхийн шинжилгээг хийх ба мөн сайн дураар шүүхийн шинжилгээг хийлгэж болох талаар заасан байдаг.

2003 онд энэхүү Шүүхийн шинжилгээний хуульд нэмэлт, өөрчлөлт орсон.

Цагдаагийн байцаан шийтгэх ажиллагаанд энэхүү Шүүхийн шинжилгээний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай давхцан мөн нэмэлт, өөрчлөлт орсон байдаг. Энэхүү хууль нь сэжигтэнд шүүхийн шинжилгээ хийх талаар тус хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тодорхойлохдоо:

1. гэмт хэрэг үйлдсэн газар дээрээ цагдаагийн ажилтанд сэжиглэгдэн баривчлагдсан этгээд;

2. гэмт хэрэгт ямар нэгэн байдлаар холбогдсон этгээд;

3. хэн нэгэн этгээдийн мэдүүлгээр гэмт хэрэгт холбоотой гэж шалгагдаж байгаа этгээд.

Гэмт хэргийн /Шүүхийн шинжилгээний тухай/ хуулийн 353.А зүйлд хууль ёсоор баривчлагдсан этгээдээс цусны шинжилгээ, шүлс болон үсний дээж авах тухай заасан.

Шүүхийн шинжилгээг явуулах хэлбэр.

Энэ хууль нь сэжигтэнд хийх шүүхийн шинжилгээний ажиллагааг 3 хэлбэрт хувааж

үзсэн байдаг.

- Биеийн ил хэсэгт хийх шинжилгээ /хуруу, гарын алганы хээ, биеийн нууц хэсэг хамаарагдахгүй үс, хумснаас авах шинжилгээнүүд байдаг/

- Далд хэсэгт хийх шинжилгээ/ цуснаас авах шинжилгээ, шүдний мөр гэх мэт/

- Хөвөн, марль зэргээр хийх арчдасын шинжилгээ

Шүүхийн шинжилгээг хийх журам:

Хуулийн дагуу сэжигтэнд шүүхийн шинжилгээг хийлгэх асуудлыг ахлах мөрдөн байцаагчийн тогтоолоор онцгой тохиолдолд шүүхийн зөвшөөрлөөр хийдэг байна. Мөн сэжигтэн этгээдээс зөвшөөрөл авахын өмнө мөрдөн байцаагч дараах зүйлийг тодруулсан байх ёстой байдаг.

1. Сэжигтэн этгээдээс шүүхийн шинжилгээг авахдаа тухайн этгээд гэмт хэрэгт холбогдсон байх ёстой байдаг.

2. Мөн насанд хүрээгүй этгээд болон мөн хэрэг харуцах чадваргүй этгээд биш гэдгийг нь тодруулах, Хэрвээ ийм этгээдүүд байвал шүүхийн шинжилгээг зөвхөн шүүхийн зөвшөөрлөөр хийдэг байна.

3. Шүүхийн шинжилгээг хийснээр тухайн сэжигтэн гэмт хэрэг үйлдсэн эсвэл гэм буруугүй этгээд юм уу гэдгийг нь нотлох ноцтой учир шалтгаан байгаа бол.

4. Зөвшөөрлийн хүсэлт тавьсан байдал нь бүхий л нөхцөл байдалд шалгагдсан байх.

Бүх шүүхийн шинжилгээг хийх гэж байгаа сэжигтэн этгээд

⁹ Research and Development: Numerous research projects are drawn up every year to cope with a growing number of crimes and accidents brought about by diversified social and economic statuses. In accordance with these projects, a variety of research is undertaken to improve criminal investigation techniques and to prevent crime and juvenile delinquency. They are also designed to implement countermeasures for traffic accidents, traffic congestion and pollution. The work of this institute is inevitably broadening scope.

¹⁰ Analysis and Identification: From the viewpoint of promoting scientific criminal investigation, the analysis and identification of criminal evidence has been the fundamental objective of this institute ever since its establishment. Such analysis and identification is requested not only by the police organization, but also by the courts and the public prosecutor's office. All counterfeit currencies discovered and firearms and bullets seized in connection with crimes are exclusively and systematically analyzed at this institute. In this respect, the institute is greatly contributing to the arraignment of criminals in courts of justice.

¹¹ Training: In view of the rapid progress in science and technology, it is of paramount importance to innovate and standardize the techniques of scientific criminal investigation based on sound principles of methodology. For this reason, a series of training courses in major fields of forensic science is provided at the Training Center of Forensic Science for all scientists in Prefectural police laboratories nationwide. The Training Center also hosts several international seminars to help developing countries improve their identification techniques. The researchers also help local police scientists improve their techniques by advising them on cases and by hosting seminars.

дүүдэд шинжилгээний үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг өгсөн байх, гэмт хэрэгт хэрэгт холбоотой учраас шалгагдаж байгаа боловч тагталзах эрхтэй гэдгийг нь тайлбарлан өгөх зорилгыг агуулдаг.

Сэжигтэнд хүмүүстэй харилцах болон хувиараа ажилладаг хуульчид хандах үндэслэлтэй боломжийг олгох ёстой¹².

Хэрвээ баривчлагдсан сэжигтэн этгээд зөвшөөрөхгүй байгаа тохиолдолд ахлах мөрдөн байцаагч биеийн ил хэсэгт хийх шүүхийн шинжилгээг явуулах зөвшөөрөл өгдөг ба харин түүнээс өөр шүүхийн шинжилгээ хийгдэх бол шүүхийн тогтоолыг авах хэрэгтэй болдог.

Ингэхдээ ахлах мөрдөн байцаагч биеийн ил хэсэгт хийх энэхүү шинжилгээний зөвшөөрөл өгөхийн өмнө дараах зүйлийг тогтоосон байх шаардлагатай.

- Сэжигтэн хууль ёсны дагуу баривчлагдсан байх;

- Сэжигтэн нь насанд хүрээгүй болон хэрэг хариуцах чадваргүй этгээд биш байх;

- Тухайн сэжигтэн этгээд гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх хангалттай үндэслэл, шалтгаан байгаад итгэлтэй байх;

- Шүүхийн шинжилгээг тухайн этгээдэд хийснээр сэжигтэн этгээд гэм буруутай эсвэл гэм буруугүй гэдгийг тодруулах нотлох баримтыг бий болгох үндэслэлтэй шалтгаан байгаа гэдэгт итгэлтэй байх;

- Шүүхийн шинжилгээг зөвшөөрөлгүйгээр хийж байгаа бүхий л нөхцөл байдлыг баталсан байх хэрэгтэй.¹³

Зөвхөн шүүхийн тогтоолоор хийгддэг дараах шинжилгээнүүд байдаг. Үүнийг тус хуулийн 8 дугаар зүйл болон 23 дугаар зүйлд заасан байдаг.

- Насанд хүрээгүй этгээд болон хэрэг хариуцах чадваргүй этгээдэд хийх ямар нэгэн шинжилгээ,

- Цагдан хоригдоогүй байгаа сэжигтэн этгээдээс шинжилгээ хийлгэх зөвшөөрөл өгөхгүй байх

тохиолдолд хийх ямар нэгэн шинжилгээ;

- Биеийн далд хэсгийн болон арчдасын шинжилгээ хийлгэхийг цагдан хоригдож байгаа этгээд зөвшөөрөхгүй байх үед хийх шинжилгээ.

Шүүхийн тогтоол гаргах шүүгчийн шалгуур нь ахлах мөрдөн байцаагчийн тодруулдаг асуудлууд мөн гарч ирнэ. Тухайлбал, тухайн этгээд нь сэжигтэн байх, шүүхийн шинжилгээ хийх зайлшгүй үл үндэстэй шалтгаан байгаа гэдэгт итгэлтэй байх, шүүхийн шинжилгээг хийснээр тухайн этгээдийг гэм буруутайг нотлох болон гэм буруутайг үгүйсгэх нөхцөл байдлыг бий болгох мөн шүүхийн шинжилгээний үйл ажиллагаа нь бүхий л нөхцөл байдалд шалгагдсан байх ёстой гэх мэтчилэн.¹⁴

Мөн энэхүү шүүхийн тогтоолыг сэжигтэн давж заалдах гомдол гаргах эрхийг нь хуулийн 115.А-д заасан байна. Хуулийн 50 дугаар зүйлд зааснаар биеийн далд хэсэгт хийх шинжилгээг сэжигтэн этгээдтэй ижил хүйсийн хүн хийдэг байна.

Австрали:
АХУ¹⁵-ын Тасмани¹⁶
мужийн Шүүх шинжилгээний байгууллагын бүтэц зохион байгуулалт, тогтолцоо, хууль тогтоомжийн талаар хийсэн тойм судалгаа

Тасмани мужийн шүүхийн шинжилгээний байгууллагын зохион байгуулалт - Тасманий мужийн Шүүх шинжилгээний байгууллага нь Цагдаагийн болон Онцгой байдлын яамны Шүүх шинжилгээний үйлчилгээ үзүүлдэг, уг яамны бүрэлдэхүүнд байдаг. Цагдаагийн болон онцгой байдлын яамны бүрэлдэхүүнд байдаг Шүүх шинжилгээний байгууллага нь

хими, биологи зэрэг төрөлжсөн үйлчилгээг төрийн болон орон нутгийн байгууллага, агентлаг, үйлдвэрийн салбар болон нийтэд төлбөртэй үндсэн дээр шинжилгээ хийдэг байна.

Одоогийн байдлаар цагдаагийн болон онцгой байдлын яамны дэргэдэх шүүхийн шинжилгээний байгууллага нь өөрийн түүхэнд хэд хэдэн удаа бүтцийн өөрчлөлт хийж, 2000 оноос эхлэн тус байгууллага нь Тасманий шүүх шинжилгээний гэсэн нэртэйгээр Цагдаагийн болон онцгой байдлын яамны харьяанд шилжин ирсэн байна. Уг байгууллага нь Цагдаагийн байгууллагад үндсэн туслалцаа үзүүлдэг байгууллага мөн бөгөөд бусад төрийн болон хувийн, нийтэд үйлчилгээ үзүүлдэг байгууллага юм. Шүүхийн шинжилгээний байгууллагын захирал нь Төрийн нарийн бичгийн дарга, Цагдаагийн болон Онцгой байдлын яаманд тайлангаа танилцуулдаг байна.

Шүүх шинжилгээний байгууллагын дотоод бүтэц:

- Захиргаа;
- Хими шинжилгээ;
- Биологийн шинжилгээ;
- ДНК;

Шүүх шинжилгээний байгууллагыг Захирал удирдах бөгөөд уг хэсэг нь гэмт хэрэг гарсан газар дараах чиглэл, төрлийн шинжилгээний ажлыг хийдэг байна. Үүнд:

- Баллистик;
- Баримт бичгийн;
- Уламжлалт гарын хээ;
- ДНК-ийн шинжилгээ;
- Гэрэл зураг.

Хэргийн газарт үзлэг хийх нь гэмт хэргийн илрүүлэх чухал бүрэлдэхүүн хэсэг байдаг бөгөөд үүнд шүүх шинжилгээний байгууллагын хувь нэмэр нэн чухал гэж үздэг байна.

Шүүхийн шинжилгээний журмын хуулийн тойм

Австралийн Холбооны улсын муж бүр шүүхийн шинжилгээний журмын тухай хуультай бөгөөд

¹² Хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг болон 10 дугаар зүйлийн 6 дахь хэсэг

¹³ Хуулийн 20 дугаар зүйл

¹⁴ Хуулийн 25 дугаар зүйл

¹⁵ Австралийн Холбооны Улс

¹⁶ Тасмани нь Австралийн Холбооны улсын муж болно.

зарим муж нь шүүхийн шинжилгээний журмын тухай хуулийг бие даасан байдлаар гаргасан байхад зарим муж нь эрүүгийн хуулийн тусгай хэсэг, бүлэг болгон шүүх шинжилгээний журмын ажлыг зохицуулсан байна. Хууль зүй болон Үйлдвэрийн яам нь Цагдаагийн болон онцгой байдал, түүний харьяа шүүхийн шинжилгээний байгууллагыг бодлого, арга зүйн удирдлагаар хангах зэрэг үндсэн чиг үүрэг хэрэг-жүүлж байна.

Шүүхийн шинжилгээний журмын тухай хуулийн тухайд

Ерөнхий зүйл

Тасманий шүүхийн шинжилгээний журмын тухай хууль¹⁷ 2000 онд батлагдсан бөгөөд уг хуулийн гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээд болон хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээд, цагдаагийн байгууллагад гэмт хэргийг илрүүлэхэд туслалцаа үзүүлэхэд шүүхийн шинжилгээ хийх үндэслэл, журмыг тодорхойлсон байна. Хуульд зааснаар шүүхийн шинжилгээ нь биед болон биед бус гэсэн төрөлд хуваадаг байна.

Хуулиар тогтоосон хязгаарлалт

Хуульд шүүхийн шинжилгээг гэмт хэргийн хохирогч болон 10 доош настай хүүхдэд шүүхийн шинжилгээ хийхийг хориглосон байдаг. Мөн Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны явцад хийсэн гэрэл зураг болон видео бичлэг хамаарахгүйгээр хуульд заасан байна.

Шүүхийн шинжилгээ хийх нөхцөл

Хэрвээ сэжиглэгдэж байгаа болон эрүүгийн хэргийн сэжигтэн 15 доош настай байвал шүүхийн шинжилгээ явуулах зөвшөөрлийг түүний эцэг эхээс авсан байна. Хэрвээ хүүхдийн эцэг, эх шинжилгээ явуулах зөвшөөрөл өгөхгүй бол шүүхэд хандаж шүүхээс шинжилгээ явуулах шийдвэр гаргуулсан байна.

Шүүхийн шинжилгээг явуулах журам

Шүүхийн шинжилгээг явуулах ажиллагаа нь этгээдийн нууцлалыг хадгалсан нөхцөл явагдах бөгөөд эмнэлгийн стандартын дагуу явагдана.

Шүүхийн шинжилгээг зөвшөөрөлтэй этгээд явуулна. Хуульд шүүхийн шинжилгээг явуулах жагсаалт, мөн шинжилгээ явуулах эрх бүхий этгээдийн талаар зохицуулсан байна. Үүнд ерөнхийд нь эмнэлгийн ажилтан, шүдний эмч, сувилагч болон зарим тохиодолд цагдаа-гийн ажилтан байна.

Шүүхийн шинжилгээнд 15-аас доош насны хүүхэд орж байгаа бол түүний эцэг, эхийг заавал байлцуулсан байна. Хэрвээ эцэг, эх нь байлцах боломжгүй бол цагдаагийн ажилтан, сэжигтэн биш 18 дээш насны хөндлөгийн этгээдийг байлцуулан шинжилгээнд оруулсан байна.

Хуульд заасны дагуу шүүхийн шинжилгээний аюулгүй байдал, нууцлал, нотлох баримтыг хамгаалах, мөрдөн шалгалт болон шүүхийн шинжилгээг үр дүнтэй явуулах зорилгоор Цагдаагийн ажилтан шинжилгээний үед байлцаж болно.

Хүч хэрэглэх журам

Хэрвээ хуулиар тухайн төрлийн шүүхийн шинжилгээ авахаар зөвшөөрөгдсөн бол шинжилгээ явуулах эрх бүхий зөвшөөрөлтэй этгээд болон цагдаагийн ажилтан шүүхийн шинжилгээ явуулах тохирсон, боломжит арга хэрэгслээр шинжилгээг явуулж, шинжилгээний дээж устаж алдагдахаас урьдчилан сэргийлсэн байна.

Шүүхийн шийдвэр гаргуулах

Цагдаагийн ажилтан сэжиглэгдэж буй этгээд болон эрүүгийн хэрэгт татагдсан сэжигтний биед үзлэг хийх болон бусад төрлийн шүүхийн шинжилгээ явуулах, зөвшөөрөл олгох асуудлаар шүүхэд хандаж

захирамж гаргуулна. Мөн шүүхийн шинжилгээнд орж буй этгээд 15-аас доош настай байвал мөн шүүхээс шүүхийн шинжилгээ явуулах талаар захирамж гаргуулсан байна. Хуулийн шаардлагыг хангаж байгаа нөхцөлд шүүх захирамж гаргана.

САНАЛ, ДҮГНЭЛТ

Хуулийн байгууллагуудын гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиг үүргээ хэрэг-жүүлэх үүднээс шинэлэг үзэл баримтлалаар эрх зүйн зохицуулалт хийх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Өөрөөр хэлбэл, шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо, үйл ажиллагаа, шинжээчийн эрх зүйн байдлыг "хараат бус" байдлаар хуульчлах шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

1. Шүүхийн шинжилгээний тухай хуулийг батлан гаргах;
2. Шүүхийн шинжилгээний тухай хуульд шинжилгээний байгууллагын эрх зүйн байдал, бүтэц зохион байгуулалтыг оруулж өгөх;
3. Шинжилгээний байгууллагын хийх шинжилгээний төрлийг заах;
4. Шинжээч гэдэг ойлголтыг хуульд зааснаар биш илүү өргөн практик үйл ажиллагааны хүрээнд тодорхойлж өгөх.

Хохирлын хэмжээг тогтоох, үнэлэх талаар

Судалгаагаар байцаан шийтгэх ажиллагааны явцад гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг тогтоох буюу үнэлэх ажиллагаа зохих журмын дагуу хийгддэггүй, хамгийн төлөвшсөн гэж үзэх боломжтой эд хөрөнгийн үнэлгээ хийх аргачлал, журам байдаггүй, эрх зүйн зохицуулалт нь боловсронгуй биш учраас хохирлын хэмжээг тогтоох, үнэлэх ажиллагаа бэрхшээлтэй, шийдвэрлэхэд төвөгтэй тулгамдсан асуудлын нэг болох нь тодорхойлогдсон.

¹⁷ Тасманий Шүүхийн шинжилгээний журмын тухай хууль нь 2000 онд хүчин төгөлдөр болсон бөгөөд уг хууль 68 зүйл, заалт бүхий хууль байдаг.

Ялангуяа Шүүхийн шинжилгээний тухай хуулийг батлан гаргах шаардлагатай байгаа нь судалгаанаас харагдаж байна гэж дүгнэв.

Зохион байгуулалтын хүрээнд:

1. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын зэрэг, шинж байдлыг иж бүрэн тогтоох шинжилгээний байгууллага бий болгох, энэ чиг үүргийг Шүүхийн шинжилгээний үндэсний төвд хариуцуулах;

2. Гадаадын орнуудын шүүхийн шинжилгээ явуулж буй жишгийг шүүхийн шинжилгээний


хууль батлахдаа харгалзан үзэх жишээ нь зарим оронд цагдаагийн байгууллагын харъяанд байхад зарим оронд хараат бус бие даасан хэлбэртэй байдаг. Түүнчлэн хууль тогтоомжоор үйл ажиллагаа зохицуулдаг байхад нөгөө хэсэг нь журмаар үйл ажиллагаа зохицуулдаг байна.

3. Шинжээчийг илүү олон төрлийн салбарын мэргэжилтнүүдээс бүрдүүлэх, шинжилгээ хийх төрлийг олшруулах, албан хаагчдыг бэлтгэх сургах, дадлагажуулахад анхаарах

4. Шинжилгээ хийж байгаа албан хаагч нь цагдаагийн алба хаагчийн нэгэн адил захирах,

захирагдах үүрэг хүлээх нь шинжээчийн дүгнэлт гаргахад нөлөөлж болох эсэхийг харгалзах, өөрөөр хэлбэл шүүхийн шинжилгээний байгууллагыг цагдаагийн байгууллагын бүтцэд оруулах нь тэдгээрийн шийдвэр, өдөр тутмын үйл ажиллагаанд нөлөөлж болох юм.

Эцэст нь дүгнэхэд гадаадын зарим орны шүүхийн шинжилгээний байгууллагуудын хууль тогтоомж, бүтэц зохион байгуулалтын ололттой талуудыг нэвтрүүлж ажиллах нь манай улсын шүүхийн шинжилгээний байгууллагын хөгжилтөд зохих хувь нэмэр оруулах нэг "түлхүүр" юм.





ХЗҮТ-ийн Криминологийн судалгааны секторын эрдэм
шинжилгээний дэд ажилтан,
Хууль зүйн магистр Б.Одонгэрэл

ОЛОН УЛСЫН ЭРҮҮГИЙН ШҮҮХИЙН ДҮРМИЙГ МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬТАЙ ХАРЬЦУУЛАН ҮЗЭХ НЬ

Монгол Улс Олон улсын эрүүгийн шүүхийн дүрмийг¹ /цаашид Дүрэм гэнэ/ 2002 онд соёрхон баталж түүнийг даган мөрдөж, сахин биелүүлэх үүргийг хүлээсэн дэлхийн 105 улсын нэг болсон билээ. Сахин биелүүлэх үүрэг хүлээснийхээ хувьд мөн олон улсын эрүүгийн эрх зүйн жишигт дотоодын хууль тогтоомжоо хүргэх үүднээс бид Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг тусгайлан авч үзэж энэхүү дүрэмд хэрхэн нийцэж байгаа талаар өгүүлэх гэсэн билээ.

Монгол Улсын хуульд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь аливаа гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлж, гэмт этгээдийг олж тогтоох, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд зохих ялыг шударгаар ногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх явдлыг хангах зорилготой байдаг.

Харин Дүрмийн зорилго нь тус дүрмийн дагуу хэлэлцэгдэх 4 гэмт хэргийг илрүүлэх, гэмт этгээдийг олж тогтоон зохих ялыг шударга ёсны дагуу ногдуулах өөрөөр хэлбэл гэм буруутай этгээдийг ял завшуулан үлдээхгүй байх явдал юм.

Энэ зорилгоо биелүүлэхийн тулд Олон улсын эрүүгийн Шүүх нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг хэрхэн явуулах ёстойг уг дүрэмд зааж өгсөн байдаг.

Бид Ромын дүрмийн зүйл, заалттай манай улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль хэрхэн нийцэж байгаа талаар мөн нийцэхгүй байгаа зүйл заалтуудыг илрүүлэхийг зорьсон юм.

НЭГ. Мөрдөн байцаалтыг эхлэх буюу Дүрмийн 53 дугаар зүйлд зааснаар "Прокурор хэрэв энэхүү дүрмийн дагуу үйлдлийг хүлээн авах бодит үндэслэлгүй гэж тодорхойлоогүй нөхцөлд түүнд гаргаж өгсөн мэдээллийг үнэлж үзээд мөрдөн байцаалтыг эхэлнэ," гэжээ. Монгол Улсын ЭБШХ-д² "гэмт хэрэг гарсан талаар аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан мэдээлсэн, гэмт хэрэг үйлдсэн хэмээн өөрийгөө илчилж ирсэн, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор гэмт хэргийн шинж тэмдгийг өөрсдөө шууд илрүүлсэн, гэмт хэргийн талаар гүйцэтгэх ажлын шугамаар авагдаж, баримтжуулагдсан мэдээ баримт байгаа бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор эрүүгийн хэрэг үүсгэж, энэ тухай тогтоол гаргана," гэсэн байна. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрүүгийн хэрэг үүсгэсэн бол тогтоолыг 72 цагийн дотор прокурорт танилцуулж, эрүүгийн хэргийн дугаар авна. ЭБШХ-ийн 174.1.1-т "прокурор хэргийг бүртгэн, эрүүгийн хэргийн дугаар олгож хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагын аль нэгэнд мөрдүүлэхээр харъяал-лын дагуу шилжүүлэх", мөн ЭБШХ-ийн 175.1-т "Гомдол, мэдээллийг

хянах явцад эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл байхгүй, эсхүл байцаан шийтгэх ажиллагаа явуулж болохгүй нөхцөл байдал тогтоогдсон бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн саналыг үндэслэн прокурор эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах тухай тогтоол гаргана," гэсэн нь эрүүгийн хэргийг үүсгэх болон хэрэг үүсгэхээс татгалзах нь прокурорын эрх хэмжээний асуудал мөн гэж үзэх үндэслэлтэй. Иймээс Дүрмийн дээрх заалттай манай улсын холбогдох заалт нийцэж байна.

ХОЁР. Дүрмийн 67 дугаар зүйлд заасан "Яллагдагчийн эрх" гэсэн хэсэгт аливаа яллагааг тодорхойлоход яллагдагч хэргээ нийтийн өмнө хэлэлцүүлэх, шударга, аль нэг талыг барихгүй явагдах шүүх хуралдаанд орох эрхтэй. Бүрэн тэгш эрхийн үндсэн дээр яллагдагч бүрэн хэмжээгээр ойлгодог болон ярьдаг хэл дээр түүнд тулгаж байгаа яллагааны шинж чанар, үндэслэл болон агуулгын талаар дэлгэрэнгүй мэдээллийг нэн даруй авах баталгаатай байх, өөрийгөө хамгаалахад зориулсан хангалттай цаг хугацаа болон боломжтой байх, түүнчлэн сонгож авсан өмгөөлөгчтэйгээ нууцыг хадгалах нөхцөлд чөлөөтэй харилцах, зүй бус саадгүйгээр хэргээ хэлэлцүүлэх, өөрийгөө өмгөөлөхийн тулд ам тангараг өгөлгүйгээр амаар буюу бичгээр мэдэгдэл хийх гэх мэт эрхүүдийг эдэлнэ гэсэн байдаг. Тэгвэл манай улсын ЭБШХ-ийн 36 дугаар зүйлийн дагуу яллагдагч

¹ Олон улсын эрүүгийн шүүхийн дүрэм "Төрийн мэдээлэл". 2005 он, Тусгай дугаар II боть.
² Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 173 дугаар зүйл. "Төрийн мэдээлэл". 2002 он, №6

нь 18 эрх эдэлдэг.

Монгол Улсын ЭБШХ-ийн дагуу олгогдсон тэдгээр эрх нь яллагдагчийн эрхийг хангах зайлшгүй шаардлагатай эрхүүдийг заасан боловч ОУЭШД-д заасан "яллагдагч нь түүний эсрэг мэдүүлэг өгч байгаа гэрчүүдээс асуух буюу эдгээр гэрчүүдийг байцаалгах эрхтэй байх, түүнчлэн эсрэг мэдүүлэг өгч байгаа гэрчүүдийн хувьд хэрэглэдэг нөхцөлийн дагуу түүний талд мэдүүлэг өгч байгаа гэрчүүдийг дуудах болон байцаалгах эрхтэй" гэсэн заалтын хувьд анхааран үзэх хоёр асуудал байгаа юм.

• "Яллагдагч нь түүний эсрэг мэдүүлэг өгч байгаа гэрчүүдээс асуух буюу эдгээр гэрчүүдийг байцаалгах эрхтэй байх" гэсэн Дүрмийн дээрх заалт нь өнөөгийн ЭБШХ-ийн яллагдагчийн эрхэд хамаардаггүй. 2002 оноос өмнө эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд яллагдагч өөрийн эсрэг болон зөрүүтэй мэдүүлэг өгч байгаа этгээдтэй нүүрэлдэх эрхтэй /1963 оны ЭБШХ-ийн 44 дүгээр зүйл/ гэсэн эрх зүйн зохицуулалт байсан тус хуулийн 162 дугаар зүйлд нүүрэлдүүлж байцаах журмын талаар "...харилцан нүүрэлдэж байгаа этгээдүүд бие биедээ асуулт тавьж болох ба..." гэсэн байна. Тэгэхлээр манай улсын 1963 оны ЭБШХ-д Дүрмийн дээрх агуулгатай нийцэх заалт байсан ба 2002 оны ЭБШХ-аар яллагдагчийн энэ эрх байхгүй болсон байна.

• "Эсрэг мэдүүлэг өгч байгаа гэрчүүдийн хувьд хэрэглэдэг нөхцөлийн дагуу түүний талд мэдүүлэг өгч байгаа гэрчүүдийг дуудах болон байцаалгах эрхтэй" гэсэн Дүрмийн тус заалттай ЭБШХ-ийн 36 дугаар зүйлийн 3.7-д заасан "яллагдагч баримт сэлт гаргаж өгөх, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах эрхтэй" гэсэн заалт илүү ойр очиж байна гэж үзэх, өөрөөр хэлбэл түүний талд мэдүүлэг өгч байгаа гэрчийн мэдүүлгийг яллагдагчийн "нотлох

баримт шалгуулах хүсэлт гаргах эрх"-д хамруулан ойлгож болох юм.

ГУРАВ. Хохирогч ба гэрчийн хамгаалалт болон шүүх хуралдаанд тэдгээрийн оролцоо гэсэн зүйлд /Дүрмийн 68 дугаар зүйл/ "Шүүх хохирогч болон гэрчүүдийн хувийн амьдралын аюулгүй байдал, бие махбодийн болон сэтгэл санааны сайн сайхан байдал, нэр төр болон хувийн халдашгүй байдлыг хамгаалахын тулд шаардлагатай арга хэмжээ авна. Ингэхдээ Шүүх нас, хүйсийн хүчин зүйл болон эрүүл мэндийн байдал түүнчлэн гэмт хэргийн шинж чанар болон зөвхөн үүгээр хязгаарлахгүйгээр гэмт хэргэ нь бэлгий, хүйсийн буюу үүхдийн хохирчигийг хамарсан нөхцөл байдал зэрэг холбогдох бүх хүчин зүйлийг харгалзан үзнэ" гэсэн байдаг. ЭБШХ-ийн хохирогч /ЭБШХ-42/ болон гэрчийн /ЭБШХ-45/ эрхэд хувийн халдашгүй байдлаа хамгаалуулах эрхийг зааж өгөөгүй байдаг тул энэ заалтыг ЭБШХ-д нэн даруй нэмж оруулах нь зүйтэй байна.

ДӨРӨВ. Шүүгчдийн хараат бус байдал гэсэн Дүрмийн 40 дүгээр зүйлд шүүгчид чиг үүргээ гүйцэтгэхдээ хараат бус байж мөн өөрсдийн шүүгчийн чиг үүргээ гүйцэтгэхдээ саад учруулах буюу тэдгээрийн хараат бус байдалд эргэлзээ төрүүлж болох үйл ажиллагаанд оролцохгүй гэдгийг тодорхойлж өгсөн байдаг. ЭБШХ-ийн 15.1-д Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхэд шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захи-рагдана. 15.2-т Албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, нөлөөлхийг хорлолоно гэсэн заалтууд байдаг. ЭБШХ-ийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг "Шүүгчид өөрсдийн чиг үүргээ гүйцэтгэхдээ саад учруулах буюу тэдгээрийн хараат бус байдалд эргэлзээ төрүүлж болох үйл ажиллагаанд оролцохгүй" гэсэн заалттай бүрэн нийцэж

байна гэж үзэх нь учир дутагдалтай тул Дүрмийн тус заалтыг ЭБШХ-ийн 15 дугаар зүйлд нэмж оруулах нь зүйтэй байж болох юм.

ТАВ. Нотлох баримтын тухай "талууд хэрэгт холбогдолтой нотлох баримт гаргаж болох ба шүүх үнэнийг тогтоохын тулд зайлшгүй шаардлагатай гэж үзсэн бүх нотлох баримт гаргаж өгөхийг шаардах эрхтэй" гэж Дүрмийн 69 дүгээр зүйлд заасан байдаг. Мөн "Шүүх Дэгийн болон нотолгооны журмын дагуу нотлох баримтын шинж чанар, түүнчлэн шударга шүүх хуралдаан хийх буюу гэрчийн мэдүүлгийг шударгаар үнэлэхэд хохирол учруулж болох тийм нотлох баримтын анхааралдаа авах замаар аливаа нотлох баримтын хамаарал болон хүлээн авч болох эсэх тухай шийдвэр гаргаж болно" гэсэн байна. ЭБШХ-ийн 79 дүгээр зүйлд "Нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх талаар хуульд заасан журмыг баримтлаагүй буюу зөрчсөн бол эдгээр нь нотлох чадвараа алдах бөгөөд шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй." гэсэн байна.

ЭБШХ-ийн 84 дүгээр зүйлд "Гэрч нь хэргийг нотлоход хамааралтай бүхий л байдал, түүний дотор сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн хувийн байдал, түүнчлэн түүнтэй ямар харилцаатай болох тухай асуудлаар үнэн зөв мэдүүлэг өгөх үүрэгтэй." гэсэн байдаг бол ЭБШХ-ийн 90 дүгээр зүйлд "Энэ хуулийн 93 дугаар зүйлд заасны дагуу олж авсан, гаргаж өгсөн соронзон болон дүрс бичлэг, гэрэл зураг нь баримт бичигт хамаарна" /ЭБШХ-ийн 90.3/ гэжээ.

ЭБШХ-д сэжигтэн баримт сэлт гаргаж өгөх, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах /ЭБШХ-ийн 35.2.3/, яллагдагч баримт сэлт гаргаж өгөх, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах, /ЭБШХ-ийн 36.3.7/ шүүгч, иргэдийн төлөөлөгч нотлох баримтыг шинжлэхэд оролцож, аль ч үед тодруулах

асуулт тавих эрхтэй /ЭБШХ-ийн 261.3/ гэсэн байдаг. Иймд Дүрмийн 69 дүгээр зүйлийн нотлох браимтын талаарх заалтуудтай ЭБШХ-ийн холбогдох заалтууд нийцэж байна.

ЗУРГАА. Дүрмийн 85 дугаар зүйлийн **“Баривчлагдсан буюу гэм буруутай этгээдэд нөхөн төлбөр төлөх”** гэсэн заалтын дагуу хууль бусаар баривчлагдсан буюу хоригдсоны золиос болсон хүн бүр нөхөн төлбөр авах эрхтэй ба хэрэв ямар нэгэн этгээд гэм буруутай гэж тооцогдож гаргасан шийтгэх тогтоол нь шинэ буюу шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн алдаа болох нь нотлогдон өөрчлөгдсөн бол хуулийн дагуу нөхөн олговрыг авна гэсэн байдаг. Мөн онцгой тохиолдолд Шүүх шүүхийн бүдүүлэг бөгөөд гарцаагүй алдаа байсныг гэрчлэх маргаашгүй баримт илрүүлээд хэргийг хэрэгсэхгүй болгох буюу шүүн таслах ажиллагааг зогсоох тухай эцсийн шийдвэр гаргавал өөрийн үзэмжээр нөхөн олгохоор шийдвэрлэж болно гэжээ. Тэгвэл энэхүү заалтын талаар манай улсын хуульд заахдаа “Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харъяалалгүй хүн нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохирлоо нөхөн төлүүлэх, сэтгэл санааны үр дагавраа арилгуулах болон тэтгэвэр, тэтгэмж авах, орон сууц эзэмших хийгээд бусад эрхээ нөхөн сэргээлгэх эрхтэй /ЭБШХ-381.1/” гэсэн байна. Хохирол нөхөн төлүүлэх эрх нь баривчлагдсан буюу цагдан хоригдсон этгээд гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс суллагдсан, тухайн иргэнийг цагаатгасан шүүхийн тогтоол гарсан, тухайн хэрэг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, эсхүл тухайн этгээд гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс хэргийг хэрэгсэхгүй болго-сон, эмнэлгийн чанартай албад-лагын арга хэмжээ хэрэглэх тухай

шүүхийн хууль бус тогтоолыг хүчингүй болгосон бол үүснэ /ЭХ-ийн 389.21-389.2.4/ гэсэн нь байдаг ч “гаргасан шийтгэх тогтоол нь шинэ буюу шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн алдаа болох нь нотлогдон өөрчлөгдсөн болон онцгой тохиолдолд Шүүх шүүхийн бүдүүлэг бөгөөд гарцаагүй алдаа байсныг гэрчлэх маргаашгүй баримт илрүүлээд хэргийг хэрэгсэхгүй болгох буюу шүүн таслах ажиллагааг зогсоох тухай эцсийн шийдвэр гаргавал өөрийн үзэмжээр нөхөн олговор олгохоор шийдвэрлэж болно” гэсэн Дүрмийн заалтыг анхааран үзэх нь зүйтэй.

ДОЛОО. Давж заалдах хэргийн талаар мөн ОУЭШРД-ийн 84 дүгээр зүйлд “Гэм буруутай гэж тооцогдсон буюу түүнийг нас барсны дараа эхнэр болон нөхөр, хүүхэд нь буюу эцэг эх, эсхүл яллагдагч нас барах үед хамт амьдарч байсан бөгөөд түүнд тийм нэхэмжлэл гаргах талаар бичгээр тодорхой чиглэл өгсөн этгээд буюу гэм буруутай хэмээн тооцогдсон этгээдийн нэрийн өмнөөс Прокурор шийтгэсэн буюу ял ногдуулсан тогтоолыг буюу эцсийн шийдвэрийг хянан үзэх тухай хүсэлтийг Давж заалдах шатны танхим гаргаж болно” гэсэн байдаг. Гэхдээ шүүх хуралдааны үед байгаагүй бөгөөд байгаагүйн хариуцлагыг хүсэлт гаргасан тал хариуцах ёсгүй, мөн тэдгээрийг шүүх хуралдааны явцад гаргасан бол өөр шийдвэр гаргахад хүргэх байсан нэлээд чухал баримт, шүүх хуралдааны явцад анхаа-ралд авсан бөгөөд түүнийг шийтгэсэн тогтоол гарахад нөлөө үзүүлсэн нотлох баримт нь худал буюу зохиомол болохыг нотолсон шинэ баримтууд илэрсэн бол, шийтгэх тогтоол гаргах буюу яллаагаар батлахад оролцсон нэг буюу хэд

хэдэн шүүгч хэргийг хянан хэлэлцэх явцад тэр шүүгч буюу шүүгчдийг албан тушаалаас нь огцруулах үндэслэл болоход хангалттай хэмжээний хүнд байдлаар өөрийн үүргээ ноцтой зөрчсөн бол гэсэн үндэслэлүүд байгаа тохиолдолд Прокурор давж заалдах хүсэлтийг гаргадаг.

Манай улсын ЭБШХ-ийн 303.1-д “Ялтан, хохирогч, тэдгээрийн өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч шүүхийн тогтоолд давж заалдах гомдол гаргах, улсын яллагч, дээд шатны прокурор эсэргүүцэл бичих эрхтэй.” гэсэн байдаг. Дүрмийн дагуу Прокурор давж заалдах хүсэлт гаргадаг бол манай эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд прокурор эсэргүүцэл бичих эрхтэй байдаг байна. Иймээс эдгээр ойлголт нь зөрүүтэй байгаа хэдий ч оролцогч улсуудын дотоодын шүүх нь Олон улсын эрүүгийн Шүүхээс бүтэц, зохион байгуулалтаар өөр байж болохыг Дүрмээр хориглоогүй байдаг юм.

НАЙМ. Дүрмийн 100 дугаар зүйлд **Шүүхийн зардлын** талаар өгүүлсэн байна.

Монгол Улсын ЭБШХ-д³ заасан байцаан шийтгэх ажиллагааны зардлын тухай заалт нь Дүрмийн энэ тухай заалттай үндсэндээ нийцэж байх боловч Монгол Улсын ЭБШХ-д гэрч, хохирогч, шинжээчдийг хамгаалах тухай зохицуулалт байдаггүйтэй холбоотойгоор Дүрэмд заасан гэрч, шинжээчдийн болон тэдгээрийн аюулгүй байдлыг хангахад гарсан зардлыг шүүхийн зардалд багтаан заагаагүй байна. Монгол Улсын ЭБШХ-д дээр дурдсанаар “Гэрч, хохирогч, шинжээчийг хамгаалах, тэдэнд туслалцаа үзүүлэх” тухай зохицуулалт нэмж оруулахын хамт тэдний аюулгүй байдлыг хангах, хамгаалахад төлсөн зардлыг шүүхийн зардалд оруулан хуульчлах нь зүйтэй байна.

³ Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 99 дүгээр зүйл, “Төрийн мэдээлэл”, 2002 он, №6



Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн
багш Х.Цогзолмаа

НОТАРИАТЫН ТҮҮХЭН ХӨГЖЛИЙГ ХАРЬЦУУЛАН СУДЛАХ НЬ

НОТАРИАТЫН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ, ТОГТӨЛЦОО

1. Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуулийг бүх нийтээрээ даган мөрдөж, хууль ёсыг хэрэгжүүлэхэд нотариатын байгууллага нь чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд нотариатчийн хувьд эрх зүйн харилцаанд оролцогчдын үйл ажиллагааг хуульд нийцүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэн цагаас эрх зүйн тогтолцоо ч өөрчлөгдөн хөгжихийн зэрэгцээ үл хөдлөх эд хөрөнгө эдийн засгийн харилцаанд орж, Монгол Улсын иргэд үл хөдлөх хөрөнгө, түүний дотор газар өмчлөх асуудлыг цэгцлэх харилцааг зохицуулахад нотариатын гүйцэтгэх чиг үүрэг өсөн нэмэгдсээр байна.¹

Энэ ч утгаараа нотариат нь эдийн засгийн харилцаанд тогтвортой, эрсдэлгүй аюулгүй байдлыг хангах замаар эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх, эрх чөлөөг ханган баталгаажуулах үүргийг төрийн нэрийн өмнөөс хэрэгжүүлж буй утгаараа төрийн эрх мэдэл хуваарилах тогтолцоонд онцгой чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Нотариатын байгууллагын үүсэл хөгжлийг нийгмийн харилцааны объектив шалтгаан нөхцөлтэй холбон тайлбарладаг бөгөөд орчин үеийн агуулгаараа эртний Ромд үүсч, хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг хэв шинжээр нь шүүхийн байгууллагын дараа үүсэн бий болсон анхны

хуульчийн мэргэжил хэмээн үздэг.² Дэлхийн түүхийн эх сурвалжуудаас үзвэл нотариатын үүсэл хөгжил нь эдийн засгийн харилцааны хөгжил, гэрээ хэлцлийн аюулгүй, гарцаагүй, тодорхой байдлыг хангах зорилготой шууд холбоотой бөгөөд хэлцлийн талууд өөрсдийн хүсэл зоригийг бичмэл хэлбэрт оруулж, улмаар түүнийг хараат бус бие даасан мэргэжлийн байгууллагаар гэрчлүүлснээр ирээдүйд бий болох тодорхой бус үр дагавараас өөрсдийгөө хамгаална гэсэн үзэл хандлагатай холбон тайлбарлаж байжээ.³

Нотариатчийг түүхийн эхэн үед бичээч, шүүхийн туслах гэсэн утгаар ойлгож байжээ.⁴ Энэхүү институт нь тухайн үеийн магистрат болон шүүхийн гаргасан шийдвэрийг хэлбэржүүлэн баталгаажуулах чиг үүргийг гүйцэтгэж байсан бөгөөд нийтийн болон хувийн бичээч гэсэн төрөлтэй байсан. Хувийн бичээч *[exceptores et notarii]* нь баян чинээлэг Ромчуудын удирдлагаас шууд хараат байж, тэдний хүсэл зоригт нийцүүлэн ажилладаг байсан бол нийтийн бичээч буюу *[scribae]* нь төрийн

албанд харьяалагддаг байснаараа нэлээд онцлогтой. Тэдгээрийг Ромын үндсэн иргэдийн дундаас магистрат бүх насаар нь томилдог байжээ. Нийтийн эрх зүйн бичээч (*Scribae*) нь төрийн албан хаагч болохын хувьд магистратаас гаргасан нийтийн эрх зүйд хамаарах шийдвэр (*tabulae publicae*), захирамжуудыг бэлтгэж, тэдгээрийг бүртгэн данслах, хадгалах үүрэгтэй байсан бол харин шүүхийн байгууллагын тогтолцоонд хамаарахын хувьд шүүх хуралдааны тэмдэглэлийг хөтөлдөг байжээ.⁵

Гэвч дээрх бичээч нараас гадна эрх зүйн баримт бичиг болон хэлцэл нь хуульд заагдсан хэлбэр болон агуулгын шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянах, тэдгээрийг хууль ёсны болгон хэлбэржүүлэх чиг үүрэг бүхий табеллион хэмээх албан тушаалтан үйл ажиллагаа явуулж байсан нь хожмын нотариатын байгууллагын эцэг хэмээн нэрлэгдэх болжээ.⁶

Тэрээр төрийн алба болон хэн нэгэн өмч хөрөнгөтнөөс хараат бусаар үйл ажиллагаа явуулдаг эрх чөлөөт иргэд байснаараа дээрх бичээч нараас

¹ Монгол Улсад нотариатын байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ойд зориулан Монгол Улсын Их Хурлын дарга Ц.Нямдоржийн илгээсэн илгээлт.

² www.notariat.ru/Официальный сайт негбюджетного нотариата Российской Федерации/ -

³ О.Ю.Гаверилова, Понятие и характер нотариальных функций, Нижний Новгород-2004 г., С.тр.4

⁴ www.en.wikipedia.org/wiki/Notary

⁵ www.garant-e.ru/index.php/article/archive/192/ - Ляпишевский Н. История нотариата. - Москва: университетская типография, 1875 г.

⁶ www.notariat.ru/Официальный сайт негбюджетного нотариата Российской Федерации/ -

Из мировой истории нотариата

нэлээд ялгаатай байсан ч түүний үйл ажиллагаанд төрийн байгууллагын зүгээс хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлдэг байв.

Табеллион нь төрөөс тогтоосон тодорхой хөлстэйгээр шүүхийн баримт бичиг болон хууль зүйн бусад баримтыг гэрчилдэг байснаараа хэрэгжүүлж буй чиг үүргийн хувьд төрөөс хараат бус, харин үйл ажиллагааныхаа арга хэлбэрийн хувьд төрөөс харьцангуй хамааралтай байжээ.⁷

Харин IV зуунаас хойш сүм хийд нийгэм, улс төрийн амьдралд удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэх болсонтой холбогдон сүм хийдийн нотариат гэсэн ойлголт шинээр бий болж, үүнээс хойш нотариатын чиг үүргийг төрийн байгууллагын чиг үүрэгтэй холбон тайлбарлах болжээ.

Энэ үед нотариат нь хууль зүйн баримт бичиг болон сүм хийдийн шийдвэрийг хуулбарлах, шашны дээд хэргэм зэрэгтнийг томилсон тухай актыг хууль ёсны болгон баталгаажуулах, эрх зүйн маргааныг шийдвэрлэсэн сүм хийдийн хуралдааны тэмдэглэлийг хөтлөх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлж байжээ.

Тэдгээрийн голлох үүрэг нь гэрээ хэлцэл болон сүм хийдийн удирдлагын гаргасан шийдвэрийг хууль ёсны болгон гэрчлэх, баталгаажуулах явдал байв.

Харин X зуунд дэлхийн түүхэнд өрнөсөн эдийн засгийн байгууламж, феодалын харилцааны өөрчлөлттэй холбоотойгоор нотариат нь эдийн засгийн ялангуяа хэлцлийн эрх зүйн харилцаанд гэрээ хэлцлийн агуулга болон хэлбэр нь хууль ёсны шаардлагыг хангаж байгаа эсэхэд шинжлэх ухааны үүднээс үнэлэлт дүгнэлт өгч улмаар хууль ёсны хэлцлийг гэрчлэх үүргийг хэрэгжүүлэх болсон.

Өөрөөр хэлбэл, Нотариатын чиг үүргийн өөрчлөлт нь IX-X зуунд өрнөсөн таваар мөнгөний харилцааны хөгжилтэй холбоотойгоор бий болж, хэлцлийг бүртгэснээр уг баримт бичиг нь нотлох баримтын шинжтэй болохыг хуульчилсан.

Үүний үр дүнд хууль бус агуулга бүхий хэлцлийг хязгаарлах замаар иргэний эрх зүйн харилцааны тогтвортой, зөрчилгүй байдлыг хангах боломж бүрдэх бөгөөд энэ асуудлыг шийдвэрлэх нэгэн арга зам нь тухайн харилцаа хууль ёсны дагуу явагдсан эсэхийг тогтоох үүрэг бүхий төрөөс томилогдсон нотариатыг бий болгох явдал байлаа.

Нотариатын энэхүү чиг үүргийг шүүхийн гаргасан шийдвэрийг бүртгэж, шүүхийн нарийн бичгийн чиг үүргийг хэрэгжүүлж байсан⁸ байгууллагын үйл ажиллагаатай салшгүй холбоотой хэмээн үздэг. Учир нь түүхийн эхэн үед нотариат нь шүүхийн байгууллагад хамаарагдаж, түүнээс гаргасан шийдвэрийг баталгаажуулдаг.

XI зууны үеэс нотариатын үйл ажиллагаанд нийгмийн зүгээс ихээхэн ач холбогдол өгч, нийгмийн шударга ёсны илэрхийлэл хэмээн үзэх болж, улмаар Рыцаруудтай эрх зүйн хувьд адил тэгш эрхтэй болж, шүүхийн язгууртны мэргэжилд хамаарах болсон нь хожмын Латин нотариатын бие даасан тогтолцоо үүсэн бий болох нөхцөлийг бүрдүүлсэн.⁹

XV зуунд эдийн засгийн харилцаанд төрийн оролцоо нэмэгдэж, төрөөс нийгмийн харилцаанд шууд нөлөөлөх язгууртны удирдлагын тогтолцоо улам хүчирхэгжсэнээр нотариат нь бүрэн утгаараа төрийн байгууллагад хамаарах болсон. Ялангуяа энэхүү өөрчлөлт Италийн томоохон хотуудад илүү өрнөж, нотариатын үйл ажиллагааг тусгайлан хууль тогтоомжоор зохицуулж, нотариатчдын эрх

ашгийг хамгаалах зорилгоор нэгдсэн удирдлага бүхий байгууллага бий болжээ.¹⁰

Ийнхүү нотариатын байгууллага нь төрийн эрх мэдлийн болон бусад байгууллагын хүсэл зоригт хөтлөгдөхгүйгээр хараат бус, бие даасан байдлаар ажиллах үндсэн эхлэл нь болсон.

2. Орчин үеийн эрх зүйн тогтолцоонд нотариатын байгууллага өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ төрийн ямар нэг байгууллагын тогтолцоонд хамаарах, эсхүл хууль ёсыг сахиж бие даан үйл ажиллагаа явуулах эсэх нь түүхийн туршид нэлээдгүй маргаантай байжээ. ОХУ-ын эрдэмтэн Н.Б.Зейдер: Иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн байгууллагаас гадна хүний эрх, эрх чөлөөг хамгаалах чиг үүрэг бүхий бусад байгууллага оролцох бөгөөд энэ утгаараа шүүхийн байгууллагын тогтолцоонд нотариатын байгууллагыг хамааруулан ойлгохоор үзэж байжээ. Энэ үзэл хандлага нь эртний Ромын эрх зүйн тогтолцоонд нотариатыг шүүх эрх мэдлийн байгууллагын тогтолцоонд хамааруулан үзэж байсан уламжлалт сэтгэлгээ, нөгөөтэйгүүр тухайн үеийн социалист хэв маягийн төрийн эрх мэдэл хуваарилах тогтолцоотой холбоотой.¹¹

3. Харин ардчилсан Үндсэн хууль батлагдсан 1992 оноос хойш төрийн байгууллагын тогтолцоог хуулиар тодорхойлохдоо Үндсэн хуульт ёс, эрх зүйт төрийн үнэлэмжийг удирдлага болгон төрийн эрх мэдэл хуваарилах онол, зарчмын дагуу эрх мэдлийг Хууль тогтоох, Гүйцэтгэх, Шүүх эрх мэдлийн байгууллага хэмээн

⁷ www.garant-e.ru/index.php/article/archive/192/; - Ляпидевский Н. История нотариата - Москва университетская типография, 1875 г.

⁸ Юридическая Энциклопедия – Под редакцией академика Б.Н.Топорнина, Москва 2001.- С 630

⁹ Written by Jean Lambert "The Latin notary: the civil law: title insurance" 04/10/2007 notary at Montreal, www.cdna.org

¹⁰ www.notalariat.ru/ Официальный сайт небюджетного нотариата Российской Федерации - Из мировой истории нотариата

¹¹ Дам ишлээ. Ярков В.В "Место нотариата в правовой системе России и среди органов гражданской юрисдикции", 2003

ангилсанаар нотариатын байгууллагыг бүрэн бие даасан статустай болгон өөрчилж, түүний үйл ажиллагааг хуулиар зохицуулах замаар төрийн зүгээс хяналтыг хэрэгжүүлэх зарчмыг баталгаажуулсан Нотариатын хуулийг 1997 онд батлан гаргасан байна.

Энэ хуулийн зорилго нь нотариатын байгууллагын бие даасан удирдлага зохион байгуулалтыг бий болгож, нотариатын үйлдэл хийх замаар иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад чиглэгдсэн болно.

Орчин үед нотариатын байгууллагын чиг үүрэг нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, иргэний эрх зүйн харилцаанд тогтвортой байдлыг хангах агуулгаараа нийтийн эрх зүйд хамаарах боловч энэ нь төрийн зүгээс түүний үйл ажиллагаанд шууд хяналтыг хэрэгжүүлнэ гэсэн үг биш.¹²

Хэдийгээр нотариатын чиг үүрэг нь төрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах боловч орчин үеийн улс орнуудад гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага өөрийн зарим бүрэн эрхийг хуулийн болон гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллагад шилжүүлж болохыг Үндсэн хуулийн эрх зүйгээр хүлээн зөвшөөрдөг. Тухайлбал, Монгол Улсын хувьд авч үзэхэд ийм байгууллагын нэг нь Нотариат юм.

Нэгэнт гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага өөрийн зарим бүрэн эрхийг төрийн бус олон нийтийн байгууллагад шилжүүлсэн тохиолдолд хуульд зааснаар тэдгээр байгууллагын үйл ажиллагааг төрөөс хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэхээс бус үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлдэггүй.

Өөрөөр хэлбэл, Латин нотариатын тогтолцоотой улс орнуудад нотариатч нь хэлцлийн

үнэн зөв эсэх, түүний агуулга нь хууль болон нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахууны хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхэд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлдэг тул тэрээр заавал хуульч мэргэжилтэй, тодорхой дадлага туршлагатай байх ерөнхий шаардлага тавьдаг учир нотариатчийг шилж сонгох, томилох, хууль зөрчсөн үйлдэлд хяналт тавих, таслан зогсоох үүрэг нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад харьцангуй утгаараа хадгалагдана. Энэ нь нотариатын гүйцэтгэж буй чиг үүрэг нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах төрийн чиг үүрэг байдагтай холбоотой.

Тиймээс нотариатчийг Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалтад болон түүнчлэн нотариатчийн мэргэшлийн шалгалтад тэнцсэн Аж ахуйн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд олгож, Нотариатын тухай хуулийн дагуу үйл ажиллагаанд нь Хууль зүй, дотоод хэргийн яам хяналт тавьдаг.

Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага нь нотариатын бие даасан хараат байдлыг хэзээ ч гажуудуулж, зөрчиж болохгүй. Тиймээс гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын тогтолцоонд нотариатын байгууллагыг хамааруулдаггүй. Ийм ч учраас 1997 оны Нотариатын тухай хуулийн 2 дугаар зүйлд Нотариат нь хууль дээдлэх, үйл ажиллагаагаа явуулахдаа хараат бус байх, өөрийн буруутай үйл ажиллагаанаас учруулсан хохирлыг бүрэн хариуцах зэрэг зарчмыг өөрийн үйл ажиллагаандаа баримтлахад хуульчилж, Нотариатчид улсын хэмжээнд үйл ажиллагаагаа

явдан зохицуулах зорилгоор нэгдэн Нотариатчдын танхим байгуулахаар заасан.

Нотариатын хэрэгжүүлж буй зарим чиг үүрэгтэй холбоотойгоор түүнийг шүүх эрх мэдлийн байгууллагад хамааруулан ойлгох явдал нэлээдгүй бий.

Энэ нь шүүхийн болон нотариатын байгууллага нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах нийтийн чиг үүргийг хэрэгжүүлж, хараат бус бие даан үйл ажиллагаа явуулдаг зэрэг нийтлэг шинж болон манай улс дахь нотариатын байгууллагын үүсэл хөгжилтэй холбоотой.

Нотариатын байгууллагын удирдлагын эрх мэдэл 1964 оноос эхэлж БНМАУ-ын Дээд шүүхэд төвлөрч байсан. Уг байгууллагаас нотариатын байгууллага нь БНМАУ-ын хууль дүрэм, тогтоол, нотариатын дүрэм, зааврын дагуу эрхэн ажлаа явуулж байгаа, нотариатын байгууллагаас хийж байгаа гэрчлэлт баталгаа нь үнэн зөв явагдаж байгаа эсэхэд хяналт тавьж, гарсан алдаа зөрчлийг засах, ажлыг нь шалган зааварлах, нотариатын албаны хүмүүсийн ажлын хариуцлага мэргэжил боловсролыг дээшлүүлэх зэрэг удирдлагын бүрэн эрхийг хэрэгжүүлж байсан.¹³

Монгол Улс нийгмийн ардчилсан тогтолцоонд шилжсэнээр нотариатын байгууллагын удирдлагын тогтолцоонд агуулгын шинжтэй өөрчлөлт орсон хэдий ч зарим хуулийн зүйл заалтыг хуучны уламжлалт сэтгэлгээгээр ойлгох, тайлбарлах хандлага байгаар засан сайжруулж зөвөөр ойлгох нь хууль хэрэглэх практикт чухал ач холбогдолтой.¹⁴ Тухайлбал: Нотариатын тухай хуулийн 27¹ дугаар зүйлд "Нотариатч төлбөрийг нотолсон баримт бичгийг үндэслэн өвлөх эрх, тэжээн тэтгэхтэй холбогдсон харилцаанд төлбөр төлөгчөөс мөнгө,

¹² Гавриллова О.Ю. "Понятие и характер нотариальных функций" Нижний Новгород, 2004. Стр. 4.

¹³ Б.Гомбосүрэн "БНМАУ-ын нотариат", Улаанбаатар хот, 1972 он, 12 дахь тал

¹⁴ Яков В.В. "Место нотариата в правовой системе России и среди органов государственной юрисдикции", 2003

эд хөрөнгийг гаргуулахаар талууд харилцан тохиролцож байгуулсан гэрээг гэрчлэн мэдэгдэх хуудас үйлдэнэ". Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 183 дугаар зүйлийн 1-д "Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл шүүхийн шийдвэр болон шүүхээр баталгаажуулсан цэргийн анги, байгууллагын захирагч/дарга/-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал, арбитрын шийдвэр, нотариатын мэдэгдэх хуудас, захиргааны шийтгэвэр тэдгээрийн үндсэн дээр олгогдсон гүйцэтгэх хуудас байна", мөн хуулийн 184 дүгээр зүйлийн 1-д "эрх зүйн маргааныг энэ хуулийн 13.2-д зааснаар арбитр шийдвэрлэсэн, талууд гэрээндээ үл маргах журмаар биелүүлэхээр тохиролцож нотариатаар гэрчлүүлсэн бол нотариатын мэдэгдэх хуудас шүүхээр баталгаажсан байна" хэмээн тус тус заасныг удирдлага болгон нотариатыг шүүхийн байгууллагын тогтолцоонд хамааруулан ойлгох буруу практик байна.

Дээрх хуулийн зүйл заалтын агуулгаас үзвэл нотариат нь мэдэгдэх хуудсаар өр төлбөр, өвлөх эрх, тэжээн тэтгэхтэй холбоотой маргаантай харилцааг хөндлөнгийн журмаар шийдвэрлэж байгаа бус харин зохих хууль ёсны баримт бичгийг үндэслэн талууд сайн дураар хэлэлцэн тохиролцож байгуулсан тохиролцоог хууль ёсны болгон гэрчилж байгаа хэрэг юм.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 183,184 дүгээр зүйлд зааснаар нотариатчийн мэдэгдэх хуудас нь бие даан хууль зүйн факт буюу заавал биелэгдэх шинжийг агуулдаггүй, харин шүүхээр баталгаажиж байх хууль ёсны болдог онцлогтой. Нотариатын дээрх чиг үүрэгтэй холбоотойгоор шүүх эрх мэдлийн байгууллагын тогтолцоонд хамааруулах нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долоодугаар зүйлд заасан "Монгол

Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ", "Ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг шүүх өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно" гэсэн үндсэн хуульд ёсны зарчмуудтай зөрчилдөх юм.

Энэ бүхнээс дүгнэвэл нотариат нь нотариатын үйлдэл хийх замаар иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах нийтлэг чиг үүрэг бүхий Үндсэн хуулийн шинжтэй байгууллага¹⁵ бөгөөд Үндсэн хуульд заагдсан төрийн чиг үүргийг хуулийн дагуу хэрэгжүүлж, хараат бусаар үйл ажиллагаа явуулж байгаа эрх зүйн этгээд юм.

Эдүгээ нотариатын байгууллагын нийгэмд гүйцэтгэх чиг үүрэг, үүсэн бий болсон онцлог хэв шинжээс хамааран дэлхийн эх орнууд нь Ром-Германы болон Англо-Саксоны эрх зүйн бүлийн онцлогоос шалтгаалан өөрийн нотариатын тогтолцоог бүрдүүлсэн юм.

Товчхоноор хэлэхэд Common law буюу нийтийн эрх зүйн бүлийн улс орнуудад public notary эсхүл notarial officer нэр томъёо хэрэглэгддэг бол Civil Law буюу эх газрын эрх зүйн системтэй улс орнуудад Latin notary гэсэн ойлголтоор илэрхийлэгддэг. Эдгээр тогтолцоо нь нотариатын гүйцэтгэж буй чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээгээр хоорондоо эрс ялгаатай.¹⁶

Латин нотариатын тогтолцоо нь эртний Ромын соёл иргэншил буюу тухайн үед нийтийн эрх зүйн субъектуудын хоорондын эрх зүйн баримт бичгийг гэрчилж байсан notarii, Tabellion гэх зэрэг албан тушаалтнуудтай холбоо-

той бөгөөд эх газрын эрх зүйн бүлийн онцлог шинж болох харилцаанд оролцогч субъектууд нь аливаа гэрээ, хэлцлийг хийх, нийгмийн харилцаанд оролцохдоо хууль ёсыг дээдэлж, төрийн хуулийг даган биелүүлэх гэсэн хууль дээдлэх зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор нотариат нь гэрчлэгдэж байгаа баримт бичиг, гэрээ, хэлцэл нь хуульд заасан хэлбэрийн болон агуулгын шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавьдаг.

Харин эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх хуулиар эрх олгогдсон байгууллагын хэрэг маргааныг шийдвэрлэхэд үндэслэл болгох нотлох баримт нь нотариатаар баталгаажиж, гэрчлэгдэж байх хууль ёсны бөгөөд шүүхийн шийдвэрийн үндэслэл болно хэмээн үздэг.¹⁷

Энэ тогтолцоонд нотариатч нь өөрийн үйл ажиллагаандаа хийж буй үйлдэлдээ эргэлзвэл тухайн үйлдэл хийхээс татгалзах, гагцхүү үнэнийг эрхэмлэх, нэр төртэй байх, шударга ёсыг удирдлага болгох, нотариатчийн эрхэм үүрэг бол хүмүүс хоорондын харилцаанд маргаан гаргахгүй байх явдал гэдгийг байнга санаж явах гэсэн хэд хэдэн үзэл санааг баримтлахыг шаарддаг.

Эдгээр үзэл санаа буюу зарчмыг нотариатын үйл ажиллагаанд баримталдаг улс орнууд нь түүхэн харилцааны онцлогоороо нэгдэн нийлж орчин үеийн Латин нотариатын загварыг бий болгож эдүгээ 78 гаруй улс орныг эгнээндээ нэгтгэсэн Латин нотариатчдын Олон улсын байгууллага болтлоо хөгжсөн байна.¹⁸

Гэхдээ АНУ-ын Louisiana, Alabama, Florida болон Английн

¹⁵ Гаврилова О.Ю. "Понятие и характер нотариальных функций" Нижний Новгород, 2004. С1

¹⁶ Written by Jean Lambert "The Latin notary, the civil law title insurance" 04/10/2007 notary at Montreal www.peng.org

¹⁷ Pedro A Malavet, "The foreign Notarial legal services Monopoly. Why should we care?" 956-957 (1998)

¹⁸ www.Wikipedia.com the free encyclopedia

Эдүгээ европын улс орнууд дахь нийт нотариатын 23 буюу, 30000 гаруй нотариат энэ тогтолцоогоор ажиллаж байна. Европын нийт 34 улс: Albania, Andorra, Armenia, Austria, Belgium (FR), NL), Bulgaria, Croatia, Czech Republic, Estonia, France, Germany, Greece, Hungary, Italy, Latvia, Lithuania, United Kingdom (only the city of London), Luxembourg, Malta, Moldova, Monaco, Netherlands, Poland, Portugal, Romania, Russia, San Marino, Slovakia, Slovenia, Spain, Switzerland, Macedonia, The Vatican and Turkey.

- Америкийн нийт 23 улс: Argentina, Bolivia, Brazil, Canada, Chile, Colombia, Costa Rica, Cuba, Dominican Republic, El Salvador, Ecuador, Guatemala, Haiti, Honduras, Mexico, Nicaragua, Panama, Paraguay, Peru, Puerto Rico, Uruguay, United States (only the State of Louisiana) and Venezuela.

- Африкийн нийт 15 улс: Algeria, Benin, Burkina Faso, Cameroon, Central African Republic, Chad, Congo, Gabon, Guinea, Ivory Coast, Mali, Morocco, Niger, Senegal and Togo.

- Азийн 3 улс: China (People's Republic), Indonesia, Japan.

Лондон хот, Канадын Quebec гэх зэрэг нэгж Латин нотариатын тогтолцоог хэрэгжүүлдгээс үзэхэд Англо-Саксоны эрх зүйн бүлийн улс орнууд Латин нотариатын тогтолцоог төсөөлөн ойлгох нь учир дутагдалтай. Английн хувьд civil law нотариат нь зөвхөн public notary үйл ажиллагаа явуулах боломжгүй үед түүний үүргийг нөхөх зорилгоор үйл ажиллагаа явуулдаг төдийгүй гэрээслэл гэх зэрэг зарим хэлцлийг гэрчлэх эрхгүй байдаг. Харин АНУ-ын дээрх мужид латин загварын нотариатын үйл ажиллагаа нь үндсэн бөгөөд заавал хэрэгжих шинжтэй байдаг.¹⁹

АНУ-ын Нью-Йорк мужийн Колумбын Их сургуулийн харьцуулсан эрх зүй судлалын профессор Alejandro Garro-гийн хэлснээр уламжлалт Civil law тогтолцоонд хууль нь нийгмийн харилцааг нарийвчлан журамлан зохицуулсан хэм хэмжээнээс бүрдэх бөгөөд тэдгээрийг шүүхээс тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэхдээ заавал баримтлах ёстой байдаг бол эрх зүйн common law тогтолцоо бичмэл хууль дээр үндэслэж хөгжөөгүй харин тодорхой хэрэг маргааныг шийдвэрлээд гаргасан олон тооны прецедентэд үндэслэсэн байдаг. АНУ дахь нотариатч нь хуульч бус мэргэжилтэй хүн байгаа нь public нотариатын тогтолцоог нэлээд шүүмжлэхэд хүргэж байна.²⁰

Энэ байдал нь магадгүй Латин болон Англо-Саксоны загварын аль алиных нь шинжийг агуулсан холимог шинжтэй нотариатын шинэ тогтолцоог бий болгохыг үгүйсгэхгүй.²¹

Сүүлийн жилүүдэд Латин нотариатын нийгэмд гүйцэтгэх чиг үүргийг Англо-Саксоны бүлийн улс орнууд хүлээн зөвшөөрч, зарим тохиолдолд хэрэглэх хандлага ажиглагдаж байна. Тухайлбал сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд АНУ-ын хуульчдын дунд тус улсын

шүүхийн эрх мэдлийн байгууллага болон Электрон нотариатын үйл ажиллагааг нарийвчлан тодорхойлох нь нэлээд тулгамдсан асуудал болж улмаар тус улсад хэрэглэгдэж байгаа нотариатын тогтолцоог Латин нотариатын тогтолцоогоор өөрчлөх санал санаачилга гарч байна. Энэ санаачлагыг АНУ-ын Colorado-гийн Их Сургуулийн эрх зүйн урьдчилан сэргийлэх төвөөс анх боловсруулсан бөгөөд тэдний үзлээр нотариатын үүргийг хуульч бус мэргэжлийн этгээд гүйцэтгэх нь харилцаанд эрсдэлтэй байдлыг бий болгох тул хуульчийг бэлтгэх, сургах асуудлыг зайлшгүй шийдвэрлэх ёстой хэмээн үзэж зөвлөмж боловсруулж байжээ.

Хожим 1993 онд Америкийн Мэдээллийн Аюулгүй байдлын хороо, Америкийн Барийн Холбоо хамтран Cybernotary буюу электрон нотариатын тогтолцоог үүсгэх, цаашид боловсронгуй болгох төлөвлөгөөг боловсруулахдаа электрон худалдааг гэрчлэх аюулгүй байдлыг хангах асуудлын нэг мөр тодорхой болгохын тулд Латин нотариатын тогтолцоог бий болгох санаачилгыг гаргаж зөвлөмж боловсруулсан байна.

Одоохондоо энэхүү санаачилга нь бүх нийтийг хамарч амжилтад хүрээгүй ч Америкийн нэгдсэн улсын Florida, Alabama гэх зэрэг хэд хэдэн муж Латин нотариатын тогтолцоог өөрийн улсдаа бий болгох талаар нэлээд санал санаачилга гарган ажиллаж байна.²²

Ром-Германы эрх зүйн бүлийн улс орнуудын нотариат нь баримт бичгийг гэрчилж, баталгаажуулж байгаа нь энэ эрх зүйн бүлийн дараах онцлог шинжтэй холбоотой.²³

1. Бичмэл нотлох баримтад онцгой ач холбогдол өгөх бөгөөд түүний агуулга хамгийн чухал

бөгөөд үнэн зөв хэмээн үздэг.

2. Хууль зүйн ач холбогдол бүхий үйлдэл, үйл ажиллагаа нь /үл хөдлөх эд хөрөнгийн эрх, түүнтэй холбоотой бусад эрх гэх зэрэг/ улсын бүртгэлд бүртгэгдэх бөгөөд тэрхүү бүртгэгдсэн эрхийн мэдээллийг үнэн зөв хэмээн үздэг.

3. Латин нотариатын улс орнуудын үндэсний эрх зүйн тогтолцоонд хууль үндсэн эх сурвалж болох тул нотариатчийн гол үүрэг нь нотариатын үйлдэл хийхдээ аливаа гэрээ хэлцлийн агуулга нь хуульд нийцэж байгаа эсэхэд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж, тогтвортой аюулгүй байдлыг хангахад чиглэгддэг. Өөрөөр хэлбэл шүүхээс гэрээ, хэлцлийн хэрэгжилтийг хангадаг бол нотариат нь уг хэлцэл нь хууль ёсны дагуу үнэн зөв хийгдсэн эсэхийг хангах үүргийг хүлээдэг. Харин Англо-Саксоны тогтолцоотой орнуудад нотариатчийн чиг үүрэг хууль ёсыг сахиулах, шударга ёс, тэгш байдлыг тогтоохоос илүүтэйгээр харилцаанд оролцогчдын хүсэл зоригийг ханган баталгаажуулахад оршино.

4. Латин загварын тогтолцоонд нотариатч нь хууль хэрэглэх, харилцаанд оролцогчдын үйлдэл, эс үйлдэхгүй эрх зүйн үүднээс үнэлэлт дүгнэлт өгч, уг харилцааны үр дагаварыг тайлбарлан таниулах үүрэгтэй байдаг тул тэрээр зайлшгүй хууль зүйн дээд боловсролтой, нотариатын үйл ажиллагаа эрхлэх шалгалтад орж тэнцэн тусгай зөвшөөрөл авсан байхыг шаарддаг. Харин Англо-Саксоны системийн нотариатч нь ерөнхий суурь мэдлэг эзэмшсэн, ёс суртахууны хувьд үнэнч нэгэн байхад л хангалттай.

5. Латин нотариатын тогтолцоонд нотариатч нь ёс суртахууны алдаа гаргаагүй,

¹⁹ www.notarius.history

²⁰ Common law and Civil law Notaries: A World of Difference. By David S.Thun

²¹ Carmen H.Carlos – director of Puerto Rico Office for Inspection of Deeds

²² www. Essence of notarial service

²³ Written by Jean Lambert "The Latin notary; the Civil law: title insurance" 04/10/2007 notary at Montreal, www.cdng.org

хууль зөрчөөгүй л бол бүх насаараа ажиллах боломжтой байдаг бол нийтийн эрх зүйн тогтолцоонд нотариатын бүрэн эрх нь тодорхой хугацаагаар хязгаарлагддаг.

6. Латин нотариатын тогтолцоонд нотариатч нь хэлцлийн үнэн зөв, хууль ёсны байдлыг хангах бөгөөд хуулиар заавал гэрчлэгдэх гэрээ, хэлцэл нь гэрчлэгдээгүй тохиолдолд шүүхэд нотлох баримтаар үнэлэгддэггүй. Харин Америкийн Нэгдсэн Улсын хувьд нотариатчийн гэрчилсэн үйлдэл нь зөвхөн тухайн баримтын үнэн зөв эсэхийг таамаглах боломж олгохоос бус үнэн зөв эсэх талаарх баталгаа өгдөггүй бөгөөд зөвхөн гэрчлэгдсэн баримт бичгийн үнэн зөв эсэхийг итгүүлэхэд л хангалттай. Гэвч энэхүү таамаглал нь гагцхүү гарын үсгийн үнэн зөвөөр тогтоогдох боломжтой гэж үздэг.

7. Англо-Саксоны улс

орнуудын нотариат нь гэрээг хэлбэржүүлэх онолыг баримталдаггүй бөгөөд нэг үг болон нэг гар барилтад ёс суртахууны өндөр ач холбогдол өгдөг. Өөрөөр хэлбэл, шударгаар ажиллах, ажил хэрэгч харилцааг илүүд үздэг. Харин Латин нотариатын тогтолцоонд аман тохиролцоо, ёс суртахууны үнэт чанараас илүүтэйгээр бичмэл баримтад онцгой ач холбогдол өгдөг. Энэ тогтолцооны үед хуульчдад баримталдаг гол зарчим нь нийгмийн гишүүдийн субъектив олон хүчин зүйлээс хамааран тодорхой бус нөхцөл байдлууд нь хардалт, болгоомжлолыг бий болгодог. Тиймээс бодит байдлыг субъектив нөлөөллөөс хамгаалах, маргаан үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор тодорхой бичмэл баримтад нотолгооны өндөр ач холбогдол өгдөг төдийгүй нийгмийн ёс суртахуун зохицуулалтаас

илүүтэйгээр төрөөс батлан гаргасан хуулийн зохицуулалтыг ач холбогдолтойд тооцдог.

8. Латин нотариатын тогтолцоонд нотариатчид нь өөрсдийн эрх ашгаа хамгаалах, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах зорилгоор танхим байгуулан ажилладаг бол Англо-Саксоны нотариатчдын хувьд тэдгээр нь нотариатын үүрэг, төрийн албыг хавсран гүйцэтгэдэг тул хэрэгжүүлж буй чиг үүргээрээ төдийлөн нэгдэж тусгай байгууллага байгуулдаггүй.

9. Ром-Германы эрх зүйн систем нь төрөөс батлан гаргасан бичмэл хэм хэмжээнд илүүтэй ач холбогдол өгдөг бол Англиас гаралтай Англо-Саксоны эрх зүйн бүлийн нотариат нь бичмэл бус заншил, шүүхийн прецедент болон талуудын хүсэл зоригийг хүндэтгэх зарчимд үндэслэгддэг.²⁴

²⁴ Common law and Civil law Notaries: A World of Difference. By David S.Thun



Хууль зүйн магистр А.Дэлгэрмаа

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХУУЛЬ ДАХЬ ЭЗЭМШЛИЙН ТАЛААРХ ЗОХИЦУУЛАЛТ, ЗӨРЧИЛДӨӨНТ БАЙДАЛ

“Эзэмшил”-ийн талаарх цуврал өгүүлүүдийн гурав дахь хэсэгт Иргэний хууль дахь эзэмшлийн зохицуулалтаас гадна мөн судалгааны ажлынхаа гол дүгнэлт, саналыг тоймлон оруулж байна. Цаашид энэ сэдвээр судалгааны ажлыг үргэлжлүүлж, энэхүү сэтгүүлээр дамжуулан Та бүхэнд хүргэж байх юм. Өмнөх өгүүлүүдэд¹ “эзэмшил” хэмээх ойлголын талаар онолын талаас нь хөндөж, мөн гадаад орнуудын зохицуулалтыг харьцуулан хүргэж байсан бол энэ удаад манай улсын одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Иргэний хуулийн эзэмшлийн талаарх зохицуулалт, түүнд хийсэн дүн шинжилгээг хүргэх болно.

2002 онд УИХ-аас батлан гаргасан, одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Иргэний шинэ хуулийн 10 дугаар бүлэгт “Эдийн болон эдийн бус баялаг”-ийн, 11 дүгээр бүлэгт “Эзэмшил”-ийн талаархи зохицуулалт тус тус орсон. Шинэ Иргэний хуульд эдгээр ойлголт тусдаа бие даасан бүлэг болон орсон нь иргэний эрх зүйн хөгжилд томоохон хувь нэмэр бүхий ач холбогдолтой зүйл болсон. Ялангуяа “Эзэмшил”-ийн талаар нэг бүлэг /Иргэний хуулийн 89–98 дугаар зүйл/ болгон тусад нь зохицуулж өгсөн нь энэ талаарх эрх зүйн зохицуулалт илүү тодорхой, нарийн болсон ач холбогдолтой юм. 1994 оны Иргэний хуульд

эзэмшигчийн эрх ашгаас түрүүнд өмчлөгчийн эрхийг тавьсан байдлаар зохицуулсан байсан бол 2002 оны хуулиар энэ асуудлыг өмчлөх эрхийн нэг элемент бус бие даасан институт болохын хувьд авч үзсэнээрээ ихээхэн дэвшилтэт зүйл болсон байна.

Эзэмшлийн талаархи зохицуулалтыг тоймлон дурдвал:

Эзэмшил нь хүсэл зоригийн дагуу эрх, эд юмсыг хууль ёсоор мэдэлдээ авах замаар үүсэх; өөр этгээдээс бүрэн эрх олгогдсоны дагуу түүний ашиг сонирхлын үүднээс эд хөрөнгийг тухайн үед өөрийн мэдэлд байлгаж байгаа этгээдийг эзэмшигч гэж үзэхгүй ба энэ тохиолдолд бүрэн эрх олгосон этгээд нь эзэмшигч байх; өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын дагуу хууль буюу хэлцлийн үндсэн дээр тодорхой хугацаагаар эд хөрөнгийг эзэмших эрх олж авсан буюу үүрэг хүлээсэн этгээдийг шууд эзэмшигч гэх ба харин эрх буюу үүргээ шилжүүлсэн этгээд нь шууд бус эзэмшигч байх; эд хөрөнгийг хууль ёсоор эзэмшиж байгаа буюу түүнийг эзэмших эрхтэй болох нь илт тодорхой байгаа этгээдийг шударга эзэмшигч гэх ба шударга эзэмшигч нь эд хөрөнгөө өөрийн эзэмшлээс алдсан бол 3 жилийн дотор шинэ эзэмшигчээс тухайн эд хөрөнгөө буцаан шаардах эрхтэй байх талаар тусгасан

байна. Өмчлөгч болон хууль ёсны эзэмшигч, хууль бус боловч шударга эзэмшигчийн эрх зүйн баталгааг бүрдүүлсэн бөгөөд эзэмших эрхийг өргөтгөж гуравдагч этгээдийн хувьд эд хөрөнгийн эзэмшигч нь тухайн эд хөрөнгийн өмчлөгч гэж тооцогдох; эд хөрөнгийг хадгалах, арчлах, засан сайжруулах талаар гаргасан зардал нь гагцхүү эрх бүхий этгээдэд орох ашгийг нэмэгдүүлсэн тохиолдолд тэрээр дээрх зардлыг эрх бүхий этгээдээс шаардах эрхтэй ба энэхүү шаардлагын үнийн дүн нь эд хөрөнгийн үнийн болон ашгийн нийлбэрээс хэтрэхгүй байх зэрэг шинэ заалтууд орсон байна. Түүнчлэн эзэмшигч эзэмшлээсээ бүрмөсөн татгалзсан, эсхүл өмчлөгч буюу хууль ёсны эзэмшигч бусад хэлбэрээр эд хөрөнгийг мэдэлдээ байлгах эрхээ бусдад алдсан бол эзэмшил дуусгавар болох; өвийн журмаар шилжих эзэмшил өвлүүлэгчид байсан хэмжээгээр өвлөгчид шилжих; өмчлөгч буюу хууль ёсны эзэмшигч нь үндэслэл бүхий шаардлагыг эд хөрөнгө эзэмшигчид гаргаснаар эд хөрөнгө эзэмшигчийн эзэмшил дуусгавар болох; эзэмших эрхээ алдсан бол эзэмшилд байх хугацаа тасалдах, энэхүү тасалдсаны дараа эзэмшилд байх эрхийг сэргээн хэрэгжүүлэхэд өмнө өнгөрсөн хугацааг оруулахгүйгээр эзэмшилд байх хугацааг тасалдсан үеэс шинээр эхлэн тоолох, хэрэв эзэмшигч нь

¹ А.Дэлгэрмаа “Эзэмшил – Эд юмсын эрх зүйн нэг ухагдахуун болох нь”, “Хууль дээдлэх ёс сэтгүүл”, УБ., 2007 он, № 3 (18), 52 – 58 дахь тал; А.Дэлгэрмаа “Гадаад орнуудын Иргэний эрх зүй болон Иргэний хууль тогтоомж дахь Эзэмшлийн талаарх эрх зүйн зохицуулалт”, “Хууль дээдлэх ёс сэтгүүл”, УБ., 2008 оны № 1 (20), 68 – 74 дэх тал

өөрийн хүсэл зоригоос гадуур буюу гуравдагч этгээдийн нэхэмжлэлийн үндсэн дээр эзэмших эрхээ алдсанаас хойш 1 жилийн дотор уг эрхээ буцаан олж авсан бол эзэмшилд байх хугацааг тасалдсан гэж үзэхгүй байх зэргээр тус тус нарийвчлан зохицуулсан байна.

Иргэний хуулийн эзэмшлийн зохицуулалтын зөрчилтэй байдал болон бусад асуудал

Хэдийгээр дээр дурдсанчлан эзэмшлийн талаархи Иргэний хуулийн зохицуулалтад олон шинэлэг зохицуулалт, эерэг тал, ач холбогдол байгаа боловч эзэмшлийн талаарх тодорхойлолтоос авахуулаад хоорондоо зөрчилдсөн, онолын хүрээнд няцаагдахаар, зарим тохиолдолд ойлгомжгүй байхаар хэд хэдэн зүйл, заалт байгаа юм. Энэ талаар "Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Ерөнхий анги)" -ын 10, 11 дүгээр бүлгийн тайлбараас харж болохоор байна. Хамгийн эхэнд анхаарал татаж буй асуудал бол "эзэмшил"-ийн талаар манай хуульд өгсөн тодорхойлолт юм. Иргэний хуулийн 89 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Хүсэл зоригийн дагуу эрх, эд юмсыг хууль ёсоор мэдэлдээ авах замаар эзэмшил үүснэ" гэсэн нь эзэмшлийн талаархи онолын хэд хэдэн зарчмыг зөрчсөн байдалтай байна. Юуны түрүүнд эзэмшил заавал хүсэл зоригийн дагуу байх эсэх нь одоог хүртэл эрдэмтдийн дунд маргаантай сэдэв байсаар байгаа билээ. Нөгөө талаар "эрх"-ийг эзэмших нь онолын хүрээнд зөвшөөрөгдөөгүйгээс гадна эрх эзэмших тухай практик ч одоогоор тодорхой бус байна. Гэхдээ "эрх эзэмших" тухай зохицуулалтыг оруулахдаа оюуны үнэт зүйл, оюуны өмч эзэмших; патент, лиценз, хувьцаа эзэмших зэрэг нь эрх эзэмших гэсэн утгыг илэрхийлж буй бөгөөд энэ тохиолдолд эзэмшлийн талаархи зохицуулалтыг төсөөтэй хэрэглэхээр оруулж

өгсөн болов уу гэж үзэж байна. Германы эд юмсын эрх зүйгээс ялгаатай нь манай Иргэний хуульд Эдийн болон эдийн бус баялгийн эрхийн томьёолол дор эдийн болон эдийн бус аль аль баялгийг хамаатуулан заасан бөгөөд эзэмшилд эд юмс ч байна, эдийн бус баялаг ч байна гэсэнд гол учир нь оршиж байна. Германы эд юмсын эрх зүйд зөвхөн материаллаг эд юмсыг ойлгодог тул эрх эзэмших, оюуны өмч эзэмших тухай ойлголт байхгүй байгаа нь гол ялгаа болж байгаа юм. Манай Иргэний хуульд эдийн бус баялгийн эзэмшлийн талаар дурдаж, оруулсан нь доорхи хэд хэдэн асуултыг зүй ёсоор бий болгож байна. Үүнд:

- Эрхийг эзэмших нь бодит буюу объектив шинжтэй байх ёстой эзэмшлийн үндсэн онолтой зөрчилдөж байна. Тэгэхээр Монголын иргэний эрх зүйн дагуу "эзэмшил"-ийг бодит болон бодит бус хийсвэр байж болно гэж үзэж байна гэж ойлгож болох уу?

- Эрх эзэмшихэд эзэмшлийн зохицуулалтыг төсөөтэй хэрэглэнэ гэсний дагуу эзэмшлийн ангилалууд эрх эзэмшихэд мөн тавигдах уу? Өөрөөр хэлбэл, хууль ёсны болон хууль бус, шударга болон шударга бус эзэмшигчийг хэрхэн тогтоох вэ?

- Э з э м ш л и зохицуулалтыг эрх эзэмшихэд төсөөтэй хэрэглэхийн учир шалтгаан юу вэ? Эзэмшлийг тогтоохын тулд төсөөтэй хэрэглэж байна гэж үзвэл улсын бүртгэлийн ач холбогдол яах вэ?

- Иргэний хуулийн 183.3¹ дахь хэсэгт "жинхэнэ эзэмшигч" гэсэн нь хууль ёсны эзэмшигчийг хэлж байна уу? Эсвэл өөр нэр томьёо юу? гэх мэтчилэн хэд хэдэн асуулт гарч болох бөгөөд гол нь практик хэрэгжилтийн талаасаа төвөгтэй байдлыг үүсгэж болзошгүй гэж үзэж байна. Учир нь хэрвээ эзэмшлийн

суурь зохицуулалт болгон Иргэний хуулийн зохицуулалтыг хэрэглэх үед доор дурдах зөрчилдөөнтэй, тулгамдсан асуудал зүй ёсоор тавигдах болно.

Түүнчлэн эд юмсыг хууль ёсоор мэдэлдээ авснаар эзэмшил үүснэ гэснээрээ эзэмшлийн өөрийнх нь онолын тодорхойлолтыг үгүйсгэсэн зохицуулалт болжээ. Эд юмсыг эзэмшилдээ олж авах нь хууль ёсоор ч тэр, хууль бусаар ч тэр хаа сайгүй л үүсэж байдаг зүйл бөгөөд энд хууль ёсны байх асуудал нь чухал үүрэг гүйцэтгэхгүй юм. Хулгайч ч, дээрэмчин ч эд юмсыг мөн л эзэмшилдээ авч байдаг.² 89 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Өөр этгээдээс бүрэн эрх олгогдсоны дагуу түүний ашиг сонирхолын үүднээс эд хөрөнгийг тухайн үед өөрийн мэдэлд байлгаж байгаа этгээдийг эзэмшигч гэж үзэхгүй. Энэ тохиолдолд бүрэн эрх олгосон этгээд эзэмшигч байна" гэснээс харахад тээвэрлэлт, хадгалалт, даалгаврын гэрээний болон хөлсөөр ажиллах гэрээгээр бусдын мал маллах зэрэг үед эд хөрөнгө шилжүүлэн авч мэдэлдээ байлгаж байгаа этгээд эзэмшигч болохгүй юм. Иргэний хууль 92 дугаар болон 94 дүгээр зүйлд хууль ёсны болон хууль бус эзэмшигчдийн хооронд ялган зохицуулсан байна. Гэвч эдгээр зохицуулалт нь эд юмсыг эзэмшилдээ олж авсан этгээдийн үйлдэл нь хууль бус ч байсан, хууль ёсны ч байсан тухайн этгээд нь эзэмшигч л байна гэснээс өөрөөр ойлгогдохгүй байна.⁴ Хэрвээ эзэмшигч нь объектив эрхийн хувьд эзэмших эрхтэй байвал, өөрөөр хэлбэл тэрээр хууль ёсны эзэмшигч байвал тухайн эзэмшлийг шударга болон шударга бус гэж ангилах нь ач холбогдолгүй

¹ Иргэний хуулийн 183.3 "Улсын бүртгэлд бүртгэлтэй эрхийн жинхэнэ эзэмшигчийг үнэн зөв тогтоохын тулд улсын бүртгэлд бичигдсэн тэмдэг-лэл буруу, ташаа болж тухай өргөдлийг эрх нь зөригдөж байгаа этгээд бүртгэлийн байгууллагад гаргах эрхтэй."

² Монгол улсын Иргэний хуулийн тайлбар (Ерөнхий анги), 2005 он, 359 айд тал

³ Мөн тэнд

болох юм. Тодруулбал, Иргэний хуулийн 90.1 дэх хэсэгт хууль ёсны эзэмшигч нь шударга эзэмшигч байна гэсэн нь лопкийн хувьд алдаатай зохицуулалт болсон байна. **Угтаа бол эзэмшил нь хууль ёсны болон хууль бус гэж ангилалддаг бөгөөд хууль бус эзэмшлийг дотор нь шударга ба шударга бус эзэмшил гэж ангилдаг сонгодог ангилалтай манай хуулийн зохицуулалт зөрчилдөж байгаа юм.** Ер нь хууль ёсны эзэмшлийг шударга, шударга бус гэж үзэх нь ойлгомжгүй байгаа юм. Тодруулбал, хууль ёсны дагуу эзэмшил үүсэх тухай дурдсан мөртлөө Иргэний хуулийн 90-95 дугаар зүйлд шударга болон шударга бус эзэмшигчийн тухай зохицуулсан байна. Шударга болон шударга бус эзэмшигч нь зөвхөн хууль бус эзэмшлийн үед яригддаг. Энэ утгаараа эзэмшил үүсэх талаархи тодорхойлолтод хууль бус эзэмшлийг тооцохгүй мэтээр заасан байснаа хууль бус эзэмшлийн төрлүүдийг нарийн оруулж ирсэн нь бас л зөрчилтэй байдлыг бий болгож байна. Өөрөөр хэлбэл эзэмшил үүсэхэд **"хууль ёсны замаар"** гэсэн урьдчилсан нөхцөл илүүц болж байгаа юм. Ер нь шударга болон шударга бус эзэмшигчийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай, ингэснээр эзэмшил тогтоох болон эзэмшлийг хамгаалалт, гэм хор, хохирлыг арилгах зэрэг асуудалд чухал ач холбогдолтой байх юм. Мөн Иргэний хуулийн 89 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Өөр этгээдээс бүрэн эрх олгогдсон дагуу түүний ашиг сонирхлын үүднээс эд хөрөнгийг тухайн үед өөрийн мэдэлд байлгаж байгаа этгээдийг эзэмшигч гэж үзэхгүй. Энэ тохиолдолд бүрэн эрх олгосон этгээд эзэмшигч байна." гэсэн нь бусдын төлөө, бусдын нэрийн өмнөөс эзэмшиж байдаг эзэмшигчийг үгүйсгэсэн заалт болсон бөгөөд угтаа эзэмшил нь эд юмсыг **бодитоор эрх мэдэлдээ байлгах явдал** гэсэн сонгодог

онолтой зөрчилдөж байна. 89 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "Нэг эд хөрөнгийг хоёр буюу түүнээс дээш этгээд хамтран эзэмшиж байвал тэдгээр нь хамтран эзэмшигч байна", 89 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт "Нэг эд хөрөнгийн тодорхой хэсгүүдийг хэд хэдэн этгээд эзэмшиж байвал тэдгээр нь тус бүрдээ өөрт оногдох хэсгийн эзэмшигч байна" гэсний дагуу нийтийн зориулалттай орон сууцны сууц өмчлөгчид нь дундын өмчлөлийн зүйлийг хэсгээр, харин нэг сууцны гэр бүлийн гишүүд тухайн сууцыг хамтран эзэмшигчид болох юм.

Иргэний хуулийн 90 дүгээр зүйлийн 2-т "Шударга эзэмшигч өөрийн эзэмшлээс алдсан эд хөрөнгөө гурван жилийн дотор шинэ эзэмшигчээс буцаан шаардах эрхтэй", 90 дүгээр зүйлийн 3-т "Хууран мэхлэх, хүч хэрэглэх замаар эд хөрөнгийг олж авснаас бусад тохиолдолд шинэ эзэмшигч тухайн эд хөрөнгийн хувьд өмнөх эзэмшигчээс илүү эрхтэй бол энэ хуулийн 90.2 дахь хэсэгт заасан журам үйлчлэхгүй" гэсэн нь **шударга эзэмшигчийн эрхийг хамгаалсан** чухал зохицуулалт болжээ. Мөн 92 дугаар зүйлийн 1-д "Шударга эзэмшигчийн эд хөрөнгө түүний эзэмшилд нь байгаа боловч эзэмшиж ашиглах эрхээ хэрэгжүүлэхэд хэн нэгэн этгээд саад болж байвал уг саадыг арилгуулахаар өмчлөгчийн нэгэн ач шашаардах эрхтэй" хэмээн **шударга эзэмшигчийн эрхийн хамгаалалтыг** заажээ. Өмчлөгч буюу хууль ёсны эзэмшигчийн эрхийг хамгаалах үүднээс 94 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн заалтыг оруулсан байна. Энд "Засан сайжруулалтын улмаас эд хөрөнгийн үнэ нэмэгдсэн бөл уг эд хөрөнгийг буцааж өгөх үеийн засан сайжруулалтын үнэлгээгээр шаардлагын хэмжээг тодорхойлно. Энэ тохиолдолд шаардлагын үнийн дүн нь эд хөрөнгийн үнийн болон ашгийн нийлбэрээс хэтрэхгүй" гэжээ. Энэ нь эзэмшигчийн шаардах эрхийн

хэмжээг хязгаарласан утгатай байна. Өөрөөр хэлбэл, эзэмшигч өөрөөс нь гарсан бодит зардлаа л шаардах эрхтэй. Тухайн эд хөрөнгийн үнэ гаргасан зардлаас нь хамаагүй ихээр нэмэгдсэн байсан ч гэсэн зөвхөн гаргасан зардлынхаа хэмжээгээр төлүүлэх бололцоотой. Хэрэв эд хөрөнгийн үнэ гаргасан зардлаас нь бага хэмжээгээр өссөн бол эзэмшигч тэр бага хэмжээг л шаардах эрхтэй. Шударга эзэмшигчийн хувьд эрх бүхий этгээдэд эд хөрөнгийг буцааж өгөх хүртэл эд хөрөнгө болон эрхийн үр шимийг эзэмших эрхтэй бол хуулийн 95 дугаар зүйлийн 1-д зааснаар шударга бус эзэмшигч нь үүнийг буцааж өгөх, хэрэв өөрийн буруугаар үр шимийг олж авч чадаагүй бол олох ёстой байсан үр шимийг нөхөн төлөх үүрэгтэй байдаг байна. Шударга бус эзэмшигч тухайн эд хөрөнгийг зориулалтын дагуу орлого олохуйцаар ашиглаагүй бол тэр олох байсан орлого нь хохирол болж тэр учирсан хохирлыг арилгах үүрэг хүлээнэ гэсэн үг юм. Үүний үндэслэл нь түүний оронд байсан хэн ч зориулалтаар нь ашиглах байсан гэдгээс үүдэлтэй. 95 дугаар зүйлийн 2-т заасны дагуу шударга бус эзэмшигч нь шударга эзэмшигчийн нэгэн адил эд хөрөнгийг хадгалах, арчлах, засан сайжруулахад зориулж гаргасан зардлыг шаардах эрхтэй. Гэхдээ энэ зардал нь эрх бүхий этгээдэд орох ашгийг нэмэгдүүлсэн байх ёстой гэсэн нөхцөлийг хуульд тусгажээ. Түүнчлэн энэхүү шаардлагын үнийн дүн нь эд хөрөнгийн үнэ болон ашгийн нийлбэрээс хэтрэхгүй байна.

Энд ажиглагдсан нэг чухал зүйл бол эзэмшлийн хамгаалалтын үүднээс **хууль ёсны эзэмшигч хууль бус эзэмшлээс** эд хөрөнгөө шаардах, эсвэл эзэмших эрхээ хэрэгжүүлэхэд саад болж буй үйлдлийг зогсоохыг шаардах, хохирол учруулбал арилгахыг шаардах зэрэг эрхийн тухай зохицуулалт

тодорхойгүй байна. Энэ тохиолдолд зөвхөн өмчийн эрхийн хамгаалалтын үүднээс хууль ёсны эзэмшигчийн эрхийн хамгаалалтыг тогтоох уу? Хэрвээ тэгнэ гэвэл өмчлөгч бус хууль ёсны эзэмшигчийн хувьд шаардах эрхийн хууль зүйн үндэслэл аль нь байх нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл, Иргэний хуулийн 106.1 дэх хэсэгт "Өмчлөгч хөрөнгөө бусдын хууль бус эзэмшлээс шаардах эрхтэй" гэж заасан нь өмчлөгч бус хууль ёсны эзэмшигчид мөн хамаарах уу? 106 дугаар зүйлийн бусад хэсгийн эд хөрөнгийн бус шаардах эрхийн тухай зохицуулалт өмчлөгч бус эзэмшигчийн хувьд тодорхойгүй байна гэж үзэж байна. Мөн түүнчлэн өөртөө туслах үйлдлийг хууль ёсны болон шударга эзэмшигч хийх эрхтэй байхаар тусгайлсан зохицуулалт хийх шаардлагатай эсэхийг бодолцох хэрэгтэй болов уу. Хуулийн 97 дугаар зүйлд эзэмшилд байх хугацаа тасалдаг тухай зохицуулалт оруулсан нь эзэмшилд байх хугацаанаас шалтгаалж өмчлөх эрх олж авах явдалтай холбоотой юм. 97 дугаар зүйлийн 2-т "Эзэмшигч өөрийн хүсэл зоригоос гадуур буюу гуравдагч этгээдийн нэхэмжлэлийн үндсэн дээр эзэмших эрхээ алдсанаас хойш 1 жилийн дотор уг эрхээ буцааж олж авсан бол эзэмшилд байх хугацааг тасалдсан гэж үзэхгүй" гэсэн нь эзэмшсэн хугацаанаас хамаарч өмчлөх эрх олж авах эзэмшигчид ашигтай зохицуулалт болжээ.

98 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Оюуны үнэт зүйл, эрхийг эзэмшилдээ авахад энэ хуулийн 89-94 дүгээр зүйлийн холбогдох хэсэг, заалт нэгэн адил хамаарна" гэсэн нь ойлгоход төвөгтэй байдлыг үүсгэж байна. Эд юмсыг бодитойгоор эрх мэдэлдээ байлгадаг эзэмшлийг зөвхөн биет эд юмсын хувьд хэрэгжүүлдэг тухай эзэмшлийн

үндсэн тодорхойлолттой энэхүү заалт нь зөрчилдөж байна. Эзэмшил нь зөвхөн биет зүйл дээр бодит байдлаар илэрдэг тул оюуны өмч болон эрхийг эзэмших нь боломжгүй зүйл гэж хуульчид үздэг. Тиймдээ ч энэхүү заалтын практик үйлчлэл үгүйсгэгдэнэ.⁵ Харин хуульд энэ талаар оруулахдаа эзэмшлийн зохицуулалтыг төсөөтэй байдлаар хэрэглэх зорилгоор оруулсан байна. Гэтэл оюуны өмч бол тусгай эрх зүйн зохицуулалт бүхий онцлог сэдэв. Оюуны өмчийн хамгаалалтын хувьд тусдаа бие даасан эрх зүйн салбар, бие даасан хуулиуд, олон улсын эрх зүйн хэм хэмжээнүүд байдаг. Тэгвэл ямар тохиолдолд Иргэний хуулийн эзэмшлийн зохицуулалтыг төсөөтэй хэрэглэх нь тодорхойгүй байна. Ялангуяа эд хөрөнгийн бус амины эрх болох зохиогчийн болон хамаарах эрхийн хувьд эзэмшлийн зохицуулалт ач холбогдол багатай гэж үзэж байна. Учир нь тухайн зохиогчийн өмч болохыг баталгаажуулж бүртгүүлдэг байгууллага байдаг бөгөөд оюуны өмчийг нь хамгаалж байдаг олон арга хэрэгсэлтэй. Харин бүтээл ашиглах онцгой эрх буюу эдийн баялагтай холбоотой эд хөрөнгийн эрхийн хувьд байж болох талтай. Жишээ нь, хуулбарлах, олшруулах, нийтийн хүртээл болгох гэх мэт. Мөн түүнчлэн аж үйлдвэрийн өмчийн тухай ойлголтод эзэмшлийн тухай ярих боломжтой. Жишээ нь, бүтээгдэхүүний загвар, шинэ нээлт, патент эзэмших, барааны тэмдэг гэх мэт. Гэхдээ энд зайлшгүй анхаарах нэг чухал асуудал бол хэрвээ Иргэний эрх зүй дэх эзэмшлийн зохицуулалтыг оюуны өмчийн дээрхи хэлбэрт хэрэглэхээр бол тусгайлсан эрх зүйн зохицуулалтын хувьд аль нь суурь зохицуулалт болох талаар тодорхой зааг хязгаарыг

томъёолох хэрэгтэй юм. Жишээ нь, "Х" гэсэн барааны тэмдгийг А нь эхлээд эзэмшин бараандаа хэрэглэж байсан, харин Б-гийн хувьд "Х" барааны тэмдгийг А-гаас хойш эзэмшсэн, гэхдээ бүртгэлийн газарт бүртгүүлсэн байгаа. Энэ тохиолдолд маргаан үүсэн эзэмшлийг тогтоох шаардлагатай бол барааны тэмдгийн хуулийн зохицуулалтыг баримтлах уу, эсвэл Иргэний хуулийн эзэмшлийн зохицуулалтыг баримтлах уу? гэх мэт асуудал зүй ёсоор тавигдах юм. Мэдээж хэрэг Иргэний хууль бол суурь зохицуулалт, оюуны өмчийн чиглэлийн хуулиуд Иргэний хуульд суурилж, зөрчилдөөнтэй хэм хэмжээ байх аваас Иргэний хуулийг суурь зохицуулалт болгох нь дамжиггүй. Гэтэл оюуны өмчийн эрхийн хамгаалалт, олон улсын эрх зүйн гэрээ, хэлэлцээр зэргийн хамгаалалтын зохицуулалтууд хэрхэх вэ? Өөрөөр хэлбэл, бодиг зүйлд тогтоодог эзэмшлийн асуудлыг оюуны өмчийн эрх зүйд мөн адил хэрэглэх нь хэр зохимжтой вэ гэдэг нь эргэлзээтэй асуудал юм.

Мөн Иргэний хуулийн 96, 134, 135, 499, 500, 501, 502 дугаар зүйлд "өмчлөгч буюу эзэмшигч" гэсэн ойлголтыг томъёолсон нь шууд уншихад нэг этгээдийг хэлж буй мэт боловч хууль боловсруулагчийн санаа нь тухайн этгээд нь өмчлөгч эзэмшигч аль нь ч байж болохоор заасан байна. Өөрөөр хэлбэл "буюу" гэсэн холбоосыг хууль тогтоомжид янз бүрийн байдлаар, нэгдсэн нэг ойлголтгүйгээр хэрэглэж буй нь уг ойлголтыг өөр байдлаар төөрөгдөж ойлгох, хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байхыг үгүйсгэхгүй. Энэ мэтчилэн эзэмшлийн талаархи Иргэний хуулийн зөрчилдөөнтэй зохицуулалтууд нь нэн тэргүүнд хуулийг нэг мөр, зөв ойлгож

⁵ Монгол Олсын Иргэний хуулийн тайлбар (Еринхий анги), 2005 он, 404 зүйл тал

хэрэглэхэд, ялангуяа шүүхийн практикт төвөгтэй байдлыг бий болгох нь дамжиггүй.

ДҮГНЭЛТ

Эзэмшлийн талаархи онолын үзэл баримтлалын хүрээнд

Бидний өдөр тутмын амьдралд байнга тохиолдож байдаг үзэгдэл болох "эзэмшил" хэмээх ойлголт нь бүр эртний Ромын үеэс өнөөг хүртэл судалгааны янз бүрийн түвшинд судлагдан ирж, маргаантай байсан олон асуудалд хариулт өгөх, нэгдсэн ойлголтыг бий болгох зорилгоор

• Субъектив эзэмшлийн онол;

• Объектив эзэмшлийн онол;

• Иргэний энх тайвны онол;

• Пухтын онол зэрэг олон онол бий болж, эдгээрээс эзэмшлийн сонгодог онолууд болох субъектив болон объектив онол нь түлхүү хөгжиж, эх газрын тогтолцоотой орнуудын хууль, эрх зүйд биеллээ олсон болох нь судалгааны явцад тогтоогдсон. Монгол Улсын Иргэний хуулийн 11 дүгээр бүлгийн эзэмшлийн эрх зүйн зохицуулалт төдийгүй, зарим талаар онолын хувьд зөрчилдсөн зохицуулалт хийгдсэн болох нь судалгааны явцад ажиглагдсан юм. Өөрөөр хэлбэл, онолын суурь судалгаа, мэдээлэл дутмагаас эзэмшлийн талаар нэгдсэн ойлголт байхгүй буй нь зарим нэг сөрөг үр дагаврыг бий болгож байна. Иймд эзэмшлийн онолын үзэл баримтлалыг судалгааны үндсэн дээр тогтоон хэвшүүлэх нь зүйтэй гэж үзэж буй бөгөөд энэхүү судалгааны ажлын зорилго ч үүнд чиглэсэн юм. Эзэмшил бол аливаа нэг этгээдээс эд юмстай харьцаж буй харьцаа, эд юмсыг бодитойгоор мэдэлдээ байлгаж буй байдал гэдэг нь судалгааны явцад батлагдаж байна. Өөрөөр хэлбэл, эд юмсыг эзэмшиж буй этгээд тухайн эд юмсыг эзэмших

эрхтэй эсэхээс үл хамаарч мэдэлдээ байлгаж байгаагаар эзэмшил тодорхойлогддог тухай эзэмшлийн объектив онолыг чиг баримжаалж, Монголын Иргэний эрх зүйн хэм хэмжээг загварчлах шаардлагатай гэж үзэж байна. Гэхдээ хэт нэг талыг буюу дан объектив онолыг баримтлах нь явцуу болох учраас эзэмшлийн хууль ёсны байх, хууль ёсны болон шударга эзэмшигчийн эрхийг хамгаалах асуудлыг түлхүү анхаарсан бодлого баримтлах нь зүйтэй. Ингэснээр хулгайн болон хууль бус эзэмшлийг хамгаалах зохицуулалтаас татгалзаж чадах юм. Мөн эзэмшилтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын объектив шинжийг гол хүчин зүйл болгон логик уялдаатай авч үзсэнээр хууль тогтоомжийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэхэд ач холбогдолтой болох юм. Түүнчлэн субъектив онолын хүсэл зориогийн шинж чанарыг хэвээр хадгалж үлдэх нь эзэмшигчийн жинхэнэ санааг тодорхойлоход ач холбогдолтой хэвээр байх болно.

Дүгнэлт: Монголын иргэний эрх зүйд "Эзэмшил"-ийн онолын үзэл баримтлалыг тодорхойлоходоо эзэмшлийн объектив онолыг түлхүүгээр болон субъектив онолыг оролцуулан холимог хэлбэрээр тогтоох нь манай Иргэний хуульд зөв зохицуулалтыг тогтоох боломжийг бүрдүүлнэ.

Иргэний хууль дахь Эзэмшлийн зохицуулалтын талаар

1. Монгол Улсын Иргэний шинэ хуульд эзэмшлийн талаархи ойлголтыг өмнөх Иргэний хуулиудад өмчлөх эрхийн нэг элемент гэж үзэж байснаас татгалзаж илүү өргөн хүрээнд авч үзэн эд юмсын эрхийн нэг институ́т болохын хувьд зохицуулсан нь **томоохон дэвшил** болсон гэж үзэж байна. Эзэмшил нь нийгмийн харилцаа болохын хувьд эдийн засгийн

амьдралд хамгийн түгээмэл байдаг, өмчлөлөөс илүү өргөн хүрээтэй учраас эрх зүйн нарийвчилсан зохицуулалт шаардлагатай юм.

2. Ерөнхийдөө Монгол Улсын Иргэний хуулийн 11 дүгээр бүлгийн зохицуулалтыг буюу эзэмшлийн тухай зүйл, заалтуудыг авч үзэхэд Иргэний хуулийн төслийг боловсруулахаас өмнөх үеийн судалгаа шинжилгээ бага хийгдсэн нь харагдаж байна. Учир нь эзэмшлийн талаархи зохицуулалтад Германы хуульчдын санал, зөвлөгөөг авсан хэдий ч эзэмшлийн агуулгыг тодорхойлсон 89 дүгээр зүйлд эзэмшлийг хууль ёсны замаар үүснэ гэсэн нь энэхүү ойлголтын **объектив шинжийг үгүйсгэсэн** зохицуулалт болсон байна. Тодруулбал, эзэмшлийг хууль ёсны байх ёстой гэж буй нь эзэмшлийн ангилал болон логик уялдааг алдагдуулж байна. Эзэмшлийг хууль ёсны болон хууль бус гэж ангилж буй бөгөөд харин хууль бус эзэмшлийг дотор нь шударга ба шударга бус гэж ангилдаг. Харин Монголын Иргэний хуульд онговчтой томъёолоогүйгээс хууль ёсны эзэмшлийг дотор нь шударга ба шударга бус гэж ангилж болох мэт ойлгогдохоор байгаа юм. Нөгөө талаар шүүхийн практикт Иргэний хуулийн 89 дүгээр зүйлийг хэрэглэхэд буюу хууль ёсны болон хууль бус эзэмшлийг тогтооход "хууль ёсны байх" тухай дээрхи асуудал нь эзэмшлийн талаархи үндсэн ойлголтыг төөрөгдүүлж, **хууль хэрэглэхэд төвөгтэй** байдлыг бий болгож буй нь судалгааны явцад тогтоогдсон.

• Дээрхи асуудлаас үүдээд Иргэний хуульд эзэмшил хууль ёсны болон хууль бус байх, хууль бус эзэмшил нь шударга болон шударга бус байж болохыг ялгамжтайгаар хуульчилж өгөх шаардлагатай байгаа ба

• Иргэний хуульд хууль ёсны эзэмшигчийн бусдын хууль бус эзэмшлээс эд хөрөнгөө гаргуулахаар шаардах, эсхүл

ээзмших эрхэд саад болж буй үйлдлийг зогсоохыг шаардах зэргээр хууль ёсны эзэмшигчийн эрхийг хамгаалсан заалт оруулах нь зүйтэй гэж үзэж байна. Иргэний хуулийн 92 дугаар зүйлийн зохицуулалт нь зөвхөн шударга эзэмшигчид хамааралтай бөгөөд хууль ёсны эзэмшигч энэ тохиолдолд хэрхэх талаар тодорхой зохицуулалт байхгүй байгаа нь уг хуулийн логик уялдаа алдагдсантай холбоотой юм.

3. Иргэний хуулийн 89 дүгээр зүйлд "эрх эзэмших" тухай хуульчилсан нь ойлгомжгүй байгааг анхаарах хэрэгтэй юм. Учир нь эд юмсын эрх зүйд эрх эзэмших тухай ойлголт байдаггүй. Иргэний хуульд эрх эзэмших асуудлыг тусгахдаа эд юмсын хязгаарлагдмал эрхүүдийн хүрээнд ойлгож оруулсан байх магадлалтай. Утгаа бол эд юмсыг бодит байдлаар эзэмшдэг тухай онолын дагуу эрхийг эзэмших асуудал нь хууль зүйн утгаараа боломжгүй гэж үзэж байна. Эндээс үзэхэд эзэмшил болон эд юмсын хязгаарлагдмал эрхийн харилцан хамаарлын талаар тусгайлан судлах шаардлагатай бөгөөд судал-гаандаа үндэслэн эрх эзэмших тухай ойлголт байх эсэхийг тогтоох, мөн түүний эрх зүйн зохицуулалтыг зөв тодорхойлох нь зүйтэй.

4. Иргэний хуулийн 11 дүгээр бүлэгт хууль ёсны болон шударга эзэмшигчийн эрхийг хамгаалах зорилгоор, цаг хугацаа болон хөрөнгө хүчний талаас боломжийн арга болох, эзэмшлийн хамгаалалтын гол аргуудын нэг өөртөө туслах аргын талаар тусгайлан дурдаж өгөх шаардлагатай. Ингэснээр хууль ёсны эзэмшигчийн эд юмсын эрхийг хамгаалах чухал зохицуулалт бий болох юм.

Бусад

1. Газар эзэмших асуудлын хувьд эзэмшлийн талаархи үндсэн асуудалд Иргэний хуулийн эзэмшлийн зохицуулалтыг баримтлах ёстой юм. Тиймээс газрын тухай холбогдох ойлголтуудад эзэмшлийн

ойлголтыг Иргэний хуулиас гадгуур зохицуулсан байх үчиргүй. Үүнтэй холбоотойгоор газар эзэмших тухай асуудлыг тусгайлан авч үзэн судалж, Иргэний хуулийн эзэмшлийн зохицуулалттай газрын талаархи хуулиудын холбогдох заалтууд нийцэж буй эсэхийг судлан үзэж, хэрэв зөрчилдөөнтэй байх аваас нийцүүлэх ажлыг хийх хэрэгтэй юм.

2. Энэхүү судалгаагаар "эзэмшил"-ийн талаар харьцангуй судалгаа багатай манай орны хувьд энэхүү сэдвийг улам гүнзгийрүүлэн судалж үзэх нь хууль зүйн шинжлэх ухаанд, иргэний эрх зүйн хөгжилд бодитой хувь нэмэр оруулна гэж үзэж байна. Үүний тулд хуульч эрдэмтэн, судлаачид, хуулийн ангийн оюутнуудын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эзэмшил болон эд юмсын хязгаарлагдмал эрхийн (бусдын газар дээр барилга байгууламж барих, сервитут, уузуфрукт) хүрээнд дэх нарийвчилсан судалгаанд чиглүүлэх шаардлагатай юм.

ИРГЭНИЙ ХУУЛЬД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН САНАЛ:

Энэхүү судалгааны ажлын хүрээнд Монгол Улсын Иргэний хууль дахь "эзэмшил"-ийн талаар зохицуулсан зарим зүйл, заалт, хэсгийг дараах байдлаар өөрчлөн найруулах саналтай байна:

Нэгдүгээрт, 89 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг "Хүсэл зоригийн дагуу эд юмсыг бодитоор эрх мэдэлдээ авах замаар эзэмшил үүснэ." Энэ тохиолдолд бодитоор эрх эзэмших тухай асуудлын практик үйлчлэл судалгааны явцад тогтоогдохгүй байсан тул, нөгөөтэйгүүр 98 дугаар зүйлийн зохицуулалт нэгэнт буй тул "эрх"-ийг эзэмшил үүсэх хэсгээс хассан болно. 89 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "... дундаа хамтран эзэмшиж байвал ..." гэж оруулах.

Хоёрдугаарт, 90 дүгээр зүйлийг бүхэлд нь өөрчлөн найруулах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, эзэмшлийн хууль ёсны

болон хууль бус байж болох тухай ангиллыг 89 дүгээр зүйлд тодорхойлоод 90 дүгээр зүйлд "Хууль бус эзэмшил нь шударга болон шударга бус гэсэн хэлбэртэй байна" гэсний дагуу шударга болон шударга бус эзэмшигч гэж хэнийг ойлгох тухай 94 болон 95 дугаар зүйлүүдэд тодорхойлон тусгавал шударга эзэмшигчид хамгаа-лалтыг хэрэгжүүлэхэд ойлгомж-той, тодорхой болно.

Гуравдугаарт, Хууль ёсны эзэмшигчийн эрхийг хамгаалах зорилгоор, эзэмшлийн хамгаалалтын гол аргуудын нэг болох өөртөө туслах аргын талаар эзэмшлийн талаархи 11 дүгээр бүлэгт тусгайлан дурдаж өгөх шаардлагатай. Ийнхүү тусгахдаа өөртөө туслах аргыг хэрэгжүүлэх боломжийг зөвхөн хууль ёсны болон шударга эзэмшигчид олгохоор зааж, мөн хязгаарлалтын хэр хэмжээг оруулах нь зүйтэй.

Дөрөвдүгээрт, 93 дугаар зүйлд хууль ёсны эзэмшигчийн хууль бус эзэмшлээс эд хөрөнгөө шаардах болон эзэмших, ашиглах эрхэд саад болж буй үйлдлийг зогсоохыг шаардах эрх олгосон зохицуулалт тусгайлан оруулах шаардлагатай. Гэхдээ энэхүү зохицуулалт нь өмчлөгч бус хууль ёсны эзэмшигчид чиглэсэн байхаараа Иргэний хуулийн 106 дугаар зүйлээс ялгагдах бөгөөд гол нь зүйлчлэлийн талаасаа эзэмш-лийн талаархи бүлэгт хамаарч байх юм. Энэ тохиолдолд 106 дугаар зүйлийн 4 дэх заалт шаардлагагүй болох юм. Эсвэл дээрхи зохицуулалтыг эзэмш-лийн хэсэгт тусгайлан оруулах-гүй тохиолдолд 106 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Энэ хуулийн 1-3 дахь заалт хууль ёсны эзэмшигчид нэгэн адил хамаарна" гэж өөрчлөх нь зүйтэй. Ингэснээрээ хууль ёсны эзэмшигчийн эд хөрөнгө шаардах эрхийг давхар баталгаажуулах ач холбогдолтой.



ХЗҮТ-ийн Иргэний хууль тогтоомжийн секторын
эрдэм шинжилгээний ажилтан О.ОТГОНБАЯР

ШҮҮХИЙН ЖУРМААР ГЭРЛЭЛТ ЦУЦЛАХ НЬ ГЭРЛЭЛТ ДУУСГАВАР БОЛОХ НӨХЦӨЛ МӨН

Энэхүү нийтлэлээр шүүхийн журмаар гэрлэлтээ цуцлуулахын онцлог, шүүхэд нэхэмжлэл гаргасан этгээдийн онцлог, гэрлэлтээ цуцлуулах болсон шалтгаан зэргийг хөндөхийг зорилоо.

Гэрлэлтийн харилцааг дуусгавар болгох зохицуулалтын үндсэн хэлбэр нь гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлах явдал юм.

Гэрлэлтийн үр дүнд бий болсон эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон гэрлэгчдийн хамтын амьдрал тэдний хүсэл зоригийн үндсэн дээр эрх бүхий байгууллагаас тогтоосон журмын дагуу дуусгавар болох асуудлыг гэрлэлт цуцлалт гэж ойлгоно.

Шүүхийн журмаар гэрлэлтээ цуцлуулах харилцааны гол онцлог нь гэрлэгчид хоорондоо харилцан тохиролцох боломжгүй нөхцөл байдал болох хүүхдийн асрамж, эд хөрөнгө, тэжээн тэтгэх маргаантай байдгаараа захиргааны журмаар гэрлэлтээ цуцлуулахаас ялгаатай юм.

2007 онд 2579 гэр бүл гэрлэлтээ цуцлуулсан байгаа нь өмнөх онтой харьцуулбал 342 хэргээр буюу 15.28 хувиар өссөн байна.

Улсын дээд шүүхээс гэрлэлт цуцлалттай холбоотой маргааныг 1999-2008 оны II улирал хүртэл шийдвэрлэсэн статистикийг үзүүлбэл:

Гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлуулсан тоо¹

/Улсын хэмжээнд/

№	Он	Нийт шийдвэрлэсэн гэр бүлийн маргаан	Гэрлэлт цуцлалт
1.	1993	2782	
2.	1994	2101	
3.	1995	1996	
4.	1996	2504	
5.	1997	2410	
6.	1998	2485	1637
7.	1999	2191	1425
8.	2000	2192	1517
9.	2001	2412	1657
10.	2002	2630	1799
11.	2003	2777	1890
12.	2004	2939	2004
13.	2005	2955	2094
14.	2006	2989	2237
15.	2007	3544	2579
16.	2008 оны II улирал	1677	1244
Нийт		40584	20083

2008 оны хагас жилийн байдлаар 1677 гэр бүл гэрлэлтээ цуцлуулсан нь нийгэмд гэр бүл салалтын тоо өсөн нэмэгдэх хандлагатай байгааг харуулж байна.

Харин гэрлэлтээ цуцлуулсны бүртгэл хийлгэсэн гэр бүлийн тоо нь улсын хэмжээнд 2006 онд 1354 байгаа бол 2007 онд 1734 байгаа нь өмнөх оныхоос 28 хувиар өссөн байна. Гэвч улсын хэмжээнд шүүхийн журмаар гэрлэлтээ цуцлуулсан гэр бүл 2579 байгаа тоотой харьцуулбал 845 буюу 48.8 хувиар бага байгаа нь Иргэний бүртгэлийн хуульд "Гэрлэлтээ шүүхийн журмаар цуцлуулсан иргэн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш 10 хоногийн дотор иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд бүртгүүлнэ" гэж зааснаар бүртгүүлж гэрлэлт цуцлуулсны гэрчилгээ аваагүй байгаа буюу хуулийн энэ заалт төдийлөн сайн хэрэгжихгүй байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Гэрлэлт цуцлалтын бүртгэл

/Улсын хэмжээнд/

№	Он	Гэрлэлт цуцлалтын бүртгэл
1	1999	756
2	2000	928
3	2001	574
4	2002	558
5	2003	1050
6	2004	791
7	2005	1653
8	2006	1354
9	2007	1734
Нийт		9398

Гэр бүлийн тухай хуульд "Шүүх гэрлэлт цуцалсан тухай шийдвэрийн хувийг хүчин төгөлдөр болсноос хойш ажлын гурав хоногийн дотор гэрлэлтийг бүртгэсэн иргэний бүртгэлийн байгууллагад явуулна" гэж

¹ Улсын дээд шүүхийн судалгааны төвөөс авсан статистик

заасан үүргээ шүүх биелүүлж байгаад судалгаа хийх хэрэгцээ, шаардлага байгааг харуулж байна.

Шүүхийн журмаар гэрлэлтээ цуцлуулсан 256 хавтас хэрэгт дараахь байдлаар дүн шинжилгээ хийлээ. Үүнд:

Гэрлэлтээ шүүхийн журмаар цуцлуулсан хавтас хэрэгт дүн шинжилгээ хийсэн байдал

/Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянгол, Баянзүрх дүүргийн
шүүхээр 1999, 2007 онд шийдвэрлэсэн 256 хэрэг/

[illegible]

Чингэлтэй дүүргийн шүүхээр 1999-2007 онд нийт 11055 иргэний хэрэг3 шийдвэрлэснээс гэр бүлийн маргаантай холбоотой 1322 хэрэг шийдвэрлэсэн байна. Үүнээс:

◆ Гэрлэлт цуцлахаар шийдвэрлэсэн 1031 хэрэг буюу 78 хувь

- ◆ Гэрлэлт цуцалж, хүүхдийн асрамжийн маргаан шийдвэрлэсэн 23 хэрэг буюу 1.8 хувь
- ◆ Гэрлэлт цуцалж, хүүхдийн тэтгэлэг гаргуулах маргааныг шийдвэрлэсэн 54 хэрэг буюу 4.1 хувь

- ◆ Гэрлэлт цуцалж, дундын эд хөрөнгө хуваах маргааныг шийдвэрлэсэн 2 хэрэг буюу 0.15 хувь
- ◆ Гэрлэлт цуцалж, хүүхдэд асрамж тогтоож, тэтгэлэг гаргуулах маргааныг шийдвэрлэсэн 5 хэрэг буюу 0.37 хувь
- ◆ Гэрлэлт цуцалж хүүхдэд асрамж тогтоолгож, дундын эд хөрөнгөө хуваах маргааныг шийдвэрлэсэн 1 хэрэг буюу 0,07 хувийг тус тус эзэлж байна.

Гэр бүлийн маргааныг шийдвэрлэсэн нийт хэргийн 78 хувийг гэрлэлт цуцлалттай холбоотой маргаан эзэлж байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 129 дугаар зүйлд шүүгч шаардлагатай гэж үзвэл гэр бүлийн холбогдолтой хэрэг маргааныг шийдвэрлэхдээ насанд хүрээгүй хүүхэд болон хөдөлмөрийн чадваргүй эцэг, эхийг тэжээн тэтгүүлэх, насанд хүрээгүй хүүхдийг эцэг, эхийн хэн нэг дээр байлгах, гэрлэгчдийг тусдаа амьдрахыг даалгах, гэрлэгч хэн нэгийг тэжээн тэтгүүлэх, орон сууц болон хамтран өмчлөх дундын өмч, үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрхийг бусдад шилжүүлэх, худалдах, бэлэглэх, захиран зарцуулахыг хориглох, шүүхийн зардлын зохих хувийг урьдчилгаа болгон төлүүлэх, зохигчийг эвлэрэх талаар хугацаа заах гэсэн арга хэмжээг урьдчилан авахаар захирамж гаргаж болно гэж заасан.

Гэр бүлийн тухай хуульд зааснаар шүүх шаардлагатай гэж үзвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж, энэ хугацаанд гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээ авна гэж заасны дагуу 2007 онд Сонгинохайрхан, Баянгол, Чингэлтэй, Баянзүрх дүүргийн шүүхээр, 1999 онд Баянгол дүүргийн шүүхээр

шийдвэрлэсэн 256 хэргээс 37 хэрэг буюу 14.4 хувьд нь зохигчийг 14 хоногоос 3 сар хүртэл хугацаагаар эвлэрүүлэх хугацаа заасан байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлд зааснаар зохигчид эвлэрсэн 5, шүүхээс заасан эвлэрүүлэх хугацаанд 8 зохигч эвлэрсэн байна.

Улсын дээд шүүхийн 2002 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн Гэр бүлийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай 71 дүгээр тогтоолын 11-д "Гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээ авна" гэдэгт гэрлэгч тус бүртээ ганцаарчилан уулзах, зөвлөлгөө өгөх, гэрлэлтийг цуцлуулах болсон шалтгаануудыг нарийвчлан судалж үндэслэлтэй эсэхийг нь тайлбарлах, шаардлагатай тохиолдолд сэтгэл судлаач, сурган хүмүүжүүлэгчдийг татан оролцуулах зэрэг гэрлэгчдийг эвлэрүүлэхэд ач холбогдолтой бүхий л арга хэмжээг авна гэж тайлбарласан боловч шүүхийн практикт шүүгч л гэрлэгчдэд гэрлэлт цуцлуулсаны үр дагаварыг тайлбарлаж байгаа болохоос биш сэтгэл судлаач, сурган хүмүүжүүлэгчийг татан оролцуулж тэр бүр чадахгүй байна. Мөн сэтгэл судлаач, сурган хүмүүжүүлэгчид хандлаа гэхэд тэр хүмүүс ирж бодитой зөвлөлтөө өгөхөд эргэлзээтэй байна.

Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянгол, Баянзүрх дүүргийн шүүхээр 2007 онд Баянгол дүүргийн шүүхээр 1999 онд шийдвэрлэсэн 256 хэргийн шийдвэрлэсэн байдлыг авч үзвэл:

◆ Нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн-231 /90.2 хувь/

◆ Давж заалдах гомдол гаргасан-3 /1.1 хувь/

◆ Талууд эвлэрсэн -13 /5.3 хувь/

◆ Н э х э м ж л э л г ч нэхэмжлээсээ татгалзсан-8 /3.1 хувь/

◆ Хариуцагч шаардлагыг хүлээн зөвшөөрсөн-1 /0.3 хувь/

◆ Хэргийг хэрэгсэхгүй болгосон-3 /1.1 хувь/

Дүгнэлт:

1. Гэр бүлийн маргааныг гэр бүлийн асуудлаар мэргэшсэн шүүгч шийдвэрлэдэг болох, гэр бүлийн гишүүдийн эрхийг зөрчих, дарамт шахалт үзүүлэх, хүчирхийлэх явдалтай тэмцэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох арга хэмжээнүүдийг шат дараалан чанартай гүйцэтгэснээр 2003 онд Улсын Их Хурлаас 16 дугаар тогтоолоор Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гэр бүлийн эрх зүйн орчинг боловсронгуй болгоно. Эрх зүйн орчин боловсронгуй болсноор шүүхээр шийдвэрлүүлж буй Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар шийдвэрлүүлэх маргааны тоо буурах давуу талтай юм.

2. 2007 онд шийдвэрлэсэн нийт хэргийн 11.6 хувь гэр бүлийн харилцаатай холбоотой маргаан эзэлж байгаа нь өмнөх оноос 18.6 хувиар өссөн байгаа нь жил бүр гэр бүлийн харилцаатай холбоотой маргаан өсөн нэмэгдэж байгааг харуулж байна. Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-т "... эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно" гэж заасны дагуу гэр бүлийн дагнасан шүүхийг байгуулах хэрэгцээ, шаардлага аль хэдийнээ бий болсон байна.

3. Гэр бүлийн тухай хуульд "Гэрлэгчид бие биедээ үнэнч байх" үүргийг хүлээхээр

зааж өгсөн. 1999, 2007 онд 4 дүүргийн шүүхээр шийдвэрлэсэн гэрлэлт цуцлалттай холбоотой 256 маргаан байна. Хавтаст хэрэгтэй танилцаж байх явцад гэрлэлтээ цуцлуулахаар ямар шалтгаанаар хандсан байдлыг авч үзвэл нийт маргааны 18 хувь нь хардалтаас, тусдаа амьдралтай болсон гэж хариулсан нь хууль ёсны гэр бүл нь бие биедээ үнэнч биш байсныхаа төлөө ямар хариуцлага хүлээх талаар нарийвчлан зохицуулах хэрэгтэй болов уу.

4. ХЗДХЯ-ны дэргэд эсвэл төрийн бус байгууллагын статустай "Гэр бүлийн маргааныг эвлэрүүлэн зуучлах байгууллага"-ыг байгуулж "Төрөөс гэр бүлийн хөгжлийг талдаар баримтлах бодлого"-д заасан арга хэмжээ, сургалт, таниулах ажлыг цогцоор нь хэрэгжүүлэх чиглэлтэй байхаар зохион байгуулах;

5. Төрөөс гэр бүлийн хөгжлийг талаар баримтлах бодлогод заасан аймаг, нийслэлийн түвшинд хүн ам, гэр бүлийн асуудал хариуцсан хэлтэс, сум, дүүрэг, хооронд гэр бүлд туслах нийгмийн ажилтан ажиллуулах;

6. Сургалт, мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг дагнасан байгууллага болох Хууль зүйн үндэсний төвийг түшиглэн Нийслэл, дүүргийн шүүх, Хүүхдийн төлөө үндэсний газар, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвтэй хамтран эрүү, иргэн, захиргааны чиглэлээр мэргэшсэн, ажиллаж байгаагаас нь үл хамааран бүх чиглэлийн хуульч, иргэний бүртгэлийн байгууллагын ажилтан, дүүрэг, хороодын нийгмийн ажилтан, цагдаагийн ажилтан, бусад ажилтан, албан хаагчдад гэр бүлийн эрх зүйн талаар сургалт тогтвортой явуулж хэвшүүлэх.



МУИС-ийн Хууль зүйн сургуулийн
Төр, захиргааны эрх зүйн тэнхимийн багш
Г.БАНЗРАГЧ (РН.Д)

ГЕРМАН УЛСЫН ЗАХИРГААНЫ ШҮҮХИЙН ХӨГЖЛИЙН ТУХАЙ ТОЙМ

Өнөөгийн Герман улсын Захиргааны шүүх нь урт удаан хугацааны түүхэн хөгжлийн явцад янз бүрийн үзэл бодлын зөвшилцлийн үр дүнд бий болсон институт билээ. Захиргааны шүүхийн мөн чанарыг тодорхойлохын тулд захиргааны үйл ажиллагааны эсрэг иргэдэд үзүүлж байсан эрх зүйн туслалцааны хэлбэрүүдэд анхаарлаа хандуулах шаардлагатай юм. Дор хөндөгдөх асуудлууд нь зөвхөн өнөөгийн Захиргааны шүүх эрх мэдлийн шинж чанарыг тодорхойлоход ач холбогдол бүхий асуудлуудаар хязгаарлагдана. Тухайлбал, Захиргааны шүүх эрх мэдэл хэдийд, яагаад, хэрхэн үүссэн болон ямар зорилгыг агуулж байсан, түүнчлэн ямар түүхийн бэрхшээлийг даван туулсан, ямар үр дүнд хүрсэн гэх мэт.

Герман улсын Захиргааны шүүхийн хөгжлийг дараах үед ангилж болох юм.

1. Герман үндэстний Ариун Ромын эзэнт гүрний үе дэх Захиргааны эрх зүйн туслалцаа (1495-1806);

2. Герман үндэстний Ариун Ромын эзэнт гүрний бутралын дараах үе дэх Захиргааны шүүхийн анхны хэлбэрүүд (1806-1919);

а. XIX зууны эхний хагас үе Administrativjustiz;

б. XIX сүүлийн хагас үе Justizstaat.

3. Ваймарын Бүгд Найрамдах Улсын үеийн Захиргааны шүүх (1919-1933);

4. Гуравдугаар гүрний үе дэх Захиргааны шүүхийн уналтын үе (1933-1945);

5. Захиргааны шүүхийн дахин сэргэлтийн үе (1945-1990)

6. Захиргааны шүүхийн хөгжлийн орчин үе (1990 оноос хойш өнөөг хүртэлх).

1. Герман үндэстний Ариун Ромын эзэнт гүрний үе дэх захиргааны эрх зүйн туслалцаа

Герман улсад Захиргааны тусгай шүүх нь XIX зууны хоёрдугаар хагаст бий болсон хэдий ч эрхэс дээдсийн эсрэг хувь этгээдэд үзүүлэх эрх зүйн туслалцааны анхын хэлбэр нь бүр Герман үндэстний Ариун Ромын эзэнт улсын (Heiliges Roemisches Reich Deutscher Nation) үед үүсчээ. Энэхүү эзэнт улс нь 1806 оныг дуустал оршин тогтносон бөгөөд түүний шүүх эрх мэдлийн байгууллага нь "Эзэнт гүрний танхимын шүүх" (Reichskammergericht) болон "Эзэнт гүрний дээд зөвлөл" (Reichshofrat) байжээ.¹

1.1. Эзэнт гүрний танхимын шүүх

"Эзэнт гүрний танхимын шүүх"-ийг анх 1495 онд улс төр, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд

эзэн хааны мэдлийн дор байгуулжээ. Учир нь энэ шүүхийн өмнөх хэлбэр болох "хааны танхимын шүүх" (Koenigliches Kammergericht) нь хааныг хаа байгаа газар нь дагалдан явдаг, суурин биш байсан нь эзэнт гүрний нутаг дэвсгэр тэлэхийн хэрээр төвөгтэй болж эхэлсэн бөгөөд энэ нь тухайн үеийн улс төрийн нөхцөл байдалд сөргөөр нөлөөлж байжээ. Энэхүү сул талыг өөрчлөхийн тулд 1495 онд Worms-д дээд язгууртнууд Reichstag-ийг хуралдуулан дээд шүүхийг суурин болгохоор шийдсэн байна. Тухайн үеийн эзэн хаан I Maximilian уг шаардлагыг хүлээн авахаас өөр аргагүй байдалд хүрчээ.²

Эзэнт гүрний танхимын шүүхийн³ зорилго нь "улс гүрний мөнхийн найрамдалт байдал"-ыг хангах явдал байв. Мөнхийн найрамдал гэдэгт эзэнт гүрний дотор эрхэс ноёдоос өөрсдийн эрхээ хамгаалахын тулд аливаа хүч хэрэглэхээс татгалзах тухай (ялангуяа өшөө хонзон авахыг хориглох⁴) тэдний хоорондын гэрээний шинжтэй зөвшилцөлийг хэлнэ. Энэхүү зөвшилцөлийн үр дүнд аливаа хэрэг маргаан нь тэмцлийн замаар бус шүүхийн журмаар шийдвэрлэгдэх ёстой бөгөөд энэ чиг үүргийг эзэнт гүрний танхимын шүүх хэрэгжүүлэхээр заажээ. Эзэнт

¹ Wuerftenberger, Mep. 37.

² Sellert, x.

³ Эзэнт улсын шүүх нь 1495 оны 10 дугаар сарын 31-нд Франкфурт Майнд байгуулагдсан бөгөөд 1527 оноос Шпайерт, түүнийг сүйдсэний дараа 1689-1806 онд Ветцларт байрлаж байжээ.

⁴ Өшөө авах нь эртний Германы эрх зүйд хамаарах гэмт хэргийг шийтгэх арга бөгөөд үүнийг хохирогчийн омгийнхон гэмт хэргэний омгийн эсрэг хэрэглэдэг байсан байна.

гүрний танхимын шүүх нь шийдвэр гаргахдаа нийтлэг эрхийг⁵ хэрэглэж байсан бөгөөд процессын хувьд эзэн хаан болон Reichstag-ийн хамтран баталсан журмаар зохицуулагдаж байв. Түүнээс гадна уг шүүх нь өөрөө шийдвэр гарган процессын хэм хэмжээг тогтоож байжээ.

Эзэнт гүрний танхимын шүүх нь анхан шатны шүүхийн шийдвэрийг хяналтын шатны журмаар хянах бөгөөд түүний эрх мэдэлд энгийн эрх иргэдээс эзэн ноёдынхоо эсрэг эрхээ хамгаалуулахаар гаргасан нэхэмжлэлүүд мөн хамаарч байжээ. XVIII зууны дунд хавиас энэ төрлийн нэхэмжлэлүүд эрс нэмэгдсэн байна. Эдгээрт барилга барих, оршин суух, аж ахуй эрхлэх, өмчийн эрх, биеийн халдашгүй байх зэрэг эрх хамаарч байжээ. Үүнээс үзвэл тухайн үед хэдийгээр нийтийн болон хувийн эрх зүйн ялгаа бий болоогүй байсан ч өнөөгийн ойлголтоор нийтийн эрх зүйд хамаарагдахуйц маргааныг эзэнт гүрний шүүх нь хянан шийдвэрлэж байжээ.⁶

Энэхүү шүүх нь тухайн үеийн эрх зүйн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Учир нь түүний үйл ажиллагааны үр дүнд эзэнт гүрний дотор эрх зүйн нэгдмэл байдал бий болсноор улс төрийн нэгдмэл байдал бий болоход чухал үүрэг гүйцэтгэжээ. Эзэн хаан нь улс орны эв найрамдлыг хангах болон шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх талаарх өөрийн монополь эрхийн зарим хэсгийг бусад эрх мэдэлтэнд (Reichstag-ийн гишүүдэд) шилжүүлсэн явдал нь "төрийн" байгууллагын (өөрөөр хэлбэл нэг хүний бус) засаглал бүрэлдэх эхэлсэн, энэ утгаараа эрх мэдлийн хуваарилалтын анхны хэлбэр бий болсныг харуулж байна.

1.2. Эзэнт гүрний дээд зөвлөл

I. Maximilian хаан дээд шүүхийг газар зүйн болоод зохион байгуулалтын хувьд эзэн хааны

хараат байдлаас ангижруулах тухай Reichstag-ийн шаардлагад дургүй байвч хүлээн зөвшөөрөхөөс өөр аргүй байдалд хүрсэн нь тэрээр XV зууны сүүлээр "Эзэнт гүрний дээд зөвлөл" хэмээх өөрийн гэсэн дээд шүүхийг байгуулахад хүргэжээ. Тийм ч учраас энэхүү шүүх нь эзэнт гүрний танхимын шүүхтэй харьцуулбал зохион байгуулалт, боловсон хүчний хувьд эзэн хаанаас шууд хараат байсан бөгөөд дээд шүүхийн хэлбэрээр түүнтэй зэрэгцэн оршиж байжээ. Эзэнт гүрний танхимын шүүх нь үүсэн байгуулагдснаасаа хойш "жинхэнэ" шүүхийн хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байсан бол дээд зөвлөл нь илүү зуучлах үүргийг (ялангуяа I Maximilian, V. Karl, I Ferdinand-ийн засаглалын үед) гүйцэтгэж байжээ. Дээд зөвлөл нь анхнаасаа процессын үйл ажиллагаанд бус харин талуудын ашиг сонирхлын зөрөлдөөнийг зохицуулах, тэдгээрийн хооронд зөвшилцөлийг олоход илүү анхаарлаа чиглүүлж байв.⁷ Түүний эрх мэдэлд эзэнт гүрний дотоод удирдлага, зохион байгуулалт, нутаг дэвсгэрийн хуваарилалт, эзэн хааны онцгой бүрэн эрхийн талаар болон улс төрийн зөрчилд амархан хүрэхүйц жижиг болон хүчтэй ноёрхлын хоорондын маргаанууд хамаарч байжээ. Үүнээс үзвэл орчин үеийн ойлголтоор дээд зөвлөл нь танхимын шүүхийг бодвол илүү төрийн эрх зүйн шинжтэй маргаануудыг шийдвэрлэж байсан нь харагдаж байна. 1806 онд Райны холбоо⁸ байгуулагдан эзэнт гүрнээс бие даан гарснаар Герман үндэстний Ариун Ромын эзэнт гүрэн эргэлт буцалтгүйгээр задран унах нөхцөлийг бүрдүүлсэн бөгөөд түүний хамт

шүүх эрх мэдлийн тогтолцоо нь үгүй болсон билээ.

2. XIX зуун дахь Захиргааны шүүхийн хөгжил (1806-1912)

2.1. XIX зууны эхний хагас: "Administrativjustiz"

1806 онд Ариун Ромын эзэнт гүрний шүүхийн тогтолцоо эргэлт буцалтгүйгээр задран унасны дараа буюу XIX зууны эхэн үеэс шинжлэх ухаан болон практикт захиргааны үйл ажиллагааны эсрэг эрх зүйн туслалцаа буюу хамгаалалт үзүүлэх асуудал илүү яригдах болжээ. Маргааны төвд энэхүү эрх зүйн хамгаалалт нь шүүх эрх мэдэлд хамаарах уу, эсвэл захиргаанд өөрт нь харьяалагдах уу (үүнийг Administrativjustiz гэж нэрлэж байсан) гэдэг асуудал тавигдаж байсан бөгөөд сүүлийн хэлбэр болох Administrativjustiz-т илүү анхаарлаа хандуулах болсон.⁹

Administrativjustiz гэдэг нь захиргааны байгууллагаас захиргааны эрх зүйн хамгаалалт үзүүлэх гэсэн утгатай юм.¹⁰ Энэхүү ойлголтыг дэмжигчид нь иргэн захиргаа хоёрын хоорондох маргааныг шүүхээс хянан шийдвэрлэхийг эрс эсэргүүцэж, түүний оронд харин захиргаа нь өөрөө маргааныг түргэвчилсэн журмаар шийдвэрлэх ёстой гэж үзэж байжээ. Уг үзэл баримтлалаа үндэслэхдээ: Эрх мэдэл хуваарилах онолын үүднээс шүүгч нь гүйцэтгэх засаглал буюу захиргааны тэргүүн байх учиргүй, гүйцэтгэх болон шүүх засаглал нь хоорондоо агуулга, мөн чанарын хувьд ялгаатай. Учир нь захиргаа нь эрх зүйн хүрээнд нийтийн ашиг сонирхлыг хэрэгжүүлдэг бол шүүхийн үйл ажиллагаа нь шударга ёсны үүднээс шийдвэр гаргахад чиглэгддэг.

⁵ Нийтлэг эрх гэдэгт тухайн үеийн Ромын болон Канонын (Католик сүмийн эрх) эрхүүд хамаарах бөгөөд энэ нь заншлын хэм хэмжээнээс ялгаатай.

⁶ Wuerftenberger, Мер. 37-38.

⁷ Sellert, x.

⁸ Rheinbund нь I. Наполеоны шахалтаар 1806 онд Парист байгуулагдсан Германы пан гүн нарын холбоо бөгөөд энэ нь Ариун Ромын эзэнт гүрнээс бие даан гарсан юм.

⁹ Stump, x. 21; Sydow, x. 11

¹⁰ Grawert, Verwaltungsrechtsschutz in der Weimerer Republik, in: FS fuer Menger, 1985, x. 47.

Энэхүү ялгаатай чиг баримжаанаас хамааран шүүгч нь захиргааны үйл ажиллагааны зорилгыг хангалттай таньж чадахгүй хэмээн үзэж байжээ.¹¹ Administrativjustiz нь шүүхийн процесс болон түүний үндсэн зарчмуудыг үүсгэж байсан тул түүнийг эрх зүйт төрийн үүднээс тодорхойлох боломжгүй юм.

Administrativjustiz нь XX зууны Захиргааны шүүхийн өмнөх хэлбэр гэхээсээ илүү өмнөх шат нь байсан¹² ба харин энэ нь орчин үеийн урьдчилан шийдвэрлэх ажиллагааны өмнөх хэлбэртэй илүү ойролцоо байсан гэж дүгнэж болохор байна.

Энэ үед төрийн эрх мэдлийг хуваарилах тухай асуудал зарчмын хувьд хүлээн зөвшөөрөгдсөн байсан. Гэхдээ эрх мэдлийг гурав ангилах тухай сонгодог ойлголтын хэмжээнд бус, харин хууль тогтоох, гүйцэтгэх гэсэн хоёр эрх мэдлийн хүрээнд илүү яригдаж байжээ.¹³ Шүүх эрх мэдлийн чиг үүрэг нь ердөө эрүүгийн хэрэг болоод зөвхөн албат иргэдийн хооронд үүссэн иргэний маргааныг хянан шийдвэрлэхээр хязгаарлагдаж байсан. Ямартаа ч хаант засаглалын эсрэг төрийн эрх мэдлийн хуваарилалтыг хүлээн зөвшөөрсөн явдал нь тухайн үеийн түүхийн ололт бөгөөд энэ нь Герман улсад цаашид эрх зүйт төрийн онол хөгжих үндэс суурь нь болсон билээ. Түүнээс гадна захиргааны үйл ажиллагааны эсрэг иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай асуудал анх удаа онол болон практикт гарч ирсэн нь чухал ач холбогдолтой байв. Ийнхүү аажмаар нийтийн эрх зүйн шүүх зайлшгүй хэрэгцээтэй болох нь эргэлзээгүй болсон хэдий ч гүйцэтгэх эрх мэдлээс шүүх эрх мэдэл тусгаарлахад цаг хугацааны хувьд арай эрт байсан.

2.2. XIX зууны хоёр-дугаар хагас: Захиргаа болон шүүхийн тусгаарлалт

XIX зууны хоёрдугаар хагаст Германд анх удаа захиргааны тусгай шүүх бий болсон билээ.¹⁴

Чухамхүү энэ үеэс л Германы эрх зүйн шинжлэх ухаан Англосаксоны эрх зүйн нөлөөн дор, гэхдээ өөрийн гэсэн онцлогтойгоор хөгжлийн шинэ шатанд шилжсэн юм. Тодруулбал "Rule of Law"¹⁵-оос "Эрх зүйт төр" ("Rechtsstaat") хэмээх шинэ ойлголтыг бий болгожээ. Энэхүү хоёр ойлголтын үүсэл хөгжил, хамрах хүрээ нь нэлээд ялгаатай юм. Robert von Mohl (1848/49 онд Франкфуртын үндэсний хурлын гишүүн, сүүлд Reichstag-ийн гишүүн байсан) анх удаа өөрийн бүтээлдээ "Эрх зүйт төр" хэмээх ойлголтыг хэрэглэжээ.¹⁶ Тэрээр 1840 онд: "Эрх зүйт төр буюу ард түмний төлөөлөл бүхий засаглалын мөн чанар нь төрөөс иргэнийг өөрийн зорилгодоо хүрэх арга хэрэгсэл болгоход бус, өөрөөр хэлбэл иргэн нь төрийн өмнө зөвхөн үүрэг хүлээсэн этгээд гэдэг үүднээс бус, харин иргэн өөрөө төрийн зорилго буюу халдашгүй эрхтэй этгээд болохыг хүлээн зөвшөөрөхөд орших юм. Тиймээс энэхүү төр иргэн хоёрын хоорондын харилцан хүлээх эрх үүргийг тодорхойлохын тулд Үндсэн хуулийг батлах ёстой бөгөөд, үүний үр дүнд тэдгээр эрх үүргийн агуулга болон хэлбэрийн талаарх маргаан тэр болгон үүсээд байхгүй юм"¹⁷ хэмээн бичиж байжээ. Иймд түүнийхээр эрх зүйт төрийн үндсэн зорилгын нэг нь иргэдийн үндсэн эрхийг хууль бус халдлагаас хамгаалах явдал байв.¹⁸

"Эрх зүйт төр"-ийн тухай ойлголтод "хууль ёсны" зарчмыг анх Otto Mayer (1846-1924) Францын эрх зүйгээс Германы эрх зүйд нэвтрүүлсэн бөгөөд "Захиргааны эрх зүй" хэмээх бүтээлдээ энэ эрх зүйт төрийн

үндсэн шинж хэмээн бичсэн байна.¹⁹ Түүний үзэж байснаар эрх зүйт төр гэдэг нь захиргаанаас хууль ёсны зарчмыг баримтлахыг хэлэх бөгөөд "хууль ёсны" зарчим нь "хуулийн нэмүү үнэлэмж" (Mehrwert des Gesetzes), "хуульд үндэслэх" (Vorbehalt des Gesetzes), "хууль дээдлэх" (Vorrang des Gesetzes) гэсэн ойлголтоос бүрдэнэ хэмээн үзжээ. Үүнээс "хуулийн нэмүү үнэлэмж" (Mehrwert des Gesetzes) хэмээх ойлголт нь хөгжлийн явцад ач холбогдлоо алдсан байна.²⁰ Харин "хуульд үндэслэх" болон "хууль дээдлэх" тухай ойлголт нь захиргааны үйл ажиллагааны болон эрх зүйт төрийн үндсэн зарчим болон үлджээ. Иймд захиргааны акт нь ямар нэгэн хуулийн үндсэн дээр гарсан эсэх, түүнчлэн энэ нь үйлчилж буй хуулиудад нийцсэн эсэхийг шалгадаг.²¹

Захиргааны тусгай шүүхийн үүсэл хөгжил нь дээрх эрх зүйт төрийн тухай ойлголттой салшгүй холбоотой. Учир нь эрх зүйт төрийн хэлбэрт нийтийн засаглал нь хууль, эрх зүйг баримтлах ёстой бөгөөд үүний үр дүнд иргэнийг төрийн дурар авирлах явдлаас хамгаалж чадах юм. Чухамхүү эндээс л нийтийн засаглалын эсрэг эрх зүйн хамгаалалтыг баталгаажуулах хараат бус, бие даасан шүүхийн тухай үзэл бодол бий болсон байна. Үүнтэй холбоотойгоор либерал үзэлтэнгүүд Administrativjustiz-ийг хэрэгжүүлэгч байгууллага нь боловсон хүчин болон үйл ажиллагааны хувьд захиргаанаас хараат байдаг, талуудын зарчим үйлчилдэггүй, түүнчлэн захиргааны албан тушаалтанд

¹¹ Stump, x. 21; Unruh, x. 12.

¹² Pahlow, x. 20, 30; Харьц. Hufen, § 1 Мөр. 2.

¹³ Pahlow, x. 23.

¹⁴ Ruefner, Verwaltungsrechtsschutz in Preußen, 1962.

¹⁵ A.V. Dicey, The Law of the Constitution, London, 1959, p. 202.

¹⁶ Nowatius, x. 60.

¹⁷ R. V. Mohl, Bd. 1, x. 323.

¹⁸ Unruh, x. 15-16.

¹⁹ Mayer, x. 92-93.

²⁰ Forsthoff, Die Umbildung des Verfassungsgesetzes, in: FS fuer Carl Schmitt, 1959, x. 35.

²¹ Харьц. Rupp, x. 54..., x. 143.

шүүх үйл ажиллагаа явуулахад шаардлагатай эрх зүйн мэдлэг дутагдалтай байдаг, шүүх үйл ажиллагааг зохицуулсан журам байхгүй тул шударга шийдвэр гарах баталгаа байхгүй зэргээр ширүүн шүүмжлэх болжээ. Иймд иргэний зөрчигдсөн эрхийг гагцхүү хараат бус хөндлөнгийн "жинхэнэ" шүүх л хамгаалж чадна хэмээн үзэж байв.²²

Эдгээр шаардлага нь XIX зууны дунд үеэс улам хүчээ авах болсон бөгөөд 1849 оны Паулын сүмийн Үндсэн хуулийн (Paulskirchenverfassung) 183 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: "Захиргаанаас шүүх үйл ажиллагаа явуулахыг хориглоно: бүхий л эрхийн зөрчлүүд нь шүүхээр шийдвэрлэгдэнэ" хэмээн заажээ. Ийнхүү захиргаанд тавих хяналтыг Administrativjustiz-ээс салгаж, энгийн шүүхэд шилжүүлсэн байна.²³ Хэдийгээр уг заалт нь энгийн шүүхээс салангид захиргааны тусгай шүүхийг байгуулах талаар дурдаагүй боловч гол нь захиргааны маргаан нь захиргааны байгууллагаас бус, харин хараат бус хөндлөнгийн шүүхээр шийдвэрлэгдэх ёстой гэдгийг онцолсон явдал нь чухал ач холбогдолтой байв.²⁴ Нөгөө талаар захиргаанд тавих хяналтыг ердийн шүүхэд хамруулах тухай нэгдмэл үзэл санаа ч байсангүй.²⁵ Энэхүү Үндсэн хуулийн зохицуулалт нь эцэстээ захиргааны тусгай шүүх байгуулах тухай үзэл бодлыг бий болгосон байна.²⁶

1864 онд Германы эрх зүй судлаач Otto Baehr эрх зүйт төр хэмээх нэр томъёог өөрийн бүтээлдээ нэлээд гүзгийрүүлэн судалсан байдаг. Түүнийхээр эрх зүйт төр гэдэг нь захиргааны үйл ажиллагаа нь шүүхээр хянагддаг байхыг ойлгож байсан. Өөрөөр хэлбэл, эрх зүйт төрийг захиргааны үйл ажиллагааг хянадаг хараат бус шүүхийн үйл ажиллагаагаар ойлгож байсан гэж хэлж болно.

XIX зууны 60-аад оны үеэс захиргааны үйл ажиллагаанд дахь

хууль ёсны хяналт болон зүй ёсны эрх зүйн хамгаалалт нь гагцхүү хараат бус бие даасан Захиргааны шүүхээр л хэрэгжих боломжтой гэсэн үзэл нэгэнт тогтжээ. Ийнхүү захиргааны эрх зүйн хөгжилтэй холбоотойгоор захиргааны бие даасан шүүхийг байгуулах тухай асуудал улам хүчээ авсан бөгөөд түүний үр дүнд өмнөд болон хойд Германы (буюу preußisches System) гэсэн Захиргааны шүүхийн хоёр тогтолцоо үүсчээ.

а) Хойд Германы буюу Пруссийн тогтолцоо

1875 онд Захиргааны шүүхүүд болон захиргааны маргааныг шийдвэрлэх үйл ажиллагааны тухай хуулийн дагуу Пруссийн Захиргааны дээд шүүх байгуулагджээ.²⁷ Төрийн болон захиргааны эрх зүйн онолч Rudolf von Gneist (1816–1895) уг хуулийн төсөлд ихээхэн нөлөөлсөн байдаг. Тэрээр объектив эрхийн хамгаалалтыг илүү чухалчилж байжээ.²⁸ Түүний гаргасан санал нь Английн self government-ийн зарчимд түшиглэж байв. Тодруулбал, захиргааны үйл ажиллагаанд тавих эрх зүйн хяналт нь Administrativjustiz-д хэвээр үлдэх ёстой ба гэхдээ түүний үйл ажиллагаа нь шүүхийн үндсэн зарчмуудын дагуу хэрэгжих нь зүйтэй гэж үзэж байжээ.²⁹ Ийнхүү тэрээр эрх зүйт төрийг үгүйсгэдэг гэдэг үндэслэлээр Administrativjustiz-ийн анхдагч хэлбэрээс ч (захиргааны албан тушаалтнуудын хэрэгжүүлдэг); шүүгчид нь захиргааны үйл ажиллагааны талаар хангалттай мэдлэггүй гэдэг үндэслэлээр ердийн шүүхийн хяналтын хэлбэрээс ч бас татгалзаж байв. Түүний үзэж байснаар эрх зүйн хяналтыг анхан болон давах шатанд

байнгын, бие даасан буюу хараат бус албан тушаалтан болон олон нийтийн төлөөлөгчөөс бүрдсэн хамтын байгууллага хэрэгжүүлэх нь зүйтэй байв. Энэхүү зөвлөлийн үйл ажиллагаа нь хараат бус, талуудын тэгш эрхийг баталгаажуулах ёстой. Уг хэлбэр нь маргааныг бүхэлд нь хянах боломжийг олгодоггоороо давуу талтай гэж үзсэн. Тэрээр хэргийн бодит болон эрх зүйн хүрээг ялган салгах нь маш төвөгтэй бөгөөд анхан шатанд ингэж ялгаж ч болохгүй, харин эцсийн шатны хяналт нь зөвхөн эрх зүйн асуудлаар хязгаарлагдах боломжтой юм, учир нь уг хяналтыг хэрэгжүүлэгч дээд шүүх нь хэргийн бодит байдлыг шийдвэрлэхэд хэт хол байдаг гэжээ. Энэ бүхнээс үзвэл тэрээр Захиргааны шүүх гэдгийг үнэн чанартаа өөр арга барил бүхий захиргаагаар л ойлгож байжээ. Гнеист-ийн загвар нь консерватив болон либерал үзлийн хоорондын зөвшилцөлийг эрэлхийлсэн арга байсан гэж үзэж болох юм.³⁰

Пруссийн Захиргааны шүүхийн байгууллага нь тойргийн зөвлөл (тойргийн Захиргааны шүүхийн хувиар), дүүргийн Захиргааны шүүх болон захиргааны дээд шүүхээс бүрдэж байжээ. Тойргийн зөвлөл нь Landrat буюу зөвлөлийн дарга болон бусад мэргэжлийн бус зургаан гишүүнээс, харин хотын зөвлөл нь Bürgermeister болон бусад дөрвөн гишүүнээс бүрдэж байв. Дүүргийн Захиргааны шүүх нь хаанаас бүх насаараа томилогдсон хоёр гишүүн (тазний нэг нь шүүхэд, нөгөө нь дээд шатны захиргааны байгууллагад ажиллаж байх ёстой байжээ) болон мэргэжлийн бус гурван гишүүнээс бүрддэг байжээ.³¹

²² Pohl, x. 26-29; Stump, x. 22; Харь, Sydow, x. 41-42.

²³ Hufen, § 1 Меп. 5.

²⁴ Wuerftenberger, Меп. 41; Unruh, x. 19; Vgl. Sommermann, x. 3.

²⁵ Hufen, § 1 Меп. 7; Unruh, x. 18-19.

²⁶ Unruh, x. 23.

²⁷ Jäsch, Das Ringen um die Verwaltungsgerichtsbarkeit, in: ZS Die Verwaltung, №4, 2005, x. 1.

²⁸ Stump, x. 23; Nowatius, x. 53...

²⁹ Stump, x. 24; Nowatius, x. 55-56.

³⁰ Stump, x. 24-25; Nowatius, x. 56-57.

³¹ Stump, x. 36-37.

Тэдгээр мэргэжлийн бус сайн дурын гишүүн нь анхан болон дунд шатны хяналтын түвшинд захиргаа дур зоргоор авирлахаас сэргийлэх баталгаа болох ёстой байв. Харин дээд шатны шүүхэд сайн дурын буюу мэргэжлийн бус гишүүд байсангүй, түүнд зөвхөн шүүх болон дээд шатны захиргааны байгууллагад ажилладаг албан тушаалтнууд хамаарч байжээ.³²

Захиргааны шүүхүүд нь захиргааны үйл ажиллагаа хууль ёсны эсэхийг шалгадаг байсан бөгөөд бүрэн эрх нь "нэрлэх зарчмаар" (Enumerationsprinzip) хязгаарлагддаг байв. Учир нь шинэ болон хуучин захиргааны байгууллагуудын олон янзын байдал, анхан шатны ялгаатай зохицуулалтаас шалтгаалан шүүхийн бүрэн эрхийг ийнхүү нэг бүрчлэн тодорхой заахаас өөр аргагүй байжээ. Иймд Захиргааны шүүхүүд нь зөвхөн хуулиар тодорхой заасан хэргүүдийг л хянан шийдвэрлэдэг байв. Хэдийгээр Пруссийн Захиргааны шүүх нь эрх зүйт төрийг бэхжүүлэхэд шийдвэрлэх чиг үүргийг гүйцэтгэсэн ч, энэ нь хангалттай баталгаа болж чадаагүй байна.³³

б)Өмнөд Германы тогтолцоо

Бүр 1863 он гэхэд Baden-д Heidelberg-ийн эрх зүйн онолч Johann Caspar Bluntschli (1808-1881)-ийн оролцоотойгоор хамгийн анхны захиргаанаас тусгаарлагдсан, бие даасан шүүх байгуулагдсан байжээ. Түүнийг Verwaltungsgerichtshof гэх бөгөөд энэ нь эцсийн буюу дээд шатны Захиргааны шүүх байжээ. Энэхүү загварыг Württemberg 1876 онд, Bayern 1879 онд дагасан.³⁴

Өмнөд Германы Захиргааны шүүхүүд нь юуны түрүүнд хувь хүний буюу (нийтийн эрх зүйн) субъектив эрхийн хамгаалалтыг илүү чухалчилж байв. Otto Baehr (1817-1895) "Эрх зүйт төр" хэмээх бүтээлдээ: "Нийтийн болон хувийн эрх зүйн салбар дахь шүүх үйл ажиллагааны хооронд хэзээ ч бүрэн төгс ялгаа гарахгүй

юм".³⁵ Учир нь захиргааны эрх зүйн зохицуулалт нь гарлын хувьд хувийн эрх зүйгээс ялгаагүй, хоёулаа хувь хүний эрхийн хүрээг хамгаалахад чиглэгддэг. Энэхүү хувь хүний эрхийн хүрээг хамгаалах нь хэзээ ч төрийн эрх хэрэгжүүлэгчийн (захиргааны) үйл хэрэг байж чадахгүй. Учир нь нийтийн эрх ашиг болон төрийн үйл ажиллагааны зорилгот байдлын үүднээс өөрийн субъектив үнэлэмжийн хүрээнд тодорхой үйл хэргийг шийдсэн этгээд нь (захиргаа нь) тухайн эрхийг дахин объектив үнэлэмжийн үүднээс таслан шийдвэрлэх боломжгүй юм. Иймд захиргааны эрх зүйн хамгаалалтыг захиргааны байгууллага бус, харин бие даасан ердийн шүүх хэрэгжүүлэх нь зүйтэй. Хэрэв ердийн шүүхийг зохимжгүй гэж үзвэл нийтийн эрх зүйн бие даасан шүүхийг байгуулж болох юм. Гэхдээ энэ нь ямар ч тохиолдолд эрх зүйн нэгдмэл байдлыг хангах үүднээс эцсийн шатандаа ердийн шүүхэд хамаарагдах ёстой хэмээн үзэж байжээ.³⁶

1863 оны Baden-ийн хуулийн дагуу Захиргааны шүүхийн үйл ажиллагааг анхан шатанд дүүргийн зөвлөлүүд (Bezirksräte) хэрэгжүүлдэг байв. Зөвлөлийн гишүүд нь (Bezirksamtmänner) сайн дурын, хуулийн мэдлэггүй хүмүүс байсан. Гэсэн ч тэдгээр нь захиргааны дээд шүүхийн шүүгчдийн адил муж улсын гүнтэнгүүдээс томилогддог байжээ. Шүүхийн эрх мэдэл нь хуулиар нэг бүрчлэн тоочсон, хязгаарлагдмал шинжтэй байсан ч Засгийн газраас үг эрхийн каталогийг өргөтөх боломжтой байжээ. Тиймээс ч 1886 оны 6 дугаар сарын 14-нд Захиргааны эрхийн туслалцааны тухай хуулиар Захиргааны шүүхийн эрх мэдлийг өргөжүүлсэн байна. Уг

хуулийн дагуу захиргааны шийдвэрийн улмаас эрх нь зөрчигдсөн хэн боловч шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй болжээ. Харин зөвхөн хууль ёсны сонирхол нь зөрчигдсөн бол гомдлоор шийдвэрлэх боломжийг олгосон байна. Гэхдээ тодорхой тохиолдлын хувьд эрх, сонирхол хэмээх хоёр ойлголтыг ялгахад ямагт бэрхшээл учирдаг байжээ. Baden-ийн Захиргааны шүүхийн зорилго нь иргэдийн нийтийн эрхийг хувийн эрхийнх нь нэгэн адил хамгаалахад чиглэгдэж байсан.³⁷

XIX зууны хоёрдугаар хагасын эрх зүйн байдлыг Захиргааны шүүхийн хөгжилтэй холбон нэгтгэн үзвэл дараах онцлог шинжийг дурдаж болохоор байна: 1849 оны Паулын сүмийн Үндсэн хуулийн (Paulskirchenverfassung) 182 зүйл нь Герман улсад бие даасан Захиргааны шүүх бий болох эрх зүйн зохицуулалтын эхлэлийг тавьсан байна. Уг зүйлээр нэгдүгээрт шүүх эрх мэдлийг эрх зүйт төрийн зорилго болох төрийн эрх мэдлийн хуваарилалтын гурав дахь бие даасан засаглал болохыг нь хүлээн зөвшөөрч баталгаажуулсан; хоёрдугаарт, захиргааны үйл ажиллагаан дахь шүүхийн хяналтыг бий болгосон явдал юм. Үүнд мөн XIX зууны явцад нийтийн болон хувийн эрх зүйн хоорондын ялгаа илүү тодорхой болж эхэлсэн нь нөлөөлсөн. Захиргааг хянах шүүхийн тухайд үндсэн хоёр асуудал анхаарал татаж байв. Үүнд: нэгдүгээрт, уг хяналтыг эрдийн шүүх хэрэгжүүлэх нь зүйтэй юу, эсвэл захиргааны тусгай шүүх байгуулах уу; хоёрдугаарт, тухайн шүүхийн зорилго нь хувь этгээдийн субъектив эрхийг хамгаалахад уу, эсвэл объектив эрхийг

³² Stump, x. 304-305.

³³ Schenke, Entwicklung und heutiger Stand der Verwaltungsgenichtsbarkeit in Deutschland, in: FS fuer Jong Hyun Seok, Seoul, Korea 2003, x. 111; Stump, x. 303-305.

³⁴ Sommermann, x. 1; Hufen, § 2 мпр. 9; Sydow, x. 54.

³⁵ Baehr, x.

³⁶ Stump, x. 23.

³⁷ Unruh, x. 28-29.

баталгаажуулахад чиглэгдэх үү?³⁸ Дээр нэгэнт дурдсанчлан захиргааны тусгай шүүх байгуулах нь зүйтэй хэмээн үзсэн нь Герман даяар захиргааны тусгай шүүхийн тогтолцоо бий болоход шийдвэрлэх алхам болжээ. Нийтийн эрх зүйн субьектив эрхийн хамгаалалт нь зарчмын хувьд Захиргааны шүүхийн анхдагч (өмнөд Германы хувьд) юмуу хоёрдогч (хойд Германы хувьд) зорилго хэмээн тооцогдох болсон. Өөрөөр хэлбэл, энэ цаг үед эрх зүйт төрийн тухай ойлголт болон Захиргааны шүүхийн хөгжлийн хувьд гол алхмууд хийгдсэн гэж үзэж болно. Тодруулбал, төрийн засаглалын төвлөрсөн хэлбэрээс эрх мэдэл хуваарилах хэлбэрт шилжсэн, түүнчлэн захиргаа өөрөө өөрийгөө хянах хэлбэрээс татгалзаж хөндлөнгийн хараат бус шүүхээр хянагдах болсон.

3. Weimar-ийн үе дэх Захиргааны шүүх (1919-1933)

Бүр 1912 онд Reichstag Захиргааны дээд шүүх (Reichsverwaltungsgericht) байгуулах тухай саналыг авсан байсан хэдий ч дэлхийн нэгдүгээр дайнаас болж уг ажил хэрэгжээгүй юм. Дайны дараа 1919 онд Weimar-ийн Үндсэн хуулийн 107 дугаар зүйлд: "Эзэнт улсын хэмжээнд (Reich) болон муж улсуудад Захиргааны шүүхийн тухай хуулийн дагуу захиргааны байгууллагын захирамж болон шийдвэрийн эсрэг иргэдэд үзүүлэх эрх зүйн хамгаалалт байх ёстой" хэмээн заажээ. Гэвч энэ нь хоосон заалт байсан юм. Учир нь уг зүйлд заасанчлан Reichsverwaltungsgericht ч байгуулагдаагүй, муж улсуудын хүрээнд анхан шатны Захиргааны шүүхүүд ч нэмэгдээгүй билээ.³⁹ Нийт улсын хэмжээнд Захиргааны шүүхийн байгууллага нь нэгдмэл бус, муж улсууд нь Захиргааны шүүхүүдийнхээ үйл ажиллагааг өөрсдөө зохицуулах эрхтэй байсан тул процессын ялгаатай

хуулиуд үйлчилж байв. Захиргааны шүүгчдийн бие даасан байдал хангалттай баталгаажуулаагүй байв.⁴⁰ Гэсэн хэдий ч дээр дурдсан Үндсэн хуулийн заалт нь ердийн шүүхээс бүхий л хэргийг (үүний дотор захиргааны хэргийг) шийддэг байсан өмнөх тогтолцоо буюу Justizstaat-ийг халснаараа ач холбогдолтой юм. Weimar-ийн Үндсэн хуулийн 31 II, 107, 166 зүйлүүдэд заасан байсан Reichsverwaltungsgericht-ийн оронд эрүү-иргэний хэргийг хянан шийдвэрлэдэг Дээд шүүх (Reichsgericht) болон захиргааны тусгай шүүхүүд захиргааны эрх зүйн хамгаалалтыг үзүүлж байжээ. Захиргааны тусгай шүүхүүдэд санхүүгийн шүүх, эдийн засгийн шүүх, картеллийн шүүх, патентын алба, цэргийн хангамжийн шүүх, нийгмийн халамжийн шүүх, төмөр замын шүүх, даатгалын албаны сенат, орон нутгийн асуудлыг эрхэлсэн шүүх болоод тэнгисийн алба хамаарагдаж байсан. Эдгээрийн зарим нь анхан, зарим нь дээд шатны шүүхүүд байсан бөгөөд эрх хэмжээ нь их бага хэмжээгээр тусгайлсан хэргүүдээр хязгаарлагдаж байв. Ийнхүү Weimar-ийн бүгд найрамдах улс дахь Захиргааны шүүх нь олон талын, тусгай хэлбэртэй, үйл ажиллагаа нь хязгаарлагдмал шинжтэй байжээ.⁴¹

Энэ бүхнийг нийтэд нь дүгнэн үзвэл Weimar-ийн бүгд найрамдах улсын үед Үндсэн хуулийн 107 дугаар зүйлээр Захиргааны шүүхээс хэрэгжүүлэх нийтийн эрх зүйн хамгаалалтыг баталгаажуулсныг өөрөөр хэлбэл Justizstaat-аас татгалзсаныг⁴² эс тооцвол бие даасан Захиргааны шүүхийн

хувьд дорвитой өөрчлөлт дэвшил гараагүй байна.

4. Гуравдугаар гүрний үе дэх (Das dritte Reich) Захиргааны шүүх (1933-1945)

1933 онд үндэстний социалистууд (Nationalsozialisten) засгийн эрхэнд гарснаар Захиргааны шүүх нь аажим аажмаар үгүй болж эхэлжээ. Эхэндээ Захиргааны шүүхийн байгууллагыг хэвээр хадгалсан хэдий ч түүний үйл ажиллагаа нь "удирдагчийн зарчим" (Fuehrerprinzip) болон "ард түмний нэгдэл"-ийн (Volksgemeinschaft) хангах үүднээс хуулиар хязгаарласан. Төрийн эрх баригчаас гаргасан эрх зүйн хэм хэмжээ, заавар журам болон улс төрийн шинжтэй захиргааны шийдвэр, актыг шүүх хянах эрхгүй болсон. Учир нь улс төрийн удирдлагын нэгдмэл байдал нь аливаа хяналтыг үгүйсгэж байжээ.⁴³ Ийнхүү эрх зүйт төрийн тухай ойлголт алдагдаж эхэлсэн байна. Эдгээрийг "еврейн үзэл" хэмээн нэрлэж, түүний эсрэг "ард түмний" хэмээн тодорхойлогдсон Захиргааны шүүхийг бий болгосон.⁴⁴ Уг Захиргааны шүүхийн чиг үүрэг нь хувь хүний тусын тулд бус, харин нэгдмэл байдлыг хангах үүднээс "ардын нөхдийн" (Volkesgenossen) эрх зүйн байдлыг баталгаажуулахдаа оршиж байв. Захиргааны шүүх нь ямар ч тохиолдолд удирдагчийн шийдвэрт саад учруулах, эсэргүүцэх эрхгүй болжээ. Ийнхүү Захиргааны шүүх нь чиг үүргээ алдсанаар үндсэндээ ач холбогдолгүй болж эхэлсэн байна. Энэ нь 1939 оны 8 дугаар, 11 дүгээр сарын Захиргааг хялбарчлах тухай (хүнд сурталгүй, хурдан шийдвэр гаргаж байхыг шаардсан)

³⁸ Sommermann, x. 4-5.

³⁹ Hufen, § 1 мөп. 17.

⁴⁰ Schenke, in: FS fuer Jong Hyun Seok, x. 112.

⁴¹ Jasch, x. 6; Grawert, Verwaltungsschutzscheidung in der Weimarer Republik, in: FS fuer Menger, 1985, x. 53.

⁴² Харьц, Unruh, x. 66.

⁴³ Unruh, x. 67.

⁴⁴ Wuertenberger, мөп. 49, 50; Schenke, in: FS fuer Jong Hyun Seok, x. 113; Hufen, § 2 мөп. 19.

удирдагчий шийдвэрүүдээр муж улсуудын Захиргааны шүүхүү-дийг татан буулгасан байна. Тэдгээрийн оронд захиргааны байгууллагууд өөрсдөө хэргийг шийдвэрлэх болжээ. Гэвч энэ байдал нь төдийлөн удаан үргэлжилсэнгүй.⁴⁵ Удалгүй Захиргааны шүүхийг хэвээр нь байлгах тухай яриа эрчимтэй өрнөж эхэлжээ. Уг үзлийг дэмжигчийн нэг нь тухайн үеийн төрийн нарийн бичгийн дарга Wilhelm Stuckart (1902-1953) байсан. Түүний үзэж байснаар Захиргааны шүүхийг байгуулах нь эрх зүйн нэгдмэл байдлыг хангах мотор нь болох ёстой байв. Тэрээр Захиргааны шүүх хэмээх либераль институтыг "удирдагчийн зарчим"-тай нийцүүлэхийн тулд "удирдлага", "захиргаа" хэмээх хоёр ойлголтыг ялган тайлбарласан байдаг. Stuckart-ийн үзлээр Захиргааны шүүхийн үйлчлэлийн үр нөлөө нь улс төрийн шинжтэй шийдвэрт хамаарах ёсгүй байв. Учир нь улс төрийн шийдвэрийн үнэн зөв эсэхийг хуулийн хэмжүүрээр үнэлэх боломжгүй, шүүгч болон шүүх нь улс төрийн шийдвэр гаргах эрхгүй. Тиймээс Захиргааны шүүхэд гагцхүү улс төрийн шинжгүй захиргааны шийдвэрүүд л хамаарагдах болно. Захиргааны шүүхийн хяналт захиргааны үйл ажиллагааны өөрөөр хэлбэл төрийн үйл ажиллагааны улс төрийн бүс хүрэн дэх эрх зүйн баталгаа, эв нэгдлийг хангахад чиглэгдэх ёстой байв. Түүнээс гадна тэрээр объектив эрхийг хамгаалах нь Захиргааны шүүхийн хоёр дахь чиг үүрэг хэмээн тодорхойлж байв. Энэ бүхнээс үзвэл Stuckart-ийн хувьд Захиргааны шүүх гэдэг нь ард түмнийг гэхээсээ илүү захиргааг өөрийг нь хамгаалах, энэ утгаараа эрх зүйт төрийн шүүх бус, харин нэгдмэл захиргааны эрх зүйг бүрдүүлэх, түүнчлэн хатуу чанга, төвлөрсөн, тоталитари төрийг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах үүрэг бүхий

институт байв. Stuckart-ийн үзлийн үндсэн дээр 1935 оны намар Дотоод яаман дээр Захиргааны шүүхийн хуулийн (Reichsverwaltungsgesetz) төслийг боловсруулжээ. Гэвч захиргааны дээд шүүхийг байгуулах хүртэл нэлээд хэдэн жил шаадагджээ.⁴⁶

1940 онд Дотоод хэргийн сайд Wilhelm Frick Захиргааны шүүхийн талаар: "Эрх зүйн төвөгтэй асуудлыг шийдвэрлэхэд Захиргааны шүүх зайлшгүй хэрэгтэй болохыг туршлага харуулж байна. Хэргийн бодит байдлыг тогтоохын тулд нотлох баримтыг хангалттай цуглуулах шаардлага байсаар байх нөхцөлд, эсвэл шийдвэр нь холбогдох этгээдэд эдийн засгийн онцгой хүндрэл учруулахаар тохиолдолд хэргийг Захиргааны шүүхээс шийдвэрлэх нь захиргаа дотооддоо шийдвэрлэхээс илүү давуу талтай юм" хэмээн бичжээ.⁴⁷ Энэ бүхний эцэст 1941 оны 4 дүгээр сарын 3-ны Fuehrer болон Reichskanzler-ийн шийдвэрээр Пруссийн захиргааны дээд шүүх (preußisches Oberverwaltungsgericht), Wien дэх Захиргааны дээд шүүх (Verwaltungsgerichtshof in Wien), эдийн засгийн шүүх (Reichswirtschaftsgericht) болон бусад Захиргааны шүүхийг нэгтгэсэн Reichsverwaltungsgericht-г албан ёсоор байгуулжээ.⁴⁸ Гэхдээ энэхүү шүүх нь Stuckart-ийн төсөөлж байсан шиг нэгдмэл Захиргааны шүүх эрх мэдлийг бүрдүүлэхэд бус харин захиргааны үйл ажиллагааг хялбарчлах, боловсон хүчин болон бусад захиргааны зардлыг хэмнэхэд чиглэгдэж байжээ. Stuckart-ийн төлөвлөгөөг эсэргүүцэгчид их байсан тул түүний бодол биелэлээ олж чадаагүй юм. Иймд Reichsverwaltungsgericht нь үндэсний социалист үзэл бодлыг

хэрэгжүүлэхийн тулд дээд шүүхүүдийг хооронд нэгтгэснээс өөр зүйл байсангүй.⁴⁹

Энэ үеийн Захиргааны шүүх байгууллагыг нэгтгэн дүгнэвэл зохион байгуулалтын хувьд тодорхой дэвшилд хүрсэн ч түүний гол чиг үүрэг болох хувь хүний эрхийн хамгаалах тал дээр ач холбогдлоо бүрэн алдсан, энэ утгаараа бие даасан Захиргааны шүүхийн хувьд ч мөн эрх зүйт төрийн хувьд ч ухралтын үе байсан.⁵⁰

5. Захиргааны шүүхийн дахин сэргэлтийн үе (1945-1990)

Дэлхийн хоёрдугаар дайны дараа Захиргааны шүүхийн хувьд цаашилбал нийтийн эрх зүйн хөгжлийн хувьд шинэ үе эхэлсэн. 1941 онд байгуулагдсан Reichsverwaltungsgericht-г 1946 оны Холбоотнуудын хяналтын зөвлөлийн хуулиар татан буулгаж, шинэ Захиргааны шүүхийн тогтолцоог бий болгохоор шийдсэн байна. Шинэ Захиргааны шүүх нь эзлэлтийн дөрвөн бүсэд хуваагдсан. Үүнд Америкийн, Британийн, Францын, Зөвлөлтийн бүс хамаарна. Эдгээр нь өөр хоорондоо шүүхийн шат, эрх хэмжээ, процессын үйл ажиллагааны төрөл, шүүхэд гаргах нэхэмжлэлийн төрлүүд зэргээрээ ялгаатай байсан.

1949 оны 5 дугаар сарын 23-нд батлагдсан Үндсэн хуулиар барууны гурван бүсийн хувьд хараат бус бие даасан Захиргааны шүүхийн эрх зүйн үндэс нь бүрэлдсэн юм. ҮХ-ийн 97 дугаар зүйлээр шүүгчийн, түүн дотор Захиргааны шүүхийн шүүгчийн хараат бус байдал, 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсгээр нийтийн засаглалын үйл ажиллагааны эсрэг эрх зүйн хамгаалалтыг баталгаажуулснаар Захиргааны шүүх нь

⁴⁵ Jasch, x. 10-11.

⁴⁶ Jasch, x. 12...

⁴⁷ Jasch, x. 11.

⁴⁸ Jasch, x. 12.; Wuertenberger, мөр. 49, 50; Schenke, in: FS fuer Jong Hyun Seok, x. 113, Hufen, § 2 мөр. 19, Unruh, x. 68.

⁴⁹ Jasch, x. 30-31.

⁵⁰ Unruh, x. 5-6; Hufen, § 2 мөр. 19.

эрх зүйт төрийн үндсэн шинж, хүний эрхийн хэрэг-жилтийн баталгаа болох үндсэн нөхцөлүүд нь бүрдсэн байна.

Холбооны улсын хувьд эхлээд Холбооны Захиргааны шүүхийн тухай хууль 1952 оны 9 дүгээр сарын 23-нд батлагдсан бөгөөд энэ хуулиар уг шүүхийг дээд шатны хяналтын шүүхийн хувьд муж улсуудын Захиргааны дээд шүүхийн шийдвэрийг хянах эрхтэй байхаар заажээ. Холбооны Захиргааны шүүхийг байгуулснаар нийт улсын

хэмжээнд Захиргааны шүүхийн тогтолцоо нэг мөр болсон юм. Захиргааны шүүхийн процессын хууль нь харин 1960 оны 4 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон.

Зөвлөлтийн бүс буюу зүүн Германы хувьд 1947 онд Захиргааны шүүхийг нэлээн хязгаарлагдмал эрхтэй байгуулсан ч хожим нь 1952 онд Захиргааны шүүхийн хяналт нь социалист төрийн эрх мэдэл нэгдмэл байх зарчимтай үл нийцнэ гэдэг үндэслэлээр

ХБНАГУ-ын Дотоод хэргийн яамны шийдвэрээр энэхүү шүүхийн тогтолцоог үгүй хийсэн. Иймд 1968 оны Үндсэн хууль нь Захиргааны шүүхийн талаар огт дурдаагүй байдаг.

6.1990 оны 10 дугаар сарын 3-наас Холбооны Германы Захиргааны шүүхийн тухай хууль үйлчлэх болсноор энэ бүсэд Захиргааны шүүхийн тогтолцоо шинээр бий болсон бөгөөд үүнээс хойш Захиргааны шүүх нь хөгжлийн орчин үеийн чиг хандлагаа олсон юм.



Үндэсний Их Хурлын Хууль зүйн албаны Хуульч СУН СУ МИ

БНСУ-ЫН ҮНДЭСНИЙ ИХ ХУРЛЫН ХУУЛЬ ТОГТООХ АЖИЛЛАГАА

Оршил

Хууль тогтоомжийн онол ба ойрын нөхцөл байдал

1. Хууль тогтоомжийн онол
2. Хууль хэлэлцэх үйл ажиллагааны чанар

3. Солонгос Улсын хуулийн хэлэлцүүлгийн нөхцөл байдал
Солонгос Улсын Үндэсний хурлын хууль тогтоох үйл ажиллагаа

1. Хуулийн төслийн хэлэлцүүлэг;
2. Хууль төслийн санал гаргах;
3. Чуулганы тайлан ба Үндэсний Хурлын бэлтгэл ажил;
4. Хорооны хянан шалгалт;
5. Хууль зүйн албаны дэргэдэх шүүх хорооны зохион байгуулалт бүтцийн хяналт;
6. Бүх гишүүний зөвлөх хорооны хяналт;
7. Чуулганы тайлан санал хураалт;
8. Хуулийн төслийг нийтэд зарлах, дахин хэлэлцэх.

Хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагааны сүүлийн үеийн онцлог

1. Улсын Үндэсний Хурал гишүүний санаачилсан хуулийн төслийн өсөлт;
2. Хуулийн төсөл санхүүжүүлэх албыг мэргэжлийн түвшинд болгох шаардлага;
3. Хуулийн төслийн зарлагыг тооцох системийн оролцоо;
4. Улсын Үндэсний Хурал хуулийн төслийн шалгалтын шаардлага хангах чанарын өсөлт;
5. Төгсгөл.

Оршил

Энэ жил БНСУ тунхагласны 60

жилийн ой юм. Энэ хугацаанд Солонгос Улс эдийн засгийн ололт, улс төр гэсэн том зүйлийг хослуулан хөгжүүлэхдээ амаргүй замыг туулж ирсэн. Цаашид өндөр хөгжилтэй орны тоонд багтахын тулд хийх ажил, авах арга хэмжээ их байна.

Улс тунхагласны 60 жилийн ойн зэрэгцээ 1948 оны 5 сарын 31-ний өдөр анх байгуулагдсан Улсын Их Хурал 60 дахь жилтэйгээ золгож байна. Үндэсний Хурал 4 дүгээр сарын 9-ний өдрийн нийтийн сонгуулиар Үндэсний Хурал гишүүдээ сонгож дуусаад 5 дугаар сарын 30-ны өдрөөс үйл ажиллагааныхаа хугацан 31-ний өдөр анх байгуулагдсан Улсын Их Хурал 60 дахь жилтэйгээ золгож байна. Энэ нь 18 дахь удаагийн сонгууль бөгөөд бэлтгэл ажилдаа орсон. Анх Үндэсний Хурлын гишүүнээр сонгогдсон хүмүүсийн нэрсийн бүртгэлээс эхлээд гишүүний идэвхтэй үйл ажиллагаанд зориулж янз бүрийн сургалтад хамруулж Үндэсний Хурлын шинэ бүрэлдэхүүнийг бий болох бэлтгэл явагдаж байна. Үндэсний Хурал шинээр бүрэлдэж шинэ гишүүдээс шинэ хууль тогтоох үйл ажиллагаа идэвхтэй өрнөнө гэж найдаж, хуульд ард түмний аятай тавтай байдлыг хангах, хөдөлмөр эрхлэлт, амьдрах таатай нөхцөл зэрэг янз бүрийн салбарын олон асуудлыг тусгаж хөндөөсэй хэмээн хүсэж байна.

Энэ илтгэлд Үндэсний Хурлын төсөл өргөн барих, хэлэлцэх талаар голлон танилцуулах болно. Түүний хажуугаар манай улсын хууль төсөл боловсруулах, өргөн барих, хэлэлцэх

ажиллагааг дэлгэрэнгүйгээр ойлгохын тулд олон талаас нь хүлээн зөвшөөрөх үзэл бодол бас шаардагдана. Тиймээс асуудлыг танилцуулахын өмнө дахиж буюу шинээр санал боловсруулах, түүнийг хэлэлцэх ажиллагааны онцлог чанарыг дүгнэх нь ойлгоход тус дэм болно.

Хууль тогтоомжийн онол ба ойрын нөхцөл байдал

1. Хууль тогтоомжийн онол
Хууль тогтоомжийн онолыг зарчмын утгаар товч тодорхойлбол хуулийн төсөл санаачлах, өргөн барих, хэлэлцэх, хүчин төгөлдөр болох явц гэж хэлнэ. Үндсэн эх сурвалж нь хууль тогтоомжийн болон хэм хэмжээ тогтоосон акт боловсруулах хууль тогтоох үйл ажиллагааг хэлнэ.

Гэвч энэ илтгэлд хууль тогтоох үйл ажиллагаатай голлож танилцана. Энэ нь ерөнхийдөө Хуулийн төсөл "Үндэсний хурлаас хэлэлцэж шийдэх", "Хуулийн төслийг Засгийн Газарт шилжүүлэх", "Ерөнхийлөгчийн батламж" гэсэн шат дараалалтайгаар явагддаг.

2. Хууль хэлэлцэх үйл ажиллагааны чанар

Хууль тогтоох үйл ажиллагааны хэлбэр нь ардчилсан улс төрийн системд хэр тохирч, хууль тогтоомжид бодлого тусгагдаж боловсруулагдсан байх ёстой гэж үзээд дараах гол шинжийг

агуулан.

Нэгт: Ард түмний ашиг сонирхолд нийцсэн байх. Хууль тогтоогч нь хуулийн төслийг боловсруулахдаа юуны өмнө ард түмний санал бодлыг сайн тусгаж, ардчилсан нийгэмд нийцсэн ерөнхий төлөвлөгөө нь хууль тогтоох үйл ажиллагаа нь ард түмний ашиг сонирхолд нийцсэн байх чанар юм.

Хоёрт: Зөрчлийг шийдэх буюу нэгтгэх чанар. Хууль тогтоомж хоорондоо зөрчилдөх эсвэл харшилдах янз бүрийн хуулийн саналыг зөв зохицуулан, ард түмэн хэрэгжүүлж болох нийтлэг хуулийг тогтоох нь чухал юм. Ардчилсан, ил тод нийгэмд ард түмнийг төлөөлж байгаа Үндэсний Хурал хууль тогтоох үйл ажиллагаагаар дамжуулан нийгмийн зөрчлийг шийдэж зөв нэгдэлтэй байлгах чанар юм.

Гуравт: Улс төржсөн чанар. Хууль тогтоох эрхийг хэрэгжүүлдэг Үндэсний Хурал гишүүд

хоорондын, мөн нам хооронд хуулийн хэлэлцүүлэгт өөрсдийн байр суурийг ажиглаж, өөрсөдөө илүү давамгайл орчныг бий болгох улс төржсөн чанар үйлчилнэ.

3. Солонгос Улсын хууль хэлэлцүүлгийн нөхцөл байдал

Одоогийн байдлаар манай орны нийт хэмжээнд үйлчилж байгаа хууль тогтоомжийн тоог гаргавал Үндсэн хууль 1, Үндэсний хурлын баталсан хууль 1246, Ерөнхийлөгчийн болон яамдын гаргасан тушаал 3054 нийт 4301 хууль тогтоомж байна. Эдгээр хууль тогтоомж нь ард түмний амьдралын хэмжүүр болж байгаа бөгөөд тэр тоо нэмэгдсээр байх болно.

Хууль тогтоомжийн тоон өсөлт нь цаашид илүү ихээр төрөлжиж олон талаас үйлчлэх ба ардчилсан, нээлттэй нийгмийн өөрчлөлттэй холбоотой. Бас ард

түмний хууль ёсны эрх ба хууль дээдлэх ойлголт дээшилсэнтэй холбоотой бөгөөд болж өгвөл хууль тогтоомжид бүх төрлийн тохиолдлыг тусган заах гэсэнтэй холбоотойгоор хууль тогтоомжийн инфляци явагдсан гэж ойлгож болно. Энэ нь хууль тогтоомжийн чанарыг бууруулж эрх зүйт нийгэмд саад бэрхшээлийг бий болгон, ард түмний амгалан тайван байдалд их хэмжээний зөрчил ба тав тухгүй байдлыг, хуулийг үл тоомсорлох хуулийн цоорхой бий болоход нөлөөлөх тул тоон өсөлтийг дэмжих боломжгүй юм. Гэлээ ч хууль нь нийгмийн харилцааг зохицуулж дэг журмыг цэгцэлдэг арга барилын хувьд түүнд агуулагдаж байгаа уян хатан чанарыг үгүйсгэх аргагүй бөгөөд тодорхой хэмжээгээр зохицуулан амьдралд хэрэгжүүлэх нь зүйтэй. Тиймээс сайн чанарын, зөв зохистой хуулийг тогтоох нь юунаас илүү чухал юм.

Хүснэгт 1. Хууль тогтоомжийн өнөөгийн байдал /2008.3.31 –ний өдрийн байдлаар/

Ангилал		Тоо
Үндсэн хууль		1
Хууль тогтоомж	Хууль	1, 246
	Ерөнхийлөгч	1, 615
	Ерөнхий сайд	74
	Орлогч Ерөнхийлөгч	1, 365
	Бүгд	4, 300
нийт		4, 301

Хууль зүйн алба (<http://www.moleg.go.kr>)

Он/ангилал	Хууль	Ерөнхийлөгч	Ерөнхий сайд Орлогч Ерөнхийлөгч	Бүгд
1978	689	1, 230	945	2, 864
1979	695	1, 264	985	2, 944
1980	719	1, 288	1, 006	3, 013
1981	733	1, 309	1, 015	3, 057
1982	732	1, 262	950	2, 944
1983	736	1, 253	938	2, 927
1984	741	1, 253	938	2, 932
1985	743	1, 264	936	2, 943

б. Солонгос Улсын Үндэсний Хурлын хууль тогтоох үйл ажиллагаа

1. Хуулийн төсөл санаачлах

Хуулийн төсөл санаачлах эрх Үндсэн хуулийн 52 дугаар бүлэгт зааснаар Улсын Үндэсний Хурал гишүүн, ба Засгийн газарт байдаг. Тиймээс бид хуулийн төслийг боловсруулах үйл ажиллагааг Засгийн газрын санаачилсан хуулийн төсөл болон гишүүний санаачилсан хуулийн төсөл гэсэн хоёр ангилалтай танилцана. Засгийн газраас хуулийн төслийг боловсруулахдаа Засгийн газрын хариуцлага бүхий албанд төслийн эх бэлтгэгдэж, холбоо бүхий хэлтэстэй хэлэлцэж, удирдан зөвлөх хэлтэс, хууль тогтоолын санал дэвшил, үзлэг хяналт, хууль зүйн албаны шалгалт, Үндэсний Хурлын даргын санал, Ерөнхийлөгчийн гарын үсэг болон Ерөнхий сайд, гишүүдийн хэлтэс зэрэг шат дарааллыг дамжин батлагдана.

Үндэсний Хурлын гишүүн хуулийн төслийг боловсруулахдаа гишүүн өөрөө санал

1986	748	1, 267	943	2, 958
1987	765	1, 286	948	2, 999
1988	776	1, 305	953	3, 034
1989	799	1, 331	964	3, 094
1990	820	1, 363	998	3, 181
1991	861	1, 261	1, 022	3, 144
1992	869	1, 289	1, 053	3, 211
1993	886	1, 302	1, 065	3, 253
1994	896	1, 320	1, 086	3, 302
1995	931	1, 305	1, 106	3, 342
1996	941	1, 320	1, 086	3, 347
1997	952	1, 319	1, 129	3, 400
1998	955	1, 327	1, 194	3, 476
1999	952	1, 314	1, 195	3, 461
2000	978	1, 335	1, 212	3, 525
2001	1, 004	1, 347	1, 231	3, 582
2002	1, 026	1, 372	1, 251	3, 649
2003	1, 057	1, 391	1, 296	3, 744
2004	1, 106	1, 448	1, 317	3, 871
2005	1, 142	1, 506	1, 362	4, 010
2006	1, 163	1, 552	1, 407	4, 122
2007	1, 223	1, 612	1, 431	4, 266
2008	1, 224	1, 621	1, 438	4, 283

дэвшүүлэх эсвэл хувиараа хуулийн мэргэжилтний хүнтэй санал солилцох, мөн өөрийн харъяа намын төсөл боловсруулах хэлтэс, төсөл боловсруулах эрдэм шинжилгээний хүрээлэн, гишүүний дэмжигчдээр дамжуулан санал сонсож болно. Гэвч ихэнх нь Үндэсний Хурлын дэргэдэх хууль зүйн албаар дамжин боловсруулагддаг тул энэ албаны эрэлт хэрэгцээ нэмэгдэж байгаа.

2. Хуулийн төслийг өргөн барих

Засгийн газар хуулийн төслийг боловсруулахдаа Үндэсний Хурлаар шийдвэрлүүлэн Ерөнхийлөгчийн нэрээр санал дэвшигдэж Ерөнхий сайд болон холбогдох албанд өгнө. (Үндсэн хуулийн 82 дугаар бүлэг, 89 дүгээр бүлэг)

Хууль төслийг улсын бодлого хариуцсан алба Төв захиргааны албанаас бататгаад тухайн хуулийн төслийн талаар санал солилцож шаардлагатай гэж үзвэл тухайн төслийг засаж залруулах арга хэмжээ авна.

Тухайн төсөлд Улсын чухал бодлого ард түмний амьдралд хүчтэй нөлөө бүхий сэдвийг олонхын суудал авсан намтай санал солилцох, цөөнхийн суудалтай намтай санал нийлэхийг уриалж болно.

Засаг захиргааны алба тодорхойлогдвол хяналт шалгалтын үйл ажиллагаа ба засгийн хянан шалгах ерөнхий хуулийн дагуу хянан шалгах хууль зүйн албаны шалгалт (сэдвийн тохиромжтой чанар, бодит амьдралтай нийцэж байгаа эсэх, зарчмын чанар). Дэд сайд болон Үндэсний Хурал даргын саналаар дамжин Ерөнхийлөгчийн зөвшөөрлийн дагуу Ерөнхий сайд болон холбоо гишүүд шалгасны дараа Үндэсний Хуралд очно.

Үндэсний Хурал гишүүн хуулийн төслийг боловсруулахдаа 10-аас дээш гишүүн түүний саналыг дэмжих ёстой бөгөөд тухайн хуулийн төслийг дэмжиж байгаа гишүүдийн саналыг бичгээр өгнө. Санхүүжилтийг санхүүгийн үндсэн дээр

хуулийн төслийг боловсруулсан бол санхүүгийн тайлан, баримтыг хамт хүргүүлнэ. (Үндсэн хуулийн 79 дүгээр бүлэг 1 дүгээр хэсэг 2 дугаар хэсэг)

Үндэсний Хурлын гишүүн хууль зүйн сэдэвтэй хуулийн төслийг өөрөө боловсруулан өгч болох бөгөөд үүнийг гишүүний бие даасан хуулийн төслийн хүрээнд авч хэлэлцэнэ. (Үндэсний Хурал хуулийн 51 дүгээр бүлэг)

Үндэсний Хурлаас санал болгосон хуулийн төслийг Үндэсний Хурал өөрөө санал хураалт явуулж шийднэ. Тухайн хуулийн төслийг хянан шалгасны дүнд түүнийг засч сайжруулах нь нийтлэг чанартай.

3. Чуулганы тайлан ба Үндэсний Хурлын бэлтгэл ажил

Үндэсний хурлын дарга өргөн барьсан төслийг хувиалан гишүүдэд тарааж Үндэсний хурлын чуулганд танилцуулна. (Үндэсний Хурлын хуулийн 51 дүгээр бүлгийн 1 дүгээр зүйл).

Хуулийн төсөл нь аль байнгын хороонд харьяалагдах нь тодорхой биш бол Үндэсний хурлын дарга нь Үндэсний хурлын Тамгын газар, байнгын хороотой зөвшилцөн холбогдох байнгын хороог тогтоох ба зөвшилцөлд хүрээгүй бол Үндэсний хурлын дарга дангаар шийдвэрлэх эрхтэй. Үндэсний Хуралд дарга хэрэгтэй хэлэлцүүлэх шаардлагатай хуулийн төслийн талаар Чуулганаас санал хураалт явуулж түүнийг Төв байнгын хороонд хүлээлгэж өгнө.

(Үндэсний Хурал хуулийн 81 дүгээр бүлгийн 2 дугаар зүйл).

4. Хорооны хянан шалгалт

Үндэсний Хурал нь Чуулган болон Байнгын хороо гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Үндэсний Хуралд өргөн баригдсан төслүүд Хууль зүйн байнгын хороогоор хэлэлцүүлсний дараа чуулганаар дамжиж эцсийн шийдвэр гарна. Хуулийн бүх төслүүд Хууль зүйн байнгын хороогоор

дамжин шийдэгдэх " Хороог гол зарчим болгох" онцлогийг агуулж байгаа ч, Үндэсний Хурлын чуулган нь ихэвчлэн тогтсон зарчмын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг талтай.

• Хуулийн төслийг тогтоолын санал дэвшил: Байнгын хорооноос оруулсан хуулийн төслийн тухай хуулийн зорилго, гол санаа зэргийг тэмдэглэн авч чуулганаар хэлэлцүүлэх санал дэвшүүлж болно. Гэвч хуулийн төслийг хэлэлцүүлэх системд Үндэсний Хурлын зарчимд нийцээгүй байх, хуулийн төсөл санал дэвшүүлэх үйл ажиллагааг албан бус сайн дураар хэрэгжүүлэх нь өнөөгийн бодит байдал юм.

а. Байнгын хороо: Хуулийн төслийг Зөвлөх байнгын хороо хүлээж авангуут хорооны шалгалт шууд хэрэгжихгүй харин Хорооны дарга зохион байгуулагчтай зөвөлж санал хураалтын өдрийг товлож хорооны хэлэлцүүлэг хэрэгжинэ. Хуулийн төслийн тухай хэлэлцэх хугацаа нь 15 хоног, хууль тогтоомж болон шинэ хууль тогтоомж нь 20 хоног гэсэн хугацаатайгаар хязгаарласан.

б. Тайлбар танилцуулга, мэргэжлийн түвшиний тайлан судалгаа болон нэмэлт хэлэлцүүлэг: Хуулийн төслийг хороо хүлээж аваад хуулийн төслийг хянахдаа эхлээд илтгэсэн хүн (Засгийн газраас боловсруулсан хуулийн төслийг хувьд Улсын хууль зүйн албаны ажилтан, гишүүдийн санаачилсан хуулийн төслийг тухайн гишүүн)- нээс хуулийн төслийн тухай тайлбар танилцуулгыг сонсоно. Дараа нь мэргэжлийн дүгнэлт тайлан судалгааг сонсох бөгөөд энэ нь мэргэжлийн түвшинд бодитой талаас нь хуулийн төслийн ёс зүйн чанар, саад бэрхшээлтэй тал, онцлог зэргийг төсөлд тусгах системийн хувьд гишүүний чадавхыг давхар шалгах зорилготой.

Нэмэлт хэлэлцүүлэг нь хуулийн төслийн талаарх

дэлгэрэнгүй тайлбараас өмнө төслийн ерөнхий дутагдлыг хэлэлцэх энгийн хэлэлцүүлэг юм. Тиймээс хуулийн төслийг санаачилсан этгээдэд асуулт тавьж, тайлбар сонсох маягаар явагдана.

с. Хууль зүйн байнгын хороо: Байнгын хороо хуулийн төслийн тухай болон бусад төслийг хянахдаа заавал хуулийн төсөл хянах алба, хороонд шилжүүлэн түүнийг шалгаж тайлбарлана. (Үндэсний Хурлын хуулийн 58 дугаар бүлгийн 2 дугаар зүйл). Хууль зүйн байнгын хорооны саналын дагуу байгуулагдах түүний бүтэц болон удирдлага нь зарчмын хувьд хорооны төлөвлөгөөний дагуу хянан шалгагдана. Хууль зүйн байнгын хорооны хурлын үйл ажиллагааг ил тод байдлаар хийх ёстой гэж заасан боловч тусгай үед санал хураалтаар нууц байдалд хуралдахыг зөвшөөрнө. (Үндэсний Хурлын хуулийн 57 дугаар бүлгийн 5 дугаар зүйл).

д. Чуулганыг нээлттэй явуулах: Байнгын хороо нь чухал хуулийн төсөл болон мэдлэг шаардсан хуулийн төслийг шалгахын тулд хорооны нийт гишүүний оролцоотойгоор нээлттэй хийнэ. Түүнчлэн санхүүгийн тухай хуулийн төсөл болон мэргэжлийн түвшиний хуулийн төслийг боловсруулахдаа чуулганыг заавал нээлттэй явуулах үүрэгтэй.

е. Өгүүлбэрийн бүтцийн хянан шалгалт: Хуулийн төслийн өгүүлбэрийн мөр болгоныг уншиж хянаж Хорооны хэлэлцүүлэг явагдсаны дараа гүнзгий шалгах зорилготой. Санхүүгийн тухай хуулийн төсөл болон мэргэжлийн түвшингийн хуулийн төслийг боловсруулахдаа заавал нэг бүрчлэн хянан шалгах аргыг хэрэглэнэ.

ф. Эсрэг эерэг маргаан, санал хураалт: Хууль зүйн байнгын хорооны шалгалтын тайлан болон өгүүлбэрийн бүтцийг хянах шалгалт дуусаад хуулийн төслийн тухай эргэлзээтэй эсэхийг асууж, эргэлзээгүй бол

сонголт хийнэ. Гэвч хуулийн төслийн тухай эсрэг эерэг санал их үед дахин хэлэлцүүлгийг зохион байгуулна.

Хуулийн төслийн тухай асуулт хэлэлцүүлэг дуусахад Хорооны дарга эцсийн шийдвэрийг зарлан Үндэсний Хурлын санал хураалтыг явуулна. (Үндэсний Хурлын хуулийн 58 дугаар бүлгийн 1 дүгээр зүйл). Хуулийн төслийг бүхэлд нь хуульд оруулах, засах, хасаад өөр зүйлийг нэмэх эсэхийг шийдвэрлэхийн тулд юм. Хорооны хувьд санал хураалтыг үр дүнтэй явуулахын төлөө олонхийн саналаар шийдвэрлэнэ.


5. Хууль зүйн албаны дэргэдэх шүүх хороо (Хуулийн төслийн эрх зүйн үндэс болон нэр томъёог шалгах)

Хуулийн төслийг Байнгын хороогоор хэлэлцсэний дараа төслийг дахин шалгуулахын тулд хууль зүйн албаны дэргэдэх хороо (хуулийн төслийн эрх зүйн үндэс болон нэр томъёог шалгах хороо) хууль эрхт Засгийн газрын байнгын хорооны хуулийн төслийн тухай шалгалтыг дуусгаад төлөв ёсоор түүнийг хууль зүйн албаны дэргэдэх шүүх хороонд өгч зохион байгуулалт бүтцийг шалгуулна. Зохион байгуулалтын шалгалт гэдэг нь хуулийн төслийн сэдэв хэр зэрэг Үндсэн хуульд харш болох, холбоо хууль дүрэмтэй хэр зэрэг зохицож байгаа, бусад заалттай сөргөлдөж байгаа зэргийг шалгах нь хуулийн заалтыг боловсруултын шалгуур юм. Бүтцийн хяналтад хууль зүйн нэр томъёо оновчтой зөв нийтэд ойлгогдохоор байгаа эсэхийг шалгах зэрэг орно. (Үндэсний Хурал хуулийн 86 дугаар бүлгийн 1 дүгээр зүйл).

Энэ шалгалтын хүрээ нь ямар ч үед зохих хяналт шалгалтаар хязгаарлагдах боловч хууль төслийн улс төрийн үзэл бодитоор олж шалгаж чадахгүй нь энгийн ойлголт юм. Нөгөөтэйгүүр, энэ хорооноос хуулийн төслийн зохион

байгуулалт, бүтцийн хяналтын хүрээний талаар холбогдох байнгын хороотой санал үл нийцэх тохиолдол олон гарсан ч тухайн хуулийн төслийн тухай нэмэлт тайлбарыг шаардана.

<Зураг 1> Хорооноос хүүлийн төслийг хянаж шалгах шат дараалал



Хууль зүйн албаны дэргэдэх шүүх хороо нь хуулийн төслийн зохион байгуулалт бүтцийн хянан шалгалтын дараа үр дүнг Хууль зүйн байнгын хороонд (Jurisdiction Committee) мэдэгдэж, тэндээс хуулийн бүх төслийг шалгаж танхимын эрхлэгчид тушаана. Танхимын эрхлэгч хууль зүйн албаны дэргэдэх шүүх хорооны хуулийн төслийн зохион байгуулалт бүтцийн хянан шалгалтын тухай харилцагч намын тэргүүлэгч нартай зөвлөлдөж хэлэлцээрийг хэзээ хийх хугацаагаа тохиролцоно. Хууль зүйн албаны дэргэдэх шүүх хорооноос тодорхой шалтгаангүйгээр товлосон хугацаандаа шалгалтыг дуусгаагүй бол тэр хуулийн төслийг шууд чуулганд дамжуулж болно. Ийм үед танхимын эрхлэгч Чуулгаанаас итгэмжлэл авч хуулийн төслийн тухай санал хураалт явагдсаны

“Хууль дээдлэх ёс”, 2008 он, №3

дараа хоорондоо харшилдах
заалт, бүтэц, тоо зэргийг
цэгцлэнэ. (Үндэсний Хурлын
хуулийн 86 дугаар бүлгийн 2
дугаар зүйл).

Хууль зүйн албаны дэргэдэх шүүх хорооны хуулийн төслийн зохион байгуулалт бүтцийн хянаш шалгалтын систем нь Үндэсний Хурлын чухал системийн нэг юм. Энэ нь хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагааны нэг дамжлагын хувьд гадаадын бусад орноос ялгаатай систем юм. Шотланд Улсын хууль хуулийн төслийн суурь үндэслэлийн хорооноос хяналт хийх, Герман улсад холбогдох зөвлөл хорооноос, Япон, Америк Канад зэрэг оронд хууль зүйн товчоо буюу хууль зүйн албанд хамааралтай газраас энэ үүргийг хариуцдаг байдг жишээтэй.

6. Бүх гишүүний зөвлөх

хорооны хяналт (All members committee)

Бүх гишүүний зөвлөх хорооны систем нь чуулганы хуулийн төслийн хяналтын ерөнхий зарчмыг хадгалах зорилготой. Үүнийг "өөрчлөлт чуулган" гэж нэрлэх бөгөөд чуулганы хяналтын үйл ажиллагааны хувьд Засгийн газрын байнгын хорооны дэргэдэх Зөвлөл (the National Assembly Standing Committee)-тэй адил систем юм. Ер нь бол АНУ-д Чуулганы нийт гишүүний доод хэмжээ 100-аас дээш байж хуулийн төслийн асуудлыг гүнзгий шуурхай үр ашгитайгаар шийдэх зорилттой ажилладаг. Манай-улсын Чуулганы давтагдах чанараас болж илүү зарчмын дагуу явдагддаг. Бүх гишүүний зөвлөх хорооны систем нь 2000 оны 2 дугаар сарын 9-ний өдөр Үндэсний Хурал хуулиар шинээр батлагдан Үндэсний Хурлын бүтэц зохион байгуулалтад нөлөөлөх болсон. Энэ систем анх бий болсон бус харин 1948 оны анхны хуульд оруулж байсан жишээ бий. Харин 1960 оны 9 дүгээр сард Үндэсний Хурал хууль боловруулах явцад хассан.

Бүх гишүүний зөвлөх хороо хуулийн төслийг засах тухай саналыг гаргаж болох бөгөөд энэ үед бүх гишүүдийн зөвлөх хорооны дарга өөрөө хариуцан санал өгнө. Ийм тохиолдолд Үндэсний Хурлын дарга түүнийг Үндэсний Хурал орлогч даргаар томилно.

Бүх гишүүний зөвлөх хорооны хянан шалгах хуулийн төсөл гэдэгт Зөвлөх хороогоор дамжиж эсвэл Зөвлөх хорооноос санал дэвшүүлсэн хуулийн төслөөс Засаг захиргааны бүтцийн тухай хуулийн төсөл, татвар болон ард түмэнд ачаалал нэмсэн сэдэвтэй хуулийн төслүүд орно. Хуулийн төслийг өгөх хугацаа нь чуулганы өмнө эсвэл дараа байх бөгөөд үндсэн гишүүдийн 4/1-ээс дээш байхыг шаардах үед хяналтыг бүх гишүүнээс бүтсэн бүх гишүүнийг зөвлөх хороог нээж хуралдахыг зөвшөөрнө. (Үндэс-

ний Хурлын хуулийн 63 дугаар бүлгийн 2 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэг).

7. Чуулганы тайлан санал хураалт

• Санал дэвшүүлэх цаг хугацааны хэлэлцээр: Чуулган санал дэвшүүлэх хурлын хугацаа товлөгдвол дарааллын дагуу нэг хуулийн төслийн тухай авч хэлэлцэх нь зарчимд нийцэх бөгөөд шаардлагатай гэж үзвэл хоёроос дээш хуулийн төслийн тухай хэлэлцэнэ.

а. Шалгалтын талаарх илтгэл, нэмэлт тайлбар: Зөвлөх хорооноос шалгал дууссан хуулийн төслийг дутуу гэж үзвэл зөвлөх хорооны дарга болон тухайн хорооны ажилтан, хороон даргын нэр цохсон гишүүн тэр хуулийн төслийн тухай шалгалтын дүн, цөөнхийн санал, холбоотой гишүүний санал зэрэг хэрэгтэй зүйлийг чуулганд танилцуулна. (Үндэсний Хурлын хуулийн 67 дугаар бүлгийн 1 дүгээр зүйл).

б. Асуулт хэлэлцүүлэг, санал хураалт: Чуулганд хууль зүйн байнгын хорооны даргын шалгалтын тухай илтгэлийг сонсч, хуулийн төслийн талаар асууж хэлэлцээд санал хураалт явуулна. Санал хураалтад тусгай дэгийг заагаагүй тохиолдолд олонхийн саналыг дэмжин батална. Санал хураалтыг автоматаар өгөх нь зөв боловч

биеэр босож санал өгөх, эсэргүүцэх, бичгээр санал өгөх, нууцаар санал өгөх, нэр дуудаж санал өгөх зэрэг арга байна.

с. Засгийн газарт шилжүүлэх: Санал хураалт явуулсан хуулийн төслийг Зөвлөх хорооны дарга Засгийн газарт шилжүүлнэ. (Үндэсний Хурал хуулийн 93, 98 дугаар бүлэг).

8. Хуулийн төслийг нийтэд зарлах, дахин хэлэлцэх

Ерөнхийлөгч шилжин ирсэн хуулийн төслийг 15 хоногийн дотор нийтэд зарлах ёстой. (Үндсэн хуулийн 53 дугаар бүлгийн 1 дүгээр зүйл).

Гэвч Үндэсний Хурлаар санал хураагдан Засгийн газарт шилжсэн хуулийн төслийн сэдвийн талаар Ерөнхийлөгч эргэлзээтэй гэж үзвэл Үндэсний Хурлаас дахин хэлэлцэхийг шаардаж болно. Энэ нь Ерөнхийлөгч хуулийн төсөлд хориг тавих эрхийг эдэлж байгаа бөгөөд ийм үед Ерөнхийлөгч 15 хоногийн дотор учир шалтгааныг тайлбарлан Үндэсний Хуралд тайлбарлан дахин хэлэлцүүлэхийг шаардаж болно. Үндэсний Хурал хуулийн төслийг хасах үед ч мөн адил. (Үндсэн хуулийн 53 дугаар бүлгийн 2 дугаар зүйл).

Ерөнхийлөгчийн хуулийн төсөлд хориг тавих эрх нь ерөнхийдөө хуулийн төсөл Үндсэн хуульд харшлах, хэрэгжих чадваргүй,


улс орны ашиг сонирхолд үл нийцсэн, Засгийн газрын талаарх Үндэсний Хурал буруу нөлөө бүхий байх зэрэгт хүчинтэй.

Ерөнхийлөгч хуулийн төслийн нэг хэсгийг эсвэл хуулийн төслийн алдаатай хэсгийг засах эрхтэй. (Үндсэн хуулийн 53 дугаар бүлгийн 3 дугаар зүйл).

Ерөнхийлөгчөөс буцаасан хуулийн төслийг Үндэсний Хурлын Хууль зүйн байнгын хороонд өгөхгүйгээр шууд Чуулганд шилжүүлэн нууцаар санал хураалт явуулж олонхын суудал эзэлсэн намын гишүүдийн саналаар санал зөвшөөрөгдөл тухайн хуулийн төсөл нь батлагдана. (Үндсэн хуулийн 53 дугаар бүлгийн 4 дүгээр зүйл, Үндэсний Хурал хуулийн 112 дугаар бүлгийн 5 дугаар зүйл).

Ерөнхийлөгч Үндэсний Хурал шийдвэрээр ирсэн хууль төслийг 15 хоногийн дотор батламжилж нийтэд зарлаагүй эсвэл дахин хэлэлцүүлгийг шаардаагүй бол тэр хуулийн төсөл хууль, тогтоол болж батлагдсан гэж үзнэ. Батлагдсан хууль тогтоомж Засгийн газарт шилжиж Ерөнхийлөгч түүнийг саадгүйгээр тунхаглана. Таван өдрийн дотор Ерөнхийлөгч зарлахгүй бол Үндэсний Хурал дарга нийтэд зарлана. (Үндсэн хуулийн 53 дугаар бүлгийн 5 дугаар зүйл 6 дахь хэсэг).

<Зураг 2> Үндэсний Их Хурал хууль төслийн үйл ажиллагааны шатлал



с. Солонгосын хууль төсөл боловсруулах үйл ажиллагааны сүүлийн үеийн онцлог

1. Үндэсний Хурал гишүүний зүгээс санаачилсан хуулийн төслийн өсөлт

Сүүлийн үеийн хуулийн төслийг боловсруулах үйл ажиллагааны гол онцлог бол ерөнхий хуулийн төсөл эрчтэй өсөж байгаагийн хамт гишүүн өөрөө санал гаргах нь нэмэгдэж байгаа. Хууль тогтоомжийг Засгийн газраас санаачлах нь нийтлэг бөгөөд үүнтэй холбогдуулан сүүлийн үед гишүүн өөрөө хуулийн төсөл боловсруулах нь нэмэгдсэн.

XVII Үндэсний Хурал (2004-2008) шинэ хуулийн төслийн нийт тоо 7,467 хүрч, XVI Үндэсний Хурал (2000-2004) нийт 2,507, бодвол 3 дахин өсөж, XV Үндэсний Хурал (1196-2000) нийт

1,951 буюу 3.8 дахин өссөн нь үүний баталгаа юм.

Үндэсний Хурал гишүүний боловсруулсан хуулийн төсөл болон Засгийн газраар боловсруулсан хуулийн төслийн хэмжээг харьцуулбал, гишүүний хуулийн төсөл 16 дахь Үндэсний Хурлаас 17 дахь Үндэсний Хуралд 3.3 дахин өссөн, харин Засгийн газраас боловсруулсан хуулийн төсөл 1.9 дахин өссөн байна. 16 дахь Үндэсний Хурал нийт хуулийн төслийн дотор гишүүний хуулийн төсөл 76 хувийг эзэлж, 17 дахь Үндэсний Хурал 85 хувийг тус тус эзэлж байгаа нь хуулийн төслийн хурдтай өсөлтийг харуулж байна.

Гэвч хуулийн төслийн санал хураалтын хувь нь Засгийн газраас боловсруулсан хуулийн

төсөл харьцангуй их байна. 17 дахь Үндэсний Хурлын түвшингээс харахад Засгийн газраас боловсруулсан хуулийн төслийн санал хураалт 72 хувь байхад гишүүнийх зөвхөн 27 хувь байх жишээтэй. Үүнийг Засгийн газраас боловсруулсан хуулийн төсөл илүү мэргэжлийн түвшинд боловсруулагдсан гэж хэлж болно. Гэхдээ санал хураалт явуулснаар хууль тогтоомж батлагдаж байгаа бол зөвхөн гишүүний зүгээс боловсруулсан хуулийн төсөл мэргэжлийг шаардлагыг дутуу хангасан гэж дүгнэнэ.

Үүнд гишүүний зүгээс боловсруулсан хуулийн төсөл Үндсэн хууль, улс төр, нийгэм, эдийн засаг, соёл иргэншилд хэр нийцэх тэнцвэрийг зөв тогтооход оршино.

<Хүснэгт3> Гишүүний зүгээс боловсруулсан хуулийн төсөл Засгийн газраар боловсруулсан хуулийн төслийн харьцаа


Хугацаа (он)	Нийт хууль төслийн хэмжээ	Гишүүний зүгээс боловсруулсан хуулийн төсөл			Засгийн газраар боловсруулсан хуулийн төсөл		
		Санал дэвшүүлэг	Санал хураалт	Санал хураалтын хувь	Санал дэвшүүлэг	Санал хураалт	Санал хураалтын хувь
Анхны Үндэсний Хурал (48-50)	234	89	43	48%	145	106	73%
2 дугаар (50-54)	398	182	77	42%	216	137	63%
3 дугаар	410	169	72	43%	241	85	35%
4 дүгээр (58-60)	322	120	31	26%	202	44	22%
5 дугаар (60-61)	296	137	30	22%	159	40	25%
Улс дахин тогтоосон Үндэсний Хурал (61-63)	1,162	554	514	93%	608	501	82%
6 дугаар (63-67)	658	416	178	43%	242	154	64%
7 дугаар (67-71)	535	244	123	50%	291	234	80%
8 дугаар (71-72)	138	43	6	14%	95	33	35%
9 дугаар 73-79)	633	154	84	55%	479	460	96%
10 дугаар (79-80)	129	5	3	60%	124	97	78%
Улсын батлан хамгаалах хууль тогтоох Үндэсний Хурал (80-81)	189	33	33	100%	155	155	100%
11 дугаар (81-85)	498	202	83	41%	287	257	90%
12 дугаар (85-88)	379	211	66	31%	168	155	93%
13 дугаар (88-92)	938	570	171	30%	368	321	87%
14 дугаар (92-96)	902	321	119	37%	581	537	92%
15 дугаар (96-00)	1,951	1,144	461	40%	807	659	82%
16 дугаар (00-04)	2,507	1,912	516	27%	595	431	72%
17 дугаар (04-08.4.28)	7,467	6,366	1,316	21%	1101	557	50%

Үндэсний Хурал хууль төсөл мэдээлэх систем (<http://likms.assembly.go.kr>)

2. Хуулийн төсөл санхүүжүүлэх албыг мэргэжлийн түвшинд болгох шаардлага.

Хууль зүйн төсөл санхүүжүүлэх алба гэдэг нь өргөн утгаараа хуулийн төсөл боловсруулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хуулийн төсөлд хэрэгтэй судалгаа, дүгнэлт, шинжилгээ, үр дүн зэрэгтэй холбоотой хүний болон хөрөнгийн хангамжийг хэлнэ. Нарийн утгаараа гишүүний хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагаанд шууд туслалцаа үзүүлдэг алба гэж ойлгоно. Хуулийн төсөл санхүүжүүлэх алба Үндсэн хуульд зааснаар Үндэсний Хурал хууль төсөл боловсруулах эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай. Бүх салбарын мэргэжилтнүүдийг хамруулах хууль ёсны шаардлага болон санхүү төсвийг гартаа авсан Засгийн газрыг бодвол мэргэжлийн түвшингийн шаардлага дутуу хангагдсан хуулийн төслийн чанар сулрахаас өөр аргагүй бөгөөд улмаар Засгийн газрын хууль боловсруулах давуу эрхээ бүрэн гүйцэд ашиглаж голлон удирдана.

<Зураг 3> Үндэсний Их Хурлын дэргэдэх хороо зөвлөл



төслийн суурь болон бусад холбоотой хууль зүйн ажлыг санхүүжүүлнэ.

Гуравт: Төсвийн дүгнэлтийг тооцоолж гаргах үүргийг Үндэсний Хурал төсөв санхүү бодлогын хэлтэс хариуцна. Төсөв санхүү бодлогын хэлтэс нь 2003 онд байгуулагдсаны хувьд Үндэсний Хурал санхүү эдийн засгийг зохицуулах чадавхыг илүү бататгахын төлөө Зөвлөл хороо болон гишүүний хүсэлтээр татварын орлого зарлагыг шийдэхэд хэрэгтэй дүгнэлтийг гаргаж, төсөв зарлагын үйл явцад шаардлагатай мэдээллийг өгөх зэрэг шууд нөлөө бүхий мэргэжлийн түвшингийн туслалцааг үүргийг хэрэгжүүлнэ.

Дөрөвт: Хуулийн төсөл болон улсын бодлого боловсруулах байгууллагын албан үүргийг Үндэсний Хурал хуулийн төсөл судалгааны хэлтэс хариуцна. Хуулийн төсөл судалгааны хэлтэс нь 2007 онд байгуулагдсан. Уг хэлтэс нь хуулийн төсөл болон шинэ бодлого боловсруулах үйл ажиллагааг сайжруулах үүрэг хүлээсэн байгууллагын хувьд холбогдох бүх асуудлыг бие дааж, мэргэжлийн түвшинд судалж гарсан үр дүнг Зөвлөл хороо, Үндэсний Хурлын гишүүнд мэдэгдэнэ.

<Хүснэгт 4> Хуулийн төслийн талаар гишүүн өөрөө хууль зүйн албатай зөдлөлдсөн сүүлийн үеийн дүгнэлт /2008 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар/

Ангилал	16 дугаар ('00~'04)		17 дугаар ('04~'08.4.28)	
	Хуулийн төслийн хариу	Үндэсний Хуралд тушаасан	Хуулийн төслийн хариу	Үндэсний Хуралд тушаасан
тоо	1, 682	891	4, 379	2,495

3. Хуулийн төслийн зарлагыг тооцох системийн оролцоо

Хуулийн төслийн зарлагыг үнэлэх систем нь санхүү төсөв шаардсан хуулийн төслийг хэрэгжүүлэхэд зарцуулах төсвийн нийт зардал болон жил болгоны зардалын хэмжээг тус тусад нь үнэлж тооцоолох арга юм.

Хуулийн төслийн зарлагыг тооцоход санхүүгийн дэмжлэгийн хууль, Улсын санхүү эдийн засагт хэр нөлөөтэй эсэхийг урьчилан судалж утга учиргүй хуулийн төслөөс болж Улсын санхүү эдийн засаг муудах үзэгдлийг гаргахгүйн

төлөө өөдрөг үзлээр хуулийн төслийг хэрэгжүүлвэл бодит үр дүн сайжирна. Төсвийн асуудал хууль тогтоомжоос өөр зарчмаар шийдэгдэх ба хоорондоо зохицох тэнцвэрийн ялгаа их учир хоёр талын уялдаа холбоог тодорхойлоход зардлын үнэлгээ тооцоог үр ашигтайгаар хийнэ.

2003 онд Үндэсний Хурал төсөв бодлогын хэлтэс үйл ажиллагаагаа эхэлснээр зардал үнэлгээг зохицуулах мэргэжилтэн бий болж гишүүн өөрөө хуулийн төслийг боловсруулахад Үндэсний Хурал төсөв бодлогын хэлтсээс зардал тооцоотой холбоотой ганцаарчилсан

асуултыг авч байгаа. 2005 оны 7 дугаар сарын 6-ны өдөр Үндэсний Хурал хууль тогтоомжийг шинэчилж Улсын Үндэсний Хурал гишүүн, Хороо зөвлөл, Засгийн газраас төсөв санхүүжүүлэлттэй холбоотой хуулийн төслийг өгөхдөө тухайн хуулийн төсөлд зарцуулах төсвийн тооцооны хуудсыг хамт өгөх ёстой.

Үүнтэй холбогдуулж зарлагын төсөв тооцооны хуудас 16 дугаар Үндэсний Хуралд 4 хувьтай байсан бол 17 дахь Үндэсний Хурал байдлаар 18,7хувь байна.

<Хүснэгт 5> Гишүүний хуулийн төслийн зарлагын төсөв тооцооны хуудсыг тушаасан байдал /2006оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар/

Ангилал	Гишүүний хуулийн төсөл	Зарлагын төсөв тооцооны хуудас	Зарлагын төсөв тооцооны хуудсын хувь
13 дугаар	570	20	.5
14 дүгээр	321	12	3.7
15 дугаар	1, 144	13	1.1
16 дугаар	1, 907	76	4.0
17 дугаар	4,077	764	18.7
Бүгд	8,019	885	11.0

4. Үндэсний Хурал хуулийн төслийн шалгалтын шаардлага хангах чанарын өсөлт

Үндэсний Хурал гишүүний зүгээс боловсруулах хуулийн төслийн тооны өсөлт нийт хуулийн төслийн ихэнх хувийг эзэлж байгаа бөгөөд сэдвийн утгыг нарийн авч үзвэл нийгмийн зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдэх, нийгмийн зөв нэгдлийн чадавхыг хэр зэрэг сайн хэрэглэхийг тусгах нь орчин үеийн хуулийн төслийг

боловсруулах үйл ажиллагааны салшгүй чухал хэсэг юм.

Энэ тухай Үндэсний Хурлын зүгээс шалгахдаа Засгийн газраас боловсруулсан хууль төсөл хэр хэмжээтэйгээр засагдаж Үндэсний Хуралд очсон болох, улмаар засалт хийсэн нийт хувийн хэмжээ нь Хууль зүйн эрх байгууллага Үндэсний Хурлын төлөө идэвхтэй үүргээ гүйцэтгэсэнийг тодруулна.

Засгийн газрын хуулийн төсөл засагдах нь Ерөнхий-

лөгчийн намын гишүүнээс өөр сэдвийг санал дэвшүүлэх эсвэл хуулийн мэргэжилтний зөвлөгөөний дагуу засаж санал дэвшүүлэх аргаар засагдаж байгаа.

Засалтын хувийг тогтоохдоо Засгийн газрын хуулийн төслийн засалттай хэлбэр болон гишүүний эсрэг саналыг хамт өгнө. Зөвлөл хорооноос хорооны саналыг дэвшүүлэхдээ холбоотой хуулийн төслийг судалсны дараа тухайн хуулийн төслийг устгах тогтолцоотой учир бодит

амьдрал дээр Зөвлөх хорооны саналын дагуу сэдэв засагдсан гэсэн үр дүнг авчирна.

5. Төгсгөл

Бид БНСУ-ын хууль төсөл боловсруулах үйл ажиллагаа болон түүний онцлогтой танилцлаа.

Үндэсний Хурал хуулийн төслийн чадавхын гол түлхүүр нь яаж ч хүчилсэн хэм хэмжээгээ барина. Гэхдээ бидний түүхийг эргэн харахад харамсалтай нь Үндэсний Хурал хуулийн төслийн чадавх нь бусад хүчин нөлөөг бодвол тэр чухал үүргээ хэвээр нь хүлээн зөвшөөрүүлж хэрэгжиж чадаагүй. Зарим гишүүний идэвхтэй хөдөлгөөний үр дүн, Үндэсний Хурал нарийн бичгийн хорооны хууль зүйн

алба, Үндэсний Хурал төсөв бодлогын хэлтэс, Улсын Үндэсний Хурал хуулийн төсөл судалгааны хэлтэс байгуулагдсанаар хуулийн төслийн чадавх XV Үндэсний Хурлаас хойш илүү боловсронгуй болж байгаа нь нааштай үзэгдэл юм.

Хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагаанд ил тод, үр ашигтай чанарыг хамтад нь тусгаж өгөх системийн арга барил чухал юм. Ил тод чанар нь хуулийн төсөл тогтвортой байхад нөлөөлөх бөгөөд үр ашигтай чанар нь хамгийн бага зардал болон хөдөлмөрийн дүнд шаардлагатай хууль тогтоомж аль болох ихээр батлагдахад нөлөө бүхий чадавхыг хэлнэ.

Сайн чанарын хууль

тогтоомж гаргахын тулд хуулийн төслийг ил тод, үр ашигтайгаар боловсруулж бүх шатлалдаа тусгаж илүү төрөлжсөн үзлээр батлагдах ёстой.

Мөн сайн чанарын хууль тогтоомж гаргахын тулд Үндэсний Хурал мэргэжлийн чадавх сайжрах ёстой бөгөөд хуулийн төслийн чанар илүү өсөж Үндэсний Хурлын хуулийн төсөл боловсруулах гол байгууллага болохын төлөө төсөлд хэрэгтэй бодлого, мэдээлэл, шинэ санаа оноо, хүч нөлөө бүхий хууль зүйн технологийг заавал байлгах ёстой. Үүний төлөө Хууль Зүйн Яамны төрийн албан хаагчийн эрчтэй үйл ажиллагаа байх ёстой.





I. Хууль зүйн мэдээллийн тухай ойлголт, онцлог

Хууль зүйн мэдээллийн хамрах хүрээ

Явцуу хүрээнд хууль зүйн мэдээлэл нь: Төрөөс баталсан Үндсэн хууль болоод хууль, зарлиг, (Ерөнхийлөгч, Ерөнхий сайд гэх мэт) тогтоол шийдэр (Парламент, Дээд шүүх, Үндсэн хуулийн шүүх, Сонгуулийн Ерөнхий хороо, Үндэсний Аудитын газар) түүнчлэн Парламентаас соёрхон баталсан олон улсын гэрээг хамруулна. Хуулийн энгийн мэдээллээс гадна сүүлийн үед он дараалласан мэдээлэл болон гадаадын хуулиуд (ялангуяа англи хэлээр гарсан)-ын хэрэгцээ өсч илүү чухалчлах болсон.

Өргөн хүрээнд хууль зүйн мэдээлэл нь: Явцуу хүрээний мэдээлэл дээр нэмж орон нутгийн засаг захиргааны байгууллагаас гаргасан тогтоол шийдвэр, шүүхийн шийдвэр, захиргааны шүүхийн шийдвэр, төрийн яам тус бүрээс гаргасан тогтоол, журам, заавар түүнчлэн хуулийн тайлбар асуулт хариулт зэрэг агуулгаараа өргөн хүрээг хамарна.

1. Хууль зүйн мэдээлэл

• *Хуулийн мэдээллийг дамжуулах хэрэгсэл*

Хэвлэмэл байдлаар: Одоо мөрдөж байгаа хуулийг бүгдийг эмхтгэн сар тутам товхимол хэлбэрээр гаргадаг хуулийн эмхтгэл (БНСУ-ын Хууль зүйн төвөөс эрхлэн гаргадаг) болон хэсэгчлэн түүвэрлэж аваад толь бичиг хэлбэрээр гаргадаг хуулийн гарын авлагууд.

Цахим хэлбэрээр: Дижитал буюу цахим хэлбэрээр хуулийн

БНСУ-ын Хууль тогтоомжийн хүрээлэнгийн Хууль зүйн солилцоо, хамтын ажиллагааг дэмжих төвийн захирал СОН ХИ ДҮ

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ, ТҮҮНИЙ УДИРДЛАГА

- I. Хууль зүйн мэдээллийн тухай ойлголт, онцлог
- II. Хууль зүйн мэдээллийн үйлчилгээний өнөөгийн байдал
- III. Хууль зүйн мэдээлэл ба ALIN
- IV. Хууль зүйн мэдээллийн үнэлгээ ба тулгамдсан асуудлууд

мэдээллийг ашиглан интернэт, CD, электрон ном гэх мэт хэлбэрээр.

2. Хуулийн мэдээллийн онцлог

• *Хуулийн мэдээллийн үнэ цэн*
Мэдээллийн нийгэмд шилжин хөгжихийн хэрээр мэдээлэл амьдралд хэрэгцээтэй мэдлэг байхаас хэтэрч нийгэмд шууд мөнгө, эрх мэдэл болж байгаа мэт ойлголт бий болсон.

• *Хуулийн мэдээллийн нөлөө*

Хуулийн мэдээлэл иргэдийн амьдралд үзүүлэх нөлөө нь бусад ямар ч мэдээллээс илүү өргөн хүрээтэй бөгөөд шууд нөлөөтэй.

Хуулийн мэдээлэл нь мэдэж байвал сайн, мэдэхгүй байсан ч болох зүйл биш харин мэдэхгүй бол бие хүнд, эдийн засагт хохирол учруулах шууд нөлөөтэй бидний амьдралын үндсэн хэв шинж болсон учраас чухал юм

Хуулийн мэдээллийн онцлог чанар

A. Олон нийтийг хамарсан чанар

• Хуулийн мэдээлэл нь төрөөс гаргаж буй бүх нийтийн мэдээлэл ба ихэнх гадаад оронтой адил Солонгост ч хуулийн мэдээллийг төрийн байгууллагаас эрхлэн идэвхитэй нийтлэн түгээж байдаг.

Нийтийг хамарсан чанараараа бүх нийтийн мэдээлэл учир нийтэд зарлан тунхагладаг гэсэн утгаасаа гадна ихээхэн хариуцлага, итгэл дагуулж байдаг гэсэн утгыг ч хамт багтааж байдаг.

B. Үнэн бодит чанар

Хуулийн мэдээлэл бусад ямар ч мэдээллээс илүү агуулга нь үнэн

бодитой байх ёстой. Зөв бодит байдал нь хуулийн үг өгүүлбэр төдийгүй цаг хугацааны хувьд ч бодитой зөв байх шаардлагатай. Бодит бус хуулийн мэдээлэл нь эсрэгээрээ мэдэхгүй байснаас ч илүү хор хохирол учруулж болно

В. Шуурхай чанар

• Хууль нь одоо хүчинтэй мөрдөж байгаа агуулгаараа хэрэглэгчдэд шууд нэн даруй хүрч байх ёстой

• БНСУ-д одоо мөрдөж байгаа нийт 4307 хуулийн(2008 оны 4 дүгээр сарын 30-ны байдлаарх Хууль зүйн хүрээлэнгийн статистик) дотроос 2007 онд 1944 хуулийг шинээр нийтэд зарласан (1 өдөрт ойролцоогоор 5.3 хууль шинээр батлагдан, өөрчлөлт орох эсвэл хүчингүй болж байна гэсэн үг).

• Үнэн бодит байхын тулд хүчин төгөлдөр болох өдөр болон мэдээлэл шинэчлэх хоорондын хугацааг багасгахын тулд хичээж ажиллах хэрэгтэй.

Г. Нийтлэг чанар

• Хууль журам нь нийт ард иргэдийн эрх зүйн амьдралд нөлөө үзүүлэх тул нутаг орон, анги давхарга ялгаагүй хэн ч гэсэн хялбар дөт замаар хамгийн зөв бодит хуулийн мэдээллийг авч байх ёстой.

• Хэрэглэгч нь гадаадын иргэн, гадаадын аж ахуйн нэгж, олон улсын байгууллага зэрэг хүрээгээ тэлж өргөжих хандлагатай байгаа.

II. ХУУЛЬ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Хүснэгт: Олон нийтэд хуулийн мэдээлэл хүргэх үйлчилгээний байдал

Ангилал	Хуулийн мэдээллийн үйлчилгээ	Хариуцсан байгууллага	Мэдээллийн хэрэгсэл
ӨРГӨН ХҮРЭЭ	Я В Ц У У ХҮРЭЭ	Одоо мөрдөж буй хууль тогтоомж	Хууль зүйн төв (moleg.go.kr)
		Хууль зүйн хүрээлэн (klri.re.kr)	Интернэт
		Гадаад хэргийн яам (mofat.go.kr)	Интернэт (олон улсын гэрээ)
	Хуулийн он дарааллын мэдээлэл	Хууль зүйн төв (moleg.go.kr)	Интернэт
		Хууль зүйн хүрээлэн (klri.re.kr)	Он дарааллын эмхтгэл
		Хууль зүйн хүрээлэн (klri.re.kr)	Хуулийн эмхтгэл, Интернэт
	Англи хэлээр хуулиуд	Нутгийн захиргааны байгууллага	Интернэт
		Дээд шүүх (scourt.go.kr)	Интернэт, CD-ROM
		Үндсэн хуулийн шүүх (ccourt.go.kr)	Интернэт
		Захиргааны шүүх (simpan.go.kr)	Интернэт
		Бүх яам	Интернэт
		Хууль зүйн төв (moleg.go.kr)	Хуулийн тайлбарын асуулт, хариултын эмхтгэл, Интернэт
бусад	Хэвлэн нийтлэх	Яам (gwanbo.korea.go.kr)	Сонин, Интернэт

• 1999 онд Хууль зүйн хүрээлэнгээс гаргасан (одоо мөрдөж буй хуулиуд).

• 2000 оноос хойш Хууль зүйн төв, Хууль зүйн хүрээлэн зэрэг байгууллагаас шаард-пагатай үед тогтмол бус хэлбэрээр гаргаж байгаа.

Цахим хэрэгсэл

Интернэт (WWW хэлбэрээр)

• 1998 оноос эхлэн Хууль зүйн төвөөс одоо мөрдөж буй хуулийн мэдээлэл, 2001 оноос хуулийн он дарааллын мэдээл-лийн бааз DV болон одоо мөрдөж буй хуулийн мэдээллийн бааз бий болгож нэгдсэн үйлчилгээ явуулсан.

- Эхэндээ Дээд шүүх, Парламентаас ч хуулийн мэдээллийг тусдаа хуримтлуулж үйлчилж байсан бөгөөд одоо бол Хууль зүйн төвийн нэгдсэн сүлжээгээр мэдээллийн бааз ажиллуулж байгаа.

- Дээд шүүхийн шийдвэр, Парламентын хууль тогтоох болон хуулийн төслийн талаар тусгай үйлчилгээ явуулж эхэлсэн.

- Олон улсын гэрээ Гадаад харилцаа, худалдааны яамны вэб хуудаснаас мэдээлэл өгч байгаа.

Хэвлэн нийтлэх

• Хууль, тогтоол зэргийг Засгийн газраас албан ёсоор зарлан түгээх хэлбэр

• Товхимол, цахим болон хэвлэмэл сонинд нийтлэх (2000 оны 9 дүгээр сараас хойш)

1. Одоо мөрдөж буй хууль зүйн мэдээллийг түгээх нь

Хуулийн эмхтгэл

• 1954 онд Хууль зүйн төв БНСУ-ын Хуулийн эмхтгэл (1 багц 3 боть) хэвлүүлсэн.

• 1990 онд Хуулийн хүрээлэнгээс БНСУ-д мөрдөж буй хуулийн эмхтгэл (1 багц 50 боть 78 ном) хэвлүүлсэн.

• Сар бүр (жилд 12 удаа) товхимол хэвлүүлж гаргадаг.


Цахим хэлбэрээр

Компьютерын цахилгаан холбоо (Telnet хэлбэр)

• 1992 онд захиргааны нэгдсэн сүлжээ (Хууль зүйн төв болон Ерөнхий сайдын алба), 1994-2002 онд одоо мөрдөж буй хуулиудын DV үйлчилгээ (Солонгосын Хууль зүйн хүрээлэн) CD-ROM

• 1997 онд Хуулийн номын сангаас гаргасан (одоо мөрдөж буй хууль тогтоомжийг багтаасан).

Хууль зүйн төвийн хуулийн нэгдсэн мэдээлийн интернет үйлчилгээний эхний хуудас



2. Хуулийн он дарааллын мэдээлэл

Хуулийн он дарааллын эмхтгэл

• Эмхтгэлд одоо мөрдөж байгаа төдийгүй ЗГ байгуулагдснаас хойш өнөөг хүртэлх баталсан, нэмэлт, өөрчлөлт орсон, хүчингүй болсон бүх хуулийг он дарааллаар оруулсан.

- 1965, 1978, 1985 онд Хууль зүйн төвөөс эмхтгэл гаргасан.
- 1994 онд Хууль зүйн хүрээлэн "БНСУ-ын хуулийн он дарааллын эмхтгэл" (1 багц 32 боть 47 ном) хэвлүүлж (жилд 4 удаа нэмж байна).

Интернэт

- 3 жилийн (1998-2000) хугацаанд эмхтгэл гаргасан DV (Хууль зүйн төв)
- 2001 оноос Хууль зүйн төв нэгдсэн сүлжээгээр үйлчилсэн.

3. Англи хэл дээрх хууль зүйн мэдээлэл, түгээлт

Англи хэлээр гаргасан хуулийн эмхтгэл

1983 онд Хууль зүйн төвөөс англи хэлээр эмхтгэл гаргасан (Current Laws of the Republic of Korea) 1 багц 2 боть

- 1990 онд Хууль зүйн хүрээлэн 1 багц 6 боть гаргасан.
- 1998 онд ойролцоогоор 800 хууль, шийдвэр багтсан эмхтгэл гарсан (Statutes of the Republic of Korea) 1 багц 20 боть 27 ном (жилд 4 удаа нэмж гардаг).

Интернэт

- 2000 оноос Хууль зүйн хүрээлэн англи хэлээр гарсан хуулийн мэдээллээр цахим үйлчилгээ үзүүлж байна.

4. Бусад хууль зүйн мэдээллийн үйлчилгээ

Хуулиас бусад эрх зүйн өргөн хүрээний мэдээлэл

- Дотоод журам: Орон нутгийн засаг захиргааны байгууллагын вэб хуудас болон хууль журмын эмхтгэл.

• Шүүхийн шийдвэр: Дээд шүүхийн вэб хуудас болон шүүхийн номын сангаас эмхтгэл.

• Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр: Үндсэн хуулийн шүүхийн вэб хуудас болон эмхтгэл.

• Захиргааны шүүхийн шийдвэр: Захиргааны шүүхийн шийдвэрийн эмхтгэл, Иргэний эрхийн хорооны вэб хуудас.

• Журам, тогтоол: яам тус бүрийн вэб хуудас болон эмхтгэл.

• Хуулийн тайлбар: Хууль зүйн төвийн хуулийн тайлбарын хэлтэс хариуцан ажиллуулдаг вэб хуудас болон асуулт, хариултын эмхтгэл.

4. ALIN-ны үүрэг

ALIN: Asia Legal Information Network

- Азийн орны хуулийн төрөл бүрийн мэдээллийг цуглуулах, хариуцах, судалдаг байгууллагууд хоорондоо хүмүүсийн болон материалын сүлжээг бий болгон хууль, шийдвэр тогтоол, эрдэм шинжилгээний бүтээл бусад хууль зүйн мэдээллийг болон судалгааны бүтээлээ солилцон холбогдох судлаач, албан хаагч, эрдэмтдийг харилцан айлчлал хийлгэх зэргээр хамтын ажиллагааг бэхжүүлж байгаа төсөл.

ALIN-ны үйл ажиллагаа

• ALIN сүлжээг бий болгох тогтвортой ажиллах (Ерөнхий чуулган, ажлын хэсгийн хуралдаан);

• Цахим болон цахим бус хэлбэрээр хууль зүйн мэдээлэл солилцох, хамтран эзэмших;

• Олон улсын эрдэм шинжилгээний хурал хийх, сэтгүүл гаргах, хамтарсан судалгаа хийх зэрэг эрдэм шинжилгээний ажлууд;


• Эрх зүйн тогтолцоог сайжруулахад туслалцаа үзүүлэх, сургалт явуулах;

ALIN-ны өнөөгийн байдал

- Өнөөгийн байдлаар 14 орны 22 байгууллага оролцож байна. Үүнд:

Монгол, БНСУ, БНХАУ, Япон, ОХУ, Тайвань, Тайланд, Филиппин, Индонез, Малайз, Вьетнам, Энэтхэг, Узбекистан, Казакстан гэх мэт.

- Жилд 1 удаа нэгдсэн хуралдаан болон эрдэм шинжилгээний хурал зохион байгуулдаг.
- вэб сайт ажиллуулдаг.

**IV. ХУУЛЬ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН ҮНЭЛГЭЭ БА ТУЛГАМДСАН АСУУДЛУУД****Хууль зүйн мэдээллийн үнэлгээ**

Хууль зүйн мэдээллийн хувьд хамгийн чухал элемент нь агуулгын бодит тодорхой байдал.

- Түгээх хэлбэр олон янз болон үйлчилгээний хялбар байдал буй болсноос үйлчилгээний чанар хойш тавигдах болсон.
- Бодит байдлыг үгүйсгэн байж үйлчилгээний түвшинг өндөржүүлэх шаардлагагүй.

Хууль зүйн мэдээллийн тулгамдсан асуудлууд

Хууль зүйн мэдээллийн бааз DV ажиллуулах, яам хоорондын хамтын ажиллагаа.

- Хайлтыг хялбар болгох түлхүүр үг, хайлтын цонхыг бэхжүүлэх.
- Шинэ хэрэгсэл болох түгээх хэлбэрийг хэрэгжүүлэх: электрон шуудан(Уетйшл), гар утсанд мессэж илгээх, цахим ном(үемүүо) ашиглах гэх мэт.
- Хууль зүйн мэдээллийн глобальчлал ALIN зэрэг олон улсын сүлжээ, ОУ-ын мэдээллийн бааз DV (Westlaw, Lexis) ашиглах, өөрийн орны хуулийг гадаад хэлээр орчуулж үйлчлэх гэх мэт.



Сөүлийн Их Сургуулийн Хуулийн зүйн
сургуулийн доктор Ли Хю Вон

БНСУ-ЫН ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГАА БА ХҮНИЙ ЭРХ

**Шинэчилсэн эрүүгийн
хэргийн байцаан шийтгэх
хуулийн гол зорилго болох
хүнлэг аргаар байцаан
шийтгэх зарчим**

Оршил

2007 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг БНСУ-ын Их Хурлаар шинэчлэн хэлэлцүүлж 2007 оны 6 дугаар сарын 1-ний өдөр баталжээ. Уг хууль нь 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөж байна. Эрүүгийн байцаан шийтгэх хууль шинэчлэгдсэн нь хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг дээдлэн, хууль дээдлэх ёс, хуульчийн ёс зүйн чанарыг илүүд үзэж хуулийн байгууллагын үйл ажиллагаа болон эрүүгийн хэргийн нотлох баримттай холбоотой асуудал, зэргийг байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын тэгш эрхэд нийцсэн байна. Улмаар үндэслэл бүхий нотлох баримтад видео бичлэгийг хамааруулан, байцаан шийтгэх ажиллагааг үр дүнтэй болгох тал дээр анхаарч хэрэгтэн хохирогч хоёр талын хувь хүний эрхийг хүлээн зөвшөөрч хүнлэг аргаар байцаан шийтгэх системийг илүүд анхаарч үзсэн.

БНСУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн гол зорилго нь байцаан шийтгэх ажиллагааг бодитоор хэрэгжүүлж, гэмт хэрэг гарсан шалтгаан нөхцөлийг олж тогтоон хэргийн бодит үнэнийг

бүрэн дүүрэн олж илрүүлэн түүний үндсэн дээр Эрүүгийн хуулийн дагуу гэмт хэрэг үйлдсэн этгээдэд зохих ялыг ногдуулахад оршино. Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар тогтоосон цагдан хорих журам нь гэмт хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж байгаа этгээдээс хохирогчтой харьцах биеийн чөлөөт байдалд хорио хязгаар тавьж, албадан ирүүлэх, мөрдөн байцаах, зохих байгууллагын шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд уг хэргийг хуулийн дагуу шийдэх зорилго агуулдаг. Цагдан хорих журам нь Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан үндэслэл журмын дагуу гүйцэтгэж, гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлж, хохирогчийн эрхийг хамгаалахын төлөө хүлээсэн үүрэг бүхий таслан сэргийлэх арга хэмжээ билээ. Гэвч хуулийн байгууллагын ажилтнууд энэ эрхээ буруугаар ашиглах үзэгдэл гардаг. Тиймээс орчин үеийн хэмжээт эрхт үзэлтнүүд цагдаагийн байгууллагууд Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар тогтоосон үүрэг хариуцлага, эрх мэдлээ зөвөөр эдэлж байгаа эсэх хувь хүний эрх чөлөөнд бүдүүлгээр халдах зэргээс сэргийлэн байцаан шийтгэх ажиллагааны дэг журмыг дээдлэх асуудлыг илүү өргөн хүрээнд дэлгэрэнгүйгээр шийдвэрлэх талаас нь санал тавьж ирсэн. Шинэ Эрүүгийн байцаан шийтгэх хууль дахь цагдан хорих арга нь энгийн

иргэдийн хүний эрх ба эрх чөлөөг хамгаалсан бодит үнэнийг тодруулж, шүүх зорилготой. Иймээс энэхүү хууль шинэчлэлт маань хэмжээт эрхт үзлийг суурь болгон Үндсэн хууль болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу тайлбарлагдаж хэрэгжинэ.

2. Үндсэн хууль дахь хүний эрх, цагдан хорих журам

А. Үндсэн хуулийн ерөнхий утга

Цагдан хорих журмын тухай Үндсэн хуулийн 12 дугаар бүлэгт заасан ерөнхий утгыг авч үзвэл хуулийн үндэслэл журмын дагуу эрх зүйн зөвлөгөө, туслалцаа авах, хууль бусаар цагдан хоригдохоос чөлөөлөгдөх, үүнээс учирсан хохирлыг барагдуулах хүсэлт гаргах, түүнчлэн Үндсэн хуулийн 37 дугаар бүлгийн 2 дугаар хэсэгт зааснаар биеийн халдашгүй байх эрхийн талаарх заалт нь шууд хууль мэт үйлчилнэ. Өөрөөр хэлбэл, хүнийг цагдан хорих журам нь хүний эрх чөлөөг хязгаарласан учир Үндсэн хуулийн заалтыг харьцуулж ойлгоно. Хүний эрхийг хязгаарлаж цагдан хорих тухай Үндсэн хуулийн заалт ба Үндсэн хуулийн зарчим нь Эрүүгийн хэргийн байцаан шийтгэх хуулийн шинэчилсэн заалтуудтай тохирч байгаа эсэхийг судалж дүгнэн, стандарт түвшинд нийцүүлэх хэрэгтэй.

Б.Хуулийг чанд баримтлах

Үндсэн хуулийн 12 дугаар бүлгийн 1 дүгээр хэсэгт "иргэн халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Хэн ч хууль бусаар бусдыг баривчлах, цагдан хорих, мөрдөн мөшгөх ёсгүй. Хууль ёсны дагуу биш бол хэн ч ял шийтгэл хүчирхийлэлд автагдах ёсгүй" гэж зааж, хууль хэрэгжүүлэгч нь цагдан хорих ажиллагааг хууль ёсны зарчмын дагуу үйлдэхийг шаардсан утгатай. "Хууль" гэдэг нь Хууль тогтох дээд байгууллагаас тогтоосон албан ёсны утгыг агуулсан хууль болон үүнтэй адил хүчин чадал бүхий эрх зүйн акт, тогтоол, яаралтай санхүүгийн шийдвэр зэргийг хамаарах ойлголт бөгөөд Эрүүгийн байцаан шийтгэх хууль үүнд голлох байр суурь эзэлнэ. Харин "баривчлах" гэдэг нь албадан, хүчээр хүнийг богино хугацаагаар цагдан хорих үйлдэл хийх, барьж хүчлэн хорих, таньж мэдэхгүй газар орхиж төөрүүлэх зэрэг хувь хүний хөдөлгөөнийг хорьсон үйлдлүүдийг хэлнэ.

Түүнчлэн "цагдан хорих" гэдэг нь хүний чөлөөтэй халдашгүй байх эрхийг хүчээр хязгаарлан тодорхой урт хугацаагаар нэг газарт байлгахыг хэлэх бөгөөд хоригдогч этгээд, нөгөө талаас түүнийг хэрэгжүүлж байгаа субъект хоёрын хүрээнд хамаарагдах үйлдэл. Энэ нь хуулийн дагуу явагдаж байгаа ч гэсэн зөвхөн хөдөл-гөөний эрхийг хязгаарлана. Үндсэн хуулийн 37 дугаар бүлгийн 2 дугаар хэсэгт цагдан хорих ажиллагаа нь тодорхой зорилготой байх ёстой бөгөөд энэ утгаараа цагдан хорихтой холбоотой тогтсон дүрмийг зөрчиж болохгүй. Тодруулбал, Үндсэн хуулийн 12 дугаар бүлгийн 1 дүгээр хэсэг нь Үндсэн хуулийн 37 дугаар бүлгийн 2 дугаар хэсэгтэй нэгэн адил үйлчилнэ.

В. Хууль ёсны зарчмын дагуу явуулах

Үндсэн хуулийн 12 дугаар

бүлгийн 3 дугаар хэсэгт баривчлах, цагдан хорих, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахдаа хууль ёсны зарчмын дагуу прокурорын мэдэгдлийг үндэслэн шүүхэд хүсэлт гаргах хэрэгтэй" гэж заасан байгаа. Хууль ёсны зарчмын дагуу гэдэг нь цагдан хорих ажиллагаа зохих зарчмаар хэрэгжихийг хэлнэ. Үндсэн хуулийн 12 дугаар бүлгийн 1 дүгээр хэсэгт "хууль ёсны дагуу биш бол ял шийтгүүлэх, хүчирхийлэлд автагдах ёсгүй" гэж зааж цагдан хорих болон шийтгэл хүчирхийлэлд автагдсан байсан ч хууль зүйн нотлох зарчмыг баримталж байна. Энэ нь Үндсэн хуулийн заалтыг хууль сахиулагч, хүмүүнлэг, ардчилсан нийгмийн тодорхой ололт гэж Үндсэн хуулийн дагуу хүлээн зөвшөөрч байгаа. Тиймээс хууль ёсны зарчим нь зөвхөн хүний чөлөөт байдал ба хамгаалалтад хамаарах зүйл биш, Хууль тогтоох, Гүйцэтгэх, Шүүх эрх мэдлийн болон Үндсэн хуулийн шийдвэр нь бүгд Үндсэн хуулийн хүрээнд хэрэгжих ёстой. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн заалтын агуулгад нийцүүлэх ёстой. Үүнд "тохирох үйл ажиллагаа" нь зөвхөн хуулийн хүрээнд хэрэгжинэ. Тэр үйл ажиллагааг зохицуулах хууль нь тогтсон дүрэм, журмын дагуу явагдахаас гадна хуульд тусгасан арга барил нь нийтлэг оновчтой байх ёстой.

Г. Баривчлах эрх

Үндсэн хуулийн 12 дугаар бүлгийн 1 дүгээр хэсэгт "хүн бүр халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар баривчлах, цагдан хорих, мөрдөн мөшгөх ёсгүй. Хууль ёсны зарчмын дагуу л биш бол хэн ч ял шийтгүүлэх, элдэв хүчирхийлэлд автах ёсгүй" гэж заасан. Үндсэн хуулийн 12 дугаар бүлгийн 3 дугаар хэсэгт баривчлах, цагдан хорих, мөрдөн мөшгөх үйл ажиллагаа явуулахдаа журмын дагуу прокурорын мэдэгдлийг үндэслэн шүүхэд

хүсэлтээ гаргах хэрэгтэй" гэжээ. Харин хэргийн газар дээр баригдсан хэрэгтэн, 3 ба түүнээс дээш жилийн ял ногдуулах гэмт хэрэг үйлдсэн этгээд, мөн нотлох баримт устгахаас сэргийлэн баривчлах тогтоолыг мэдүүлж болно" гэсэн. Үндсэн хуулийн 12 дугаар бүлгийн 1 дүгээр хэсэгт зааснаар шүүх ажиллагааны явцад шүүгчийн эрхийн дагуу баривчлах тогтоол гаргаж болно. Үндсэн хуулийн 12 дугаар бүлгийн 3 дугаар хэсэгт зааснаар прокурорын мэдэгдлийг үндэслэн баривчлах тогтоол гаргана. Шүүх ажиллагааны явцад сэжигтнийг баривчлах талаар шүүгч тогтоол гаргах тохиолдолд прокурорын мэдэгдэх хуудас заавал байх шаардлагагүй, энэ нь хууль ёсны зарчмыг зөрчөөгүй гэж үзнэ. Баривчлах тогтоол гаргах эрх нь хэрэг шалгалтын явцад сэжиг бүхий үндэслэл илэрсэн тохиолдолд үүсэх ба тухайн этгээдийг цагдан хорихыг зөвшөөрнө. Ингэхдээ Үндсэн хууль болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар тогтоосон зарчмыг чанд хатуу сахиж, хүний халдашгүй чөлөөт эрхийг дарамтлалаас зөрчихөөс сэргийлнэ. Баривчлах эрх нь шүүхийн шийдвэрийн дагуу хувь хүний биеийн эрх халдашгүй эрх чөлөөг хязгаарласан боловч цагдан хорих биелүүлэх газар нь шүүх, шүүгчийн хяналтад байна.

Цагдан хорих, баривчлах тогтоол гаргахын өмнө цагдан хорих тогтоол бүхий эрхийн бичгийг харуулж дарааллын дагуу хуулийн хүрээнд тусгайлан хүлээн зөвшөөрсний үндсэн дээр хэрэгжинэ. Үндсэн хуульд хойшлуулшгүйгээр баривчлах тогтоолыг тусгайлан хүлээн зөвшөөрч байгаа нөхцөл нь Үндсэн хуулийн 12 дугаар бүлгийн 3 дугаар хэсэгт заасан хорьсны дараа барих тогтоол ба Үндсэн хуулийн 77 дугаар бүлгийн 3 дугаар хэсгийн Гамшгийн болон дайн бүхий байдлын үе юм. Үндсэн хуулийн 12 дугаар бүлгийн 3 дахь хэсэгт зааснаар хорьсны дараа барих

тогтоол нь гэмт хэрэгтэн мөн болох нь баталгаатай болсон үе, онц ноцтой гэмт хэрэг үйлдсэн этгээд ахин хэрэг үйлдэхээс үр дүнтэй урьдчилан сэргийлэхийн тулд Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрч хэргийн газар дээр баригдсан сэжигтэнг яаралтай баривчлахыг тодруулж өгнө. Тушаал нотлох баримтлагчдын үзлээр тухайн тогтоол нь хэрэг илрүүлэхээс өмнө, хойно байхаас хамаарахгүйгээр гэмт хэргийн нийгмийн хор аюулд тохируулан цагдан хорих үйл ажиллагаа нь оновчтой байх ёстой. Хэрэв гэмт хэргийн цар хүрээ тодорхойгүй нийтэд нь хамарсан энгийн тогтоолын дагуу бол Үндсэн хууль хүлээн зөвшөөрөхгүй.

Д. Цагдан хорихтой холбоотой эрх зүйн үндэс

1) Өмгөөлүүлэх эрх

Үндсэн хуулийн 12 дугаар бүлгийн 4 дүгээр хэсэгт "хэн боловч баривчлагдсан, цагдан хоригдсон тохиолдолд нэн даруй өмгөөлүүлэх эрхээр хангагдах эрхтэй. Харин хэргийн сэжигтэн яллагдагч өөрийгөө өмгөөлүүлэх эрхээ эдэлж чадахгүй тохиолдолд хууль зүйн дагуу улсаас өмгөөлөгч томилж өгөх үүрэгтэй" гэж заасан ба Үндсэн хуулийн 12 дугаар бүлгийн 5 дугаар хэсэгт "хэн ч баривчлах хорионд орсон тохиолдолд хурдан хугацаанд өмгөөлүүлэх эрхээ эдэлж чадахгүй бол баривчлагдах буюу цагдан хорионд байх ёсгүй. Баривчлагдах, цагдан хоригдсон этгэдийн гэр бүл болон хууль ёсны төлөөлөгчид баривчлагдсан учир шалтгаан, хугацаа, байрлал зэрэг мэдээг саадгүйгээр хүргэх ёстой." гэж заасан.

Цагдан хоригдсон этгээд гомдол гаргах нийтлэг эрхийн хүрээнд өмгөөлөгчөө өөрөө сонгон авах, өмгөөлөгчтэйгээ өөрийн эрхийн дагуу чөлөөтэй ганцаарчлан уулзах боломжийг олгох нь чухал юм. Өмгөөлүүлэх эрх нь өмгөөлөгчөө өөрөө сонгон чөлөөтэй харилцан ярих

өмгөөллийн дараах үйл ажиллагаа хамрана. Үүнд яллагдагч өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, хүний халдашгүй эрхийн хангалттай баталгааг хүсэх үүднээс өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзах боломжийг бий болгохоос гадна өмгөөлөгчийн чөлөөт эрхэнд саад учруулах асуудал нь өмгөөлөгчид учруулж байгаа дарамт нөлөө гэж үзнэ.

Өмгөөлүүлэх эрх ба бие эрхтний халдашгүй эрхийн талаар заасан Үндсэн хуулийн 37 дугаар бүлгийн 2 дугаар хэсэг нь бие эрхтний халдашгүй эрхийн хязгаар дүрмийн дагуу хориглоно. Гэвч Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр нь "өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах нь өмгөөлүүлэх эрхийн голсэдэв учир улсын аюулгүй байдал, нийгмийн дэг журам, төрийн албан байгууллага зэрэг ямар ч зүйл хязгаарлалтад нөлөөлж чадахгүй бөгөөд өмгөөлүүлэх эрхээ авсан мөчөөс эхлэн хуулиар үүнийг хориглох ёсгүй" гэж тусгасан. Энэ нь өмгөөлөгчтэй чөлөөтэй харьцах харьцаа ба өмгөөлөгчөө өөрөө сонгох эрхийн ерөнхий ойлголт гэж дүгнэнэ. Нөгөө талаар Үндсэн хуулийн 12 дугаар бүлгийн 4 дүгээр хэсэгт зааснаар шаардлагатай гэж үзвэл сэжигтэнд улсаас өмгөөлөгч томилж өгөхийг хүлээн зөвшөөрсөн. БНСУ-ын өмгөөлөгчийн систем нь нийгмийн амьдарлын түвшин доогуур иргэдийн тэгш эрхийг хамгаалах үүднээс Үндсэн хуулийн бүрэн эрхийн асуудал гэж тооцож хүлээн зөвшөөрсөн. Үндсэн хуулийн дагуу сэжигтэн улсаас томилсон өмгөөлөгч авах эрхтэйг заасан. Харин хохирогч буюу түүний хууль ёсны төлөөлөгч тал нь улсаас томилсон өмгөөлөгч авах эрхийг Үндсэн хуулиар бий Эрүүгийн хэргийн байцаан шийтгэх хуулиар баталж өгсөн байна.

2) Хууль бусаар цагдан хоригдох, баривчлагдсан эсэхийг шалгуулах эрх ба

үүнээс учирсан хохирлыг барагдуулах хүсэлт гаргах эрх

Үндсэн хуулийн 12 дугаар бүлгийн 6 дугаар хэсэгт "хэн боловч баривчлагдах буюу цагдан хоригдох болсон тохиолдолд эсрэг мэдүүлгийг хууль шүүхийн газар өгөх эрхтэй гэж заасан бөгөөд Үндсэн хуулийн 12 дугаар бүлэгт хэргийн хохирогч, сэжигтэний хувьд хуулийн дагуу хэргийг шүүх хэрэгсэхгүй болох эсвэл буруугүй гэсэн шүүхийн шийдвэр гарвал хуулиар олгогдсон эрхийн дагуу улсаас тодорхой хохирлыг барагдуулах хүсэлтээ гаргаж болно" гэж заасан. Цагдан хорихтой холбогдуулж өмгөөлөгч авах эрх нь хууль бусаар баривчлагдах, цагдан хоригдох эсэхийг шалгуулах, хууль бус үйл ажиллагаанаас учирсан хохирлыг барагдуулах хүсэлт гаргах, хэргийн шийдвэрийн дараах хууль бус хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх боломжтой гэж үзнэ.

Шүүхийн эцсийн шийдвэрээс бусад үндэслэлээр баривчлах, цагдан хорих болсон учир шалтгааны талаар шүүхэд мэдүүлэх, шалгуулах эрхийг Үндсэн хуулиар зааж өгсөн. Энэ заалт нь "баривчлах, цагдан хорих болсон" гэсэн тодорхой үед "гэм буруутай эсэхээ шалгуулах" гэсэн дэлгэрэнгүй шаталсан эрхийг баталсан. Гэвч хууль хэрэгжүүлэгчийн зүгээс үндэслэлгүй гэж үзвэл бодит байдал дээр уг эрхийг эдлэх арга байхгүй. Тиймээс мөрдөн байцаагч хуульд заасан үндэслэл журмын дагуу нотлох баримтын бүрдүүлснээр эрх зүйн талаасаа хууль үйлчилж, Үндсэн хуулийн тус тусын заалтын дагуу хэрэглэнэ.

Нөгөө талаар хууль бус ажиллагаанаас учирсан хохирлыг барагдуулах хүсэлтээ гаргах эрх нь улсаас өгсөн тогтоолын заавраар бие эрхтэний чөлөөнд хязгаар тогтоосон үед, эд материалын, сэтгэл санааны хохирлыг барагдуулах системчилсэн арга барилаар хувь хүний

халдашгүй эрхийг хангана хэмээн хүлээн зөвшөөрсөн. Улмаар хохирол барагдуулах утгаараа аль болох туслах талаас нь арга замыг хайж байгаа хэлбэр бол "Хохирол барагдуулах тухай хууль" юм. Хууль бус үйл ажиллагаанаас учирсан хохирлыг барагдуулах хүсэлт гэдэг нь улсын эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад гарсан сэтгэл санаа, бие эрүүл мэнд, нийгмийн, сэнхүүгийн хохирлыг барагдуулах эрх гэдэг утгаараа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаанаас өөрөөр ойлгогдоно.

3. Цагдан хорих хэлбэр

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хэргийн байцаан шийтгэх хуульд зааснаар хүнийг цагдан хорих буюу шүүхийн шийдвэрийн дагуу албадан саатуулах гэж хоёр ангилна. Баривчлах ажиллагаа нь мөрдөн байцаалтын эхний шатанд сэжигтнийг тодорхой нөхцөлд түр хугацаанд цагдан хорихыг хэлнэ. Баривчлах ажиллагааг "энгийн баривчлах", "яаралтай баривчлах", "хэргийн газар дээр баривчлах" гэж ангилна. Нөгөөтэйгүүр цагдан хорих ажиллагааг сэжигтэнт баригдсаны дараа үргэлжлүүлэх бөгөөд ганцаараа харьцангуй урт хугацаагаар хоригдох тохиолдолд нарийн чанга шалгалтын дүнд зөвшөөрөх бөгөөд сэжигтэнгээс ам байцаалт авснаас биечлэн асууж шалгаснаараа ялгагдана.

А. Тогтоолын дагуух цагдан хорих

Тогтоолын дагуу цагдан хорих нь прокурорын мэдэгдлийг үндэслэсэн сэжигтэнг цагдан хорих, эрх хэмжээний хүрээнд цагдан хорих тогтоол гаргаж сэжигтэнг цагдан хорих гэсэн хоёр янз байна. Сэжигтэнг цагдан хориход энгийн баривчлах, яаралтай баривчлах, хэргийн газар дээрх баривчилгаагаар дамжин цагдан хорих, баривчлах хэлбэрүүдийг дамжилгүй цагдан хорих гэж ангилна. Баривчлах хэлбэрүүдийг дамжсан үед цагдан хорих мэдүүлгийг хүлээн

авсан шүүгч саадгүйгээр байцаах ёстой. Ийм тохиолдолд хүндэтгэн үзэх шалтгаангүй бол нэг өдрийн дотор байцаана. Баривчлах хэлбэрүүдээс бусад тохиолдолд прокурорын мэдүүлгийг хүлээн авсан шүүгч сэжигтэн гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай шалтгаан байгаа гэж үзвэл цагдан хорих тогтоол гаргаж сэжигтэнг дуудаж байцаах ёстой. Сэжигтэн олдохгүй тохиолдолд мөрдөн байцаалт явуулах боломжгүй гэж үзэн асуудлыг өөрөөр шийдвэрлэнэ.

Б. Тогтоолын дагуу баривчлах

Баривчлах ажиллагааг анх 1995 оны БНСУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тусгасан юм. Энэ нь цагдан хорих тогтоолоос гадна явагддаг сэжигтэнг баривчлах шүүгчийн эрхээр хязгаарлагдаж, мөрдөн байцаалтын шинжилгээ шалгалт явуулах хэрэгцээ болон хүний эрхийн халдашгүй баталгааг харгалзан хүлээн зөвшөөрөгджээ. Гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцөлийг үнэн зөв олж тогтоох ажиллагаа нь сэжигтэнг баривчлах, цагдан хориод зогсохгүй илүү нарийн боловсронгуй нөхцөлийг шаарддаг. Баривчлах тогтоолыг цагдан хорих ажиллагааг гүйцэтгэхээс өмнө үе шат гэж ойлгож болно.

Баривчлах тогтоолын агуулгад "сэжигтний биеийн байцаалт", "байцаалтад хамрагдах", "баривчлах үндэслэл" гэсэн зүйл орно. Тухайн сэжигтэн гарцаагүй хэргийг үйлдсэн гэсэн сэжиг бүхий учир шалтгаантай байх, тодорхой шалтгаангүйгээр байцаан шалгах газраас ирсэн дуудлагыг үл ойшоох, үл тоох хандлагатай байвал, заавал баривчлах шаардлагагүй гэсэн шийдвэрийг үгүйсгэх заалт юм. "Хэргийн сэжигтэн" гэдэг нь хорьсны дараах хэргийн сэжигтэнтэй адил утгатай бөгөөд "хэрэг үйлдсэн гэсэн ихэнх магадлал"-

ыг агуулах шүүхийн шийдвэрээр эргэлзээгүй буруутай гэсэн нөхцөл байдлыг хэлнэ. Нийт таван зуун мянган воноос доош торгууль, тэтгэмж мөн цагдаагийн торгууль зэрэг хэрэгт сэжиглэгдэж байгаа сэжигтэн тодорхой оршин суух хаяг байхгүй мөн хэрэг илрүүлэх газрын дуудлагыг үл ойшоох зэрэг хуулийн тодорхой хүрээнд сэжигтэн гэж тооцно.

Сэжигтэнг баривчлах тогтоолыг прокурорын мэдүүлгийн дагуу шүүгч гаргаж прокурор эсвэл шүүх цагдаагийн ажилтан хэрэгжүүлнэ. Нэг үгээр прокурор шууд харъяа орон нутгийн шүүхийн газарт баривчлахыг хүссэн хүсэлтээ гаргана. Шүүх прокурорын гаргасан мэдэгдлийг үндэслэн баривчлах тогтоол гарган тухайн хэргийн сэжигтэнг баривчилна. Нөгөөтэйгүүр баривчлах тогтоол гарсан сэжигтэн гэмт хэрэгтэн мөн болох нь нотлогдвол баривчлах мэдэгдлийг дахин мэдүүлэхдээ тодорхой хугацааны дараа дахин өгнө. Прокурор баривчлах тогтоолыг мэдүүлэхдээ урьд нь өгсөн мэдүүлэг дээрээ хэргийн сэжигтэний талаар байцаах болсон учир шалтгааныг нэмж тэмдэглэнэ.

Баривчлах тогтоолын дагуу сэжигтэнг баривчлаад цагдан хорих гэж байгаа бол 48 цагийн дотор цагдан хорих тогтоолыг батлуулах ёстой, энэ хугацаанд мэдэгдэл хийгээгүй бол тэр даруй чөлөөлөх ёстой. Баривчлах тогтоолыг хэрэгжүүлж, сэжигтэнг баривчласан үед хэрэг илрүүлэх газар судалгаа хийж хамгийн түрүүнд ялын нөхцөл байдлыг дүгнэж дараа нь цагдан хорих зөвшөөрлийг аваад баривчилсан цагаас эхлэн 48 цагийн дотор цагдан хорих зөвшөөрлийг хүсэх ёстой, хэрэв цаашид цагдан хорих үндэслэлгүй гэж үзэж байгаа бол шууд чөлөөлөх ёстой.

В. Хэргийн газар дээр баривчлах

Баривчлах тогтоолын үндэслэлийг Эрүүгийн хэргийн

байцаан шийтгэх хуулийн 212 дугаар бүлэгт "хэргийн газар дээрх сэжигтэн хэн боловч заавал тогтоол байх шаардлагагүйгээр баривчлагдан шалгагдах ёстой" гэж заасан. "Хэргийн газар дээрх хуулийн дагуу баривчлагдаж (existing law) байгаа этгээдэд хэргийн газар дээрх сэжигтэн буюу "бүрэн бус сэжигтэн" хамарна.

Хэргийн газар дээрх сэжигтэн гэдэг нь хэргийг үйлдэж байгаа эсвэл үйлдсэний дараахан тухайн хэргийн газар дээр байгаа этгээдийг хэлнэ. **Хэргийн "бүрэн бус сэжигтэн"** гэдэг нь гэмт хэрэг үйлдсэн гэж шууд зааж өгснөөр сэжиглэгдэж байгаа, гэмт хэрэг үйлдсэн ул мөр, нотлох баримт болон гэмт хэрэг үйлдсэн байж болох зэвсэг, бусад эд зүйлийг биедээ байлгаж байгаа, биед эсвэл хувцсандаа ямар нотлох баримтын шинж бүхий зүйлийг агуулж байгаа, мөрдөн байцаалтаас зайлсхийсэн хүнийг хэлнэ. Үүнд нийт 500 мянган воноос доош торгуул болон тэтгэмж, хураамжид хамаатай гэмт хэргийн газар дээрх сэжигтний гэмт хэргийн үйлдэл тодорхой биш үед хэргийн газар дээрх сэжигтнийг нь хувьд баривчилж болно гэж хязгаар тогтоосон байгаа. Прокурор, цагдаагийн байгууллагын ажилтны зүгээс хэргийн газар дээрх сэжигтнийг баривчлахдаа тэр даруйд гэр бүл, хууль ёсны төлөөлөгчид хэл хүргэх ёстой бөгөөд шүүх цагдаагийн тогтоолд хэргийн газар дээрх сэжигтний тухай мэдээг авахдаа баривчилж байгаа хүний нэр, оршин суугаа хаяг, баривчлагдсан шалтгааныг асууж, шаардлагатай гэж үзвэл цагдаагийн газар хамт ирэхийг шаардана.

Г. Хойшлуулшгүйгээр баривчлах

Эрүүгийн хэргийн байцаан шийтгэх хуулийн 200 дугаар бүлгийн 1 дэх хэсэгт "Прокурор мөн шүүх цагдаагийн ажилтан сэжигтэн цагаар авах ял, бүх насаар нь хорих эсвэл 3 жилээс дээш хорих хэмжээний хэрэг

үйлдсэн гэж сэжиглэгдэж байгаа, сэжигтэн нотлох баримтыг устгах магадлалтай, оргон зайлахаар завдсан үед яаралтай мэдэгдэн орон нутгийн шүүх газрын тогтоол гараагүй байсан ч сэжигтэнг баривчилж болно. Хойшлуулшгүй гэдэгт сэжигтэнтэй санаандгүй таарах үед тогтоол гаргуулах цаг хугацаагүйг харгалзан нэн яаралтай баривчлахыг хэлнэ.

Хэргийн газар дээрх сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчлахын гол үндэслэл нь прокурор болон шүүх цагдаагийн ажилтан сэжигтний үйл хөдлөлд хязгаар тогтоож, яаралтай баривчилж, нэн даруй прокурорын саналыг авна. Мөн сэжигтэн яаралтай баривчлалсан прокурор, цагдаагийн байгууллагын ажилтан нар нь хойшлуулшгүйгээр баривчлах тогтоолыг бичиж бүрдүүлнэ. Энэ нь онц ноцтой гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч мөрдөн байцаалтнаас оргон зайлхийхээс урьдчилан сэргийлж, тогтсон цэрэг хамгаалалтын дэглэм дор байлгахыг хүлээн зөвшөөрч байгаа боловч үүнд хатуу хязгаар тавьж байна.

Прокурор мөн шүүх цагдаагийн ажилтан сэжигтэнг яаралтай баривчилж байцаалт авсны үр дүнд сэжигтэнг цаашид цагдан хорих шаардлагатай гэж үзвэл прокурор ямар ч саадгүйгээр харъяа орон нутгийн шүүх газар дахь шүүгчид цагдан хорих тогтоолыг мэдүүлнэ. Цагдаагийн байгууллагын ажилтан прокурорт мэдэгдэл гаргаж прокурор энэ заалтыг үндэслэж харъяа орон нутгийн шүүх газарт мэдэгдэнэ. Ийм үед баривчлах тогтоолыг 48 цагийн дотор гаргуулж, хойшлуулшгүйгээр баривчлах хуудсын хамт бүрдүүлж өгнө. Прокурор мөн шүүх, цагдаагийн ажилтан хойшлуулшгүйгээр баривчлалсан сэжигтэнг цагдан хорихгүй байх зөвшөөрөл өгөөгүй тохиолдолд сэжигтэнг суллаж бөгөөд улмаар суллагдсан сэжигтний тогтоол гараагүй байхад нэг ижил хэргийг

шалтгаанаар баривчлагдах ёсгүй гэж заасан.

Д. Дүгнэлт

Эрүүгийн хэргийн байцаан шийтгэх хуульд зааснаар хэргийн газар дээрх баривчлах болон хойшлуулшгүйгээр баривчлах үед цагдан хорих тогтоолгүйгээр үргэлжлүүлэн хорьсон болон цагдан хорих тогтоолыг хүргүүлээгүй бол тухайн шүүгчийн хайнга байдлаас болж шинжилгээний хариуг мөрдөн байцаах албанд ирүүлээгүй бол сэжигтэнг суллаж хэрэг хэрэгсэхгүй болсон гэж үзнэ. Тухайлбал, прокурор гэмт хэрэг гарсан газар сэжигтэнг яаралтай баривчилж байцаалт хийсний дүнд сэжигтнийг цаашид цагдан хорих зөвшөөрлийг гаргуулж аваагүй бол албан ёсоор түүнийг суллаж цагдан хорих үйл ажиллагааг дууссан гэж үзнэ. Ийм янзаар хойшлуулшгүйгээр баривчлах ажиллагааг хэрэгжүүлэх хор нөлөөтэй явдал гарсаар болно гэж шүүмжлэгдэж ирсэн байна.

Тиймээс БНСУ-ын шинэчилсэн Эрүүгийн байцаан шийтгэх хуульд прокурор сэжигтэнг хойшлуулшгүйгээр баривчлаад цагдан хорих зөвшөөрлийг аваагүй сулласан үед тодорхой хяналт хэрэгтэй гэж үздэг. Прокурор сэжигтэнг суллаад 30 хоногийн дотор өөрийн биеэр хойшлуулшгүйгээр баривчилсны дараа сэжигтнийг бүртгэл мэдээлэл, ямар шалтгаанаар, хаана, хэзээ баривчлах болсон тухай мэдээлэл, сулласан цаг мөч, байрлал, шалтгаан зэргийг дэлгэрэнгүй хөтөлнө. Хойшлуулшгүйгээр баривчлах болон чөлөөлөх тогтоолын хуудасны хуулбарыг бусад бичиг баримтын хамт бүрдүүлж шүүх газарт тушаана. Шүүх цагдаагийн ажилтан яаралтай баривчлалсан сэжигтнийг цагдан хорих тогтоолыг гаргаагүйгээр сулласан бол тэр даруйд прокурорт мэдэгдэж, шүүгч прокурор хоёрын эрхийн хүрээнд хэрэгжинэ. Хойшлуулшгүйгээр баривчилсны

дараа суллагдсан сэжигтэн, түүний өмгөөлөгч, гэр бүлийн хүн, ойр дотны хамаатан, төрөл садан нь мэдүүлэг өгөх болон түүнтэй холбоотой нотлох баримт бичгийг бүртгүүлж шалгуулах ёстой гэж заасан. Шинэчилсэн Эрүүгийн хэргийн байцаан шийтгэх хуульд хойшлуулшгүйгээр баривчлахыг Үндсэн хуульд заасан зарчимд хангалттай нийцүүлсэн гэж дүгнэж байна.

4. Цагдан хорих нөхцөл

А. Гэмт хэрэгт сэжиглэх

БНСУ-ын Эрүүгийн хэргийн байцаан шийтгэх хуулийн 70 дугаар бүлгийн "сэжигтнийг цагдан хорих" гэсэн хэсэгт цагдан хорих үндэслэл журмыг дурдаж "Сэжигтэн гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай шалтгаан байгаа" гэж тодотгосон байгаа. Үүнийг гэмт хэрэгт сэжиглэх гэнэ. Ерөнхий ойлголтоор тухайн хүн гэмт хэргийг үйлдэж болох магадлалыг ихээр төрүүлэх, бодит үнэнийг илрүүлэх утгаараа холбоо бүхий газарт хандах нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ.

Цагдан хорих нөхцөлийн "гэмт хэрэг үйлдсэн байж болох сэжиг бүхий хангалттай шалтгаан" нь "гэмт хэргийг хийсэн байж болох ихэнх магадлал"-ыг илэрхийлж шүүх хурлаас гэм буруутай гэж нотлоход хэрэгтэй нөхцөлийн үед заавал "бүрэн эргэлзээгүй сэжиглэлт"-ийг шаарддаггүй. Шинэчилсэн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 307 дугаар бүлгийн 2 дугаар хэсэгт "гэмт хэрэг үйлдсэн гэж нотлох нийтлэг бус чанартай нотлох баримт байхад" гэж заасан. Мөн "хангалттай шалтгаан"-ы үндэс нь бодит байдлаар харсан шүүгчийн үнэлэмж дүгнэлт бөгөөд цаашид цагдан хорих шаардлагын үүднээс дүгнэнэ.

Б. Цагдан хорих үндэслэл

Эрүүгийн хэргийн байцаан шийтгэх хуулийн 70 дугаар бүлгийн 1 дүгээр зүйлд цагдан хорих шалтгааныг дурдахдаа:

1. сэжигтэн байнгын оршин суух тодорхой хаяггүй;

2. сэжигтэн эрүүгийн хэргийн нотлох баримтыг устгаж болзошгүй;

3. сэжигтэн оргон зайлсан эсвэл оргон зайлах үйлдэл хийх гэж оролдсон гэж дурджээ.

"Байнга оршин суух хаяггүй" нь бодит амьдрал дээр бие даасан цагдан хорих шалтгаан болохгүй бөгөөд харин "оргон зайлж болзошгүй" гэдэг нь гол үндэслэл болно. "Оргон зайлж болзошгүй гэдэгт ердийн таамаглал, бүрэн бус ойлголтоороо гэмт хэрэг илрэхэд тухайн дүгнэлт янз бүрээр тайлбарлагдана. Байнга оршин суух хаяггүй үед оргон зайлах магадлал өндөр тул энэ нь нийлээд бие даасан цагдан хорих шалтгаан болно. Гэхдээ Эрүүгийн хэргийн байцаан шийтгэх хуулийн 70 дугаар бүлгийн 2 дугаар зүйлд "500 мянгаас доош торгууль, тэтгэмж, хураамжид хамаарах хэргийг 1 дүгээр хэсгийн 1 дүгээр зүйлд зааснаас бусад үед цагдан хорихгүй" гэж заасан. Хөнгөн гэмт хэрэгтэй холбоотой байнгын оршин суух хаяггүй тохиолдолд л зөвхөн цагдан хорих шалтгаан болно. Энэ утгаараа байнгын оршин суух хаяггүй байх нь цагдан хорих нэг үндэслэл болж чадна.

"Нотлох баримтыг устгах хандлагатай" гэдэг нь нотлох баримт ач холбогдол бүхий эд зүйлсийг үрэгдүүлэн гээх, солих, өөрчлөх, нуух, засах, хуурамчаар үйлдэх мөн хэргийн хамтран үйлдэгч, гэрч зэрэг хүнд хууль бусаар нөлөөлж худал мэдүүлэг өгөхийг тулгах, гуравдагч этгээдийг худал мэдүүлэг өгөхийг ятгах зэргээр хэргийн бодит үнэнийг тогтооход саад учруулахыг хэлнэ. Сэжигтэн болон гэмт хэрэгтэн харилцан хэргийн үнэнийг эсэргүүцэж аль болох өөртөө ашигтай талын нотлох баримт материалыг бүрдүүлэх, үнэн зөв мэдүүлэхээс татгалзах нь "нотлох баримтыг устгах хандлагатай"-д тооцогдохгүй.

"Сэжигтэн оргон зайлсан эсвэл оргон зайлж болзошгүй" тохиолдолд гэмт хэрэг илрүүлэх, мөрдөн байцаах, шүүх хэрэгжүүлэх зэрэг хууль ёсныг үйл ажиллагаанаас зайлсхийх зорилгоор хил нэвтрэн гадаад улсад гарах, эсвэл удаан хугацаагаар хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сураггүй алга болохыг хэлнэ. Сэжигтэн болон гэмт этгээд оргон зайлсан, зорилготой эсэх, тухайн хүн нийгэмд ямар байр суурь эзэлдэг болох мэдээ, түүний байнгын хаяг тодорхойгүй бол чухал нотлох баримт болох бөгөөд энэ бүгдийг нийтэд нь хэлэлцэн дүгнэж шийдвэр гаргана.

В. Цагдан хорих шалтгаан, дүгнэлт хүрээ

Эрүүгийн хэргийн байцаан шийтгэх хуулийн 70 дугаар бүлгийн 2 дугаар зүйлд "шүүгч нэг дэх цагдан хорих үндэслэлийг судлахдаа гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар, дахин гэмт хэрэг үйлдэж болзошгүй байдал, гэмт хэргийн хохирогч, гэрчийн аюулгүй байдал зэргийг харгалзан үзэхийг заасан. Энэ нь шинэчилсэн Эрүүгийн хэргийн байцаан шийтгэх хуульд шинээр тусгагдсан журам учир хуучин эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан цагдан хорих шалтгаанаас бусад үед хэргийн төрөл, шинж чанар, дахин гэмт хэрэг үйлдэж болзошгүй нөхцөл байдал, хохирогч болон чухал гэрчийн аюулгүй байдал зэргийг нэмэлт жишээ болгосон.

Үүний "хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар", "дахин гэмт хэрэг үйлдэж болзошгүй байдал", "хохирогч, гэрчийн аюулгүй байдал", "байнга оршин суух хаяггүй", "нотлох баримтыг устгах хандлагатай", "оргон зайлсан эсвэл оргон зайлж болзошгүй" зэрэг шалтгаан нь дангаараа цагдан хорих шалтгаан болж чадахгүй юм.

Г. Дүгнэлт

Үндсэн хуулийн 37 дугаар бүлгийн 2 дугаар зүйлд цагдан хорих үндэслэлийн тухай заахдаа шууд цагдан хорих журмыг дэлгэрүүлж тайлбарласан. Шинэчилсэн Эрүүгийн хэргийн байцаан шийтгэх хуулийн 70 дугаар бүлэгт цагдан хорих шалтгааныг хуучин хуультай адилтган зааж 2 дугаар хэсэгт цагдан хорих үндэслэлийг "шүүгч 1 дүгээр хэсэгт зааж байгаа цагдан хорих шалтгааныг судлахдаа хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар, дахин гэмт хэрэг үйлдэж болзошгүй", "хохирогч, гэрчийн аюулгүй байдлыг харгалзах" зэрэг нь шинэ заалт болно. Гэхдээ байнга оршин суух хаяггүй гэсэн үндэслэл нь Эрүүгийн хэргийн байцаан шийтгэх хуулийн зарчмаар бие даасан шалтгаан болох боловч цагдан хорих системийн зорилгод нийцүүлж үзвэл энэ нь хүний чөлөөт эрхийг хааснаар хэт цагдан хорих зарчмыг дэмжиж байна гэж ойлгоно.

Энэ хугацаанд сэжигтэнг хорьж гэмт хэрэг илрүүлэх шүүх үйл ажиллагааны шийдвэр гаргал ахин гэмт хэрэг үйлдэхээс болгоомжлон, гэмт этгээд бусдад амь насны, эрүүл мэндийн, эд хөрөнгийн хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх, цаашилбал нийгмийн тогтвортой байдлыг хадгалах үүднээс цагдан хорих үйл ажиллагааг дэмжиж байгаа. Шинэчилсэн Эрүүгийн хэргийн байцаан шийтгэх хуулийн энэхүү шинэ заалтуудыг Үндсэн хуулийн 37 дугаар бүлгийн 2 дугаар хэсэгт заасан шууд цагдан хорих зарчимтай адилтган шүүх хурлын дагуу "зорилготой зохицуулалт", "арга барилын уялдаа холбоо", "хууль зүйн ашгийн тэнцвэр" зэргийг илүү гүнзгий тунгаах хэрэгтэй гэдгийг ерөнхий ухаанаар бодолцон дүгнэсэн байна.

5. Цагдан хорих журам**А. Цагдан хорих тогтоолын агуулга**

Прокурор цагдан хорих тогтоолыг харъяа орон нутгийн шүүх газрын шүүгчид хүсэхээс гадна шүүх цагдаагийн ажилтан прокурорт цагдан хорих зөвшөөрлийн хүсэлтийг мэдүүлж болно. Прокурор цагдан хорих зөвшөөрлийг хүсэхдээ цагдан хорих шаардлагатай гэж үзэн нотлох баримт тушаах ёстой бөгөөд нэг ижил хэрэгтэй холбогдуулан сэжигтний талаарх урьд өмнөх цагдан хорих тогтоолын хүсэлтийг дахин гаргуулахдаа тодорхой шалтгааныг албан ёсоор тэмдэглэнэ.

Б. Шүүхээс сэжигтнийг байцаах

Шинэ Эрүүгийн хэргийн байцаан шийтгэх хууль нь цагдан хорихоос өмнө сэжигтнийг байцаах тухай, сэжигтэн байцаан шийдэх газар баривчлагдсан байгаа үе болон сэжигтэн баривчлагдаагүй үе гэсэн хоёр үеийн талаар заасан байгаа. Баривчлагдсан сэжигтний талаар цагдан хорих зөвшөөрлийн хүсэлтийг хүлээн авсан шүүгч нэн даруй сэжигтнийг байцаах ёстой бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаангүй бол цагдан хорих зөвшөөрлийн хүсэлт гаргаснаас хойших дараагийн өдөр хүртэл сэжигтнийг байцаах эрхтэй. Өмнөх Эрүүгийн хэргийн байцаан шийтгэх хууль нь сэжигтэн баривчлагдсан тохиолдолд сэжигтэн болон өмгөөлөгч мэдүүлэг өгч байж л цагдан хорихоос өмнө боломжтой болж байсан бөгөөд сэжигтэн баривчлагдаагүй тохиолдолд шүүх газар өөрийн эрх хэмжээний дагуу байцаах эсэхээ шийднэ хэмээн зааж байсан. Шинэчилсэн Эрүүгийн хэргийн байцаан шийтгэх хууль нь сэжигтэнг заавал цагдан хорихоос өмнө заавал байцаалтад хамруулна гэж заасан.

В. Цагдан хорих зөвшөөрөл**гаргах ба татгалзах**

Цагдан хорих тогтоолыг хүссэн мэдүүлгийг хүлээн авсан шүүгч хурдан хугацаанд цагдан хорих тогтоолыг үргэлжүүлэх эсэхээ шийдэж хэргийн нийгмийн хор аюулыг ноцтой гэж дүгнэвэл шууд цагдан хорих тогтоол гаргана. Харин цагдан хорих тогтоолыг гаргахгүй тохиолдолд уг үндэслэл шалтгааныг тэмдэглэж гарын үсэг зурсан өдрөө прокурорт мэдэгдэнэ. Дээд шатны шүүхэд цагдан хорих тогтоолоос татгалзсан шүүх шийдвэрийн талаар гомдол гаргах ёсгүй.

Баривчлах зөвшөөрөл болон хэргийн газар дээрх баривчлах болон хойшлуулшгүйгээр баривчлагдсан этгээдийг цагдан хорих тогтоол цуцлагдсан тэр даруйд суллаж, баривчлагдсан этгээдийн цагдан хорих тогтоолыг шүүхэд шилжигдсэн үед ч тэр даруйд суллана. Гэхдээ хойшлуулшгүйгээр баривчлагдсан хүний цагдан хорих тогтоол цуцлагдаж суллагдсаны дараа сэжигтэн гэмт хэрэгтэн болох нь нотлогдвол дахин баривчилж болно. Баривчлах тогтоолын дагуу баривчлагдсан хүний цагдан хорих тогтоолын хуудсыг тушаагаагүй үед суллагдсан бол шаардлагатай үед тогтоолыг дахин гаргуулж болно.

Г. Цагдан хорих тогтоолыг биелүүлэх

Сэжигтэн болон гэм хэрэгтэнтэй холбоотой цагдан хорих тогтоолыг прокурорын тушаалаар цагдаагийн байгууллага хэрэгжүүлэх бөгөөд нотлох баримтад үндэслэнэ. Цагдан хорих тогтоол байхгүй бол шаардлагатай гэсэн хэргийн нөхцөл байдал, хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг тайлбарлан тогтоолыг хэрэгжүүлж болно. Тогтоол гүйцэтгэсний дараа тэр даруйд цагдан хорих тогтоолыг гаргуулж зохих байгууллагад хүргүүлнэ.

Цагдан хорих тогтоол гарсан бол сэжигтэнг цагдан хорихгүй хүчингүй болгож, хоригдож байгаа

сэжигтэнг суллахдаа прокурор сааталгүйгээр тогтоол гаргасан шүүх газарт өөрийг биеээр мэдэгдэнэ. Мөрдөн байцах албанаас хоригдоод суллагдсан хүн өөр чухал гэмт хэрэгтэй холбоогүй үед тухайн хэрэгтнийг баривчлах эрхгүй.

Сэжигтнийг цагдан хорихдоо Үндсэн хуулиар тогтоосон нийгмийн байр суурийг баталж, шүүх яамнаас тусгаарлан, шүүх байгууллагын албан үүргийг бодолцон сэжигтнийг цагдан хорих тогтоолын хэрэгжилтийг онцгойлон авч үзэхийг хуульд тусгасан. Тодруулбал, сэжигтэнг цагдан хорьсон тохиолдолд тэр даруйд гэмт хэргийн бодит үнэнийг тогтоохыг шаардах, өмгөөлүүлэх эрхтэй мэдэгдэнэ. Цагдан хорих ажиллагааг хариуцсан шүүгч болон бусад шүүгч цагдан хорих тогтоолыг хэрэгжүүлэхдээ "хууль ёсны хорио"-г зөвшөөрнө. Сэжигтэнг цагдан хорих тогтоолын дагуу хорих бөгөөд байцаан шийтгэх газрын цагдан хорих хугацаа дууссан мөрдөгдөж байх явцадаа боловч сэжигтэн ахин болон өөр гэмт хэрэг үйлдсэн болох нь нотлогдвол дахин хорьж болох бөгөөд ингэхдээ тухайн хэргийг шалгах зорилгоор хорино.

Д. Дүгнэлт

Шинэ Эрүүгийн хэргийн байцаан шийтгэх хуулийн дагуу цагдан хорих явцад мөрдөн байцаалтыг заавал дамжиж шүүх газраас ямар ч сааталгүй сэжигтэнг байцаан шалгах ёстой гэж заасан нь Үндсэн хуулийн 12 дугаар бүлэгт заасан хууль нотлох баримтлалыг чанга хатуу мөрдөн шалгаж шийтгэх асуудлыг илүү боловсруулж, тэр тусмаа тогтоолыг нотлох баримтын хүрээнд илүү өргөн авч үзэх хэрэгтэй. Нөгөөтэйгүүр прокурорын гаргасан барих тогтоол хүсэлтгүй холбоотой хуучин Эрүүгийн хэргийн байцаан шийтгэх хуульд "баривчлагдсанаас хойш 48 цагийн дотор цагдан хорих зөвшөөрлийн хуудсыг тушаана" гэж заасан

боловч шинэ Эрүүгийн хэргийн байцаан шийтгэх хууль нь түүнийг "нэн даруй" гэж тодруулж "цагдан хорих тогтоол нь сэжигтэнг баривчлагдсанаас хойш 48 цагийн дотор нэн даруй мэдүүлнэ" гэж заасан нь бодит амьдрал дээр их ялгаа байхгүй байна.

6. Цагдан хорих тогтоолыг хүчингүй болгож батлан даалтад өгөх, түүний ач холбогдол

А. Цагдан хорих тогтоолыг хүчингүй болгох

Цагдан хорих үйл ажиллагааг хүчингүй болгох гэдэг нь цагдан хорих тогтоолын үр нөлөөг тэр хэвээр хадгалж зөвхөн ял ногдуулах үйл ажиллагааг хойшлуулахыг хэлнэ. Сэжигтнийг цагдан хорихыг хүчингүй болгох нь шүүгч болон прокурорын эрх хэмжээний хүрээнд шийдэгдэнэ. Гэмт хэргийг илрүүлж гэмт этгээдийг олж тогтоосон мөрдөн байцаах алба шүүж шийтгэх эрхийг олж авснаар прокурор хэргийг шийдэх эрхгүй болж харин шүүхийн цагдан хорихын хүчингүй болгож тухайн шаардлагатай үеэс бусад тохиолдолд үнэнийг тогтоох үүрэг хүлээх бөгөөд шүүхийн шийдвэрийн эсрэг гомдол гаргаж болно. Орон нутгийн шүүгч сэжигтэн болон гэмт хэрэгтэнтэй төрөл садангийн холбоотой, асран хамгаалах газар, бусад зохих хүнд захиx зэрэг ноцтой шалтгаан байгаа гэж үзвэл түүний оршин суугаа газрыг анхааралд авч цагдан хорих ажиллагааг хүчингүй болгоно.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд прокурор цагдан хорих үйл ажиллагааг таслан зогсоох тухай ил тод зааж тодорхойлоогүй. Эрүүгийн хэргийн байцаан шийтгэх хуулийн 204 дүгээр бүлэгт прокурор цагдан хорих тогтоолыг хүчингүй болгох мөн хоригдож байгаа сэжигтэнг суллах эрхтэйгээс гадна Эрүүгийн хэргийн байцаан

шийтгэх хуулийн 198 дугаар бүлгийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт прокурор цагдан хорих газрын онцгой эрхийн дагуу баривчлагдсан эсвэл хоригдсон сэжигтэнг суллах эрхтэй бөгөөд үүнтэй холбогдуулан прокурор цагдан хорих үйл ажиллагааг таслан зогсоох эрх бүхий субъект гэж гэнэ.

Цагдан хорих тогтоолыг хүчингүй болгоход сэжигтнийг хувьд барьцаа төлөх шаардлагагүй. Хоригдсон гэмт хэрэгтэнд хэрэг хэрэгсэхгүй болсон учраас шүүх газар цагдан хорих тогтоолын эрх зүйн үр нөлөөг тэр хэвээр нь хадгална гэдэг утгаараа барьцаат батлан даалтаас ялгаатай хандана. Гэвч барьцаат батлан даалт ч гэсэн цагдан хорих тогтоолын үр нөлөө бүхий утгыг хэвээр хадгалах мөртлөө ерөнхий утгаараа цагдан хорих үйл ажиллагааг таслан зогсоох нэг хэлбэр юм.

Б. Барьцаат батлан даалт

Барьцаат батлан даалт гэдэг нь барьцаа төлөх нөхцөлөөр шүүх газраас цагдан хорих үйл ажиллагааг зогсоон хоригдож байгаа сэжигтэнг суллах систем юм. Энэ нь шүүх байгууллагын завсрын үйл ажиллагаа ба хэргийн ялын хүрээг тэлж цагдан хорих ажиллагааны үр нөлөөг хадгалахын хажуугаар үл цагдан хорих шүүхийн журам болон яллах, цагаатгах нотлох баримт, гэм буруугүй эсэхийг тогтоолох эрхийг бодитоор хэрэгжүүлэхэд оршино. Барьцаат батлан даалт нь зайлшгүй батлан даалт, эрх мэдлийн батлан даалт гэж ангилагдана.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зайлшгүй батлан даалтыг тусгахдаа гэмт хэрэгтний зүгээс хууль зүйн үндэслэлтэй хүсэлт гаргах шалтгаанаас бусад үед шүүх байгууллага барьцаат батлан даалтыг зөвшөөрөх ёстой гэж заасан. Зайлшгүй батлан даалтад хүлээн зөвшөөрөхгүй шалтгаанд:

1. Гэмт хэрэгтнийг цаазаар

авах, насаар буюу 10жилээс дээш урт хугацаагаар ял шийтгүүлэх гэмт хэрэг үйлдсэн;

2. Хүнд гэмт хэрэг давтан үйлдэх;

3. Эрүүгийн хэргийн нотлох баримтыг устгах эсвэл устгах гэж оролдсон хангалттай шалтгаантай байгаа бол;

4. Гэмт хэрэгтэн оргон зайлсан эсвэл оргон зайлах үйлдэл хийх гэж оролдсон хангалттай нотлох баримт байгаа бол;

5. Сэжигтний оршин суугаа хаяг тодорхой бус үед;

6. Сэжигтэн яллагдагч нь тухайн хэргийн хохирогч, уг хэргийг шүүхэд хэрэгтэй мэдээллийг мэдэж байгаа гэсэн гэрч болон түүний төрөл садангийн хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсан, хохирол учруулах гэж оролдсон хангалттай нотлох баримт байхыг тооцно.

Нөгөөтэйгүүр эрх мэдлийн батлан даалтыг мөн хүлээн зөвшөөрч шаардлагын дагуух барьцаат батлан даалтын нөхцөлд үл нийцэх ноцтой шалтгаан байсан ч эрх мэдлийн дагуу болон гэмт хэрэгтний хүсэлтийн дагуу барьцаат батлан даалтыг зөвшөөрнө гэж заасан.

Гэмт хэрэгтэн, түүний өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч, гэр бүлийн хүн, төрөл садан, ах дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч хэн боловч хоригдож байгаа гэмт хэрэгтэнг барьцаат батлан даалтаар гаргах хүсэлт гаргах эрхтэй. Шүүх байгууллагын эрх хэмжээний хүрээнд сайн дурын барьцаат батлан даалт өгөх үед гэмт хэрэгтний зүгээс мэдүүлэг авах хэрэггүй. Шүүгч барьцаат батлан даалттай холбоотой шийдвэрийг гаргахаас өмнө прокурорын саналыг асуух ёстой. Ийм үед прокурор санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Хуучин Эрүүгийн хэргийн байцаан шийтгэх хуулийн 97 дугаар бүлгийн 1 дэх хэсэгт "прокурор 3 өдрийн дотор саналаа илэрхийлээгүй бол барьцаат батлан даалтыг зөвшөөрсөн гэж

ойлгоно" гэсэн. Шинэчилсэн Эрүүгийн хэргийн байцаан шийтгэх хууль нь үүнийг хасаад прокурор заавал чөлөөтэй санал өгөх ёстой гэж заасан.

Барьцаат батлан даалтад өгөх үндэслэл, журам;

1. Дуудсан хугацаанд ирэх, нотлох баримтыг үргэдүүлэхгүй гэсэн баталгаа гаргах;

2. Барьцаа төлсөн баталгаа, баримтыг тушаах;

3. Гадагш явахгүй, оргон зайлахгүй гэсэн баталгаа гаргах;

4. Гэрч, хохирогчийг ятгаж дарамтлах, заналхийлэх, айлган сүрдүүлэхийг хатуу хориглоно;

5. Гуравдагчийн ирц бүртгэлд хамаарах батлан даалтын баримт бичгийг тушаах;

6. Хил нэвтэрч гадаад улс руу гарахгүй гэсэн баталгаа;

7. Аюулгүй байдалд зориулсан гэрчийн мэдүүлэг болон батлан даалтыг тушаах;

8. Сэжигтэн буюу гуравдагчийн барьцааг төлсөн нотлох баримт болон батлан даалтыг тушаах;

9. Сэжигтнийг дуудсан хугацаанд ирүүлж байх баталгаа болгож зохих арга хэмжээг авна гэж заасан.

Барьцаат батлан даалтыг шийдэхэд гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, нийгмийн хор аюул, нотлох баримтын шинж чанар, гэмт хэрэгтэн өмнө нь ялтан байсан эсэх, гэмт хэрэгтний зан араншин, өв хөрөнгө, хохирогчийн хохирлыг төлж чадах чадвар зэрэг хэргийн дараах байдалтай холбоотой зүйлийг харгалзана. Гэмт хэрэгтний эрүүл мэнд, эд хөрөнгийн хангалтгүй байдал ажиглагдвал барьцаат батлан даалтыг хэрэгжүүлэхгүй. Барьцаат батлан даалтыг хүлээн зөвшөөрсөн шүүх байгууллагын шийдвэрт прокурор шууд гомдол гаргах эрхгүй боловч энгийн гомдол гаргаж болно.

Шүүх байгууллага нь сайн дураар эсвэл барьцаат батлан даалт өгөх мэдүүлгийн дагуух

шийдвэрээр гэмт хэрэгтний барьцаат батлан даалтын нөхцөлийг өөрчилж тодорхой хугацаанд уг нөхцөлийг хүчин төгөлдөр байлгах, зохих шалтгаантай гэж үзвэл шүүгч буюу прокурорын хүсэлтийг үндэслэн барьцаат батлан даалтыг хүчингүй тооцно.

Барьцаат батлан даалтыг хүчингүй болгох үндэслэл, журам;

1. Мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлах;

2. Сэжигтэн хэргийн нотлох баримтыг устгасан эсвэл устгах гэж оролдсон гэх үндэслэлтэй бөгөөд хангалттай шалтгаан байгаа бол;

3. Суллагдаад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа мөрдөн байцаалт, шүүхэд ирээгүй бол;

4. Сэжигтэн хохирогч, уг хэргийг шүүхэд хэрэгтэй мэдээллийг мэдэж байгаа гэрч болон түүний төрөл садангийн хүний амь нас, эрүүл мэнд, өв хөрөнгөд хохирол учруулсан, хохирол учруулж болзошгүй гэсэн хангалттай нотлох баримт байвал;

5. Шүүхээс заасан болзлыг зөрчсөн үед хүчингүй болгоно, гэж заасан.

Барьцаат түр сулралтын нөхцөлөөр барьцаанд тавьсан эд хөрөнгийг улсын эрх мэдэлд шилжүүлэхэд:

1. Суллах ажиллагаа цуцлагдсан тохиолдолд;

2. Шүүхийн эцсийн шийдвэр гаргахад хүндэтгэн үзэх шалтгаанаар хүрэлцэн ирээгүй гохиолдолд гэсэн хоёр шалтгаан хамаарна.

1 дүгээрт заасан үед хөрөнгө шүүгчийн эрх мэдэлд орно. 2 дугаарт зааснаар шүүгч өөрийн биеэр түүнчлэн прокурорын хүсэлтийн дагуу барьцааны талыг эсвэл нэг хэсгийг зайлшгүй засгийн эрх мэдэлд өгнө. Шүүгч цагдан хорихыг хүчингүй болгох эсвэл барьцаат батлан даалтыг хүчингүй болгоход барьцаанд байгаа эд хөрөнгийн нэхэмжлэл

өргөдөлийн дагуу засгийн эрх мэдэлд шилжээгүй байвал хөрөнгийг 7 хоногийн дотор буцааж өгнө. Түүнчлэн барьцаат батлан даалтыг хүчингүй болгох эсвэл цагдан хорих тогтоол үр нөлөөгүй болвол барьцаат батлан даалтын хүчин чадал ч үр нөлөөгөө алдана.

В. Цагдан хорих тогтоолыг хүчингүй болгох

Цагдан хорих тогтоолыг хүчингүй болгох нь хууль ёсны зарчмын дагуу цагдан хорих тогтоол дараах үр нөлөөгөө алдахыг хэлнэ. Үүнд:

- Цагдан хорих үйл ажиллагааг зогсоох. Энэ нь цагдан хорих үндэслэлгүй эсвэл үг хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж үзэж шүүх байгууллага сайн дураар эсвэл прокурор, сэжигтэн, гэмт хэрэгтэн, өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгчийн хэн нэгний мэдэгдэх хуудсыг үндэслэн шүүхийн шийдвэрээр цагдан хорих тогтоолыг **хүчингүй болгоно**. Прокурор ямар нэгэн тогтоолгүйгээр хууль хэрэгжүүлэх эрх, хоригдож байгаа сэжигтэнг суллах, шоронгоос яаралтай суллах зэргээр өөрийн эрх мэдлийг үндэслэн сэжигтэнг цагдан хорихоос чөлөөлж болно.

- Цагдан хоригдох хугацаа дууссан. Гэмт этгээдийг цагдан хорих хугацаанд шүүх байгууллагын ажилтан хамгийн ихээр 10 хоног, прокурор хамгийн ихээр 10 хоногт орон нутгийн шүүх газрын шүүгчийн зөвшөөрлийг авч эхний шатанд 10 хоногоос доош хугацаанд цагдан хорино.

Г. Дүгнэлт

Цагдан хорихыг таслан тогтоолыг хүчингүй болгох нь Үндсэн хуульд бүрэн нийцүүлсэн систем. Шинэчилсэн Эрүүгийн хэргийн байцаан шийтгэх хууль нь цагдан хорих тогтоолын үл хэрэгжилтэй холбоотой цагдан хорих эцсийн хугацааны талаар шүүх байгууллагын ажилтан, прокурорын заасан цагдан хорих

хугацаатай адилтган заасан бөгөөд шүүх газрын сэжигтэнг цагдан хорих хугацаа нь хуучин хуультай адилаар 2 сар байхаар заасан. Тэр шинэ санаачилга нь зарчмын хувьд хязгаарлаж байгаа боловч мөрдөн байцаалт болон сүүлийн байцаалтаар гэмт хэрэгтэн, өмгөөлөгч хоёрын мэдэгдсэн нотлох баримт ба судалгаа, хүсэлтийг бүрдүүлж гүйцээсэн өргөдлийг харгалзан дараагийн шүүх хуралд шилжүүлэн цагдан хорих хугацааг өөрчлөх боломжийг нээж өгсөн. Мөн ял ногдуулахаас өмнөх барьж цагдан хорих хугацааг хуульд заасан цагдан хорих хугацаатай хамааруулахгүйгээр ял ногдуулсан өдрийг тооцно гэж заасан. Энэ мөрдөн байцаалтын үед гомдол гаргах, байцаалтын хугацааны талаарх гомдол саналын тэмдэглэлийг шалгах хугацаа, гомдол нэхэмжлэл тушаах хугацаа зэргээс болж шүүхийн шинжилгээний хугацаа богиносгож дэлгэрэнгүй тэмдэглэлээр дамжин гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг олоход бэрхшээл тулгарч болох тул эхний шүүх хурлаар онц хүнд гэмт хэргийг байцаалтын хугацаа сунгагдсанаар эхний шатны цагдан хорих хугацаа багасах учир цагдан хорих хугацааг сунгасан юм.

Шинэчилсэн Эрүүгийн байцаан шийтгэх хууль нь гэмт хэрэгтнийг барьцаат батлан даалтад гаргахдаа өргөдөл гаргах эрхийг өргөн хүрээнд төрөлжүүлсэн бөгөөд түүнд тохируулан барьцаат батлан даалтын дамжлага ба нөхцөлийн өөрчлөлтийг илүү боловсруулж онцгойлсон. Энэ нь ерөнхийдөө бүрэн эрхэд нийцүүлж хууль ёсны зарчмын талаасаа цагдан хорихгүйгээр судалгаа авах аргыг өргөжүүлсэн нь нэг талаар сэжигтний эрхийн бодлогыг илүү бататгах үүднээс өөдрөгөөр үнэлж байгаа. Тэрчлэн барьцаат батлан даалтын нөхцөлийг тогтоохдоо шүүх байгууллагаас "онц хүнд гэмт хэргийн хүрээнд" үүнийг харгалзан үзэж бусад үед

гэмт хэрэгтнийг дуудсан үед баталгаатай байлгахын төлөө шүүх байгууллагаас заасан "зохих нөхцөл"-ийг хэрэгжүүлнэ гэсэн нь Үндсэн хуулийн 37 дугаар бүлгийн 2 дахь хэсэгт хэт цагдан хорих шаардлагатай оновчтой журмыг боловсронгуйгаар хэрэгжүүлэх гэж ойлгож болно.

7. Цагдан хорихтой холбоотой эсэргүүцэл болон шинжилгээ судалгаа

А. Баривчлах, цагдан хорих зүй ёсны судалгаа

Баривчлах, цагдан хорих зүй ёсны судалгаагаар баригдаж хоригдсон гэмт хэрэгтэн, түүний өмгөөлөгч болон хууль ёсны хэн боловч барьж цагдан хорих нь зүй ёсонд тохирох эсэхийг шалгуулах, үүнийг үндэслэн хууль бус эсвэл шударга бусаар барьж хорьсон сэжигтэнг суллах систем юм. Хэрэг илрүүлэх явцын үед сэжигтнийг суллах систем гэсэн ойлголтоор ял ногдуулсны дараа мөрдөн байцаах байгууллага цагдан хорихыг таслан зогсооно. Барьцаат батлан даалтаас тусад нь шүүхийн шийдвэрээр барьж хоригдсон сэжигтэнг суллах зарчмын хувьд орон нутгийн шүүгч буюу прокурорын гаргасан шийдвэрээс өөрөөр ойлгоно.

Баривчлах, цагдан хорих зүй ёсны шаардлагад зохистой эсэхийг шалгуулах нь ерөнхийдөө сэжигтний эрхийг хүлээн зөвшөөрч байгаа гэсэн үг. Баригдаж хоригдсон сэжигтэн, түүний өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч, эхнэр нөхөр, ах дүү, цусан төрөл, хамтран амьдрагч, хамаатан хэн боловч харъяа шүүх газарт цагдан хорих үйл ажиллагаа хууль ёс зүйн чанарт тохирч байгаа эсэхийг шалгуулах эрхтэй. Сэжигтний сонгож авсан өмгөөлөгчөөс гадна "хамтран амьдрагч, гэр бүлийн гишүүн болон хууль ёсны төлөөлөгч"-ийг хамруулах зорилготойгоор хүрээг тэлж байгаа. Баривчлах, цагдан хорих зүй ёсонд хууль ёсны

эрхтэй этгээд харьяа шүүх газарт барих цагдан хорих нь зохистой эсэхийг шалгуулж болох бөгөөд мөрдөн байцаах газар мэдэгдэх хуудсыг авсны 48 цагийн дотор барьж хоригдсон сэжигтэнг байцааж хэрэг илрүүлэхтэй холбоотой бичиг нотлох баримт ба нотлох баримт эд зүйлсийг шинжлэх үүрэгтэй. Үүнд хариуцагч шүүгч эхлээд нөхцөл байдал эсрэг хангалттай үндэслэлтэй эсэхийг шалгаж хэрэв шаардлагатай нөхцөлийг хангаагүй байвал сэжигтнээс байцаалт авалгүйгээр өргөдлийг буцааж болно. Үүнд:

1. Өргөдөл өгөх эрхгүй хүн өргөдөл өгсөн эсвэл баривчлах, цагдан хорих тогтоол гарсантай холбоотой дахин өргөдөл гаргах;

2. Гэмт хэрэг хамтран үйлдэгч болон сэжигтнүүд дараалж өргөдөл гарган хэрэг илрүүлэхэд хэрэгсэл саад бэрхшээл учруулах гэж оролдсон үед өргөдөл хүчингүйд тооцно.

Энэ заалтын дагуу судалгаанд тухайн хэрэгтэй холбоотой баривчлах цагдан хорих тогтоол гаргасан шүүгч нөлөөтэй боловч "шууд буцаах шийд"-эд гомдол гаргах эрхгүй. Хэргийг хариуцсан шүүгч зүй ёсны өргөдөл нь хууль зүйн шаардлагын нөхцөлд зохицож байвал бодит байдлыг судалж тухайн шүүгчээс гадна байцаалт судалгааны дагуу шийдвэр гаргасан дэд шүүгчийн оролцоогүйгээр хуульч судалгааны шийдвэр гаргахад оролцох боломжгүй. Хэргийг хариуцсан хуульч байцаалт авахдаа хэрэг хамтран үйлдэгчдээс тус тусад нь байцаалт авч тухайн сэдвийн нууцыг баттай хадгалахын тулд зохих арга хэмжээг авна. Байцаалтад прокурор, өмгөөлөгч, баривчлах цагдан хорих тогтоолын эсрэг мэдүүлэг өгсөн төлөөлөгч оролцож үнэн мэдүүлгийг өгнө.

Хэргийг хариуцсан шүүгч бодит нөхцөл байдлыг шалгаж баривчлах, цагдан хорих нь хууль ёсонд тохирч байгаа эсэхийг судалж чөлөөлж болно

гэж дүгнэвэл хэргийг хэрэгсэхгүйд тооцож шийдвэрийн дүнд гомдол гаргах эрхгүй.

Нөгөөтэйгүүр хоригдож байгаа сэжигтэнг онцгой тохиолдлоос бусад үед мөнгөн барьцаат болзлын дагуу түр суллаж болно. Онцгой үе гэдэгт:

1. Гэмт хэрэгтэн хэргийн нотлох баримт баталгааг устгах эсвэл устгах гэж оролдсон найдвартай бөгөөд хангалттай шалтгаантай байх;

2. Гэмт хэрэгтэн хохирогч, уг хэргийн талаар шүүхэд хэрэгтэй мэдээллийг өгч болох гэсэн хүн болон түүний төрөл садан, түүний амь нас, эрүүл мэнд, өв хөрөнгөд хохирол учруулсан айлган сүрдүүлсэн хангалттай нотлох баримт байхад хамаарна. Нэмэлт нөхцөлөөр нүүдэл суудлын хязгаарлалт, тогтоосон цаг газарт заавал ирэх ёстойг оруулан зааж болно.

В.Шалгах үйл ажиллагааны явцад гарах санал зөрчил

Шалгах үйл ажиллагааг явцад гарах санал зөрчилд прокурортой эсвэл цагдаагийн ажилтантай ямар нэгэн санал сөргөлдөөн гарвал сэжигтэн харъяалах газарт хэргийг хэрэгсэхгүй болгох, ялын хэлбэрийг өөрчлөх зэрэг гомдол хүсэлтийг харгалзан өөрчлөх систем юм. Прокурор шүүх цагдаагийн ажилтны цагдан хорих үйл ажиллагаа нь хэрэг илрүүлэх явцад шүүгчийн зүгээс гарсан барьж цагдан хорих тогтоолын хэрэгжүүлэлт болон шүүх хурлын шийдвэрийн дагуу хууль хэрэгжүүлэгч байгууллагаас цагдан хорихыг хэлнэ. Хоригдож байгаа сэжигтэн ба гэмт хэрэгтэн хоёр бусадтай чөлөөтэй харилцан ярихад хяналт тавих, цагдан хорих газрыг сайн дураар өөрчлөх нь шүүгчийн эрх мэдлийн асуудал юм. Гомдлыг өөрийн гараар бичиж шүүгчид өгнө. Шийдлийн эсэргүүцэл нь шүүх хурлын үйл ажиллагаанд ямар ч нөлөөгүй бөгөөд шүүгчийн зүгээс өргөдөлтэй холбоотой шийд гартал хэрэг илрүүлэх

байгууллагын хориог түр зогсоож болно.

Ял ногдуулахад сэжигтэнд шууд хохирол учирч болох тул хохирлыг барагдуулах хууль ёсны арга хэмжээ байх хэрэгтэй. Хэрэв цагдан хорих үйл ажиллагаа цуцлагдаж өөрчлөгдөвч хорио нь цааш үргэлжлэх боломжгүй болж өргөдлийг хэрэгсэхгүй гэж үзнэ.

В. Дүгнэлт

Шинэчилсэн Эрүүгийн байцаан шийтгэх хууль нь баривчлах, цагдан хорих хууль ёсны тогтоолыг гүйцсэж оронд нь тогтоолоор баривчлах, хойшлуулшгүйгээр баривчлах, хэргийн газар дээрх баривчлах талаар түүний ёс зүйн чанарыг нотлох баримтын үндсэн дээр зарга мэдүүлэг өгөх боломжийн хүрээг тэлэх зорилготой. Сэжигтэнг хорьсон прокурор шүүх цагдаагийн ажилтан дээрх зарга өргөдөл гаргагсдын дундаас сэжигтний зааж өгсөн хүнээс байцаалт авч болно гэж заасан. Тэрчлэн барьж цагдан хорих зохистой эсэхийг шалгах үйл ажиллагааны цуцлалтыг зарга өргөдөл өгснөөс хойш 48 цагийн дотор тусгайлан шуурхай шалгах үүрэгтэй бөгөөд цагдан хорих үйл ажиллагаанаас өмнө сэжигтнийг байцаах тэмдэглэлийг албан нотлох баримт болгон хүлээлгэнэ.

Шинэчилсэн Эрүүгийн байцаан шийтгэх хуульд баривчлах, цагдан хорих үйл ажиллагаа, шүүх хуралд хамрагдах хүний тоо өргөдөл гаргагчдын тоог нэмэх аргыг хэвээр үлдээх нь ерөнхийдөө бүрэн эрхт болон хууль ёсны зарчимд нийцэж байгаа гэж дүгнэсэн. Үүний адилаар цагдан хорих системийг үл нийцэх эсэхийг дахин шалгуулах хууль ёс зүйн хувьд бүрэн эрхт ёсыг нотлох баримтын хүрээнд мөрдөн байцаах албанаас дагалдан гарах хэлмэгдлийг зогсоох, ял ногдуулсны дараа өргөдлийг дахин шалгаж, цагдан хорих шаардлагатай эсэхийг дахин


шүүж тунгаана.

8. Төгсгөл

БНСУ-ын Үндсэн хууль нь ард түмнийг дээдлэн ардчилсан, хууль засаглалт, энэрэнгүй хүмүүнлэг нийгэм, соёлч үндэстэн, олон улсын энх тайвныг сахиулагчийн ерөнхий зарчмаар ард түмний хувийн эрх ашгийг хамгаалан нийгмээс тусад нь хувь хүний нэр хүнд, аз жаргалыг уялдан зохицуулж улс орны нэгдмэл чанарыг хэвээр хадгалахыг гол зорилгоо болгосон. Үүнээс үүдээд улс орон хувь хүний халдашгүй эрхийг бататгах

үүрэгтэй бөгөөд ард түмний чөлөөтэй байх эрхийг Үндсэн хуулийн жагсаалтад байхгүй гэж үл тоомсорлохыг хориглоно. Мөн ард иргэдийн эрх чөлөө, эрх мэдэл, улсын аюулгүй байдлын баталгаат дэг журмыг захих мөн нийгмийн тогтвортой байдлын төлөө шаардлагатай үед хуулийн зүгээс хязгаар тогтоож болох бөгөөд хязгаар заасан үед халдашгүй чөлөөт эрхэд халдаж болохгүй гэж тунхагласан. Манай Үндсэн хууль ийм Үндсэн хуульд байх ёстой ерөнхий зарчмыг

тулгуурлан улсын хүчин чадлыг, хувь хүний эрх чөлөөг хамгаалж үүнийг боловс-ронгуйгаар системчилсэн аргаар хэрэгжүүлж дээр бидний дурдсан зүйлийг боломжтой талаас нь уялдуулна гэж заасан. Ийм утгаараа Шинэчилсэн Эрүүгийн байцаан шийтгэх хууль нь бодит үнэнийг олохдоо хүний эрхийн асуудлыг хамгийн түрүүнд бодолцон хэрэгжүүлэхийн тулд цагдан хорих системийг дахин шинэчилсэн юм.





Хууль зүйн үндэсний төвийн Олон улсын эрх зүйн
секторын эрдэм шинжилгээний дэд ажилтан Н.Мөнхтуяа

ГАДААДЫН ИРГЭДИЙН АНГИЛАЛ, ТЭДГЭЭРИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛСОН НЭР ТОМЬЁОНЫ ТУХАЙД

Эх хэлний хууль зүйн нэр томьёо, гадаад /орос, англи/ нэр томьёотой харьцуулж монгол хэлний оновч, гадаад нэр томьёоны оноолтыг нягтлахдаа харьцуулан судлах арга хэрэглэлээ.

Definition—нэр томьёоны тодорхойлолт. Энэ нь дотроо **Legal definition** буюу хуулийн тодорхойлолт, **Eigene definition** буюу өөрийн шууд утгыг илэрхийлсэн хэл зүйн тодорхойлолт гэж ангилагддаг.

Нэр томьёоны тодорхойлолтыг авч үзэхдээ:

- Тухайн хуульд заасан тодорхойлолт байгаа эсэх;

- Шүүхээс тайлбарлан гаргасан тодорхойлолт байгаа эсэх;

- Өөр хууль тогтоомжид заасан тодорхойлолт байгаа эсэхийг нягтлах хэрэгтэй.

Хэрэв энэ дарааллын дагуу тухайн ойлголтыг тайлбарласан тодорхойлолт байхгүй бол бусад салбар шинжлэх ухааны тодорхойлолт байгаа эсэхийг нягтлан үзэх нь зүйтэй.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн "Нэгдүгээр бүлэг"-т тус хуулийн нийтлэг үндэслэл болох хуулийн зорилт, нэр томьёоны тодорхойлолт, уг хуулийн зохицуулалтад хамаарах этгээдийн

талаар тусгана гэж заажээ. Хуулийн төслийн текстийг үзэхэд "гадаадын иргэн", "уригч", "түр иргэгч", "хувийн хэргээр оршин суугч", "Монгол Улсад албан хэргээр оршин суугч", "харьяалалгүй хүн", "паспорт", "виз", "визийн зөвшөөрөл" зэрэг нийт 9 нэр томьёог онцгойлж авч үзсэн байна.

Харин 1993 оны Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйлд "Энэ хуулийн заалт нь Монгол Улсад зорчигч, тус улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөгч, түр буюу удаан хугацаагаар оршин суугч, байнга оршин суугч, цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүн /цаашид энэ хуульд "гадаадын иргэн" гэх/-д хамаарна" гэсэн. Энэ зүйлд заасан нэр томьёогоо тус хуулийн 22 дугаар зүйлд тодорхойлж өгчээ. "Түр оршин суугч", "албан хэргээр удаан хугацаагаар оршин суугч", "цагаач", "байнга оршин суугч", "хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суугч", "дамжин өнгөрөгч" зэрэг нийт 6 нэр томьёог онцгойлж тодорхойлсон байна. Гэхдээ хууль анх батлагдах үед эдгээр нэр томьёоноос 4 нэр томьёог тодорхойлсон байсан бөгөөд хуулийг хэрэгжүүлэх явцад буюу 1997 оны 10 дугаар сарын 31-ний

өдрийн хуулиар зарим нэр томьёог өөрчлөн найруулж, заримыг шинээр нэмж, 2000 оны 12 дугаар сарын 7-ны хуулийн нэмэлтээр зарим нэр томьёог шинээр оруулсан байна.

Эдгээр нэр томьёог тайлбарласан эсвэл 1993 онд батлагдсан Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн талаар Монгол улсын Дээд шүүхээс аливаа нэг тайлбар гараагүй байна.

Гадаадын зарим улс орны хууль тогтоомжийг үзэхэд "харьяалалгүй хүн" хэмээх нэр томьёог "Харьяатын тухай хууль"-даа тодорхойлсон байна. Үүний нэг жишээ бол 2002 оны ОХУ-ын Харьяатын тухай хууль, түүний 3 дугаар зүйл болно. Гэтэл Монгол Улсын бусад хууль тэр дундаа Харьяатын тухай хуульд энэ нэр томьёог өнөөг хүртэл тодорхойлоогүй байна. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд энэ нэр томьёог анх удаа тодорхойлсон гэж үзэж байна.

1993 онд батлагдсан Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон хуулийн төслийн текстэд тодорхойлсон нэр томьёоноос эрх зүйн харилцааны субъектийг тодорхойлох зарим нэр томьёог түүвэрлэн харьцуулан авч үзье.

Хүснэгт №1


Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, 1993 оны 12 дугаар сарын 24-ний өдөр	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль (Шинэчилсэн найруулга, 2008 он)	Бусад эрх зүйн эх сурвалж
22.3 Монгол Улсад Засгийн газар хоорондын гэрээгээр суралцаж, ажил, албан тушаал эрхлэх, гадаадын төрийн бус болон олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн удирдах бүрэлдэхүүнд ажиллах болон тэднтэй адилтгах албан тушаал эрхлэн 90 хоногос дээш хугацаагаар оршин суух гадаадын иргэнийг <u>оршин суугч</u> гэж нэрлэнэ.	4.1.5 "Монгол улсад албан хэргээр оршин суугч" гэж Монгол Улсад төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрөө удирдах байгууллагын урилгаар ирсэн буюу Засгийн газар хоорондын, гадаадын болон олон улсын төрийн бус байгууллагын төлөөлөгчийн газарт ажиллах гадаадын иргэнийг	
22.1 Энэ хуульд заасан үндэслэлээр Монгол Улсад 30 хоног хүртэл хугацаагаар албан болон хувийн хэргээр ирсэн гадаадын иргэнийг <u>зорчигч</u> гэж нэрлэнэ.	4.1.3 "түр ирэгч" гэж Монгол Улсад 30 хоног хүртэлх хугацаагаар Монгол Улсад ирсэн гадаадын иргэнийг	
22.7 Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин нэг орноос нөгөөд зорчигч байгаа этгээдийг <u>дамжин өнгөрөгч</u> гэж нэрлэнэ.		
22.2 Монгол Улсад хувийн хэргээр 90 хүртэл хоногийн хугацаагаар байгаа гадаадын иргэнийг <u>түр оршин суугч</u> гэж нэрлэнэ.	4.1.4 "хувийн хэргээр оршин суугч" гэж Монгол Улсад суралцаж, хөдөлмөр эрхлэх, хөрөнгө оруулах, гэр бүл болох болон бусад хувийн зорилгоор Монгол Улсад ирсэн гадаадын иргэнийг	
22.5 Монгол Улсын харьяат иргэнтэй гэр бүл болон нөгөөд 90 хоногос дээш хугацаагаар Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэнийг <u>байнга оршин суугч</u> гэж нэрлэнэ.		
22.6 Монгол Улсад хувийн хэргээр 90 хоногос 5 жил хүртэл хугацаагаар оршин суугаа гадаадын иргэнийг <u>хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суугч</u> гэж нэрлэнэ.		
22.4 Хувийн хэргээр Монгол Улсад амьдрааар 5 жилээс дээш хугацаагаар ирсэн гадаадын иргэнийг <u>цагаач</u> гэж нэрлэнэ.		"цагаач" гэж оршин суух газар нутаг хайж ирсэн хувийн хэлнэ
	4.1.6 "харьяалалгүй хүн" гэж аль ч улсын харьяат биш хүнийг	"харьяалалгүй хүн" гэж ОХУ-ын иргэний харьяалалгүй, өөр улсын иргэн гэдгийг нь нотлох баримт бичиггүй этгээдийг
	4.1.1 "Гадаадын иргэн" гэж Монгол Улсын иргэний харьяалалгүй хүнийг	Энэхүү тунхаглал болон холбогдох зүйлүүдэд заасан үүгээр нь "Гадаад хүн" гэж өөрийн амьдрах буй улсынхаа иргэн биш аливаа этгээдийг хэлнэ.

Дээрхи хүснэгтээс харахад хуулийн төсөлд зарим нэр томъёог, жишээ нь "зорчигч", "дамжин өнгөрөгч" гэсэн нэр томъёог нэгтгэж "түр ирэгч" гэсэн нэг нэр томъёо хэрэглэсэн байна. Мөн "түр оршин суугч", "байнга оршин суугч", "хувийн хэргээр оршин суугч" гэсэн нэр томъёог нэгтгэн "хувийн хэргээр оршин суугч" гэсэн нэр томъёог хэрэглэжээ.

1993 оны Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд гадаадын иргэний эрх зүйн байдлыг тогтооход цаг хугацааны хүчин зүйлс нөлөөлжээ. Харин хуулийн төсөлд цаг хугацааны хүчин зүйлийг нэр томъёог тодорхойлохдоо харьцангуй бага буюу зөвхөн "түр ирэгч"-ийг тодорхойлоход 30 хоног гэсэн хугацаа ашиглажээ. Харамсалтай нь зарим шаардлагатай, тухайлбал "цагаач" гэх мэт нэр томъёог хуулийн төсөлд орхигдуулсан байна. Дараах зургаас нэр томъёог тодорхойлоход цаг хугацааны хүчин зүйл хэрхэн нөлөөлснийг харж болно.

Зураг №1

байнга оршин суугч



Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон хуулийн төсөлд „хуулийн хамаарах“ этгээд гэсэн заалтад уг хуулиар болон хуулийн төсөлд тодорхойлсон бүх субъектыг "цаашид *«гадаадын иргэн»* гэж болно" гэж хаалтанд бичиж заасан нь хуульд тодорхойлсон

субъектуудын хувьд тухайн улсын нутаг дэвсгэр дээр оршин суугаа цаг хугацааны нөлөө нь тэдний эрх зүйн байдлыг тодорхойлох гол хүчин зүйл биш гэдгийг харуулах бөгөөд тэдний эдлэх эрх, хүлээх үүрэг тийм ч ялгаатай биш гэдгийг харуулж байна. Өөрөөр хэлбэл, ийнхүү

ангилан заагласан нь тус улсын нутаг дэвсгэрт орж ирэн бүртгүүлэхээс бусад буюу яг ямар эрх, үүргийн хувьд ач холбогдолтой болох нь тодорхойгүй болжээ. Иймд энэ заалтыг тийм ч оновчтой заалт болж чадаагүй гэж үзэж байна.

¹ Immigration Act, 1976 (Canada Immigration Act, 1976, Article 2) – Канадын цагаачлалын хууль, 1976 он, 2 дугаар зүйл

² ОХУ-ын харьяатын тухай Холбооны хууль, 2002 он, 3 дугаар зүйл (<http://www.legislationonline.org/rul/legislation.php?авб=сайтеас+авес>)

³ Амьдрах буй улсынхаа иргэн биш этгээдийн хүний эрхийн асуудлаархи тунхаглал, ЕА-н 40/144 зөвлөмж, НҮБ-ийн 252 дугаар 40 дэх нэмэлт баримт бичиг (#53), НҮБ-ын А/40/53 (1985) – 1 дүгээр зүйл

Хүснэгт №2

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, 1993 оны 12 дугаар сарын 24-ний өдөр 4 дүгээр зүйл. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хуулийн хамраарх этгээд	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/, 2008 он
Энэ хуулийн заалт нь Монгол Улсад зорчигч, тус улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөгч, тур буюу удаан хугацаагаар оршин суугч, байнгын оршин суугч, цэргээс гадаадын иргэн, харьяалаггүй хүн /цаашид энэ хуульд "гадаадын иргэн" гэх/-д хамрагдана.	5 дугаар зүйл. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хуулийн хамраарх этгээд 5.1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөгч, тус улсад түр ирэгч, албан болон хувийн хэрэгээр оршин суугч гадаадын иргэн /цаашид "гадаадын иргэн" гэх/-д;

Хуулийн төслийн үзэл баримтлалд "Монгол Улсад оршин сууж байгаа гадаадын иргэний ангилал, статусыг тодорхой болгож цэгцлэх шаардлагатай байна" гэж дурьдаад одоо мөрдөж байгаа хуулиар гадаадын иргэдийг 7 ангилалд хувааж байгаа нь хэт олон, ойлгомжгүй, хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа нь гадаадын иргэдэд тавих хяналтад сөргөөр нөлөөлж байна гэж үзэж байгаатай санал нэг байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалд гадаадын иргэн, цагаачлалын талаар баримтлах төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг улам боловсронгуй болгоход уг хуулийн шинэчилсэн найруулгыг хийж байгаа ач холбогдол оршиж байгаа тухай бичсэн. Цагаачлалын тухай ярихад "цагаач" гэсэн нэр томъёог тодорхойлохгүйгээр уг субъектийн эрх зүйн байдлыг тогтоож чадахгүй. Хувь хүн гадаадад амьдрахаар сайн дураараа өөрийн эх орноо орхин явахыг цагаачлах гэнэ⁴. Цагаачид⁵ (эдийн засгийн) – зөвхөн эдийн засгийн шалтгаанаар буюу материаллаг аж байдлаа дээшлүүлэх зорилгоор уугуул орноо орхин гарч байгаа хүмүүс. Эдийн засгийн цагаачид нь дүрвэгчийн эрх зүйн шалгуурт багтдаггүй, тийм учраас дүрвэгсэд мэт олон улсын хамгаалалт эдэлдэггүй.

Цагаачлалын эрх зүйн субъект нь гадаадын тодорхой улсын иргэдээс гадна хоёрдмол харьяалалтай болон харьяалаггүй хүмүүс байдаг учир "гадаадын иргэн" гэж нэрлэх нь учир дутагдалтай⁶. Аливаа улсын цагаачлалын хууль тогтоомжийн дагуу тухайн улсын нутаг

дэвсгэр дээр оршин суугаа тухайн улсын иргэн бус аливаа хүнийг "гадаадын хүн" гэдэг. Энэ талаар "Амьдарч буй улсынхаа иргэн анх этгээдийн хүний эрхийн асуудлаархи тунхаглал" НҮБ-ийн А/40/53 (1985) баримт бичигт ч заасан байдаг. Хууль зүйн толь бичиг сөхөж үзвэл *Extraneus est subditus qui extra terram, i.e., potestatem regis natus est* - харь хүн, гадаад хүн гэдэг бол улсын хилээс гадна, эсхүл хааны эрх мэдлээс гадна төрсөн хүнийг хэлнэ гэж тэмдэглэжээ (*Extraneus*⁷-харь хүн, гадаад хүн, гадны хүн). Хууль нь нэр томъёогоор амьсгалдаг, нэр томъёо зөрвөл наанадаж гажуудал, цааш хууль ёсонд хямрал үүсдэг. "Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль"⁸ (1993 он)-ийн 21 дүгээр зүйлийн гарчиг "Гадаадын хүн Монгол Улсад оршин суух" гэсэн байдгийг анхаарвал "гадаадын хүн" гэсэн нэр томъёог хуульд огт хэрэглээгүй биш, цоо шинэ нэр томъёо биш байна гэдгийг хэлэх нь зүйтэй болов уу.

Монгол Улсын Үндсэн хууль⁹ (1992)-ийн 14.2-т "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна" гэж заасан. Эндээс үзвэл аливаа хүн тухайн улсын иргэн

байна уу, гадаадын иргэн байна уу, давхар харьяалалтай этгээд байна уу, харьяалалгүй хүн байна уу гэдгээс үл шалтгаалан эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Гэвч гадаадын иргэн хоёр эрх зүйн дэглэмд захирагддаг: өөрийн улсын болон оршин суугаа улсын эрх зүйд. Уг хоёрдмол байдал нь гадаадын иргэдийн эрх зүйн өвөрмөц байдлын илэрхийлэл болдог юм.

Аливаа улсад байгаа гадаадын иргэний эрх зүйн байдлыг тодорхойлоход хүний эрх, эрх чөлөөний талаарх олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим ба хэм хэмжээ нь чухал үүрэг гүйцэтгэдэг. Олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим ба хэм хэмжээ нь Хүний эрхийн тунхаглал, Иргэний ба улс төрийн эрхийн пакт, Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай пакт, Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Европын Конвенц зэрэгт агуулагддаг. Тухайлбал Хүний эрхийн түгээмэл тунхаглал¹⁰-ын 6 дугаар зүйлд "Хүн бүр хаана ч байсан эрх зүйн чадвартай байх эрхээ хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй". Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт¹¹-ын 13 дугаар зүйлд "Энэхүү Пактад оролцогч аль нэг улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин суугаа гадаадын иргэнийг гагцхүү хуулийн дагуу гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үүднээс албадан гаргаж болох бөгөөд үндэсний аюулгүй байдлыг хамгаалах зайлшгүй шалтгаанаас бусад тохиолдолд албадан гаргахыг эсэргүүцсэн үндэслэл шалтгаанаа танилцуулах, эрх бүхий байгууллага буюу түүнээс тусгайлан томилсон этгээд буюу этгээдүүдээр хэргээ дахин

⁴ О.Пунцагдаш, Иргэний харьяалал (Олон улсын эрх зүйн асуудал), УБ, 2002, 98 дахь тал

⁵ Парламентын гишүүдэд зориулсан гарын авлага №2-2001, Дүрвэгсдийн асуудлаарх олон улсын эрх зүйн лавлах, УБ, 2007, 131 дэх тал

⁶ Г.Сэсээр "АНУ-ын цагаачлалын эрх зүйн зарим асуудал", Вашингтон хот, 2006 он, 97 дахь тал

⁷ Ж.Амарсанаа – Латин нэр томъёоны толь, 2008, 74 дэх тал

⁸ Төрийн мэдээлэл №, 1993

⁹ Төрийн мэдээлэл №, 1992

¹⁰ Төрийн мэдээлэл, ОУГ, тусгай дугаар, 2005 он, боть 1, 6-7 дахь тал

¹¹ Төрийн мэдээлэл, ОУГ, тусгай дугаар, 2005 он, боть 1, 16 дахь тал

хянуулах түүнчлэн энэ зорилгоор ийнхүү эрх бүхий байгууллага, этгээд буюу этгээдүүдэд өөрийгөө төлөөлүүлж хандах эрхтэй" гэж тус тус заажээ.

Олон улсын эрх зүйгээр тогтоосон хүний эрх тухайлбал өөрийн улсыг чөлөөтэй орхин явах, эх орондоо буцаж ирэх эрхийг хангах, хэрэгжүүлэхэд аль улсын иргэн байх, харьяалалгүй этгээд байх зэрэг үл хамаарна. Энэ талаар Хүний эрхийн түгээмэл тунхаглал¹²-ын 13 дугаар зүйлд "Хэн боловч аливаа улс орныг, түүний дотроо эх орноо орхин явах, эх орондоо эргэж очих эрхтэй", Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт¹³-ын 12 дугаар зүйлд ". Аль нэг улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор байгаа аливаа хүн тухайн нутаг дэвсгэрийн дотор чөлөөтэй шилжин явах, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй", "Аль нэг улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор байгаа аливаа хүн тухайн нутаг дэвсгэрийн дотор чөлөөтэй шилжин явах, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй", "Хүн бүр аливаа улсыг, түүний дотор эх орноо орхин явах эрхтэй" гэж тус тус заажээ. Мөн НҮБ-ийн Ерөнхий Ассамблейн 1990 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 69 дүгээр хуралдаанаар "Цагаач-ажилчид ба тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын Конвенц батлан гаргасан юм"¹⁴. Уг конвенцид цагаачид, тэдний гэр бүлийн гишүүдийн эрх зүйн харьцаанд ялгаварлан гадуурхахгүй байх, тэд ямар ч үед аливаа улс, түүний дотор харьяалах нутаг дэвсгэрээс гарч явах, зорчин очих, тэдний амь нас хуулиар хамгаалагдах зэрэг өргөн эрх, эрх чөлөөг тодорхой зааж оруулсан.

Монгол Улсын хувьд Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэний эрх, үүргийг Монгол Улсын хууль, уул иргэнийг харьяалсан улстай байгуулсан гэрээгээр тогтооно. Монгол Улс олон улсын

гэрээгээр гадаадын иргэний эрх, үүргийг тодорхойлохдоо уул иргэнийг харьяалсан улстай энэ талаар харилцан адил байх зарчим баримтална. Энэ талаар Монгол Улсын Үндсэн хуулийн 18 дугаар зүйлд заасан. 2008 оны байдлаар Монгол Улс гадаадын 74 улстай 1055 гэрээ байгуулснаас Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг¹⁵:

-эрүүгийн хэргээр эрх зүйн туслалцаа үзүүлэх - 19
-иргэний хэргээр эрх зүйн туслалцаа үзүүлэх - 18
-гэр бүлийн хэргээр - 11
-аж ахуйн асуудлаар - 2
-хөдөлмөрийн асуудлаар - 1
-гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай - 4
-алтан шилжүүлэн өгөх тухай - 1 тус тус байгуулжээ.

Гадаадын иргэн, гадаадын хүний эрх зүйн байдлыг бусад улс оронд хэрхэн авч үзсэн байдаг талаар товч авч үзье.

1981 оны гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай ЗХУ-ын хууль гадаадын иргэдийг хоёр бүлэгт хуваасан байдаг: байнгын оршин суугч болон ОХУ-д түр хугацаагаар оршин суугч. Гадаадын иргэдийг аль нэг бүлэгт оруулахдаа хугацааны нөхцөл байдлыг /оршин байх хугацаа/ нь харгалзахаас гадна түүний ОХУ-тай тогтоосон эрх зүйн холбооны тогтвортой байдлыг болон ОХУ-д байх зорилго ба шинж чанарыг нь харгалзаж үздэг. ОХУ-ын хуулиар тухайн улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа гэсэн бодит байдал нь түүний эрх зүйн байдлыг тодорхойлох гол хүчин зүйл болдог. Иймд хөдөлмөрийн үйл ажиллагаа явуулах, орон сууцаар хангагдах, эмнэлгийн туслалцаа авах, боловсрол олж авах зэрэг асуудлаар ОХУ-д байнга оршин суугч ОХУ-ын

иргэдийн адил эрх эдэлдэг. Иймд байнга оршин суугч иргэдийн статус нь түр хугацаагаар хүрэлцэн ирсэн гадаадын иргэдийн статусаас ялгаатай.

ОХУ, ТУХН-ийн болон зүүн Европын улс гүрнүүд болон БНХАУ «гадаадын иргэдийн эрх зүйг» эрх зүйн тогтолцоон дахь бие даасан салбар гэж үздэггүй. Учир нь зохицуулах зүйлсээрээ хамаарах хэм хэмжээ нь эрх зүйн тогтолцооны төрөл бүрийн салбарт багтдаг: төрийн, захиргааны, иргэний, хөдөлмөрийн, гэр бүлийн, эрүүгийн, процессийн, гэх мэт. Гэхдээ энэ нь нийлбэр цогц шинжтэй тусгай хууль тогтоомжийн зохицуулалтын практик ач холбогдлыг (зүй ёсны) үгүйсгэж байгаа гэж үзэж болохгүй юм. Ийм зохицуулалт зүй ёсны гэдгийг хүлээн зөвшөөрсний улмаас ЗХУ 1981 онд «ЗХУ дахь гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай» хуулийг батлан гаргасан билээ. ОХУ-ын хувьд «Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай» хуулийн төсөл боловсруулагдаад байна. Белорусс болон Казахстан зэрэг улс «Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай» хуультай.

Харьяалалгүй хүн гэдэг нь ОХУ-ын харьяалалд хамаарагдахгүй бөгөөд өөр аль нэг улсын харьяат гэдгийг нотлох баримтгүй хүнийг ойлгоно.

Дүрвэгч гэдэг нь ОХУ-ын харьяалалгүй бөгөөд түүний эсрэг үйлдсэн хүчирхийллийн болон бусад хэлбэрийн мөрдөн мөшгөлтийн улмаас эсхүл арсны өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, хэл мөн ямар нэгэн нийгмийн бүлэгт харьяалагддаг байдлаасаа болон улс төрийн үзэл бодлоос нь хамааран мөрдөн мөшгилтөд өртөх аюулаас зугтан өөрийн улсын нутаг дэвсгэрийг орхин гарах хүсэлттэй эсхүл шаардлагатай болсон улмаас ОХУ-ын нутаг дэвсгэрт хүрэлцэн

¹² Төрийн мэдээлэл, ОУГ, тусгай дугаар, 2005 он, боть 1, 6-7 дахь тал

¹³ Төрийн мэдээлэл, ОУГ, тусгай дугаар, 2005 он, боть 1, 16 дахь тал

¹⁴ Монголын төр эрх зүй сэтгүүл, 2002/4, О.Пунцагдау "Цагаачдын эрх зүйн байдал", 10 дахь тал

¹⁵ Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хяналт шинжилгээ, үнэлгээ тайлан, ҮБ, 2008 он, 409-410 дахь тал

ирсэн буюу тийм хүсэлтэй байгаа хувь этгээдийг ойлгоно.

Шилжин суурьшигч гэдэг нь сайн дурын үндсэн дээр болон өөрийн хүсэлтээр өөрийн улсын нутаг дэвсгэрийг орхин өөр улсын нутаг дэвсгэрт шилжин суурьшиж байгаа хувь этгээдийг ойлгоно. ОХУ нь Армени, Белорусс, Казахстан, Киргиз, Туркменистан, Латви зэрэг улстай шилжин суурьших асуудлаар хэлэлцээр хийсэн бөгөөд уг гэрээгээр шилжин сууршуулах ажиллагааг зохицуулахаас гадна шилжин суурьшигчдын эрхийг, тэр тусмаа өмчийн эрхийг нь хамгаалж өгсөн юм. Жишээлбэл, 1999 онд хүчин төгөлдөр болсон Казахстан Улстай байгуулсан гэрээнд соёлын үнэт зүйлд тогтоосон хязгаарлалтыг харгалзан бусад хөдлөх эд хөрөнгө хилээр гаргах эрхийг шилжин суурьшигчид олгосон байна.

АНУ-д гадаадын хүмүүсийг эрх зүйн байдлаас нь шалтгаалан 3 хуваадаг.

1. АНУ-ын нутаг дэвсгэр дээр түр оршин суух зөвшөөрөлтэй хүмүүс (цагаачлалын бус визтэй хүмүүс);

2. АНУ-ын нутаг дэвсгэр дээр байнга оршин суух зөвшөөрөлтэй хүмүүс (цагаачлалын визтэй

хүмүүс);

3. Хууль бусаар оршин суугаа хүмүүс.

Цагаачлалын болон цагаачлалын бус визтэй гадаадын хүний эрх зүйн байдал нь АНУ-ын нутаг дэвсгэрт оршин суух зөвшөөр-лөөрөө ялгаатай. Нэг нь байнга оршин суух, нөгөө нь түр оршин суух зөвшөөрөлтэй байдаг. Зөвшөөрлийн төрөл нь тухайн хүний АНУ-д байнга буюу түр оршин суух мэдүүлэгт дурдсан хүсэл эрмэлзэлтэй холбоотой бөгөөд нийцсэн байх ёстой. Хууль бусаар оршин суугаа хүмүүс гэж цагаачлалын хууль тогтоомжийг зөрчин АНУ-ын нутаг дэвсгэрт суугаа хүнийг хэлнэ. Энэ ангилалд хууль бусаар хил нэвтүүлэгт дурдсан хилийн хяналтаар ороогүй, хууль ёсоор орсон боловч тухайн улсын нутаг дэвсгэрт байх зөвшөөрөгдсөн хугацаага хэтрүүлэн үлдсэн, тухайн улсын нутаг дэвсгэрт хуурамч бичиг баримтаар буюу өөр хүний нэрээр орж ирсэн, эсхүл хууран мэхлэх замаар орж ирсэн, тухайн улсад орох эрхгүй мөртлөө шаардлагатай мэдээлэл нуун дарагдуулах замаар орж ирсэн (өмнө нь

албадан гаргагдсан, зөвшөөрсөн хугацаанаасаа өмнө буцаж ирсэн гэх мэт) гадаадын хүмүүсийг хамруулна.

Дүгнэлт


Дээрхи асуудлыг судалж үзсэний эцэст дараах дүгнэлтийг хийж байна.

1. Цагаачлалын эрх зүйн субъект нь гадаадын тодорхой улсын иргэдээс гадна хоёрдмол харьяалалтай болон харьяалалгүй хүмүүс байдаг учир "гадаадын иргэн" гэж нэрлэх нь учир дутагдалтай. Аливаа улсын цагаачлалын хууль тогтоомжийн дагуу тухайн улсын нутаг дэвсгэр дээр оршин суугаа тухайн улсын иргэн бус аливаа хүнийг "гадаадын хүн" гэдэг. Иймд тус хуулийн төслийн нэрийг "Гадаад хүний эрх зүйн байдал" эсвэл "Монгол Улсын иргэн биш этгээдийн эрх зүйн байдал" гэж нэрлэх саналтай байна.

2. Цагаачлалын тухай ярихад "цагаач" гэсэн нэр томъёог тодорхойлохгүйгээр уг субъектийн эрх зүйн байдлыг тогтоож чадахгүй. Иймд "цагаач" гэсэн нэр томъёог тус хуулийн төсөлд оруулах, нэр томъёог олон улсын эрх зүйн үүднээс тодорхойлох нь зүйтэй.




Шинэ ном



Энэхүү номд зохиогчийн сүүлийн 4-5 жилд бичиж, Улсын Их Хурал, түүний Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Монгол Улсын Шинжлэх ухааны Академи, Олон улсын Монгол судлалын холбоо, Хууль зүйн үндэсний төв, Удирдлагын Академи, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургууль, “Шихихутуг” дээд сургууль, Шүүх эрх мэдлийн болон Сонгуулийн төв байгууллага мөн Ханнс-Зайделийн сан, Нээлттэй Нийгэм Форум зэрэг төрийн бус байгууллагаас зохиосон онол практик, эрдэм шинжилгээний дотоодын хийгээд олон улсын бага хурал, хэлэлцүүлэгт бэлтгэж тавьсан илтгэл, Хууль зүйн үндэсний төв, Удирдлагын академийн эрдэм шинжилгээний ажлын төлөвлөгөөний дагуу судалж бичсэн зарим өгүүллийг анх удаа тусад нь эмхтгэл болгон нийтэлжээ.

Хэмжээ ихийн дээр хэвлэсний хойно хэрэглэхэд тохиромжтойг харгалзан хоёр дэвтэрт хувааж авсаархан болгосон аж.

Утас: 315734, 99875834




“МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ” 4 БОТЬ ХЭВЛЭГДЭН ГАРЛАА.

Энэхүү 4 ботид Монгол Улсын хүчин төгөлдөр мордоглож буй бүх хуулийг 2008 оны 5 дугаар сарын 30-ны байдлаар нэмэлт, өөрчлөлтийг нь тусган эмхтгэн орууллаа.

Монгол Улсын хуулийн 4 боть эмхтгэлийг хэрэглэхэд хялбар, цаашил нэмэлт, өөрчлөлтийг оруулан сольж болохуйц сугалбар хуудас, томор цоожлогч бүхий хатуу хавтастайгаар хэвлэсэн болно.

Дээрхи 4 ботид цаашил орох өөрчлөлтийг улирал бүр нэг багц болгон хэвлэж, захиалгын дагуу түгээх болно.

1 багцын үнэ: 200.000 төгрөг (I, II, III, IV боть 1 багц болно.)



БИЗНЕСИЙН ХОЛБОГДОЛТОЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ МОНГОЛ, АНГЛИ ХЭЛЭЭР 2 БОТИОР ХЭВЛЭГДЭН ГАРЛАА.

Бизнесийн үйл ажиллагаа эрхлэгч хэн бүхний гол хэрэглэгдэхүүн болох бизнесийн холбогдолтой Монгол Улсын 70 хуулийг эмхтгэн монгол, англи хэлээр 2 ботиор хэвлэн гаргалаа.

Энэхүү 2 ботийг хэрэглэхэд хялбар, сугалбар хуудас, томор цоожлогч бүхий хатуу хавтастайгаар хэвлэсэн болно.

Үнэ: 1. Бизнесийн холбогдолтой Монгол Улсын хууль (монгол хэлээр) 28,000 төг

2. Бизнесийн холбогдолтой Монгол Улсын хууль (англи хэлээр) 45,000 төг

Та эдгээр хуулийн эмхтгэлийг худалдан авахыг хүсвэл доорх хаяг, утсаар хандана уу.

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Сүхбаатарын талбай 7,
Хууль зүйн үндэсний төв Утас: 317494, 315735, 88007557, Факс: 315735